Монгол улсын Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн
Монгол улсын их сургуулийн Монгол хэл, соёлын сургууль
Монгол улсын Соёл урлагийн их сургуулийн Соёл урлаг судлалын хүрээлэн

ДОЖООГИЙН ЦЭДЭВ


"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО"-НЫ БЭЛГЭДЭЛ ЗҮЙ

УЛААНБААТАР
2002

Academy of Sciences of Mongolia, Institute of Language and Literature,
National University of Mongolia, School of Mongolian Language and Culture
Mongolian University of Arts and Culture, Research Institute of Arts and Culture

DOJOOGIIN TSEDEV

SYMBOLISM OF "THE SECRET HISTORY OF THE MONGOLS"



ДОЖООГИЙН ЦЭДЭВ

Монголын эрдэмтэн, зохиолч, улс олон нийтийн зүтгэлтэн Дожоогийн Цэдэв Баянхонгор аймгийн Баян-Овоо суманд төрсөн. Монголын Улсын их сургуулийг 1963 онд төгссөний дараа шинжлэх ухааны болон соёл, утга зохиол, боловсролын салбарт, ялангуяа их сургууль, хүрээлэнд олон жил ажиллаж, 1971 онд дэд эрдэмтний, 1997 онд шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалж, 1999 онд профессор цол хүртэж, 2001 онд Монголын Шинжлэх ухааны Академийн Бага чуулганы гишүүн болжээ.

1992-1996 онд Японы Токиогийн Гадаад судлалын их сургуульд багшилсан юм.

"Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл" (1973), "Монгол эх бичгийг шинжлэх арга зүйн туршиц" (Токио, 1995) "На.Сайнцогтын Монгол улсад байсан «гар дэвтэр»-ийн шүлгүүд "(Хөх хот, 1999) зэрэг шүүмж судлалын ном, "Айргийн амт" (1970), "Бодол (1979), "Тавын даваа" (1984), "Сэвтээ нь үгүй сэтгэл" (1992) зэрэг үргэлжилсэн үгийн болон яруу найргийн бүтээл нь хэвлэгджээ.

Монголд дэлгэрч түгсэн олон дуу, романсын шүлгийг зохиосон юм.

Эрдэм шинжилгээний бүтээл болон уран зохиол нь Англи, Орос, Япон, Герман, Испани, Франц, Араб, Мажар, Болгар, Вьетнам, Казах зэрэг хэлнээ орчуулагджээ.

Монголын алдарт бичгийн хүн Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ц.Дамдинсүрэн нарын бүтээл туурвил, улс төрийн зүтгэлтэн Ж.Батмөнхийн дурсамж дурдатгалын номыг бэлтгэж эрхлэн хэвлүүлжээ.

Зохиогчийн олон боть бүхий номын хуудсыг "Монголын нууц товчоо" -ны бэлгэдэл зүй хэмээх нэгэн сэдэвт бүтээл "Туурвил-1"-ээр нээж байна.

DOJOOGIIN TSEDEV

The Mongolian scholar, writer and public figure Dojoogiin Tsedev was born in Bayan-Ovoo soum, Bayankhongor aimag. After his graduation from the National University of Mongolia in 1963 he has been working in the sectors of science, culture, literature and education, including Universities and Institutes for many years. He was awarded a PhD in 1971, a ScD in 1997 and the title of professor in 1999. He became a member of the Minor Assembly of the Mongolian Academy of Sciences in 2001. He worked as a visiting professor at the Tokyo University of Foreign Studies between 1992 and 1996. He published his works including "The Tradition and Innovation of the Mongolian Poetry" (1973), "An Experiment in the Method of the Mongolian Textual Study" (Tokyo, 1995), "Verses of the Note-book of Manuscripts of Na.Saintsogt in Mongolia " (Hohhot, 1999) and the collection of his stories and poems such as "Airagiin Amt" (Taste of Koumiss, 1970) "Bodol" (Thought, 1979) "Taviin davaa" (Fifth Round, 1984) and "Sevtee ni ugui setgel" (A heart without Damage, 1992). He wrote the lyrics for many songs and romances, which are popular in Mongolia.

Some of his stories, poems and research works were published abroad in English, Russian, Japanese, German, Spanish, French, Arab, Hungarian, Bulgarian, Vietnamese and Kazakh.

D. Tsedev edited and published the works of famous Mongolian writers and scientists such as D. Natsagdorj, S. Buyannemekh, Ts. Damdinsuren and the recollection of the political figure J. Batmunkh.

The monograph on the symbolism of "The Secret History of the Mongols" being the first of many volumes enters the world of the author's works.

ОРШИЛ

Таван тивийн улс орны гол гол хэлээр орчуулагдсан, Монгол туургатны дундад эртний гайхамшигт дурсгалт бичиг болох "Монголын нууц товчоо"-гүйгээр монголын соёл иргэншлийг төсөөлөн бодох аргагүй юм. Учир иймд миний бие Монгол улсын их сургууль, Японы Токиогийн Гадаад судлалын их сургууль, Монголын Соёл урлагийн их сургуульд уг дурсгалт бичгийг эх бичиг судлалын үүднээс зааж эрдэмтэн мэргэдийн төдий л анхаарлаа хандуулаагүй талаас нь шинжлэх аянд мордсон билээ. Үүний үндсэн дээр "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл сэдвээр шинжлэх ухааны докторын зэрэг горилж, монголын болон гадаадын эрдэмтэн мэргэдийн санал бодлыг олонтаа сонссон юм.

Үүний дагуу засаж сэлбэж, заримыг нэмж, шинжилгээний үндэслэлийг нь гүнзгийрүүлэхийг чармайсан тул "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл зүй хэмээх толилуулан бүхий ном, зэрэг горилсон зохиолын хүрээгээр хязгаарлагдаагүй нь лав билээ. Өөрөөр хэлбэл "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл зүй гэсэн нэгэн сэдэвт зохиол шинээр цогцлон бий болсон юм.

"Монголын нууц товчоо"-ны бэлгэдлийн судалгаатай амин судасны хэлхээ холбоотой бөгөөд нөхвөрлөн баяжуулахад нэмэр болох "Эрдэмтэн мэргэдийн санал бодол оршибай", "Монголын нууц товчоо"-ны ертөнц хэмээх хавсралт нэг, хоёрыг хамтад толилуулав.

Чингис хааны мэлмий гийсний 840 жилийн ой (2002), Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой (2006)-д зориулсан энэхүү номыг хэвлэлд бэлтгэхэд чин сэтгэлээс тусалсан хэн бүхэнд, Интерпресс хэвлэлийн компанийн хамт олонд баярлаж гялайснаа илэрхийлмүү би.

Дожоогийн Цэдэв.

Арвандолдугаар жарны хар морин жилийн зуны адаг улаагчин хонь сарын хорин есөн, арғын 2002 оны наймдугаар сарын долооны өдөр.

FOREWORD

It is impossible to understand the Mongolian culture and civilization without "The Secret History of the Mongols ", a wonderful monument of the Mongolian nationalities of the early Middle Age, translated into the main languages of the nations of the five continents. Teaching the monument at the National University of Mongolia, Tokyo Universty of Foreign Studies and Mongolian University of Arts and Culture , from the point of the textual study, I started my research from the aspect to which the scholars had not paid much attention. During the writing of my dissertation "The Symbolism of the Secret History of the Mongols " for a scientific doctoral degree, I received many opinions and suggestions from international and Mongolian scholars. According to their opinions and suggestions I made improvements and additions to my dissertation and tried to deepen its research background. So the present monograph on the symbolism of "The Secret History of the Mongols " extended beyond the usual sphere of the research for a dissertation. One can therefore call this book a new monograph. The two appendixes "The Opinions and Thoughts of the Scholars " and the world of "The Secret History of the Mongols " are closely connected to the research of the symbolism of "The Secret History of the Mongols " and are a contribution and enrichment to it.

I would like to express my gratitude to everyone who helped me and the staff of the printing company "Interpress" for their assistance in the preparation of the book devoted to the 840th anniversary of the birth of Chinggis khaan in 2002 and the 800th anniversary of the establishment of Great Mongolia to be celebrated in 2006.

DOJOOGIIN TSEDEV

August 7, 2002

УДИРТГАЛ

Монголчуудын эд өлгийн болон оюуны соёлын өвөрмөц ялгаатай атлаа биесээ сэлбэх харилцан шүтэлцээ нь бас ч олон зуун, мянган жилийн өмнөх түүхэн үеийн дүр зургийг тал бүрээс нь сэргээн тодруулахад аргагүй бодит жишээ болно. Тэр бүхний дотроос монголчуудын оюун санааны чадвар, эрчмийн олон талыг хурц тодоор илэрхийлж, эдүгээ бидэнтэй золгосон дурсгалт бичгийн манлайн нэг нь "*Монголын нууц товчоо*" юм.

Уг зохиолыг судлаж, эдүгээгийн монгол хэлнээ уран сайхны хөрвүүлэг хийсэн Монголын эрдэмтэн Ц.Дамдинсүрэн "Нууц товчоог олон үндэстний эртний уран зохиолын нэрт дурсгалт бичгүүдтэй зэрэгцүүлэн тавьж жишээлэн хэлэлцэж болно"[1] гэж тэмдэглэсэн байхад уг туурвилыг шинжлэн, англи хэлнээ орчуулсан Америкийн эрдэмтэн Ф.Кливез "Монголын нууц товчоо бол зөвхөн XIII зууны монгол утга зохиолын буйрт дурсгал төдийгүй мөн дэлхийн утга соёлын агуу их дурсгал бичгүүдийн нэг мөн"[2] гэж үнэлжээ.

Энэхүү монгол судлалын хоёр том эрдэмтний үнэлэлт дүгнэлт чухам бодитой үндэслэлтэй гэдгийг "Монголын нууц товчооны 750 жилийн ойг тэмдэглэх тухай" НҮБ-ийн Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын асуудал эрхэлсэн байгууллага /ЮНЕСКО/-ын гүйцэтгэх товчооны 1989 оны 131 дүгээр тогтоолд "Уран сайхны гоо зүй, яруу найргийн шинж чанар, хэлний баялаг, өвөрмөц онцлог нь уг зохиолыг монголын утга зохиолын түүхэн дэх хосгүй үзэгдэл, дэлхийн аман зохиолын нэг алтан сан болгосныг" тэмдэглэн "Зөвхөн Монголын төдийгүй, дэлхий дахины соёлд түүх, утга зохиолын ач холбогдол бүхий зохиол "[3] хэмээн үнэлсэн явдал тодорхой харуулж өгсөн юм.

"Монголын нууц товчоо"-ны жинхэнэ уг эхийг эдүгээ бидний үе - XXI зуун эхэлтэл хэн ч олж илрүүлж чадсангүй. Харин дор дурдсан хоёр замаар "Монголын нууц товчоо" бидэнд дам уламжлагдан ирсэн юм. Үүнд:

"Монголын нууц товчоо"-ны 15 бүлэг бүхий Бао Тин-бо /1728-1814/ -гийн хуулбар эх /Петроградад хадгалагдаж байгаа/ мөн 15 бүлэг бүхий Цянь Да-синь /1728-1804/-гийн хуулбар эх /Бээжинд хадгалагдаж байгаа/, 12 бүлэг бүхий Гу Гуан-ци /1778-1835/-гийн хуулбар эх /Бээжинд хадгалагдаж байгаа/.

Нэн түрүүнд өгүүлсэн Бао Тин-бо, Цянь Да-синь, Гу Гуан-ци нарын эх ямар арга замаар гарсан бэ? гэсэн асуулт заавал гарна. Үүнд хариулахын тулд Хишигтогтохын ["Монголын нууц товчоо"-ны бар хэвлэлийн товч түүх]-д тулгуурлахын хамт "Мин ши-лу" /Мингийн магад тэмдэглэл/ хэмээх бичгийн Хун у-гийн 15 дугаар оны /1382/ цагаан сарын улаан нохой өдрийн тэмдэглэлийн дотор юун тухай өгүүлснийг мэдэх зайлшгүй шаардагдана. Эрдэмтэдийн тодруулснаар

"[Хаан бээр] бичгийн явдлын хорооны асран тайлбарлагч Хо Юань-цзэ нарт Хуа-и и-юй бичгийг найруулагтун хэмээн зарлиг буулгав... Хо Юань-цзэ болон найруулагч Ма-ша И-хэ нарт зарлиг буулган тэдний /монголчуудын/ хэлийг хятадаар орчуулгав... Дахин "Юаны нууц товчоо"-г авч ирж магадлал болгон үсгүүдийг нь таслан дуудлагад нь зохицуулав. Найруулан төгсмөгц зарлан хэвлүүлэн тараажээ. Түүнээс элчин түшмэл умард говь орноо одохуй ирэхүйд цөм тэдэнтэй нэвтрэлцэн чадах болов..." гэжээ. Үүнээс

1. "Хуа-и и-юй" толь бичгийг зохиох болсны учир шалтгааныг "тэдэнтэй /монголчуудтай/ нэвтрэлцэн чадах" хэмээн тодорхойлсон

2. "Хуа-и и-юй" толь бичгийг зохион найруулахад "Юаны нууц товчоо"-г /"Монголын нууц товчоо"-г/ авчирч магадлал болгосон

3. "Юаны нууц товчоо"-г магадлал болгохдоо "үсгүүдийг нь таслан дуудлагад нь зохицуулсан"

4. Найруулан бичиж дуусмагц хэвлүүлэн тараасан зэрэг хэд хэдэн санаа урган гарч байгаа юм. Уг зүйл хуваасан толь бичгийг Хун у-гийн 22 онд /1389/ хэвлэгдсэний улбаагаар нэхвэл

"Монголын нууц товчоо"-г Хо Юань-цзэ, Ма-ша И-хэ нар 1382-1389 оны хооронд галиглан буулгах зэргээр хийж гүйцэтгээд уг тольтой хамт, эсвэл дараахан нь хэвлүүлжээ. Эрдэмтэдийн дунд "Мингийн барламал эх"-хэмээн алдаршсан тэрхүү хэвлэмэл эхээс хуулбарлан 15 бүлгийг 1403-1409 оны хооронд "Юн-лэ да-дянь" /Юнлүгийн их журамлах бичиг/-ийг эмхтгэн гаргахдаа оруулсан нь бидний дээр өгүүлсэн гурван хуулбар эхийн гол үндэс болжээ. 1805 онд "Юнлүгийн их журамлах бичиг"-ээс Бао Тин-бо-гийн хуулбарлаж авсан эх Хань Тай-хуагаар дамжин 1872 онд П.Кафаров /1817-1878/-ын гарт оржээ. П.Кафаров 1878 онд А.Позднеев /1817-1920/-ыг Бээжинд очиход уг хуулбар эхийг Петроградад дамжуулсан нь эдүгээ хадгалагдан байгаа юм. Бао Тин-бо хуулбарласан эхээ нэрт эрдэмтэн Цянь Да-синьд сонирхуулсанд тэр ихэд үнэлж төгсгөл үг бичжээ. Цянь Да-синь-гийн өдрийн тэмдэглэлээс үзвэл "Ван Лүн-жүнгийн захидлыг олов. "Юаны нууц товчоон" дөрвөн дэвтрийг буцаажухуй. Тэр бээр Бао овогтын мэхүсээ мэдэрхүй (meküs-iyen mederekü) гэр /Бао Тин-бо-гийн бичгийн гэр хятадаар ... хэмээмүй/-ийн нэгэн хувь барлагдсан хэвлэлийг зээлэн үзсэн бүлгээ. Эхэн адаг дутуу ботилсон нь зээлсэн тэрхүү дэвтэр лүгээ зөрмүй" гэжээ. Энэ нь Цян Да-синьд хоёр юмуу хэдэн эхийг зэрэгцүүлэн үзэх бололцоотой байсныг илэрхийлсэн болно. Цян Да - синь үүндээ тулгуурлан төгсгөл үг бичсэн тул түүний нэрээр нэрлэгдсэн хуулбар эх Бээжинд эдүгээ хадгалагдаж байдгийн учир тэр болой. Жан Сян-юань-гийн хувийн цуглуулгад байсан "Мингийн барламал эх"-ийн бас нэгэн хууллагаас Гу Гуан-ци 1805 оны үес дам хуулан авсан нь Вэнь Ти-ши /1856-1904/-гийн сийрүүлэг, Е Дэ-хуй /1864-1927/-н модон бар зэргээр дамжин судлаачдын тулгуур эхийн нэг болжээ. Гу Гуан-ци-гийн хуулбар эх нилээд найдвартай гэдэг нь 1933 онд Бээжингийн хааны ордны хуучин номын хөмрөгөөс олдсон "Мингийн барламал эх"-ийн 41 хуудастай тулган шинжлэхэд "Дэвтрийн мөр бүрийн үсгийн тоо болон нүүр бүрийн мөрийн тоо нь хэрэг дээрээ адилхан, үсгийн

дан болон бичлэгийн онцлог ч ойролцоо"-гоор батлагдсан ажээ. Дундат улсын эрдэмтдийн тооцоолсноор "Одоо манайд ашиглагдаж байгаа Гү Гуан-ци-гийн дэвтэр, Е Дэ-хуйн дэвтэр, Цянь Да-синь-гийн дэвтэр бол бүр олон удаа дам хуулагдсан дэвтрүүд болох юм. Тийнхүү аль ч дэвтэрт алдаа буруу тун олонтой... Арван таван ботит дэвтэрт бараг 3200 илүү үсэг буруудав. Гү Гуан-ци-гийн дэвтэрт 1200 илүү үсэг буруудав. Е Дэ-хуйн дэвтэр бол Гү Гуан-ци-гийн дэвтрээс ирэлтэй юм. Тийнхүү Гү-гийн дэвтэрт буруудсан үсгүүд нь Е-гийн дэвтэрт цөм буруудсанаар үл барам бас гуч гаруй үсгийн буруу нэмэгджээ... Нууц товчоон дахь алдаануудыг хураангуйлбал: Орхигдсон, үсэг буруудсан, буруу хуваасан ба илүү холбосон, буруу залгасан, илүүдсэн ба тонгоруулсан зэрэг зургаан зүйл буй..."[4] ажээ. Алдаа мадгийг илрүүлэн тооцно гэдэг түүнийг засч залруулах чиг замыг олоход тус дэм өгч байна гэсэн үг. "Монголын нууц товчоо" шиг жинхэнэ эх нь олдоогүй ч үзэж судлахаас өөр аргагүй тийм чухал туурвилын хувьд буруугаас зөв рүү, гүехэнээс гүн рүү нь чиглэсэн эрэлчид тасраагүй , цаашид ч тасрана гэж үгүй биз ээ. "Монголын нууц товчоо"-ны эхийг сэргээх олон он жилийн эрлийн явцдаа хятад зураг үсгээс монгол хэлнээ тохируулсан "хятад-монгол бичиг"-ээс, дөрвөлжин үсгээр тэмдэглэсэн эхээс, уйгуржин монгол эхээс хятад галигаар буулгасан гэхчлэн эрдэмтэд янз янзаар үзсээр ирсэн юм. Уйгуржин монгол эхээс хятад галигаар буулгасан гэх саналыг бататгахад "Алтан товч" хэмээх судар XX зууны эхээр эрдэмтдийн хүрээнд олдож шинжлэх ухаанд мэдэгдсэн явдал чухал түлхэц болжээ. Тиймээс "Монголын нууц товчоо"-ны бидэнд дам уламжлагдсан хоёрдахь зам нь Монголын түүхч Лувсанданзаны XYII зууны эцэс, XYIII зууны эхэн үеэр зохиосон "Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч"[5] хэмээх монгол судар болно. Эрдэмтдийн тооцсоноор "Монголын нууц товчоо"-ны 282 зүйлээс 233 зүйлийг буюу 1-38, 40-176, 208-254, 256-264, 266,268 дугаар зүйлийг "Алтан товч"-д бага зэрэг

засч товчилсон байдлаар оруулжээ.

"Монголын нууц товчоо" нь хятад галиг үсгээр монгол хэлээр тэмдэглэн дам хуулагдаж олон удаа нэмэр сэлбэг авч он жилийг улираасан тул түүний эх бичгийн судалгаанд дэлхийн олон эрдэмтэн юуны өмнө анхаарлаа хандуулсаар ирсэн нь тодорхой юм. Тэдний ажлын тодорхой нэг үр дүн бол "Монголын нууц товчоо"-г анх байсан үсгээр нь сэргээн сийрүүлж, эрдэм шинжилгээний галиг, хөрвүүлэг, орчуулга хийсэн нь эх бичгийн холбогдолтой судалгаа юм. Энэ талбарт Алтан-Очир[6], Бөх хишиг[7], Баяр[8], Ш.Гаадамба[9], Ц.Дамдинсүрэн[10], Т.Дашцэдэн[11], Дугаржав[12], Иринчин[13], Жагчид сэчин[14], Калужиньски[15], П.Кафаров[16], Ф.Кливез [17], С.Козин [18], Х.Курибаяаши[19], Л.Лигети[20], Мансан[21],А.Мостэрт[22], М.Мураками[23], М.Нака[24], Ш.Озава[25], Б.Панкратов[26], П.Пеллио[27], П.Поуха[28], И.Рахевильц[29], Сей Зай-шань[30], Б.Сумъяабаатар[31], А.Темир[32], Хишигбат[33], Е.Хэниш[34], Цэнд гүн[35], Д.Цэрэнсодном[36], К.Ширатори[37], Эвен(Мари-Доминик Эвен, Родига Поп)[38], Элдэнтэй, Ардаажав[39], Элдэнтэй, Оюундалай[40] зэрэг олон эрдэмтэн хүчээ сорьсон юм. Эдгээр эрдэмтний ач буянаар "Монголын нууц товчоо"-нь судалгааны бат найдвартай эх хэрэглэгдэхүүний нэг гэдэг нь тодорхойлогдсон юм.

Эдгээрийн дотроос И.Рахевильцийн хийсэн шинжилгээний галигийг бусад эрдэмтний ололтыг ашиглаж, мадгийг залруулан эх бичигт няхуур хандаж, бүх үсгийн хэлхээ /индекс/-г цахим тоолуураар ултай хийсний нь хувьд би судалгаандаа иш татан ашиглахаар сонгов. Мөн Л.Лигетийн галигт тулгуурлан Х.Курибаяаши, Чойжинжав нарын үйлдсэнийг харгалзан үзэж, хятад галигаас нь Эрдэнэхад судлаачийн тусыг авч хуулбарлан ашигласан болно.

Монголын судлалын дотор "Монголын нууц товчоо" судлал гэх бие даасан салбар нэгэнт бий болон хөгжиж байгаа нь түүнийг тал бүрээс нь шинжлэх өргөн боломжийг нээснээр дэлхийн улс оронд дагнасан буюу хавсарсан бүтээлүүд[41] гарах

болов. Ийм мэдээлэл судалгаанаас үзэхэд өнөөгийн байдлаар "Монголын нууц товчоо" судлалын 700 гаруй бүтээл дэлхийн олон хэлээр хэвлэгдээд байна.

Эдгээрийг ангилан үзвэл "Монголын нууц товчоо" нь

1. Хэлний дурсгал мөн
2. Түүхийн сурвалж бичиг мөн
3. Аман зохиол уран зохиолын өв сан мөн гэсэн чиглэлээр судлагджээ.

"Монголын нууц товчоо"-г хэдийгээр ингэж олон жилийн турш тал талаас нь судалсаар байгаа боловч цаашид нарийвчлан шинжилвээс зохих чиглэл болон олон асуудал эзнээ хүлээсээр байгаа юм. Тийм чиглэлийн нэг нь "Монголын нууц товчоо-"г бэлгэдэл зүйн үүднээс судалж шинжлэх явдал юм. Бэлгэдэл зүй нь монгол судлалын хувьд ч шинэ тутам салбар хэмээн үзэж болно. Харин Монгол судлалын дотроос аман зохиол дахь бэлгэдлийн судалгаа эхлэл ахицтай байгаа юм.

К.Сагастер "Монгол Гэсэрийн туулийн бэлгэдэлийн тухай" /1977/, "Монгол туулийн тооны бэлгэдэл" /1981/[42] зэрэг хэд хэдэн өгүүлэлдээ монгол бэлгэдлийн тогтолцооны өргөн хөтөлбөр дэвшүүлж, түүнийгээ "Гэсэр", "Гөшөө чулуун зүрхт Хүвэй буйдар хүү","Алтай Цэмбэл хүү" зэрэг туульсын жишээнд тулгуурлан судалжээ. С.Ю.Неклюдов "Монгол түмний домог зүйн болон ардын бэлгэзүй-туульсын бэлгэдлийн тухай тэмдэглэл: Алтны бэлгэдэл" /1980/[43] өгүүлэлдээ алт гэдэг үгийг домог, баатарлаг туульсад болон бичгийн уран зохиолд яаж хэрэглэж ирснийг баялаг жишээнд нягтлан үзэж бэлгэдэлийн утгыг нь тодруулжээ. С.Дулам "Монгол домог зүйн дүр" /1989/ нэгэн сэдэвт зохиолдоо монгол домог зүйд тодорхой ялгарч байгаа зүг чиг, өнгө, тооны бэлгэдлийг судалжээ[44].

Л.Чулуунбатын "Монгол туулийн өнгө, тоо, зүг чигийн бэлгэдэлт дүрслэлийн арга" /1987/[45] өгүүлэлд дэвшүүлсэн сэдсэн санааг гүйцээж Б.Катуу "Монгол туульсын бэлгэдэл" /1996/ номдоо "туульс дээр тулгуурлан өнгө, тоо, зүг чиг, хээ дүрсийн

бэлгэдэл тус бүрийн гарал үүсэл, утга хоорондын хамаарал ялангуяа дүр дүрслэлийн чухал хэрэглүүр болох талаас нь" [46] шинжилжээ.

Монгол ардын аман зохиолын зэрэгцээ шашин мөргөл, угсаатны зүйн үүднээс бэлгэдлийг судлахад Н.Л.Жуковская "Монголын уламжлалт соёлын ай, бэлгэдэл" /1988/[47] нэгэн сэдэвт зохиолдоо аж төрөл, ёс заншил, зан үйлийн хэрэглэгдэхүүнийг голлосноороо, Х.Нямбуу "Өнөөгийн монгол ёс" /1976/, "Монгол бэлгэдэл" /1979/[48] бүтээлдээ монгол төр иргэний ёс бэлгэдлийн учир утгыг тайлснаараа, Р.Амайон "Сүнс гөрөөлөхүй" /1990/[49] туурвилдаа хүн хийгээд онгодын ертөнцийн хоорондын бэлгэдэлт харьцааны тухай онолын үндэслэл боловсруулснаараа чухал хувь нэмэр болжээ. Гэвч "Монгол бэлгэдэл зүйн асуудал тэр дундаа аман зохиол, сонгодог утга зохиол дахь бэлгэдлийг судалсан судалгаа өнөө хир гараагүй байна гэхэд болно"[50] хэмээн үзсэн С.Дулам тэрхүү зайг нөхөхөд "Монгол аман зохиол, утга зохиол дахь бэлгэдэл зүйн тогтолцоо"/1997/ гэсэн нэгэн сэдэвт бүтээлээ зориулав. Докторын зэрэг горилон бичсэн уг туурвилдаа "зөвхөн туульс дахь бэлгэдлийг бус түүнийг үлгэр домог, түүх домог зэрэг хүүрнэн өгүүлэх болон аман зохиолын бусад төрөл зүйл, улмаар бөө мөргөл тайлга тахилгын соёл, сонгодог утга зохиолын бэлгэдэлтэй харгалзуулан" тоо, өнгө, цаг, зүг чиг, дохио зангаа, хэлбэр дүрс, зүүд зөн совингийн бэлгэдэл зүйн тогтолцоог тогтоожээ. Үүнийгээ хожим дөрвөн дэвтэр болгон хэвлүүлж байгаа билээ.

"Сонгодог утга зохиолын бэлгэдэлтэй харгалзуулан..." гэдэгт "Монголын нууц товчоо"-г хамааруулж байгаа нь лавтай. Ер нь монголын бичгийн уран зохиолын бэлгэдлийн талаар өгүүлэхэд "Монголын нууц товчоо"-г тойрч өнгөрөхгүй нь мэдээж юм.

С.А.Козин "Орос, монгол туульсын туурвил дахь бэлгэдэл" /1940-өөд он/ бүтээлдээ "Игорийн хорооны тууж", "Монголын нууц товчоо"- хоёрыг зэрэгцүүлэн нийтлэг шинжийг илрүүлсэн

нь монгол бэлгэдлийг эхэлж шинжилсэн туршиц юм[51].
"Монголын нууц товчоо" монгол ардын аман зохиол хоёрын харилцан холбогдох тухай, түүний уран зохиолын дурсгал болох, утга бүрхэг зарим үг хэллэгийг тайлбарлах зэрэгтээ Ш.Гаадамба бэлгэдлийн асуудлыг ямар нэгэн хэмжээгээр хөндсөн[52] гэж үзэж болно. Түүнчлэн "Монголын нууц товчоо"-ны домог зүйн сэтгэлгээний тухай Д.Цэрэнсодномын бичсэн цуврал өгүүлэлд[53], мөн монгол аман зохиолтой "Монголын нууц товчоо"-г холбон үзсэн П.Хорлоо[54], Х.Хасуми[55], Х.Сампилдэндэв[56], Л.Сономцэрэн[57] нарын өгүүллүүдэд бэлгэдлийн зарим асуудлыг шууд болон шууд бусаар бас хөндсөн байна.

Гэвч "Монголын нууц товчоо"-г бэлгэдэл зүйн үүднээс бие даан шинжилсэн судалгаа өнөө хир гараагүй байгаа юм. Энэ нь монгол бэлгэдэл зүйг тодорхой нэгэн зохиолын жишээн дээр дагнан судласан шинжилгээний туршлага үгүйлэгдэж байгаатай юуны өмнө холбогдоно. "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл зүй гэсэн сэдвийг сонгосны минь учир утга ч үүнд оршино.

"Монголын нууц товчоо"-нд тусгагдсан бэлгэдэл зүйн соёл-түүхийн хам нөхцлийн хүрээг тогтоож, түүний гол гол ай, цогцолбор, чуулбар шинжийг илрүүлэхэд судалгааны гол гол зорилго чиглэсэн юм.

"Монголын нууц товчоо"-ны бэлгэдлийг нэгэн сэдэвт зохиолын хүрээнд судална гэдэг нь зөвхөн уг зохиолын хэмжээ цараар хязгаарлагдахгүй бөгөөд өмнөх үеийнх нь аман бүтээлийн уламжлал, дараа үеийнх нь түүх, түүх-уран сайхны бичгийн зохиолд үлдээсэн нөлөөтэй холбож шинжилнэ гэсэн үг мөн. Чухам ингэж "Монголын нууц товчоо"-г бэлгэдэл зүй үүднээс өргөтгөн гүнзгийрүүлж судалснаар дорно дахины соёлын нэгэн урсгал ундрага болсон Монголын бичгийн утга зохиол дахь бэлгэдэл зүйг тодруулан тогтоох нөхцөл бололцоог бүрдүүлэх болно.

"Монголын нууц товчоо" нь монгол хэлнээс гадна орос, англи, франц, герман, болгар, чех, польш, хятад, япон, солонгос

зэрэг дорно өрнийн олон хэлээр нэгэнт орчуулагдаж, оршил, удиртгал, тайлбар сэлттэйгээр хэвлэгдэж олны хүртээл болсон билээ. Тиймээс олон хэлээр гарсан "Монголын нууц товчоо"-ны эх бичгийн судлал, түүний судалгаа, орчуулга, тайлбарыг уг бүтээлийг туурвихад гол хэрэглэгдэхүүн болгов.

Эдгээр хэрэглэгдэхүүнийг тухайн үеийн түүхэн баримт зэргээр тодруулахад XII-XIY зууны үед монголд ирж байсан өрнө, дорнын хүмүүсийн бичиж үлдээсэн түүхэн тэмдэглэл, нөгөөтэйгүүр монгол угсаатны эртний ёс заншлын ул мөрийг хадгалсан аман зохиолын төрөл, монголын олон ястаны угсаатны зүйн сурвалж зэргийг анхааран үзсэн болно. Түүнчлэн "Монголын нууц товчоо"-ны уламжлалын дагууд гарсан "Алтан товч", "Эрдэнийн товч", "Шар тууж", "Болор эрих", "Болор толь", "Асрагч нэртийн түүх", "Их Юань улсын мандсан төрийн хөх судар" зэрэг түүх, түүх-утга зохиолын сурвалж бичгүүдийг хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

Уг судалгааг хийхдээ бэлгэдэл зүй-дохио зүйн аргыг хэрэглэж, системийн аргыг үндэс болгов. Түүнчлэн бэлгэдлийн тодорхой жишээний уламжлах, залгамжлах чанарыг тодорхойлоход хэв шинжийн хийгээд харьцуулсан судалгааны аргыг харгалзан үзсэн болно.

Онолын томъёололд монгол жишээ тулган дүйлгэх аргаар судалдаг тэр барилаар бус, "Монголын нууц товчоо"-ны бүлэг хэсгээс ургуулан бодох замаар үнэлэлт, дүгнэлт гаргахыг эрмэлзсэнд уг зохиолын нэгдэх шинэлэг тал оршино. Нүүдэлчдийн ахуй, уламжлалт ёс заншилтай холбож, түүнээс ургуулан сэтгэхүйн гүн рүү нэвтрэхийг эрмэлзэж бэлгэдэл зүйн асуудлаар өөрийн гэсэн санаа бодол дэвшүүлсэнд уг зохиолын хоёрдахь шинэлэг тал оршино.

Бэлгэдлийн уламжлах, залгамжлах шинж чанар, түүний судалгаанд анхаарч, жишээ баримтаар баяжуулан нотлохыг оролдсонд уг зохиолын гуравдахь шинэлэг тал оршино. Урьд өмнө төдий л мэдэгдээгүй байсан аман зохиолын болон уран

зохиолын зарим хэрэглэгдэхүүнийг судалгааны хүрээнд оруулсанд уг зохиолын дөрөвдэх шинэлэг тал оршино. Энэ бүхний үндсэнд бэлгэдэл зүйн асуудлыг тодорхой нэгэн бичгийн зохиол, тухайлбал "Монголын нууц товчоо"-нд тулгуурлан анх удаа нэгэн сэдэвт зохиолын хүрээнд судалсныг уг бүтээлийн шинэлэг тал гэж үзнэ.

Уг судалгаа, түүнээс гарах дүгнэлтийг гадаадын монгол судлаач, Төв Азийн соёл, түүх судлаачид болон Монголын эрдэмтэд бүтээл туурвилдаа хэрэглэж ашиглаж болно. Монголын их дээд сургууль, гадаад улс дахь монгол судлаачдыг бэлтгэдэг их сургууль, тэдгээрийн багш, докторант, аспирант, оюутан нарт гарын авлага болж болно. Уг судалгааны арга зүйн дагуу монгол аман зохиол, бичгийн уран зохиолын тодорхой бүтээлд судалгаа хийх боломжийг олгоно.

Энэхүү нэгэн сэдэвт зохиол нь удиртгал, үндсэн гурван бүлэг, дүгнэлт, ном зүйгээс бүрдсэн болно.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Ц.Дамдинсүрэн. Удиртгал. Монголын нууц товчоо. Дөрөвдэх удаагийн хэвлэл. Ред. Ш.Гаадамба. УХГ, УБ., 1990, 7-8-р тал
2. The Secret History of the Mongols. Volume 1 (translation) by Francis Woodman Cleaves. Harvard University Press, 1982, p.XI
3. Mongolica. An International annual of mongol studies. 1990. vol 1 (22). Ulan-Bator, pp. 342-344
4. C.Kesigtoγtaqu. Mongγol-un erten-ü utγ-a jokiyal-un sudulul. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1988. 1-31 (3-4, 23-24) düger tal-a.
5. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршивай. Оршил бичиж нийтлүүлсэн Академич Ш.Бира. УБ., 1990
6. /Алтан-Очир, 1942/ Mongγol-un niγuca tobciy-a orciγuluγsan kümün qarcin baraγun qosiγun-u Altan wcir-un jüng cing. Boγda Cinggis qaγan- doluγan jaγun γucin jiryuduγar on-u arban sar-a-yin arban ta-bun-a. Terigün noyan-u ordun-u darumal-un γajar.
7. /Бөххишиг, 1941/ Mongγol-un niγuca tuγuji. Mongγolcilaγsan kümün Bökekesig. Darumallan γaryaγsan anu mongγol utγ-a-yin surγal-un qural. Engke erdemtü-yin naimaduγar on γurban sar-a-yin qorin-a.
8. /Баяр, 1981/, Bayar, Mongγol-un niγuca tobciyan. Terigün, ded, γudaγar debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1981
9. /Гаадамба , 1990/ Mongγol-un niγuca tobciyan /Монголын нууц товчоо/. Худам монгол үсгээр сийрүүлсэн Ш.Гаадамба. Худам /язгуур эртний/ монгол бичгээр монгол бичиг, утга соёлын үүднээс Шанжмятавын Гаадамбын төсөөлөн найруулж сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр. УБ., 1990
10. /Дамдинсүрэн, 1947/ Mongγol-un niγuca tobciyan. C.Damdinsürüng qaγucin mongγol kelen-ece odu-yin mongγol bicig-ün kele-ber orciγulba, Ulaγanbaγatur, 1947
11. /Дашцэдэн, 1985/. Монголын нууц товчоо. Галиглан

БНМАУ
УЛСЫН НИЙТИЙН
НОМЫН САН
Х

хэвлүүлсэн Т.Дашцэдэн, ШУАХ, УБ., 1985
12. /Дугаржав, 1984/ "Mongγol-un niγuca tobciyan-u qarγuγulun kinaγsan debter. qarγuγulun kinaγsan ni Eldengtei. Oyundalai. Baγulγaγsan ni quqasai Duγarjab. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1984.
13. /Иринчин, 1987/ Irincin. Mongγol-un niγuca tobciyan Kökeqota. 1987
14. /Жагчид Сэчин, 1979/ Jagcid Secin (Sechin Jagchid). Mongγol-un niγuca tobciyan. /Шинээр орчуулж тайлбар хийсэн, хятад хэлээр/ Taipei (tayiban), 1979
15. /Калужиньски, 1970/ Stanislaw Kaluzynski. Tajna historia Mongolow. Anonimowa kronika mongolska z. XIII w. Warszawa PIW. 1970
16. /Кафаров, 1886/ Кафаров Палладий. Старинное монгольское сказание о Чингисхане. Труды членов Российской духовной миссии в Пекине. Том IY 1866. Санкт-Петербург.
17. /Кливез, 1982/ The Secret History of the Mongols. Translated and edited by F.W.Cleaves, London, 1982
18. Козин, С.А. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г. под названием Mongγol-un niγuca tobciyan. Юань чао би ши - монгольский обыденный изборник, Том 1., Изд АН СССР, М-Л., 1941
19. /Курибаяаши, Чойжинжав, 2001/Word-and suffix-index to the Secret History of the Mongols... Compiled by H.Kuribayashi & Choijinjab. The center for Northeast Asian studies Tohoku University. Sendai, Japan. 2001
20, /Лигети, 1971/ Histoire secrete des mongols. Par louis Ligeti, Budapest, 1971
21. /Мансан, 1985/ Mansang, Sin-e-ber orciγulju tayilburilaγsan. Mongγol-un niγuca tobciyan. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1985
22. /Мостэрт, 1953/ Sur quelques passages be L'histoire secrete des Mongols. Harvard-Yenching Institute, 1953

23. /Мураками, 1970-1976/ Масацүгү Мураками. Монголын нууц товчоо- Чингис хааны өгүүлэл. /Тэргүүн, дунд, доорд дэвтэр, япон хэлээр/. Токио, Биданшя, Тоёобунко, 1970, 1972, 1976
24. /Нака, 1907/ Мичиёо Нака. Чингис хааны тухай үнэн тэмдэглэл. /Орчуулга, тайлбар япон хэлээр/ Дайнихон тошё. 1907
25. /Озава. 1984-1989/ "Монголын нууц товчооны бүрэн тайлбар. /Дээд, дунд, доорд дэвтэр, япон хэлээр/ Казамашобоо, Токио,1984, 1985, 1987. "Монголын нууц товчооны бүрэн тайлбарын үргэлжлэл. /Дээд, дунд, доорд дэвтэр, япон хэлээр/ Казамашобоо. Токио, 1987, 1988, 1989
26. /Панкратов. 1962/ Юань-чао би-ши /Секретная история монголов/ Том. 1, Текст, Издание текста и предисловие Б.И.Панкратова, М., 1962
27. /Пеллио, 1949/ P.Pelliot, Histoire secrete des Mongols, Paris, 1949
28. /Поуха, 1955/ Poucha Pavel. Tajna kronica Mongolu. Praha. 1955.
29. /Рахевильц, 1972/ Index to the Secret History of the Mongols, by Igor de Rachewiltz, Indiana univertsity, Bloomington, 1972
30. /Сей Зай-шань, 1951/. Се Зай-шань. Монголын нууц товчоо /хятад хэлээр/ Кайминий хэвлэлийн газар. 1951
31. /Сумъяабаатар. 1990/ Монголын нууц товчооны галиг. УБ., 1990
32. /Темир, 1948/ Axmet Temir. Mogollarin Gizli Tarihi (Yazilisi 1240). Manghol-un Niuca Tobcaan (Yüan-chao pi-shi, I tercume; Ankara (Turk Tarin Kurumu Vayinlarindan II seri No 13) 1948.
33. /Хишигбат, 1940-1941/ Kesigbatu-yin orciγulaγsan juwan ulus-un niγuca tobciyan. Terigün noyan-u ordun-u darumal-un γajar (Ciγulaltu qaγalγ-a) 1940-1941 on.
34. /Хэниш, 1937/ E.Haenisch. Die geheime Geschichte der Mongolen, Leipzig, 1937
35. /Цэнд гүн, 1996/. Цэндийн Хандсүрэн. Цэнд гүн ба Монголын нууц товчоо. УБ., 1996
36. /Цэрэнсодном, 1990/ Монголын нууц товчоо/Шинэ орчуулга/

"Цог" сэтгүүл, 1990, № 1-4, Dalangtai-yin Cerinsodnam. Mongγol-un niγuca tobciyan-u orciγulγ-a tayilburi. ündüsün-ü keblel-ün qoriy-a, 1993. Д.Цэрэнсодном. Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Мөнхийн үсэг хэвлэх үйлдвэрт хэвлэв. Улаанбаатар 2000.

37. /Ширатори, 1943/. Ширатори Куракичи. Галиг үсгээр буулгасан Монголын нууц товчоо. Токио. Тоёобунко. 1943
38. /Эвен, 1994/ Histoire secrete des Mongols (Mongghol -un ni'uca tobciyan) chronique mongole du XIII e siecle. Trabuit du mongol, presente et annote par. Marie-Domonique Even et Robica Pop Preface be Roberte N.Namayom. Gallimard 1994.
39. /Элдэнтэй,,, Ардаажав, 1986/ Eldengtei, Ardajab seyiregülün tayilburilaba. Mongγol-un niγuca tobciyan seyiregülül tayilburi, öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a, 1986
40. /Элдэнтэй,,, Оюундалай, 1980/ Eldengtei, Oyundalai nar-un ariγutγan sigügsen debter. Kökeqota. 1980
41. а. Д.Цэрэнпил, Б.Сэржав. Монголын нууц товчооны ном зүй, судлалын тойм, УБ, 1990, 68-127-р тал
    б. А.Д.Цендина. Изучение "Сокровенного сказания" в МНР" Mongolica, М., Наука, 1993, стр 54-86
    в. Ц.Ишдорж. "Монголын нууц товчоо" зохиолыг БНМАУ-д судалсан нь. Mongol sudulul (Mongolian studies) 19, The Korean Association for Mongol studies, 1994, No 2, pp.124-143
    г. Н.С.Яхонтова. История изучения "Юань Чао би-ши" в России и СССР. Mongolica, М., Наука, стр 7-39
    д. Д.Улымжиев. Изучение "Сокровенного сказания Монголов в России и СССР" Монголын судлалын мэдээ, International Association for Mongol Studies, Ulaanbaatar, 1990, 1(5) 20-28-р тал
    е. Ц.Дугарнимаев. Монголын нууц товчоо Буриадад Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл /1990, 8-14-16, УБ.,/

ё. Ч.Далай. Хятад дахь Монголын нууц товчоо судлал. Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл. /1990.8-14-16, УБ.,/
    ж. Булаг. Дундад улс дахь МНТ-ны судлал. Өвөрмонголын багшийн их сургуулийн МНТ-ны олон улсын эрдэм шинжилгээний ярилцах хуралд тавьсан илтгэл. Хөх хот, 1988-8, т. 93-102. Булаг. Изучение "Сокровенного сказания" в Китае. Mongolica, М., Наука, 1993, стр 87-98
    з. Ж.Ринчиндорж. Монголын нууц товчооны монгол бичгийн бар хэвлэлүүд. - Монголын судлалын мэдээлэл. Bulletin the IAMS News. Information on Mongol Studies, 1990, Number 2(6), 81-85-р тал
    и. Д.Төмөртогоо, Л. Манлажав. БНХАУ дахь Монголын нууц товчооны судлал. - Mongolica. An International Annual of Mongol studies. Vol. 1 (22), УБ, 1990, 284-304-р тал
    к. Б.Сэржав. Япон дахь "Нууц товчоо"-ны судлалын тойм. - Mongolica. An International Annual of Mongol studies, Vol 1 (22) УБ., 1990, 283-293-р тал
    л. А.Хараяма. Монголын нууц товчооны номын жагсаалт. /Reprented by the editors from a 1978 Japanese edition) Mongolica. An international annual of Mongol studies, 1990, Vol 1(22), 305-341-р тал
    м. И.Шима. Чехословакийн МНТ-ны тухай мэдлэг ба судалгааны талаархи хувь нэмэр. Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан илтгэл. 1990.8.14-16, УБ.,/
    н. John R.Krueger. Chronology and Bibliography of the secret history. Mongolica. An International of Mongol studies, 1990, Vol 1(22), 277-282-р тал
42. K. Sagaster. On the Symbolism in the Mongolian Geser Epic. - Third International Congress of Mongolists 1977, Zur Zahlemsymbolik im mongolischen Epos. - Fragen der mongolischen

Heldendichtung. 1981
43. Сергей Ю.Неклюдов. Заметки о мифологической и фольклорно-эпической символике у монгольских народов: символика золота. Etnografia Polska. t.XXIY zeszyt 1. 1980. pp. 65-91
44. С.Дулам. Монгол домог зүйн дүр. УХГ. УБ., 1989, 59-60, 72, 185-186-р тал
45. Л.Чулуунбат. Туулийн өнгө, тоо, зүг чигийн бэлэгдэлт дүрслэлийн арга. Studia Folclorica... Tom XYI, Fasc 8. ШУАХ. УБ., 1987, 101-109-р тал
46. Б.Катуу. Монгол туульсын бэлгэдэл. УБ., 1997, 126-127-р тал
47. Н.Л.Жуковская. Категории и символика традиционной культуры монголов. Наука. М., 1988, стр. 170-173
48. Х.Нямбуу. Өнөөгийн монгол ёс. ШУАХ. УБ.,1976, Монгол бэлэгдэл. УХГ. УБ., 1979
49. R.Hamayon. Tricks and turns of Legitimate Perpetuation. Fragen der mongolischen Heldendichtung 1982
50. Сэндэнжавын Дулам. Монгол аман зохиол, утга зохиол дахь бэлгэдэл зүйн тогтолцоо. Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. Улаанбаатар, 1997/Цохимол эх/ 12 -р тал
51. С.А.Козин. Эпическая символика в русском и монгольском эпическом творчестве. АВ., Разряд. 1, оп 3, № 52
52. Ш.Гаадамба. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. УХГ, УБ., 1990, 103-135, 129-234-р тал
53. Д.Цэрэнсодном. Об этимологии одного из выражений "Сокровенного сказания монголов" Studia Linguae et litterarum...Tom XX, Fasc 12, ШУАХ, УБ., 1987/1984/ стр. 152-158, Д.Цэрэнсодном. "Монголын нууц товчооны" домгийн сэтгэлгээний зарим нэгэн ойлголтын тухай. Studia folclorica... Tom XYII, Fasc 1, УБ, 1987, 3-9-р тал
54. Pü.Khorlu-a. Aman jokiyal-un ulamjilal ba "Niγuca tobciyan" Mongolica . An international annual of mongol studies, 1990, Vol. 1(22). 245-264-р тал

55. Хасуми Харуо. Чингис хааны домог- монгол ардын аман зохиол. /япон хэлээр/ Цинокива, 1993
56. Х.Сампилдэндэв. Аман яруу найраг ёгтлолыг ашигласан нь. Studia folclorica... Tom X, Fasc 3. ШУАХ. УБ., 1976 /1977/ 55-68-р тал; Х.Сампилдэндэв."Монголын нууц товчоо"-нд гардаг саглагар модны учир. "Монголын нууц товчоо"-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал. I. УБ., 1995, 195-202-р тал
57. Л. Сономцэрэн (БНМАУ). Монголчуудын өнгөний билэгдлийг "Нууц товчоо"-нд тусгасан нь. Mongolica. An International annual of Mongol studies, 1990, Vol 1(22). pp.103-106

ТЭРГҮҮН БҮЛЭГ

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО"-НЫ БЭЛГЭДЛИЙН СОЁЛ-ТҮҮХИЙН ХАМ НӨХЦӨЛ, ХАМРАХ ХҮРЭЭ



Алив улс түмэн, хөгжлийнхөө явцад цогцлон бүрдсэн эдийн засаг, улс төр, соёлын хөгжлөөс үүдэн өөрсдийн оршин амьдрах нийгмийн хөрс шороо, агаар амьсгалыг бий болгодог жамтай ажээ.

XII-XIII зууны үеийн монголчууд ч гэсэн өмнөх үеэсээ уламжилж авсан ахуй амьдралаа цогцлуулахдаа тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан олон зүйлийг шинэтгэн хөгжүүлж байжээ. Энэ үүднээс үзвэл монголын соёл-түүхийн хам нөхцөл нь нэгэнтэйгүүр хэлбэржин төлөвшсөн, нөгөөтэйгүүр хувьсал хөгжил хөдөлгөөн ихтэй байжээ. Энэ бол дотоод, гадаад хүчин зүйл бүрдсэний улмаас нийгэм эрчимтэй хөгжиж байсны гэрч даруй мөн. Тухайн үеийн монголчуудын соёл-түүхийн хам нөхцөл нь тусгаар аймаг, аймгийн холбоод болон ханлигуудынхаас бүрдэж байсан учир тэдгээрийн олон шинжийн цогцолбор нийлбэр мэт байжээ. Чухамхүү ингэж нийлбэр мэт харагдах соёл-түүхийн хам нөхцөл нь гүн дотроо олон аймаг, ханлигуудын түгээмэл зүйл, өвөрмөц тал, тэдгээрийн шүтэлцээг тод илэрхийлж байсан болно. Үүний цаад үндэслэл нь хүнээс бусад хүндээ, байгальдаа, нийгэм орчиндоо харьцах харилцааны сүлжээнд оршино.

Энэ бол цөөн жилийн хугацаанд бус олон он жилийг туулан байж хэлбэршин цогцлох үзэгдэл мөн. Тодруулбал нэгэн хүний насны энгээр хязгаарлах бус хэдэн арав, зуу, мянган хүний амьдралаар давтагдах ил, далд зүйлсийн холбоо сүлжээ юм. Тиймээс ийм сүлжээ нь хэн нэгний төрөхөөс аваад насан эцэслэх хүртэлх үйлчлэлийн хүрээнд татан оруулах соёл иргэншил, ёс заншил, шүтлэг мөргөл тэргүүтэн нийгмийн ахуй ухамсарын шүтэлцээний олон илрэл тусгалтай гүн гүнзгий холбогдсон юм. Хүн бол бусдынхаа /хүний/ сэтгэлийн гүнд хүрэх, уул усны /байгалийн/ нууцад нэвтрэх, орчин ахуйнхаа /нийгмийн/ амин судсыг мэдрэх эрмэлзлэл хүслээр дүүрэн байдаг юм. Энэ харилцаа сүлжээн дунд байгаль, нийгэм, сэтгэхүйн тухай ертөнцийг үзэх үзэл бодол бий болгон хөгжүүлсэн нь мэдээж

юм. Тийм үзэл бодлын дотор монгол хүний аливааг эрхэмлэн дээдлэх, хайрлах, шүтэн бишрэх чанар, аливаагаас сэжиглэн цэрвэх, цээрлэн гэсгээх хандлага сүлэлдэн оршин багтаж байжээ.

Энэхүү хандлага "Монголын нууц товчоо"-нд хэрхэн тусгагдсан бэ? гэдгийг авч үзэх нь соёл-түүхийнх нь хам нөхцлийг тодруулж, түүний үндсэнд хамаарах хүрээг, хүний хийгээд байгаль орчинд болон нийгмийн харьцаан дунд тогтоохыг эрмэлзэнэ гэсэн үг юм. Энэ нь сав шимийн ертөнц хүний сэтгэл санаанд хэрхэн туссан, хүний санаа бодол улс гүрний харьцаанд яаж туссан хэмээх өргөн ойлголт дунд бэлгэдэл ямраар илэрснийг "Монголын нууц товчоо"-ны жишээн дээр тодосгон өгүүлж, тайлбарлахыг эрмэлзсэн хэрэг болно.

САВ ШИМ МАНДАЛ БА БЭЛГЭДЭЛ

Сав шимийн мандал дунд хүний ертөнц оршин тогтоно. Гэхдээ сав шим мандал нь хүний орчлонг багтаах орон зай төдий бус. Харин сав шим мандалтай хүн төрөлхтөн харилцан шүтэлцээн дунд оршино. Төв Азийн өндөрлөгт аж төрж байсан монгол удам угсааны хүн зон, хад чулуу, өвс ургамал, араатан жигүүртний хүрээлэл дунд амьдарч нэгийг үгтан нөгөөг үдэн он жилийг улираасан нь мэдээж. Тэнгэр газрын хооронд, төрөх нөхчихийн тавилан дунд хүн олон, сав шим мандлын хишиг буян, гамшиг нүгэлийн аль алиныг өөрийн төсөөлөл, ойлголтоор сэрж мэдэрсээр иржээ.


Чулуун зэвсгийн үеийн хүний хандлага харьцааны ул мөрийг гүнзгий хадгалсан хад чулууг эрхэмд үзэх нь Төв Азид оршин суугчид, түүний дотор монгол угсаатны дотор олон зууныг улираасныг нэгэнтэйгүүр уул хадны сүг зураг бичээс, булш бунхны олдвор, нөгөөтэйгүүр монгол ардын үе дамжсан оюуны соёл, аман зохиолын дүр дүрслэл өгүүлэмжээс тодорхой мэдэгдэнэ.

[Монгол үндэстний дунд өргөн дэлгэрч, удаан уламжлагдсан "Гэсэр", "Жангар" зэрэг маш олон нэрт туульсын дотор жич бусад ардын аман зохиол, явган үлгэр, домог, шидэт үлгэрийн дотор үлгэрийн гол баатар нь хад чулуунаас төрөх, бие цогцос нь хад чулуу байх, сая төрсөн нялх хүүхдийн хүйсийг цахиур чулуугаар огтлох, баатар эр гартаа чулуу атгаж төрөх, баатар эр нь эсрэг дайсныг чулуу мөндөрөөр устгах, хад чулуугаар мангасыг дарж тавих... зэрэг хад чулуутай холбоотой, риди шидэт юм болгон дүрслэсэн агуулгатай байдаг бөгөөд үүний эсрэгээр дайсан этгээд нь бас чулуу болж хувирах, чулуун бороо оруулах... зэрэг дүрслэл ч мөн үгүй тохиолдоно][1].

Зөвхөн энэ ишлэлийн өгүүлэмж нь монголчуудын дотор чулууны соёл хичнээн олон талтай баян байсны гэрч, хадыг эрхэмлэх хичнээн түгээмэл байсны жишээ мөн.


Түүхийн урт удаан хугацаанд хүний сэтгэл сэтгэхүйд зай эзэлсэн хад чулууны ул мөр "Монголын нууц товчоо"-нд ч бас үлджээ.


§ 80... siqui-yin amasar-a qosili[q]-un tedüi caqan gürü amasar-a bö[k]len unaju'u... tere amasar böklen unaqsan qosiliq-un tedüi caqan gürü horcin... хэмээн хоригдож хоргодож байсан шугуйгаас гарах гэсэнд Тэмүжиний замыг хошилиг гэрийн чинээ цагаан гүр /чулуу/ бөглөж байгааг өгүүлжээ. Энэ нь "чулуу тэнгэрээс бууж ирсэн гэдэг эртний хүмүүсийн гэнэн төсөөллийн уран сайхны ойлголт болно... Чулуу тэнгэрээс гаралтай гэдэг ойлголт бол хүн төрөлхтний домгийн сэтгэлгээнд эртнээс нааш түгээмэл дэлгэрсэн нийтлэг өгүүлэмж гэж хэлж болно"[2].



§ 147... edö'e qa'an-a ükü'ülde'esü halaqan-u tedüi qajar hö'ejü qocorsu soyurqaqda'asu qa'an-u emüne ce'el usun-i hoqtoru ceügen


cilawun ceürü dobtulju öksü gür ke'eksen qajar-a kökö gürü ke'ürü qal ke'eksen-tür qara gürü qamqaru dobtulju öksü ke'eba... гэж Зэбэ амийг өршөөж хоцроож соёрхвоос хүчин зүтгэнэ гэдгийг андгайлахдаа "ceügen cilawun ceürü dobtulju", "qara gürü qamqaru dobtulju" хэмээсэн үг оруулжээ. Энэ нь "хар гүрү", "цэгээн чулуу"-г хамгаас бат бэхэд тооцсоны үндсэнд тэдгээрийг "ceürü", "qamqaru" болтол зүтгэнэ гэсний бэлгэдэл андгай юм.






§ 209... jori'ulju ile'esü gür ke'eksen-tür gürü kemkelün qal ke'eksen-tür qada qaqalun ceügen cila'un-i cewülün (?) ce'el usun-i nitulun abai-je... гэж Хубилай, Зэлмэ, Зэбэ, Сүбэдэй дөрвөн баатрын чадлыг илэрхийлэхдээ "gür kemkelün", "qada qaqalun", "ceügen cila'un-i cewülün (?)" хэмээн эрсийн хүчийг сорих хамгийн бат бэхийн нэгэнд хад чулууг бэлгэдэн тооцжээ. Үүнээс Зэбийн Чингис хаанд өгсөн андгай тангарагтаа үнэнчээр зүтгэж байгаагийн үнэлэлт давхар харагдаж байна гэж үзэж болно. "ceügen cila'un-i cewülün(?)" гэсэн хэллэг "Монголын нууц товчоо"-ны өөр хэсэгт давтан гарч байна. Үүнд:

§ 72... qongqo= tadai caraqa-ebügen otcu itqaqu-tur tödö'en-girte ügülerün ce'el usun niduralu'a ceügen cilawun cewürelu'a ke'e'et newü=je'ei caraqa-ebügen-i ker itqaqu ci ke'en qoyinaca jida-bar jo qudus qatquju'u гэсэн хэсэгт Есүгэй баатарыг хальсны дараа Тайчууд Өэлүн-үжинийг үр хүүхдүүдтэй нь хар нутагт хаяж нүүхэд



Хонхотоны Чараха-өвгөн хориглон яттасны хариуд Тодоин-гиртэ "ceügen cilawun cewülelu'a" гэж хэлж байгаа юм. Тодоин-гиртэ бол Есүгэй баатарын их л ойр дотнын хүн байсан тул Өэлүн-үжин болон түүний хүүхдүүд ялангуяа Тэмүжиний хувьд цэгээн /цахиур/ чулуу мэт бат итгэлийн бэлгэдэл байжээ. Тодруулбал, эв нэгдлийн батыг, иттэх итгэлийн цулыг цахиур чулуугаар төлөөлүүлэн бэлгэддэг байжээ. Гэтэл Тодоин-гиртэ бол тэдний итгэлийг эвдэн Тайчуудыг төдийгүй бусдыг уруу татан урваж хөрвөж нүүсэн нь чухам "ceügen cilawun cewürelü'a" гэсний баталгаа болно. Гэхдээ энэ үгийг Есүгэй баатарын оромж, түүний итгэлтэн нар хэлээгүй Тодоин-гиртэ өөрөө Чараха-өвгөнд өгүүлсэн нь урьдын бүхэн ул болж эвдэршгүй гэсэн юм эвдэрч, цууршгүй гэсэн юм цуурсныг жишээлсэн хэрэг юм. Энэ бол хоёр хүн төдий бус Тайчууд, Хиад боржигин хоёр омог төрлийн нэгдэл задарч горьдлого тасарч "ceügen cilawun cewürelu'a" хэмээсний гэрч юм. "Ceügen cilawun cewürelu'a" гэсэн хэллэг нь "ce'el usun niduralu'a" гэсэн хэллэгтэй хослосон нь нэг нь нөгөөг нөхөн сэлбэж утга тодосгож чадсаны хамт хатуу шингэн хоёрын эвцэл арга билгийн хос амьсгалыг илэрхийлсэн гэж болно.




§ 164... qa'ucitcu qaldut-ta qaru'asu qamuq ulus ken medegü... хэмээсний "qaldut-ta qaru'asu" нь "хадан гэрт гарваас /хариваас/ " гэсэнтэй утга нэгэн бөгөөд сав ертөнцөд эргэн шингэнэ гэсэн итгэлд үндэслэсэн бэлгэдлийн санаатай юм.

Тодруулбал, эрт үеэс монголчууд талийгаачийнхаа толгойд чулуу дэрлүүлэн нутаглуулж ирсэн нь түүний бие сэтгэл сүнс газар шороо, хад чулуунд шингэн мөнх

орщдог гэсэн ойлголт төсөөлөлтэй уялдаа улбаатай юм. Ингэж сав мандлыг монгол хүн яаж үзэж, түүндээ итгэл бэлгэдлээ хэрхэн шингээж ирсний жишээ нь энэ болой.

Сав мандал төдийгүй шим ертөнц ч гэсэн хүн зонтой амин хүйн холбоотой билээ. "Монголын нууц товчоо"-нд ч гэсэн шим мандлын гол хоёр тулгуур багана ургамал, амьтны төлөөлөл тодорхой байр эзлэжээ. Ургамлын дотроос модыг эрхэмлэх нь монголчуудын хувьд эрт дээр үеэс уламжлалтай юм. Монгол угсаатны модны шүтлэгт хайлаас, бургас, хус, нарс, заг, сухай, яргай, арц, зандан, галибарбаасан багтаж ирсэн ажээ. Тэрчлэн ой шугуй, бөөн мод, зуун мод, өнчин мод, онцгой мод бут, горхи булгийн эхний мод зэрэг нь шүтлэгт чухал байр суурьтай байжээ. Тиймээс эх этүгэн модны, удган модны, тэнгэрлэг модны, бөөгийн модны, дээдсийн модны, овооны модны, шанши модны шүтлэг мэтчилэн дор бүрийдээ өвөрмөц зан үйлтэй байжээ[3]. Мод ургамлын тухайд эдгээр эртний гаралтай ойлголт төсөөлөл нь үнэн хэрэгтээ газар дэлхийг амьдчилах, энэ нь аяндаа тодорхой эзэд онгодтой болгож үзэх үзэлтэй холбоотой юм[4]. Тэр ч атугай "зарим ард түмэн нас нөхчигчдийн сүнс модонд шингэж амилуулсан", "өвөг дээдэс нь онгон шүтээн модонд хувилсан гэж итгэдэг тул түүнд хүндэтгэлтэй хандаж огтлох тайрах, галдах шатаалгахгүйн төлөө бололцоотой бүхнийг хийдэг"[5]-ийг Д.Фрэзер "Алтан мөчир" хэмээх суурь судалгаандаа өгүүлжээ.




Модыг эрхэмлэх, шүтэх ёс "Монголын нууц товчоо"-нд хэдэнтээ давтагдан дүрслэгджээ.

§ 57... mongqol-un jirqalang de[b]sen qurimlan jirqaqu büle'e qutula-yi qa ergü'et qorqonaq-un saqlaqar-modun horcin qabirqa-ta ha'ul(u)qa (?) ebüdük-te ölkek

bol(u)tala debseba

§ 117... qorqonag-jubur-un quldaqar-qun-nu ebür-e saqlaqar-mudun-a anda ke'eldüjü amaralduju qurimlam toyilan jirqalduju...

§ 206... bida qor=qonaq-jubur-un qutula-qan-nu de[b]segü saqlar-modun-a bawu'asu muqali-da tenggeri-yin ja'arin ja'aqsan üge temdeg-ün tula bi tende gü'ün-qo'a-yi setkijü muqali-da üge baralu'a...



Эл гурван хэсгийн § 57-д Хотулаг хаанаар өргөмжлөхөд Хорхонаг-жибурын хөндийд "saqlaqar-modun"-аа орчин дэвсэж,

§ 206-д Хотулаг хаанаар өргөмжлөн дэвсэж байсан тэр "saqlur-modun"-аа буухад Мухали тэнгэрийн заарины /Их сууринд суух тухай/ заасан үгийг Тэмүжинд хэлсэнийг цохон дурджээ.

Эдгээрээс үзвэл, Хотулаг хаанаар өргөмжлөсөн тэр дурсгалт газар нутаг, тэнд онцгойлон ургасан саглагар мод Тэмүжиний үед ч үргэлжлэн шүтэгдэж байжээ. § 117-д Тэмүжин, Жамуха хоёр анд бололцож "saqlaqar-modun-a" бас л хуримлаж байв. Энэ нь дурсгалт газар гэдэгтээ гол бус тэр л нутагт тахиж шүтэгдсэн саглагар мод байсанд л утга учир нь оршино. Саглагар мод, дэвсэх саглагар мод байж гэмээнэ тэр газар нутаг тахилгын орон болно. Саглагар мод гэдэг нь ургамлын төрөл айн нэр бус мөчир салаа, навчис нахиа ихтэй саглайж ургасан дүр дүрснээс үүдэлтэй нэр гэлцдэг нь үнэнтэй болой.

Тэгэхлээр саглагар мод чухам юуны учир утга бэлгэдэл агуулсан байж вэ? Үүнд:

Х.Буянбат "Эртний монголчуудын эх этүгэний шүтлэг буюу эх дэлхийн шүтлэг нь сагсгар модны шүтлэг дээр төвлөрөн илэрч байжээ. Анх эхлэхдээ саглагар модны шүтлэгийг удган эрхлэн гүйцэтгэж байв. Тэгэхлээр нилээд тооны саглагар мод нь

бас л удган мод хэмээх нэртэй болсон байна"[6] гэж үзсэнийг Х.Сампилдэндэв улам тодосгон жишээгээр баталж "Монголын нууц товчоонд гардаг саглагар мод нь хамаг монголчуудын эртний уламжлалт шүтлэгийн удган мод бөгөөд уд бургас байжээ"[7] гэсэн дүгнэлт хийсэн байна.

Саглагар мод нэгэнт шүтлэгийн мод болох учраас түүний тойронд "хаан өргөмжлөх", "дугуйлж хурах", "андалдах", "хүүр оршуулах", "туг сүлд догшуулах"[8] зэрэг ёс үйл гүйцэтгэдэг байсан төдийгүй "qabirqa-ta ha'u[u]qa(?) ebüdük-te ölkek bol[u]tala дэвсэх /бүжих/ удаа ч байв.


"Orqon müren-e dügüreng yisü sacunam
Quva dobun-a dügüreng yisü sacunam
Deligün bolduγ da dügüreng yisü sacunam
Debsekü saγlaγar modun-a dügüreng yisü sacunam[9]

хэмээн "Гүүний сүүний сацалын судар оршибай"-д "дэвсэх саглагар мод" уламжлан үлдсэн нь эртний зан үйлийн ул мөрийг хадгалсны жишээ юм.


Саглагар модыг түшиж, ойр орчинд нь болж байсан Хамаг монгол, Тайчууд, Жадрангийн дээр дурдсан элдэв зан үйл нь уггаа онохуй оногдохуй хоёрын шүтэлцээг харуулах бэлгэдлийн утга санааг давхар хадгалсны баталгаа болой.

Шим мандлын ургамал модод төдийгүй амьтад "Монголын нууц товчоо"-нд тодорхой байр эзлэн тусгагдсан юм. Амьтны олон шинж хүнд байдаг. Хүний олон шинж амьтанд бас бий. Хүн хийгээд амьтны төсөөт шинжийг олон талаас нь тусгасан зохиол бол "Монголын нууц товчоо" мөн. Уг зохиолд амьтан олонтаа гарах боловч тэдгээрийг хэрхэн үзэж чухам юуны бэлгэдэл болгон дүрсэлж байж вэ? гэдгийг тодруулахын үүднээс нохой, хар хэрээ, могой гурваар жишээ болгон авч үзье.

§ 195... tayang-qan jamuqa-daca asaqcu'u tede ya'ut olon qonit cino hüldejü qoton-tur gürtele hüldejü iregü metü ede ya'ut haran teyin hüldejü ayisai ke'en asaqba jamuqa ügülerün temüjin anda minu dörben noqa(i)s-i gü'ün-nü miqa-'ar teji'ejü ginjilejü huyaju aqu büle'e tede qara'ul-i bidan-u




hüldejü ayisuqun tede bui-je tede dörben noqa(i)s siremün manglaitan si'üci qosi'utan sibüge keleten temür öreten üldü mina'atan si'üder-i idejü kei unuju yabut tede alalduqui udur haran-u miqa idet tede gürülcegü üdür gü'ün-ü miqa günesület tede ginji-ben mültüldejü edö'e ese-'ü buqsaju aqsat bayiscu teyin silemeljen ayisai tede ke'ejü'üi tede dörben noqa(i)s ket tede ke'esü jebe qubilai qoyar jelme sübe'etei qoyar tede dörben bui ke'ejü'üi...


元朝秘史卷九

§ 209. basa cinggis-qahan qubilai-a ügülerün gücütü-yin güjü'ün bökö-yin bökse daruju ökba-je ci ede qubilai jelme jebe sübegetei ta dörben noqas-iyan se[t]kiksen-tür ... qubilai jelme jebe sübe'etei ta dörben noysa-iyan joriqsan qajar-a ilejü bo'orcu muqali boroqul cila'un-ba'atur ede dörben külü'üd-iyen derge-de'en a'asu qatquldu'an üdür bolu'asu jur=cedei quyildar qoyar-i uru'ut mangqud-iyar-an urida'an bayi='ulu'asu bügüde setkil-iyen amuqu büle'e bi ke'eba

§ 195 хэсэгт Зэбэ, Хубилай, Зэлмэ, Сүбэдэй дөрвийг "noqar(i)s" хэмээн Жамуха бардам түрэмгий талаас нь өгүүлсэн бол тэднийг Чингис хаан § 209 хэсэгт үнэнч итгэлтэй талаас нь хэлжээ.

Мөн § 78 хэсэгт "qarbisu-ban qajaqu qasar noqai metü" гэж Тэмүжин, Хасар хоёрыг Бэгтэрийг харвасны учир Өэлүн эх зэмлэж байхад § 188 хэсэгт цөлд Сэнгүмийг орхиж унааг нь хөтлөн Хөхөчү агтачийг гэдрэг хатирахад эм нь зэмлэнгүй үг хэлж, хоцрохыг завдахад тэр "senggüm-i erelesü ke'en buyu-je ci" гэжээ. Хөхөчүгийн энэ үгний хариуд эм нь "eme gü'ün noqai ni'urtai ke'ekdeji-je bi"




хэмээжээ. Энэхүү "eme gü'ün noqai ni'urtai" гэсэн хэллэгийг А.Мостэрт "завхай самуун"[10] гэсэн утгаар тайлсныг Ш.Гаадамба[11] дэмжиж дэлгэрүүлэн тайлбарлажээ. Эдгээртэй санал нийлэхгүй байгаагаа Хүрэлбаатар жишээ баримтаар баталж "Нохой нүүртэй" хэмээх өвөрмөц хэлц нь нохой мэт өөрийн эзэндээ үнэнч шударга явахыг хичээдэг бат журамт хүмүүнийг заахад хэргэлдэгээс биш, түүнд нүүр авах үгүй, эсхүл садар самуун гэсэн утга санаа байх үгүй"[12] гэж дүгнэжээ.

Эдгээр жишээ бол нохойн хүчтэй омогтой агаад буслад ч халтай, эзэндээ ээлтэй, итгэлтэй, үнэнч зэрэг олон талын шинжийг хүнд шилжүүлэн зүйрлэх байдлаар гаргажээ.

"Монголын нууц товчоо"-нд дурслэгдэж байгаа бас нэгэн жигүүртэн бол хар хэрээ билээ. Тэмүжин, Ван хан, Жамуха нар нэгдсэн их хүчээр Гурван мэргэдийг довтлож сүйтгэхэд Чилгэр бөкө дутааж гараад гэмшихдээ өөрийгөө хар хэрээгээр зүйрлэн буруутгадаг ажээ. Учир нь Их Чилэдүгийн гэргий Өэлүнг Есүгэй баатарт булаагдсаны өшөөг авч Гурван мэргэд довтлон ирж Тэмүжиний эхнэр Бөртэ-үжинг барин авч Чилгэр бөкөгийн гэрт байлгаж байсан юм.

§ 111... qara kere'e qalisu körisü idegü jaya'atu bö'etele qalawun toqura'un-i idesü ke'en jesin aju'u qatar mawui cilger bi qatun üjin-tür qalqu bolun qamuq merkit-te huntawu qaracu mawu cilger qara teri'ün-dür-iyen gürtegü bolba qaqcaqan amin-iyan qoroqun qarangqu qabcal sirqusu qalqa ken-e boldaqu-yu bi...



Энэ хэсэгт өөрийн хирээс давсан их хэрэгт санаархаж, Өэлүн хатанд халдсаны уршгаар хамаг мэргэддээ гай уршиг тарьж өөрөө ч хар толгойгоо алдах болсноо Чилгэр бөкө гэмшихдээ "qara kere'e qalusu körisü idegü

jaya'atu bö'etele qalawun toqura'un-i idesü ke'en jesin aju'u" гэж зүйрлэсэн нь ил байна. Үүнтэй утга нэгэн дүрслэл Жамуха таван нөхөртэй оорцог болж Танлу-д яваад тэдэнд баригдан Чингис хаанд хүргэгдэхдээ хэлсэн үгэнд байгаа болно.



§ 200... qara keri'e qarambai noqosu bariqu bolba qaracu bo'ol qantur-iyan qar gürgegü bolba qahan anda minu ya'u endegü... Энэ хэсэгт хар хэрээг доордод, харамбай нугасыг дээрдэд үзэж, хаан боолын харьцааг илэрхийлсэн ажээ. Гэхдээ харамбай нугаст хар хэрээ халдан барих болсныг буруушааж Жамухагийн өгүүлсэн нь Чингисийн үзэлд нийцсэн тул "qandur-iyan qar gürgekset haran-i urug-a anu gürtele mökörі'ülütkün гэж зарлиг буулгаж ёсоор болгожээ.




§ 124... sübe'etei-ba'adur ügülerün quluqana bolju quriya[1]dusu qara keri'e bolju qada'un bügün-i qarmaldusu nembe'e isgei bolju nemürleldün sorisu gerisge isgei bolju ger jük gerisgeleldün sorisu ke'eba Энэ хэсэгт Чингис, хаан ор суугаад тушаал хуваахад Сүбэдэй саналаа хэлэхдээ "qara keri'e bolju qada'un bügün-i qarmaldusu" гэсэн зүйрлэл оруулжээ. Хар хэрээ болж хамаг бүхнийг хармалдусу гэж Сүбэдэй хэлэхдээ түүнийг /хар хэрээг/ муулах хандлагаар бус ар гэрийн үйлсэд хурааж базаасныг хадгалж харамнахтай холбож өгүүлсэн ажээ.

Энэ гурван жишээнээс үзэхэд хар хэрээг саар сайн аль аль шинжээр нь холбогдох дүрслэлийн хүрээнд татан оруулсан

нь ил байна.

"Монголын нууц товчоо"-нд дүрслэгдсэн бас нэгэн амьтан нь могой юм.



§ 164...basa cinggis-qahan ong-qan qoyar ügüleldürün bida qoyar-i nayidaju südütü moqai-a södürte'esü södürgen-tür bu oroya südü-'er ama-'ar ügüleldüjü büsireya ara'atu moqai-a adarda'asu adarqan-i inu bu abulcaya ama-'ar kele-'er olulcaju bcsireye ke'en teyin ü=ge baralduju amara'alin alduba

Энэ хэсэг бол Чингис хаан, Ван хан нар "эцэг хөвүүн" бололцохдоо хэлэлцсэн андгайн шинжтэй юм.

Хоёрын /хүний/ хооронд яс хаягчийг могойн шүд араагаар хатгах шүтгэхтэй зүйрлэсэн нь § 177 хэсэгт давтагджээ. Могойг үзэх үзэл, түүнтэй холбогдсон ёс заншил монгол угсаатны дотор арвин бий боловч түүний дотроос эв эеийг хатгаж шүтгэн салгах нэгэн гол шинжийг нь "Монголын нууц товчоо"-нд ингэж товойлгон дүрсэлжээ.


Энэ бүх дурдсан жишээ бол амьтны /араатны/ ямар шинжийг сайны болон муугийн илэрхийлэл болгодог байсан тухайн үеийн монголчуудын үзэл бодлын илэрхийлэл мөн.

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

1. D.Caγan. Cilaγun soyul. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. 1993. 196-197. duγar tal-a
2. Аман зохиол судлал. (Studia Folclorica...) Том XYII, Fasc 1, ШУАХ. УБ., 1987, 7-р тал
3. Kh.Buyanbatu. Mongγolcud-un modun-u sitülge. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1990. 60-88 duγar tal-a
4. БНМАУ-ын угсаатны зүй, I боть. Халхын угсаатны зүй (XIX-XX зууны заг үе). Ред. С.Бадамхатан. УБ. 1987, 383-р тал
5. Джеймс Джордж Фрэзер. Золотая ветвь. Исследование магии и религии. М., Изд. Политической литературы. 1980, стр 135
6. Kh.Buyanbatu. Mongγolcud-un modun-u sitülge. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1990. 44 düger tal-a
7. Х.Сампилдэндэв. "Монголын нууц товчоонд" гардаг саглагар модны учир. "Монголын нууц товчоо"-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал. I. УБ, 1995, 201-р тал
8. Khurcabaγatur, üjüm-e. Mongγol-un böge mörgül-ün tayilγ-a takilγ-a- yin soyul. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a, 1991. 293-304 düger tal-a
9. Ce.Damdinsürüng. Mongγol uran jokiyal-un degeji jaγun bilig orusibai. MCMLIX, 48 duγar tal-a
10. A.Mostaert. Sur quelques passages de L' Histoire secrete des Mongols HYI Cambridge. 1953, pp. 107-108, 357-358
11. Ш.Гаадамба. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. УХГ. 1990, 35-37-р тал
12. Khürelbaγatur. Em-e kümün "noqai niγurtai" kemekdekü-yin ucir. öbür mongγol-un neyigem-ün sinjilekü uqaγan. 1994. No 70, 50-54 düger tal-a

ХҮНИЙ АМЬДРАЛЫН ГОЛ МӨЧЛӨГ БА БЭЛГЭДЭЛ

Хүний амьдрал гэгч эхийн хэвлийд үр тогтох тэр л үеэс эхлэнэ. Гэсэн ч төрөх, нөгчихийн хоорондын зайд хүн зоны амьдрал үргэлжлэх нь бий билээ. "Монголын нууц товчоо"-нд нэгэн хүний төдийгүй хэд хэдэн үе удмын амьдрал, түүний гол мөчлөг тусгагдсан юм. Үүгээрээ "Монголын нууц товчоо" бол хүн зоны амьдрал, тэмцлийн буурал шашдар мөн.



§ 21. sönit büri ceügen sira gü'ün ger-ün erüge dotoqa-yin gege-'er oroju ke'eli minu bilijü gege'en inu ke'eli-tür minu singgegü büle'e qarurun naran sara-yin kili-yer sira noqai metü sicabaljaju qarqu büle'e deleme yekin ügület ta tewüber uqa'asu temdek inu tenggiri-yin kö'üt buyu-je qara teri'ütü gü'ün-tür qanilqan yekin ügület ta qamuq-un qat bolu'asu qaracus tende uqat-je ke'eba

Энэ хэсэг бол, Добу мэргэний үгүй болсны хойно хоёр том хүү нь Алангоо сүүлд гурван хөвгүүн төрүүлсэнд нь сэрдэж "түүний /Маалиг баяудай хүний хүүхэд Ц.Д/ буй за" гэж эчнээ хэлэлцэхийг мэдээд эхийн хэлсэн хариу билээ. Рашид-ад-дины "Судрын чуулган"-д бас байх гэгээ хээлэнд шингэхийн улмаас Алангоо эх жирэмсэлсэн, гурван хүү төрүүлсэн гэх энэ өгүүлэмжид эрдэмтэд өөрийн үзэл бодлын үүднээс хандаж тайлбарласны дотроос гурван саналыг авч үзье.

Г.Сүхбаатар "Монголын нууц товчоо"-ны дурдсан хэсгийг Рашид-ад-дины Алангоогийн домогтой харьцуулан үзэж, хожуу үеийн монголын түүхийн сурвалж бичгүүдэд дурдсанаар баримт болгож "Тэндээс тэнгэрийн эрхт хурмастаар эх Махамая охин тэнгэрийн биед сүр өнгийг үүсгээд умайг ариун болгов... Нэвтлэгч зургаан соёо төгөлдөр зааны дүрсээр хувилж, эхийн умайд оров.

Тэр цагт их газар хөдлөөд ертөнцийн оронд бүгд гэрлийн үзэгдлээр түгээмэл болов. Эхийн зүүднээ дээр зааснаар эх өөрийн баруун зүгийн өврийг эвдэж орсон... Тэндээс Бодисадаа эхдээ хорлолгүйя хувилан төрөв. Эхийн баруун сүвээг цоолж өөд болсон..." гэх зэрэг бурхан багшийн монгол намтарт өгүүлсэн зэрэгтэй холбож "...Бөөгийн мөргөлийн үүднээс тайлбарлагдахгүй байна. Бөөгийн мөргөлд төрийн эзэн хаан хүн төрөх тухай сургаал байхгүй байна. Гэтэл бурхан шашинд гэхэд хоёр мянган жилийн өмнө боловсруулсан төрөлтийн тухай сургаал буй. Бурхан шашны сургаал ёсоор умайнаас төрөх, өндөгнөөс төрөх, чийг дулаанаас төрөх, хувилж төрөх дөрвөн янзын төрөлт байдгаас /.../ хувилж төрөх гэдэгт Алунгоогийн төрөлт холбогдож байна. Алунгоогийн энэ домог уггаа Бурхан багшийн мэндэлсэн тухай домгийн нэг монгол хувилбар мөн байна"[1] гэсэн дүгнэлт хийжээ. Тэгвэл С.Дулам "Бөө онгодоо дуудаж тамлах үес тэд тэнгэр, асарын орноосоо гэрэл туяаны хувилал болон ялгарч гэрийн өрхөөр орж хэнгэргийн задгай талаар тосон авангуут бөөгийн сугаар нэвтрэн зүрхэнд нь шунгадаг гэсэн үг. Чухам ийм үед бөө удгадын биед шингэж орох хий биет онгодын нийтлэг дүр дүрсийг гэрэл, туяагаар бэлгэддэг хэмээн хэлж болох буй заа... Энэ нь нэн түрүүнд "цэгээн шар хүн" буюу хүншүүлсэн гэрэл туяа" өрх тотгын гэгээр" юмуу өрх тотгын зай чөлөөгөөр нэвтрэн орж ирдэг гэсэн нь бөөгийн онгод хэмээн оюун санааны үүтгэл "сарны гэрэл мэт тунгарч" туяа шиг юм дайрч гэрийн өрхөөр бууж ирдэг гэдэгтэй их л ижил дөт үзэл ойлголт болно. Чингэхдээ Алангоо эхийн хэвлийг илбэж гэгээ нь хэвэлд нь шингэх, бөөгийн онгод хэнгэрэг, сугаар дамжин зүрхэнд нь шингэх хоёр мөн л хүний эмзэг чухаг эрхтнийг эзэмдэж буйгаараа төстэй зүйл юм. Харин Алангоо эхийн домогт "гарахдаа наран сарны хилээр" гардаг нь эл "цэгээн шар хүн" бол наран сарны гэрэл туяаны хувилал мөн гэдгийг ёгтлон хэлсэн бололтой. Энэ нь бөөгийн дуудлагад өгүүлсэн "сарны гэрэл мэт тунгарч буухтай" бас л авцалдаж байна гэж санамаар билээ..."[2] гэжээ.

Энэ хоёр саналаас үзэхэд

1. Гэрэл гэгээ хүний биед шингэж хувилах өгүүлэмж нь нэгэн орны хүрээнд ч, түүнээс хальж дорно дахины улс гүрний хэмжээнд ч дэлгэрсэн гэдэг нь

2. Чухам гарвалыг хааш нь холбох вэ гэхээс бус уггаа хүний сэтгэх, мэдрэхүйн тайлахуйяа бэрх нарийн сүлжээг агуулсан гэдэг нь


3. Олсон жишээ баримтдаа тулгуурлан нэг нь /Г.Сүхбаатар/ Энэтхэг, Төвд зэрэг дорно дахины нөлөөлөлтэй, нөгөө нь /С.Дулам/ уугуул хэв шинж болсон бөөгийн шүтлэгтэй холбож тайлсан гэдэг нь тодорхой байна. С.Дулам Алангоогийн домгийг бөөгийн шүтлэгтэй холбож тайлахдаа [хамгийн эцэст "шар нохой мэт шалбалзаж гарах бүлгээ" гэсэн нь тэрхүү "цэгээн шар хүн" өөр хэн ч бус монголчуудын эртний сүлд онгон болсон Бөртэ чоно бололтой байдаг. Учир нь: "Шар нохой" хэмээх нь эртний сүлд онгон болсон Бөртэ чонын эерүүлэн хүндэлсэн нэр болно. Монголчууд чонын нэрийг "хангайн нохой", "хээрийн нохой" гэхчлэн эерүүлэн дуудахаас гадна "Агарын хайрханы дуудлагад" Таннын таван шар нохой тухиралга минь /.../ хэмээн чоныг хэлж байдаг...] гэж дурджээ.

Ингэж уг домгийн гол дүрслэлийн нэг "шар нохой мэт" хэмээх хэллэгийг монголчуудын эртний сүлд онгон болсон Бөртө чонотой уялдуулсан нь "Алангуа эхийн домогт өгүүлж буй үүр шөнийн хагацлаар шар нохой мэт шарвалзан гарах тэнгэрийн цэгээн шар хүн бол тухайн үеийн домог үлгэрийн ойлголттой холбоотой уран сайхны дүрслэл болно[3]" гэсэн Д.Цэрэнсодномын саналтай нийлж байна. Харин Д.Цэрэнсодном "шар нохой мэт" гэдгийг нохой гэдэг ойлголтоор ухаарсан бол С.Дулам чонын /Бөртө чино/ эерүүлэн хүндэлсэн нэр гэдгээр тайлсан байна.

Чухам энэ гурван эрдэмтний саналаас харахад уран сайхны сэтгэлгээний гаднын нөлөөтэй холбохоос илүүтэй монгол сурвалжтай уялдуулан судалгааг гүнзгийрүүлж шинийг хайхад аман зохиол дахь "хувилж төрөх" олон арван жишээнд анхаарахад


илүү ач холбогдол өгмөөр байгаа юм. Чухам ингэж үзэх аваас эрдэмтэдийн саналын цогцод нэгэн санаа сэдлэг өгч шинэ тайлбар нэмэгдэж болно.

Урьд өмнөх судалгаанд олонтаа өртөөгүй "сайн хүн төрөх" өгүүлэмж нь "Чингис хааны Алтан товч нэрт цадаг оршибай"-д "Эрт нэгэн цаг дор Есүгэй эзэн ав авлаж явтал наана нь олон эм халхалж цаана нь ганц эм морь үзэж байхыг үзээд тэр эмс дор адас нь байнам гэж Ахун нэрт түшмэлээ илгээв. Тэр түшмэл эчиж /очиж/ үзээд нэгэн ариухан сайн эм морь үзсэн ажгуу. Алдарт сайн хөвүүн төрөх ажгуу. Алтан харгана авт морь үзэж байна гэж хэлэв"[4] гэснээр тодорч байгаа юм. Тэр эм нь Өэлүн хатан болно. Мэргэн түшмэлийн хэлсэн ёсоор нь болжээ.



§ 59. tende yisügei-ba'atur tatar-un temüjin-üge qori-buqa teri'üten ta-tar-i dawuliju ire'asu tende hö'elün-üjin ke'elitei bürün onan-nu deli'ün-boldaq-a büküi-tür jöb tende cinggis-qahan törejü'üi törekü-tür bara'un qar-tur-iyan si'a-yin tedüi nödün qatqun törejü'üi tatar-un temüjin-üge-yi a[b] ciraqsan-tur töreba ke'en temüjin nere ökküi teyimü

Энэ хэсэгт Тэмүжин "bara'un qar-tur-iyan si'a-yin tedüi nödün qatqun" төрснийг өгүүлжээ. Үүнийг Лувсанданзаны "Алтан товч"-д бас өгүүлсний зэрэгцээ Тэмүжинийг төрөөд долоо хоносны хойно "qarabtur sibaγun kürü qara cilaγun degere naran jöbsiyerekui-e ergiju γurban edür dongγodbai" гэх буюу "tere qarabtur sibaγun eriken degere inu saγuγad cinggis cinggis gejü dongγodbai"[5] гэхчлэн бэлгэдэл болгосон үйл явдал дэлгэр дүрслэгджээ. Үүний дотроос "bara'un qar-tur-iyan




si'a-yin tedüi nödün qatqun" төрсөнтэй нь холбож Өэлүн эх Тэмүжиний Бэгтэрийг хөнөөсний учир зэмлэж байгааг эрэгцүүлбэл зохино.

§78. ger-tür irejü oroqui-lu'a üjin eke qoyar kö'üked-ü'en cirai uqaju ügülerün baraqsat qala'un-aca minu qalat qarurun qar-dur-iyan qara nödün qatqun töreligi Энэ хэсэгт Өэлүн эхийн зэмлэсэн үг, Тэмүжиний "nödün" атгаж төрсөн нь цаанаа утга бэлгэ агуулсан гэсэн санааг давхар тодотгож байгаа юм.

Ингэж нялхас төрөх мэндлэхтэй холбогдол бүхий дээр дурдсан жишээнүүдэд үнэний үр байгаа нь мэдээж боловч дүр дүрсэлгээний хувьд үлгэр домгийн шинж давамгайлах аяс ажиглагдаж байна.

Хүний амьдралын дэвжин дэлгэрэхийн үндэс салаа нь худ ургийн ёсон мөн.

Эр эмээс өрх өсч, өрх гэрээс үндэс иш, ураг удам салаалж, удам ишээс улс айл бүрддэг нь жам билээ. Улс айл хаяа залгасан бүхэнтэйгээ эв эетэй оршиж, охид хөвгүүдээ гэрлүүлэн хурим найр үүсгэн байсан нь монгол угсаатны нэгэн ёсны "жаргалан" байжээ. Үүний тод жишээ нь Дэй сэцэний өгүүлсэн Хонгирад иргэний




§ 64. ba onggirat irgen erte üdür-ece je'e-yin jisün ökin-ü önggeten ulus ülü temecet qacar qo'a ökid-i qahan boluqsan-a tanu qasaq tergen-tür unu'ulju qara bu'ura kölgejü qatara'ulju otcu qatun sa'urin-

tur qamtu sa'ulumu ba ulus irgen ülü teme=cet ba öngge sayit ökid-iyen ösgejü öljigetei tergen-tür unu'ulju öle bu'ura kölgejü e'üsgejü otcu ündür sa'urin-tur öre'ele etet sa'ulqui ba erten-ece onggirat irgen qatun qalqatan ökit öcilten je'e-yin jisün ökin-ü öngge-ber büle'e ba гэсэн яруу үг бүхий дуулал юм.


"Монголын нууц товчоо"-нд худ ургийн ёсны талаар цухас дурдсан нь олон бийн дотроос доорхи хэдэн хэсэгт тогтож өгүүлж болмоор байна. § 61, 62, 63, 65, 66 хэсэгт дурдсанаас үзэхэд


1. Эхийн "törgut", хүүгийн "naqacu" талаас, тэгэхдээ хүүг "yisün" насанд хүрэхлээр охин гуйж сүй тавьдаг ёс заншил байжээ. Энэ нь "цусан" үл ойртохоос сэрэмжилсэн хатуу ёс уламжилсны жишээ юм.

2. "nu'un kö'üt manu nuntuq qarayu ökin kö'ün manu öngge üjekdeyü"... /§65/ "ökin gü'ün-nü jaya'an töreksen e'üten-tür ötölgü ügei" /§66/ гэсэн Дэй сэцэний өгүүлэмж бол охинтой эцэг хүний үг мөн. Эндээс худ худгайн талын баримтлах чиг хандлага тодорч байна. Үүний дээр Дэй сэцэний "olon-ta-wu quyu'ulju ökbesü de'ejilekdegü cö'en-te-wü quyu'ulju ökbesü doromji=laqdaqu /§66/ гэсэн үгийг нэмбэл олонтаа гуйлгаж байж охиноо өгвөл дээжлэгдэх /эрхэмлэгдэх/ цөөнтээ гуйлгаж байж өгвөл доромжлогдож үнэ хүнд алдах заншил байсныг тодруулж байна.



3. "ene kö'ün cinu nidün-tür-iyen qultu ni'ur-tur-iyan geretü kö'ün bui" /§ 62/ гэж Дэй сэцэн Тэмүжин хүүг хэлж байгаа, "ni'ur-tur-iyan geretei nidün-tür-iyen qaltai ökin-i"/§66/ гэж Есүгэй Бөртэ охиныг хэлж байгаа нь харилцан





сонжиж оюун сэтгэл нийлсний жишээ юм. Энэ бол бэр сонжих, хүү сонжих ёс байсны үл мөр болно.


4. Тэмүжин хүүг Дэй сэцэнийд Бөртэ охинтой танилцуулж дасгах зорилгоор орхисон нь хүргэн болох хүүг худгайн хүсэлтээр гэрт орхих ёс байсны илрэл юм.

5. Охин /бэр/ гуйхад эцэг явж, охиноо эх нь хүргэж өгөх ёс байсныг Тэмүжиний эцэг Есүгэй, Бөртэ охины эх Цотан /§94/ нарын үйл явдлаас мэдэж болохоор байна.

6. Есүгэй баатар, Дэй сэцэнд "kötöl morin-iyan" /§66/ өгч, Цотан эх "qara buluqan daqa" авчирсан нь бэлэг сэлт өгөлцөж байсны баримт юм. Есүгэй баатар хөтөл морио Дэй сэцэнд өгсөн нь халуун хошуут мал гэсний бэлгэдэл, Цотан эхийн авчирсан хар булган дах ч гэсэн үнэ цэнтэй зүйлийн бэлгэдэл гэсэн давхар агуулгыг хадгалсан болно.


Чухам ийм шатлал бүхий худ ургийн ёс, түүний үйлдэл бүхэн бэлгэдлийн ямар нэгэн утгыг хадгалжээ. Монгол худ ургийн ёс, хурим найр бол тэр аяараа бэлгэдлийн цогцолол мөн.

§116. temüjin jamuqa qoyar qorqonaq-jubur-a neyilen bawuju erten-ü anda bolulcaqsan-iyan duradulcan anda tungqulduju amaralduya ke'eldüba angqa urida anda bolu=lcarun temüjin harban



niken nasutu bükü-tür jamuqa quraltuq si'a temüjin-ne ökcü temüjin-ü cinggültüktü si'a anda bolulcaju anda ke'eldüksen onan-nu mölsün-tür si'aljaqui-tur tende anda ke'eldüle'ei te'ün-ü qoyina qabur alanggir numutan qarbiyaldun bükü-tür jamuqa bura'u-yin qoyar eber ni'aju nükelejü dawutu yor-iyan temüjin-e ö[k]cü temujin-ü arca manglaitu qodoli araljiju andacilalduba nököte anda ke'eldü[k]sen yosun teyimü

§ 117. uridus ötögüs-ün üge sonoscu anda gü'ün amin niken ülü tebcildün amin-u arici boluyu ke'en amaralduqui yosun teyimü edö'e basa anda tungqulduju amaraya ke'eldüjü temüjin merkid-ün toqto'a-yi arbilaju abuqsan altan büse jamuqa anda-da büsele'ülba toqto'a-yin



esgel qali'un-i jamuqa anda-da unu'ulba jamuqa uwas-merkid-ün dayir-usun-i arbilaju abuqsan altan büse temüjin anda-da büsele'ülba dayir-usun-u-gü ebertü ünügün caqa'an-i temüjin-e unu'ulba qorqonaq-jubur-un quldaqar-qun-nu ebür-e saqlaqar-mudun-a anda ke'eldüjü amaralduju qurimlan toyilan jirqalduju söni könjile-de'en qaqca qonolduqun büle'e

Энэхүү § 116, 117-р хэсэгт Тэмүжин, Жамуха нарын "amaralduju", "anda cilalduba nököte anda ke'eldü[k]sen" байсныг өгүүлэхдээ тэдний нас биеийн харьцаа, оюуны өсөлтийг солилцсон /бэлэглэсэн/ эд өлгийн зүйлээр тодруулжээ. Үүнд:

і. Жамуха "quraltuq si'a"-г Тэмүжинд, Тэмүжин "cinggültüktü si'a"-г Жамухад өгсөн нь арав гаруй настай байсан болохоор тэд тухайн үеийн хамгийн эрхэм зүйлээ солилцсон нь илэрхий байна. Шаа /шагай/ бол монгол хүүхдэд хар багаас хамгийн дуртай наадгай тоглоом нь, түүгээр дамжин уламжлалт ёс заншил, ахуйтайгаа танилцах гүн утга хадгалсан юм. "Монголчууд найр, наадам, айлчин гийчиндээ зориулсан зоог, тахилгын идээ, хурим, оршуулах зан үйлд шагай чөмөг байрлуулсан дэг ёс билэгдэл /бэлгэдэл/ цөм хүнд хандаж, амьдралын дундаршгүй ундрага болсон аж ахуйн гол үндэс болсон таван хошуу малыг төлөөлөх үндсэн гол билэгдэл /бэлгэдэл/ болж байх бөлгөө."

Энд өгүүлсэн "малыг төлөөлөх үндсэн гол билгэдэл /бэлгэдэл/" гэгдсэний нэгэн шинж тэмдэг нь шаан дөрвөн талыг хонь, ямаа, адуу, үхэр /зарим нутагт тэмээ/ хэмээн нэрлэж, тэдгээрийг байрлалаар нь бэлгэдэн төлөөлүүлдэг ёс юм. Тиймээс шаа солилцоно гэдэг аль талаар байрлуулснаар үхэр ч юм уу хонь ч юмуу аль нэгэн мал өгч авалцаж байна гэсэн бэлгэдлийн утгатай юм. Тэмүжин, Жамуха нарын солилцсон шаа үүнтэй холбоотой байж болно. Ингэж үзэх аваас Тэмүжин, Жамуха нар эр хүний хамгийн эрхэмлэх унаа "морь" солилцсон байж таарна. Монгол хүүхэд малын болон ан гөрөөсний шааг цуглуулахдаа сонголт хийдэг, засч янзалдаг билээ. Үүнээс үүдэн "зассан шагай" гэсэн тогтмол хэллэг бий болж "зассан шагай шиг" гэсэн адилтгал ч өргөн хэрэглэгдсээр иржээ. Мал малын шаа дотроо, тэр ч атугай нэгэн төрлийн малын шаа дотроо том жижиг, хэв янз өөр өөр байх нь бий. Малынхаас ан гөрөөсний шаа хэлбэр галбирын хувьд жижгэвтэр, урлаггай учир монгол хүүхэд түүнийг эрхэмд тооцдог билээ. Тиймээс сонгосон "quraltuq si'a" хэмээх гурын шааг Жамуха Тэмүжинд, Тэмүжин ч "cinggültüktü si'a" хэмээх зассан шааг, тэр дундаа мөнөө тоглодог зориулалт бүхий шааг[6] Жамухад өгчээ гэж үзэж болно. Тэд "si'a" солилцоод зогсохгүй, Ононы мөсөн дээр шаалцан /шагалцан/

наадсан нь "amaralduju" байгаагаа давхар илэрхийлжээ.

Анд бололцоход шаа солилцдогийн гол утга нь хоёр мөчийг /чөмгийг/ бат холбогчийн үүргээр нь бэлгэдэл болгосон гэж үзвэл зохилтой.

Тэмүжин, Жамуха нар нэгэн биеийн хоёр мөч /чөмөг/ гэвэл "шаа"-гаар бат холбогдов гэсэн утга бэлгэдэл тодорч байгаа болно.


2. Жамуха "bura'u-yin qoyar eber ni'aju nükelejü dawutu yor-iyan" Тэмүжинд, Тэмүжин "arca manglaitu qodoli" Жамухад өгчээ. Үүнээс Тэмүжин, Жамуха нарын нэг насаар ч атугай эр бие өсч байгааг тэдний солилцсон "dawutu yor" "qodoli" хоёр харуулж байна. Монгол хүүхэд мэдээ орсон цагаасаа алив нэгнээр харвах онох тоглоом наадгайд хүчээ сорьж улмаар жинхэнэ нум сум эзэмших дадлага туршлага суудаг ажээ. Ер нь тухайн үеийн монгол хүн бүр, ялангуяа эр хүн нум сум харваж заавал сурах ёс байсан гэж үзэж болно. Монголчууд эрт үеэс нум сум үйлдэн ан гөрөө агнах, элдэв дайснаас хамгаалах, бас ч бусад руу довтлох зэрэгтээ нум сум харвах нь хамгаалалт, довтлолтын зэвсэг төдийгүй хүч чадлыг сорих талбар учир "Эрийн гурван наадам"-ын нэгэн бас мөн. "Dawutu yor" /харвахад дуу гардаг сум/, "arca manglaitu qodoli" /манлайг нь арч модоор үйлдсэн сум/ харилцан солилцсон нь эр хүний зэр зэвсгээрээ бэлгэдэл болгосны жишээ юм.

3. Тэмүжин Мэргэдийн Тогтоагаас авсан алтан бүсийг Жамухад бүслүүлж, эсгэл халиуныг нь унуулж, Жамуха Увас мэргэдийн Дайр-үсүнээс олзолсон алтан бүсийг Тэмүжинд бүслүүлж, эвэрт ишгэн цагааныг нь унуулж анд бололцжээ. Үүнээс үзвэл Тэмүжин, Жамуха нар эрийн цээнд бүрэн хүрсэн төдийгүй дайснаа ялсан баатар эрс болсон нь илт байна. Тэмүжин, Жамуха нарын бүс, морио бэлгэдэл болгон солилцож өндөр дээд төвшинд анд бололцсон нь зөвхөн хоёр эрийн төдий бус хоёр овог аймгийн хооронд байгуулсан цэрэг-улс төрийн холбоо хэмээн үзэж болохуйц байна.

Эдгээр гурван жишээнээс үзэхэд анд бололцох нь иргэдийн хооронд ч, омог аймгийн ахлагч нарын хувьд ч болдог байжээ. Анд бололцохдоо эд өлгийн зүйлс харилцан солилцож, солилцох бүрийдээ өмнөхөө давтдаггүй байв. Энэ нь цаг улирахын хирээр солилцох эд өлгийн агуулга гүнзгийрч, тухай тухайн амин чухал бэлгэдлийг хадгалсан учир утгатай зүйлээ өгч авалцдаг байсны жишээ юм. Гуравдахь удаагийн энэ анд бололцсон нь оргил төвшиндөө хүрснийг Тэмүжин, Жамуха нарын "söni könjile-de'en qaqca qonolduqun büle'e" гэсэн жишээ харуулж байна. Дээр дурдсан гурван зүйл бол зэргэмж насны хоёрын "ах дүү" болон андалдсаны жишээ юм.

"Ах дүү" болон андалдахын зэрэгцээ "эцэг хүү" болох ёс ч байжээ.


§ 96. senggür-qoroqan-aca newüjü kelüren-müren-ü teri'ün bürgi-ergi-de nuntuqlan bawuju cotan eke-yin sitkül ke'en qara buluqan daqu abciraju büle'e tere daqu-yi temüjin qasar belgütei qurban a[b]cu




otcu erte üdür yisügei-qan ecige-lü'e kereyit irgen-ü ong-qan anda ke'eldüksen aju'u ecige-lü'e minu anda ke'eldüksen ecige metü bui-je ke'en ong-qan-i tu'ula-yin qara tün-ne buyu ke'en medejü otba ong-qan-tur temüjin gürcü ügülerün erte üdür ecige-lü'e minu anda ke'el=düksen aju'u ecige-gü metü buyu-je ke'ejü gergei bawulju emüsgel cimada a[b] ciraba ke'en buluqan daqu ökba ong-qan masi bayascu

ügülerün qara buluqan daqu-yin qari'u qaqacaqsan ulus-i cinu qamtutqaju öksü buluqan daqu-yin qari'u butaraqsan ulus-i cinu bügütke[1] düjü öksü bököre-yin bökse-tür cekere-yin ce'eji-tür aduqai ke'eba


Энэ хэсэгт Тэмүжин Хасар, Бэлгүтэй нартай хамт эцгийн хуучин анд Ван ханд очиж "ecige-lü'e minu anda ke'el=düksen aju'u ecige-gü metü buyu-je ke'ejü" хэмээн гэргий буулгаж хар булган дах авчирснаа өгчээ. Ван хан түүнийг авч "qara buluqan daqu-yin qari'u qaqacaqsan ulus-i cinu qamtutqaju öksü" хэмээн хариу "бэлэг" барьжээ. Уулзагч хоёрын нэг /Тэмүжин/ хар булган дах өгөхөд нөгөө нь /Ван хан/ "хагацагсан улусы чинь хамтатгаж өгсүү" гэсэн халуун үгээр хариулсан нь үнэндээ эцэг хүү болох бэлэг сэлт солилцсоноос юуны өөр. Гэвч "эцэг хүү" болох ёслолыг ёсоор нь үйлдээгүй болой.



§ 164... cinggis-qahan-lu'a ong-qan tu'ula-yin qara tün-na quriju ecige kö'ü ke'eldüba ecige kö'ün ke'eldükü yosun urida erte üdür yisügei-qan ecige-lü'e ong-qan anda ke'eldüksen yosu-'ar ecige metü ke'ejü ecige kö'ün ke'eldükü yosu teyimü




Харин энэ хэсэгт л Чингис хаан, Ван хан нар ёсоороо "эцэг хүү" болцгоожээ. Чингэж "ах дүү", "эцэг хүү" болох ёслолд



§ 117... and gü'ün amin niken ülü tebcildün amin-u arici boluyu ke'en amaralduqui yosun teyimü edö'e basa and tungqulduju amaraya ke'eldüjü...


§ 164 ...olon dayisun-tur ha'ulurun qamtu niken-e ha'uluya oro'a görögesün-tür abalarun niken-e-gü

qamtu abalaya ke'eldüba гэсэн андгай өргөдөг байжээ. Энэ андгай



наанаа хоёр хүний хоорондын мэт авч цаанаа тухайн үеийн овог аймгийн цэрэг улс төрийн холбооны шинж, харилцан хүлээсэн үүргийн агуулгыг гүнээ илэрхийлж байна. Гэвч андгайгаас няцах явдал байн байн үргэлжилсээр байсныг Жамуха, Ван хан нараас итгэлийг эвдэн Чингисийн эсрэг явуулсан удаа дараагийн хуйвалдаан дайн тулаан бэлхэнээ харуулна. Ван хан амар заяа үзүүлэхүй сандаргаж уулгалж байгаа учир Чингис хаан элч зарж урьдын бүхий л явдлыг дурдан сануулж "... edö'e qan ecige minu yambar cimar-tur minu cimatba ci..." /§ 177/ хэмээн асуужээ.

§ 178. ede üges-tür ong-qan ügülerün ai soyiluq kö'ün-ece-'en qaqacaqu-yu törö-dece qaqacaba hirijegü-yü üyile-dece hiriceba bi ke'en dura alja'at ügülerün edö'e kö'ü-ben üjejü mawui setki'esü ene metü cisu-ban qarqaqdasu ke'en andaqaju sigi quru'un-u'an toli onu[b]ci kituqai-bar qatquju cisun cuburi'ulju ücü'ügen daqtai-tur kijü kö'ün-e minu ök ke'ejü ileba...




Энэ хэсэг бол Чингисийн асуултын хариу мөний зэрэгцээ "sigi quru'un-u'an toli onu[b]ci kituqai-bar qatquju cisun cuburi'ulju" гэсэн зан үйлийг илэрхийлэл юм. "Sigi quru'un-u'an" цусаар андгайлах нь андын холбоог ахин сэргээсний бэлгэдэл, андгайг дахин няцвал цус гарган үхүүлэгтүн гэсний баталгаа юм. Үүнтэй уялдуулан §201 ülü singge -küi ide'e ideldüjü ülü umartaqu üges ügüleldüjü ... хэмээх Чингисээс Жамухад хандсан үгийг иш татав. Үл шингэх идээ идэлдэж, үл умартах үгс өгүүлэлдэх тогтсон ёс монголчуудад байсны гэрч энэ буюу. Үл умардах үгс гэдэг нь мэдээж андгай тангараг тавихтай холбоотой нь магад. Үл шингэх

идээ идэлдэж гэдэг нь монгол ардын баатарлаг туульс "Бум-Эрдэнэ", "Даньхүрэл", "Хаан Чингэл баатар"-ын "хоёр хуруугы үзүүрийг оттолж цусаа долоолцох"-той холбоотой сэтгэгдэл төрүүлж байна. [Энэ ёсыг тойрсон бэлгэдэл бүхий бүхэл бүтэн зан үйл байжээ гэдгийг ах дүү хоёр болж яваа хоёр нумны хөвч доогуур шургаж, илдийн ир барилцаж долоолцох, хүлгийн дэлнээс нэг нэг хялгас тасалж тайрч авалцах барилцах, амин голын үгээ харилцан шивэгнэж хүүрнэх, амтат идээг амааараа авалцаж идэх, "цустай дайн, тостой хурим"-наас бүү дуталцая гэхчлэн ам тангараг тавих мэтчилэн дэс дараалсан олон үйлдэл харуулж байгаа юм][7].

Үүний доторхи ахан дүү болох ёсны гол цөм болсон баатрууд хуруугы үзүүрээс цус гаргаж амсах долоохыг "үл шингэх идээ идэлдэх" хэмээн эрүүлэн өгүүлсэн нь баттай[8] хэмээн үзэх аваас "Үл шингэх идээ хэмээх нь... өчүүхэн хэмжээний шар алтан нунтагийг балгах"[9] хэмээснийг эргэлзээтэй тайлбар гэж үзэхэд хүрнэ вий. Ингэж чигчий /sigi/ хуруугы өндгийг зүсч цусаар андгайлах, хүж барьж ах дүү амраг садан болох ёс монгол угсаатны дунд эдүгээ ч тасраагүй байгаа ажээ.

Орчлонгийн хүний төрөх нь гарцаагүй юм бол нөхчих нь бас зайлшгүй ажээ. Тиймээс ч өлгий авс хоёрыг дамжих төрөх нөгчих хоёрхон үнэн л хорвоод бий гэлцдэг билээ. Хэн нэгний ханат гэрээс алсалж хадан гэрт, эсгий гэрээс холдож энгэр гэрт очих нь хүндэтгэл, цээрлэл дагуулсан зан үйлийн их цогцлол мөн. "Монголын нууц товчоо"-ны § 68, 129, 136, 140, 175, 201, 246, 268, 272... зэрэг хэсэгт Есүгэй, Нэүдэ цагаан гоо, Сача, Тайчу, Хуйлдар, Тэв-Тэнгэр, Жамуха, Чингис..." зэрэг олон хүний янз янзын шалтаг шалтгаанаар ертөнцийн мөнх бусыг үзүүлснийг товч хийгээд дэлгэрэнгүйгээр дүрслэжээ. Түүний дотроос Тэв Тэнгэр бөөгийн үхэл оршуулга товч атлаа ихийг өгүүлэх боломжтой юм.


§ 245... teb-tenggeri-yi terged-ün üjü'ür-e niru'u qugulju o'oruqsan-i cinggis-qahan üjejü qoyitu'ul-aca niken boro qosiliq



abcira'ulju teb-tenggeri-yin de'ere inu talbi'ulju kölge oro'ulutqun newüya ke'ejü tendece newüba.

§ 246. teb-i talbiqsan qosiliq-un erüge tülijü e'üten daruju hara saki'ulu'asu qutu'ar söni üdür sira-da ger-ün erüge ne'ejü beye selte qarcu'u bolqa'asu maqat teb inu tende bolqaqdaba cinggis-qahan ügülerün teb-tenggeri de'ü-ner-tür minu qar köl gürgeksen-ü tula de'ü-ner-ün minu ja'ura oro ügei jinggügü-yin tula tenggeri-de ese ta'alaqdaju ami-yan beye selte abcu otdaba-je ke'eb

Энэ хэсэгт Чингисийн өгүүлснээр "d'ü-ner-tür minu qar köl gürgeksen-ü tula be'ü-ner-ün minu ja'ura oro ügei jinggügü-yin tula tenggeri-de ese ta'alaqdaju" нуруугаа хугалуулан Тэв-Тэнгэр таалал төгссөн тул нэгэн бор хошилог дээр нь бариулж түүний өрхийг түлжү /таглаж/ үүдийг дарж сахиулсан ажээ. Энэ нь хүндэтгэлтэй хүнийг нөгчихөд дээр нь гэр хошилог бариулдаг ёс байсныг, мөн амьсгал хураасан хүний гэрийн өрхийг бүтээж, үүдийг дардаг заншилтайг давхар харуулж байгаа юм.



Үүнийг Жиованни дель Плано Карпинийн "Монголчуудын түүх" тэмдэглэлд монголчуудын оршуулах зан үйлтэй холбогдуулж "... шарил дээр барьж байсан гэрийг тэнд нь орхих..."[10] гэсэн өгүүлбэр бас илэрхийлж байгаа болно. Харин "qutu'ar söni üdür sira-da ger-ün erüge ne'ejü beye setle qarcu'u bolqa'asu maqat teb inu tende bolqaqdaba" гэсэн нь ид шид, домгийн


шинжийг агуулсан гэж санагдахаар байгаа юм. Тэв-Тэнгэр бурууг үйлдэж тэнгэрт эс таалагдсанаас амь биеийг авч одлоо гэх Чингисийн тайлбар байгаа ч гэсэн, "Тэр хувилгаан увидас илрүүлж ирээдүйн хэргийг зөгнөдөг байв. Тэр үргэлж тэнгэр дээр аялан явж сахиулсантай ярилцдаг гэдэг..."[11] гэж Рашид-ад-дин тодорхойлсон ч гэсэн домгийн шинжтэй өгүүлэмж гэдгийг үгүйсгэж үл чадна. Нас нөгчихийн өмнө гэрээс захиасаа хэлэхийг Есүгэй баатар "ücüget qocoruqsat de'ü-ner-iyen belbisün bergen-iyen asaraqu-yi ci mede kö'ü minu temüjin-i ötörken otcu absu ire" /§ 68/," Толуй "önecit ücüget de'ü-ner-iyen belbisün beri-yen berüde oyin-a gürtele asaraqu-yi qahan aqa medetügei" /§ 272/ гэж өгүүлснээс, нас нөгчөөхийн өмнө ам өчгийг нь авахыг Сача бэки, Тайчу /§ 136/, Жамуха /§ 201/ нартай Чингис хааны өгүүлэлцэж байгаа жишээнээс тодорхой харж болно.

Чингисийн нөхцөе /нөхөрлөе/ гэж учирласны хариуд Жамуха "jaqa-yin cinu bö'esün jahing-un cinu ör(ü)gesün bolqu bi... cisu ülü qarqan ala'ul.../§ 201/ гэж өчиж байгаа юм. Тиймээс Чингис "silta'an ügei amin-tur qor ki'esü ülü jokimui" гэж Жамухагийн бууруу булхайг дурдаж ёсоор болгожээ.



§ 201. edö'e cinu üge-ber cisu ülü qarqan nökci'etügei ke'en ügüle ke'et cisu ülü qarqan nökci'ejü yasu inu ile bu getkün sayitur baritqun ke'en jarliq bolba jamuqa-yi tende nökci'ejü yasu inu bari'ulba ... Энэ хэсэг дэх цусыг үл гарган нөхцөөж ясы нь ил бүү гээх тухай өгүүлэмж нь Марко Пологийн аяны тэмдэглэлд "Их хаан Наяны олзлогдсоныг мэдээд түүнийг цаазаар хороохыг тушаажээ. Чингээд түүнийг эсгийд ороож чивчиртэл чангалан татсаар амийг нь хороов. Ингэж алдагийн учир гэвэл хааны ураг удмын хүний цусыг газар дусаахгүй буюу агаар наранд үзүүлэхгүй алдаг

заншилтай байжээ"[12] гэсэнтэй утга авцалдаж байгаа билээ.



"Монголын нууц товчоо"-нд Чингисийн өөд болсон тухайд "... tang'ut irgen üge ügülejü üge-tür ülü gürgü-yin tula tang'ut irgen-tür cinggis-qahan nökö'e-te ayalaju tang'ut irgen-i muqutqaju irejü qaqai jil cinggis-qahan tenggeri-tür qarba..." /§ 268/ гэсэн маш товч өгүүлэмж үлджээ.

Энэ хэсгийг нөхөн сэргээж ойлгоход Лувсанданзаны "Алтан товч" дахь Гилүгэдэй баатарын эмгэнэлийн дуулал их нэмэртэй юм. Түүнд "ünen kegür-i inu: jarim-ud Burqan Qaldun-a-tur ongγolaba gekü: jarim-ud Altai Qan-u arudu: Kentei Qan-u ebür-tü Yeke Õteg neretü γajar-a ongγolaba"[13] гэж өгүүлжээ. Ямар ч байсан Чингис хааныг уугуул ус суугуул газар шороог нь түшиж, "нутагтаа ясаа тавина" гэх монгол хүний үе дамжсан гэрээсийн дагууд нутаглуулсан нь мэдээж. Марко Пологийн аяны тэмдэглэлд: "Чингисийн удам угсааны их хаадыг цөм Алтайн их ууланд онголон оршуулна. Татарын их эзэн хаад хаана халин одсон ч, ер Алтайн уулсаас зуун өдөрчийн хол газар боловч ялгаагүй, тэр ууланд аваачиж нутаглуулдагийг мэдвэл зохилтой"[14] гэсэн нь мадагтүй юм. Чухам ямар зан үйл хүндэтгэл үзүүлж нутаглуулаа вэ? гэдэг нь одоогоор ам дамжсан домогт үлдсэнээс өөр нь үгүй билээ.

Төрөхөөс нөгчих хоёр нарны хоорондох хүний амьдрал байгалийн төдийгүй нийгэм орчны хүрээлэлд үргэлжилдэг гэдгийг тэргүүн бүлэгт дурдсан бүхий л жишээ баримт харуулж байна.

Энэ бүхэн нь "Монголын нууц товчоо"-ны соёл-түүхийн хам нөхцөл, түүний хамрах ерөнхий хүрээг тогтоож тодорхойлохын уг сурвалж болж байна.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР


1. Г.Сүхбаатар. Монгол нирун улс /330-555/. УБ., 1992. 138-139-р тал
2. С.Дулам. Дархад бөөгийн уламжлал дахь бэлгэдэл зүй. Mongolica. An international annual of mongol studies. 1995. Vol 6 /27/ Ulaanbaatar. 501-502-р тал
3. Д.Цэрэнсодном. "Монголын нууц товчоо"-ны домгийн сэтгэлгээний зарим нэгэн ойлголтын тухай. Аман зохиол судлал . Studia folclorica... Tom XYII, Fasc 1-10. УБ., 1987. 6- р тал
4. Чингис хааны алтан товч нэрт цадиг оршибай. Бар хэвлэл. 1а, 2б.
5. Altan tobci (Hans-Peter Vietze, Gendeng Lubsang) Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von Blo bzan bstan'jin. Text und Index. Tokyo. 1992. p. 9
6. Мөсөн дээр "cinggültüktü si'a"-гаар шахалцан наадахын нэгэн хэлбэр нь монголчуудын дунд эдүгээ үлдсэн "өрөг харвах" буюу "мөсөн шагай харвах" тоглоом мөн. Энэ тоглоомд дөрвөн шаа, хушга, өрөг, зах буюу сум хэрэглэдэг ажээ. Хушгийг хийхдээ үхрийн боловсруулаагүй нойтон ширнээс дүгэрэг хэмжээгээр багахан зүсч аваад захыг нь тойруулан оёж, зүү хүргээгүй үлдээсэн хэсэгхэн газраар оёдлыг эргүүлж дотор талд оруулан, элс чихэж хатаана. Мөн эр үхрийн засааны арьсыг хөндий хатааж хушга хийдэг байжээ. Наадагчдын оноог зураасаар тэмдэглэх өргийг хийхдээ модон самбарын өнгөн талыг шөлний тосоор тосолж, аргалын үнс түрхэн галд ээж хатаана. Хонины буюу зээрийн шааг, мөн үхрийн шилбэний "сарлаг яс"-ыг хөрөөдөн авч уг тоглолтод хэргэлдэг. Зах буюу сумыг аргал угалзан эврийн ясыг хөрөөдөж, эсвэл гууль цутгаж хийдэг. Зах /сум/ бүтээхдээ яснаас зохих хэмжээгээр /өргөн 3,5 см, урт 4 см, зузаан 1,5 см, хүнд 200 г буюу 3 лан 5 цэнгээс илүүгүй. 2 лан 5 цэнгээс дутуугүй/ хөрөөдөн авч төв дунд нь хонхойлгон ухаж, чөлөөтэй хөдөлж холхиж байхаар бодож түүнд

хар тугалга хийгээд түүнийгээ нимгэн төмрөөр таглаж хаддаг аж. Бас зах /сум/ бүтээхдээ дан гуулиар төвд нь хар тугалга холхих зай гарган цутгадаг чөлөөтэй хөдөлж байх зорилгор дотор нь хийсэн хар тугалга нь захны /сум/ эргэлдэн гулсахад хурдны хүчийг нь тэнцүүлэх ачтай юм. Байны газар өөгүй гялгар мөсөн дээр голд нь хушга, түүнээс хоёр тийшээ 2 хуруу зайтай хоёр шагай байрлуулна. Түүнийг цовхи шаа гэнэ. Цовхи шагайнаас хоёр тийш нэгэн төө зайд үлдэх хоёрыг байрлуулна. Үүнийг зах шаа гэнэ. "Хоёр захын шагайны хоорондох хэмжээ нь яг нэг алд зайтай байх ба яг төв дунд нь хушга байрлана..." "Захын шагайг оновол 1 оноо, цовхи шагайг оновол 1 оноо, зах болон цовхи шагайн дундуур гарвал 1 оноо, хушгийг оновол 3 оноо, цовхи шагай хушга хоёрын дундуур гарвал зулбасан гэж нэрлээд оноо өгөхгүй. Харин цовхи шагай хоёрыг хамтад оновол парнайдсан гэж үзэж 1 оноо өгнө". Зураг тоглоом /Эмхтгэн бичсэн Т.Дамбийчоймбол, Г.Дондог/. Цэцэрлэг хот. 1963. 30-37-р тал; БНМАУ-ын угсаатны зүй. Гурван боть. Халхын угсаатны зүй. / XIX-XX зууны зааг үе/ 1 боть. УБ., 1987. 368-р тал
7. Д.Цэдэв (Монгол улс). Монгол ардын баатарлаг туульс дахь ах дүү болох ёсон, түүний бэлгэдлийг монгол бичгийн уран зохиолын дурсгалын дүрслэлтэй холбон үзэх нь. Төв Азийн туульс ("Төв Азийн туульс" олон улсын симпозиум-их наадам) УБ. 1998. 76-р тал
8. Сүхбаатарын Ганцэцэг. "Үл шингэх идээ идэлцсэн" гэдэг үгийн учир. "Улаанбаатар" сонин. 1995.02.25 №38, 39 (724. 725)
9. Bulaγ. Mongγol-un niγuca tobciyan-u ündüsüten-ü kelberi. öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a. Kökeqota. 1983.297 duγar tal-a; Eldengtei, Ardajab seyiregülün tayilburilaba Mongγol-un niγuca tobciyan seyiregülül tayilbüri. öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a 1986. 649-650 duγar tal-a
10. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильом де Рубрук Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ., 1988, 20-р тал

11. Рашид-ад-дин. Сборник летописей. Том I. пер.с персидского Л.А.Хетагурова Изд. АН СССР. М-Л., 1952, стр. 167
12. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин/Аяны тэмдэглэл/. УХГ, УБ., 88-р тал
13. Altan tobci (Hans-Peter Vietze, Gendeng Lubsang) Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von Blo bzan bstan'jin. Text und Index. Tokyo. 1992, p.90
14. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин /Аяны тэмдэглэл/. УХГ. УБ., 69-р тал

ДЭД БҮЛЭГ

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО"-НЫ БЭЛГЭДЛИЙН ГОЛ АЙ



Бэлгэдлийн ай гэдэг нь яг тогтчихсон ойлголт хараахан биш билээ. Тиймээс эрдэмтдийн санал бодол өөр өөр байгааг доорхи хэдэн жишээнээс үзэж болно. Үүнд: А.Ф.Лосев "Бэлгэдлийн асуудал ба реалист урлаг" /1976/ номдоо: шинжлэх ухаан, гүн ухаан, уран сайхан, домог зүй, шашин шүтлэг, сурталсэнхрүүллийн, гадаад илэрхийллийн бэлгэдэл" мэтээр 9 хэв шинж болгон тэмдэглэгдэхүүний талаас хуваасан[1] бол Ж.Шевалье, А.Геербрант нар "Бэлгэдлийн толь"- /1987/[2] номдоо "домог, зүүд, ёс заншил, дохио зангаа, хэлбэр дүрс, өнгө, тоо" гэхчлэн тэмдэглэхүүний талаас ангилжээ.Ж.Е.Кирлот "Бэлгэдлийн толь" (1971)[3] номдоо бэлгэдлийн гарал үүсэл, уламжлал, түүхэн чанар, зүүдний утга чанар бэлгэдлийн төсөөт чанар гэхчилэн 17 бичил гарчиг өгч тайлбарласан бол Е.Я.Шейнина "Бэлгэдлийн нэвтэрхий толь бичиг" (2002)[4] номдоо "Бэлгэдлүүдийг, байгалийн, хүний ертөнцийн"-ийн болон болзолт тэмдэгийн, урлагийн бэлгэдэл гэхчилэн 6 төрөл болгон авч үзжээ. "Х.Биедэрманн" "Бэлгэдэл зүйн толь" (1994)[5], В. Андреев нарын эмхтгэсэн "Бэлгэдэл, тэмдэг, бэлгэ тэмдэгийн нэвтэрхий толь бичиг" (1999)[6], У.Бекер "Бэлгэдлийн нэвтэрхий толь бичиг" (2000)[7], К.А Вильямсийн эмхтгэсэн"Хятадын бэлгэдлийн нэвтэрхий толь бичиг" (2000)[8] номд бэлгэдлийг үсгийн дэс дарааллаар тайлбарлажээ.

А.Ф. Лосев гүн ухаан-гоо зүйн үүднээс хандсан тул түүний хуваснаар тодорхой нэгэн зохиолын хувьд авч үзэхэд тохиромжгүй. Харин Ж.Шевалье, А.Геербрант нарын болон Е.Я.Шейнинагийн ангилалт нэгэн үндэс угсаатны болон тодорхой зохиолын хувьд авч үзэхэд аргачлал нь ойр дөт юм. Гэвч тодорхой зохиолын хувьд шинжлэхэд дээрх ангилалд үл хамаарах нь бас багагүй бий.

Энэ бүхнээс үзэхэд нэгэн улс орны тодорхой бүтээлийн бэлгэдэл зүйн судалгааны бэлэн загвар арга зүй гэж байх уу? гэсэн асуулт гарахад хүрч байна.

Монгол бэлгэдлийг судлах оролдлого хийсэн Н.Л.Жуковская "Монголын уламжлалт соёлын ай бэлгэдэл" /1988/[9] номдоо "орон зай, цаг тоолол, баяр ёслол, аз жаргал, хоол хүнс, бэлэг дурсгал, авир хөдлөл /основ этикета/, тоо, өнгө" хэмээн 9 үндсэн ай болгосон бол Х.Нямбуу "Сүлд, туг далбаа, тамга, сүлд дуулал, одон тэмдэг, мөнгөн тэмдэгт, нийслэл"[10] гэхчлэн их төлөв төрийн ёс зүйд тулгуурлан бэлгэдлийг авч үзжээ. Д.Тангад халхчуудын эд, оюуны соёлын олон янзын хэлбэрт хадгалагдаж байсан бэлгэдлийг "өнгийн, дүрсийн, тооны, аман үгийн, орон зайн" гэсэн таван ангид[11] хуваж шинжилгээний явцад цуглуулсан холбогдох мэдээг тайлбарлажээ.

Б.Катуу монгол туульсын бэлгэдлийг "тоо, зүг чиг, өнгө, зураг дүрслэл"-ийн 4 зүйлээр[12] авч үзсэн бол монгол аман зохиол болон бичгийн утга зохиол дахь бэлгэдлийг С.Дулам "тоо, өнгө, цаг, зүг чиг, дохио зангаа, хэлбэр дүрс, зүүд зөн совин"[12] гэсэн 7 айд ангилан судлажээ. Эдгээрийн дотроос Ж.Шевалье, А.Геербрант нарын ангилалыг С.Дулам баримталж монгол бэлгэдлийг судласан нь нилээд ул үндэстэй болжээ. Гэвч "Монголын нууц товчоо" хэмээх тодорхой нэгэн зохиолын хувьд үзэхэд бэлгэдлийн айн дээр дурдсаны аль ч ангилал нь төдийлэн тохирохгүй байгаа юм. Тиймээс "Монголын нууц товчоо"-нд байгаа баримт жишээнд тулгуурлаж тоо, өнгө, зөн совингийн бэлгэдлийн гурван айг миний бие энд авч үзэхийг эрмэлзсэн болно.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР


1. А.Ф.Лосев. Проблема символа и реалистическое искусство. М., "Искусство", 1976, стр. 186-196
2. Jean Chevalier, Alain Gheerbrant. Dictionnaire des symboles. Robert Laffont.Jupiter. 1987
3. A dictionaty of symbols. Second edition. By J.E. Cirlot. Transleted from the Spanish by Jack Sage. Routledge &. Kegan Paul Ltd.s 1962. London and Henlgy. 1971
4. Е.Я.Шейнина. Энциклопедия символов. Изд. "Торсинг"М.2002.
5. Biedermann Hans. Dictionary of symbolism. Translated by James Hulbert. Meridian Book. 1994
6. Энциклопедия символов, знаков, эмблем. Авторы-составители В.Андреева, В.Куклев, А.Ровнер. Изд. Локид-Миф.М. 1999
7. Udo Becker. The continuum encyclopedia of symbols. Translated by lance W.Garmer. Continuum. New York. London. 2000
8. Энциклопедия китайских символов (Восточный символизм) Сос. К.А. Вильямс. Изд. В.П.Царёва. М.2000
9. Н.Л.Жуковская. Категории и символика традиционной культуры монголов. М., Наука. 1988
10. Х.Нямбуу. Монголын бэлэгдэл. УБ., 1979
11. БНМАУ-ын угсаатны зүй. Халхын угсаатны зүй. 1 боть. Ред. С.Бадамхатан. УБ., 1987. 324-р тал
12. Б.Катуу. Монгол ардын баатарлаг туульс дахь бэлгэдэл. УБ., 1996
13. Сэндэнжавын Дулам. Монгол аман зохиол, утга зохиол дахь бэлгэдэл зүйн тогтолцоо /Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилсон зохиол/. УБ., 1997


ТООНЫ БЭЛГЭДЭЛ

1


Тодорхой цаг хугацааны хүрээнд тусгайлан орон зайг эзлэн оршсоор ирсэн хүн зон, байгалийн хийгээд нийгмийн элдэв үзэгдэлд хандаж харилцахдаа орчил давтамж, хэм хэмнэлтэй алхам тутамдаа учирч, түүнийг мэдэрч ухаарсныгаа бас ч үгээр болон тоогоор илэрхийлэх нь үлэмж байжээ. Тийм мэдрэмж ухаарал Төв Азийн нүүдэлчдийн хувьд ихэд хөгжсөн байсныг "Монголын нууц товчоо"-ноос ямар нэгэн хэмжээгээр мэдэж болно.


"Монголын нууц товчоо" зохиогдсон үе буюу XII-XIII зууны үед монголчууд ямар ч болов тоог амьдрал ахуйдаа өргөн хэрэглэж байв. Тиймээс тооны утга учрыг нарийн ухаарч, сайн үйлийн бэлгэдэл хийгээд саар явдлын ёр болгох нь их байв. Монголчууд амьтны нэрээр нэрлэсэн арван хоёр жил бүхий жаран жилийн тогтолцоот он тооллыг хэрэглэж байсан нь "Монголын нууц товчоо"-ны дотор гарсан quluqana /§193, 197, 269, 282/, qonin /§ 247, 250/, üqer /§198/, bars /§ 202/, ta'ulai /§ 239, 257, 272/, takiya /§ 141, 264/, noqai /§ 153, 157, 251, 265/, qaqai / 166, 268/... зэрэг он тооллоос тодорхой байгаа юм. Монголчуудын одон зурхайн цаг тооны бичиг зохион хэрэглэснийг гал туулай жил буюу 1027 оноос эхэлсэн гэдэг."Монголын нууц товчоо"-ны дотор гардаг "ja'arit nidün-tür üje'ü[l]jü nadur ji'amui" хэмээн Тэмүжинийг "улсын эзэн" болгох тухай өгүүлсэн Хорчи / §120, 121/ "möngke tenggeri-yin jarliq qan ja'arit ügülemü niken-te temüjin ulus barituqai ke'emü niken-te qasar-i ke'emü" гэж зөн мэдэгдсэн гэж Чингис хаанд өгүүлсэн Хөхөчү Тэв-Тэнгэр бөө / § 244/, Цагадай







хэцүү догшин авиртай тул "üde manaqar dergede aju setkiksen-iyen kelelen atuqai" гэж Чингис хааны зарлиг болсон Хөхөчос /§243/ болон "üjeksen-iyen ülü ni'un sonosuqsan-iyan ülü qabciqun büle'e" хэмээн Чингис хааны соёрхсон Хунан, Дэгэй, Үсүн-өвгөн... /§ 210, 216/ нар зурхайч, бөө, мэргэч төлөгчид болно. Рашид-ад-дин "Судрын чуулган" зохиолдоо "Тэр / Мэнлиг эцэг Д.Ц./ монголчуудын Тэв-Тэнгэр хэмээн нэрлэдэг Хөхөчү гэдэг хүүтэй билээ. Тэр ер нь хувилгаан увидас илрүүлж, ирээдүйн хэргийг зөгнөдөг байв. Тэр үргэлж тэнгэр дээр аялан явж, сахиулсантай ярилцдаг гэдэг..."[1] гэхчлэн бичсэн бол Гильом де Рубрук "Дорно этгээдэд зорчсон минь" тэмдэглэлдээ: "Тэдний /бөө нарын Д.Ц./ зарим нь ялангуяа тэргүүн зайран одон орны зүйл гадарладаг бөгөөд нар сар хиртэхийг зөгнөн хэлнэ... Бөө нар аливаа хэрэг ажил үйлдэх бэлэг дэмбэрэлтэй өдөр, эс бүтэх муу өдрийг зөгнөн тогтооно..."[2] хэмээн бичсэн нь дээр дурдсан зурхайч, бөө, мэргэч төлөгч нарт нэгэн адил хамаарах болно.










§ 81 ... jun-u teri'ün sara-yin harban jirwa'an-a hula'an tergel üdür tayici'ut onan-nu ergi de'ere qurimlalduju naran singge'esü tarqaba.

§118. temüjin jamuqa qoyar... jun-nu teri'ün sara-yin harban jirqo'an-a hula'an tergel üdür newüba.

§ 193. quluqana jil jun-nu teri'ün sara-yin harban jirwa'an

üdür hula'an lergel-e tuq sacu'at morilarun kelüren ö'ede jebe qubilai qoyar-i algincilaju yabu'at...



Зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр "Тайчууд Ононы эрэг дээр хуримлаж, Тэмүжин, Жамуха хоёр нүүж, туг тахиж мордоод Зэбэ, Хубилай хоёрыг "algincilaju" явуулж байгаа зэрэг нь сарын сайныг саатан тогтож, өдрийн сайныг өнжин сонгодог байсны бодит жишээ юм.

Чухамдаа зурхайч, бөө, мэргэч, төлөгч нар наран, саран, од гаригийн байршил, давтагдах хөдөлгөөнийг ажиглаж, байгалийн элдэв үзэгдлийн орчил давтамжийг ямар нэгэн хэмжээгээр мэдэрч, түүнийгээ хүний биеийн хэмнэл, давтамж хийгээд хувь заяаны нь төөрөгтэй холбож мэргэлж төлөглөхдөө зурхай зурахдаа тооны элдэв үйлдлийг чадамгай хэрэглэж байжээ. Ер нь "Монгол дахь ардын математика", "Эртний монголын математика ба одон орны мэдлэг"-ийн талаар багагүй өв уламжлалтай[3] байсныг хожмын судалгаа нэхэн илрүүлсээр байгаа билээ.




Өмнөх үеэс уламжилсан тухайн үеийн тооны мэдлэгийн тийм төвшингийн үед "Монголын нууц товчоо"-нд олонтаа гарсан тооны дотроос цөөнгүй нь бэлгэдлийн утга агуулснаас "гурав", "тав", "ес"-өөр жишээ болгон авч үзье.


"Монголын нууц товчоо"-нд гарсан тэгш, сондгой тооны дотроос юуны өмнө "гурав"-ыг бэлгэдлийн утгаар яаж хэрэглээ вэ? гэдэгт хариулахын тулд хэдэн жишээг иш татъя.

§ 4. duwa-soqor manglai dumda qaqca nidütü qurban ne'ürit qajar-a qaraqu büle'e гэсэн хэллэгийн "ne'ürit"

хэмээх ойлголт нь "qurban" гэсэн хүртээл тоотой хэрхэн холбогдож ямар утга бэлгэдэл илэрхийлнэ вэ? XII-XIII зууны үес монголчууд айл гэрээ нутаг сэлгэхийг "ne'ü" язгууртай үгээр илэрхийлдэг байжээ. "ne'ü" гэдэг нь наран ургах /үүр цайх/-аас наран жаргах /бүрэнхий болох/-ын хоорондахь хугацаанд тэмээ, үхэр буюу тэмээн тэрэг, үхэр тэргээр зай туулахыг хэлдэг ажээ. "Монголын нууц товчоо"-нд "newüjü" хэмээн олонтаа /§ 28, 96, 118, 122, 151/ гарсан нь тухайн тэр цагийн нүүдэл, суудлын байдлыг тодорхой тусгаж, "newüjü" гэдэг нь байгалийн бүс бүс нутагт өвөрмөц ойлголт мөн. Ойр газар болоод хол газар "newüjü" гэж байх төдийгүй тэмээ, үхрийн нуруу ачих, тэмээн тэрэг, үхэр тэргээр "newüjü" байсан хэд хэдэн хэлбэр байжээ. "Монголын нууц товчоо"-нд




§ 1. cinggis-qahan-nu huja'ur de'ere tenggeri-ece jaya'atu töreksen börte-cino aju'u gergei inu qo'ai-maral aji'ai tenggis ketüljü ireba onan-müren-nü teri'ün-e burqan-qaldun-na nun=tuqlaju töreksen bataciqan aju'u хэмээн гарсан тэр удмын нэг нь Duwa-soqor билээ. Тэгэхлээр Duwa-soqor - ын нутаг нь гурван мөрний эх болон Бурхан халдун хавийн уул ой хөвч, хөндий хоолой, уудам хээр хослосон газар болой. Тийм нутаг газарт "ne'ürit" гэх ойлголт юуг илэрхийлж байсан бэ? гэдгийг эрхбиш бодолцвол зохино. Монголчууд жилийн туршид цаг агаарын байдал, өвс ногооны ургац, ус ундны хүрэлцээ зэргээс шалтгаалан олонтаа нүүх боловч улирлын аясыг дагаж өвөлд /хүйтэн үед/ нөмөр дулаан газарт, хавар намрын цагт /сэрүүн үед/ хөндий хоолой, хээр нутагт, зунд /халуун үед/ ус гол, булаг шандын дэнж хөвөөг бараадан нүүдэл хийдэг ажээ.



Энэхүү зураглалаас харахад "ne'wüjü" хүрэх "ne'ürit" байр /суурь/ хүйтэн /1/, сэрүүн /2/, халуун /3/ гэсэн улирлын гурвал орчин юм. Тэдгээрээс улбаалан "newüjü" явах газрын баримжаа хэмжээний тухай ойлголт үүдэн гарсан нь зүй билээ. Монголчууд орон зайг хүний эрхтэнээр[4], малын эрхтэнээр [5], хүний мэдрэхүйд тусах тусгалаар [6], малын хөлийн явдлаар[7], сүргийн билчээрээр[8], эдлэл хэрэглэлээр[9] зэргээр хэмжүүр хийдэг байжээ. Тэдгээрээс "ne'urit" гэдэг нь малын хөлийн явдлаар баримжаа авсан орон зайн хэмжүүр юм. Үүнийг "qurban" /гурван/ гэсэн хүртээл тоотой холбохлоор олон тоог, алс холыг заасан утга санааг илэрхийлдэг болой. "Гурав" бол монголчуудын хувьд эртний сэтгэлгээний уламжлалыг хадгалж ирсэн тоо мөн. Монгол хүн, хүндийг өргөх, аливааг татах түлхэх тэргүүтэндээ бусадтай хүч тамираа нэгтгэхийн үүднээс "гурав"-ын тоонд хүч өгч уухайлдаг хийгээд басхүү тэмцэлдэх, барилдах, наадах зэрэгт "гурав"-аар шовхоо үздэг, тэрчлэн "тулгын гурван чулуу"[10]-гаар өрх гэр, гал голомт үүсгэж, эх эцэг үр "гурав"-ын нэгдэл бэлгэдэл болгодгийн ул мөр эдүгээ ч монголчуудын зарим хэсгийн дунд хадгалагдсаар байгаа юм. Монголчуудын нүүдэл суудлын уламжлал олон үеийг туулсан ч гэсэн нутаг орны байгалийн гурван бүс түүний доторхи бичил бүсийн онцлог, цаг улиралтай нягт холбоотой ойлголт мөн гэдгийг хадгалан үлдээсээр ирснийг "Монголын нууц товчоо"-ны тооны утга харуулав гэж үзэж болно. "qurban ne'ürit


qajar-a qaraqu" гэсэн нь дөрвөн цагийн эргэлтэд "qurban newüjü" газар буюу "qurban ne'ürit qajar-a" нь өөрийн гэсэн хүрээний бүх нутгийг хамран хэлж байгаа бэлгэдэл бүхий утга юм. Тиймээс ч



§ 5. niken üdür duwa-soqor dobun-mergen de'ü-lü'e-be'en burqan-qaldun de'ere qarba duwa-soqor burqan-qaldun de'erece qaraju tünggelik-qoroqan huru'u niken bölök irgen newüjü oroju ayisuqu-yi qaraju üjejü гэснээс үзэхэд Duwa-soqor "qurban ne'ürit qajar-a"-ын хүрээн дотор өөр бүлэг иргэн /qorilartai-mergen/ орж ирснийг олж харж чадаж байгаа юм.


Тэгэхлээр "qurban ne'ürit qajar-a qaraqu" гэдэг нь жирийн нэгэн харах үзэхийн утга бус тэрхүү газар нутагт оршин суусны хувьд эзэмшиж харгалзана гэсэн давхар санаа юм.

§ 9. qorilartai-mergen qori-tumad-un qajar-tur-iyan buluqan keremün görö'etei qajar-iyan qorilalduju mawulalduju qorilar oboqtu bolju burqan-qaldun-nu görö'esün görü'üli sayitu qajar sayin ke'en burqan-qaldun-nu ejet burqan-bosqaqsan sinci-bayan uriangqai-tur newüjü ayisun aju'u qori-tumad-un qorilartai-mergen-nü ökin




ariq-usun-na töre [k] sen alan-qo'a-yi tende quyuju dobun-mergen-nü abuqsan yosun teyimü хэмээсэн нь тэр үес газар нутгийг эзэмшиж байсан, түүний төлөө тэмцэлдэж байсны баримт юм. Түүгээр ч үл барам

§ 279 ... basa ulus irgen-e nuntuq usu qubiyaju ögüye nuntuq nuntu[q]la'ulqui-a minqat minqad-aca nuntu'ucin ilqaju qarqa'asu bolqu-yu basa cöl qajar-a görö'esün-ece busu ülü amui irgen-e a'ui-a saqut canai ui'urtai qoyar nuntu'ucin-i teri'ülejü cöl-ün qudu'ut eri'üljü qasituqai ... хэмээн гарч байгаа нь "Монголын газар нутаг нь улс иргэнд хуваасан нарийн хуваарьтай болоогүй ч овог аймгийн газар эзэмшил, газар эдлэнгийн хэв хууль нилээд их хүчин төгөлдөр" [11] байсны жишээ юм.




"Монголын нууц товчоо"-нд "гурав" гэсэн тоогоор орон зайн ойр холыг илэрхийлэхдээ цаг хугацааг заасан үгстэй холбож нэгэн бүрэн бүтэн ойлголт илтгэх нь олонтаа ажээ.





§ 67. yisügei-ba'atur ja'ura cekcer-ün sira-ke'er-e tatar irgen qurimlan bükü-tür jolqaju undascu qurim-tur anu bawu(1)ba tede tatar tanin aju'u yisügei-kiyan ire'ei ke'et uridan-u dawuliqdaqsan kegesü-ben duratcu oyisuladun qujirju qoro qoliju ökci'üi ja'ura mawui otcu qurban qonoq yabuju ger-tür-iyen gürü'et mawui bolju "cekcer-ün sira-ke'er-e"[12] хэмээх газраас Ононы эх Бурхан халдун хавь нутагт очиход туулах зам урт юм. Эл хэсэгт "qonoq" гэсэн цаг хугацааны нэгжийг хэрэглэсэн боловч орон зайг хамтад илэрхийлжээ. Монголчууд цаг хугацааг морьтой, тэмээтэй,

үхэртэй хүний явах цагийн хэмжээгээр жил, сар, хоног, өдөр, шөнө, үд /их үд, бага үд/... гэхчлэн баримжаагаар илэрхийлж байжээ. Тэдгээрийн нэгэн хэмжээ нь "qonoq" болой. "qonoq" гэсэн үг "qurban" гэсэн үгтэй хоршсоноор алс хол гэсэн утга санааг илтгэжээ. Гэхдээ "qurban qonoq" гэсэн нь Есүгэй баатарын нутагтаа, гэр орондоо амьд хүрэхийн багцаалсан хугацаа ажээ. Тэгэхлээр "гурав" гэсэн тооны хүрээн дотор бол өөрийн гэсэн утгыг илтгэх, "гурав"-аас цаашилбал хүнийх болмуй гэсэн ойлголт байсан гэж бодогдоно. Тиймээс "гурав хоног" нь "qurban ne'ürit" гэдэгтэй адил өөрийн хүрээний дотор гэсэн утгатай ойролцоо санааг илэрхийлсэн гэж болно.

§ 90. niken üdür sirqa aqta-tan naiman mori[t] ger-ün dergede bayiju bükü-yi de'erme irejü üjetele de'ermetcü yorciba yabuqat üjejü qocorba belgütei oqodur dargi qongqor-i unuju tarbaqacilara otcu büle'e ... temüjin ügülerün ta ülü cidaqu bi nekesü ke'ejü dargi qongqor-i temüjin unuju sirqa aqta-tan-i ebesün-ü alurqai-bar mögcgijü qurban qonoju manaqar erte mör-tür olon adu'un-tur niken gürümele kö'ün gü'ün ge'ü sa'an aqu-yi jolqaju sirqa aqta-tan-i surabasu tere kö'ün ügülerün ene manaqar naran urququ-yin urida sirqa aqta-tan naiman mori[t] eüber hü [1] dejü yorciba mör inu bi ja'aju öksü ke'et oqodur qongqor-i talbi'ulju temüjin-ne oroq singqula-yi unu'ulba ... nökör ci bürün masi mungtaniju ayisu aju'u-ere-yin mung niken bui-je bi cimatur nökösesü ecige minu naqu-bayan ke'ekdeyü bi qaqca kö'ün inu bi bo'orcu neretü bui ke'e'et sirqa a[q]ta-tan-u mör-iyar inu mögcgijü qurban qonoju üdesi naran quburi tasin bükü-tür niken güri'en irgen-tür gürba sirqa aqta-tan naiman mori[t] tere yeke güri'en-ü kija'ar-a ebesülen bayiju bükü-yi üjeba temüjin ügülerün nökör ci ende bayi bi sirqa aqta-tan tede bui hü[1] dejü qarsuqai ke'eba bo'orcu ügülerün nökösesü ke'en








irele'e bi ende yekin bayiqu ke'et qamtu do[b] tulju oro'a[t] sirqa aqta-tan-i hüldejü qarba

Эл хэсэгт, нэгэнтэйгүүр, Тэмүжиний талаас үзвэл, эхний "гурав хоног" гэдэг нь түүний "нөхөр болъёо" гэсэн өөртөө туслах итгэлт хүмүүн - Боорчийг олж авч байгаа хугацаа, дараах "гурван хоног" гэдэг нь Тэмүжиний алдсан шарга агттан найман морио өөрийн болгон авах шаталсан хугацаа юм. Нөгөөтэйгүүр "дээрэм"-ийн талаас үзвэл, "гурав хоног" дээр -гурав хоног"-ийг нэмсэн буюу хоёр "гурав хоног"-ийн хугацаа бол /тоогоор илэрсэн орон зай бол/ дээрэм үл илрэх тийм алс орон зайн баримжаа байжээ. "Гурав

хоног"ийн хүрээний газар дотор дээрэм хийвэл баригдана, түүнээс цааших нутгаас авсан бол эс мэдэгдэх тул өөрийн болгоно гэсэн ойлголт байсан гэж үзнэ.

Үүнтэй холбож "Монголын нууц товчоо"-ны нэгэн хэсгийг тодруулан авч үзье.

§56. qurba'ula qoyinaca nekejü dolo'an quburi dabatala hüldejü qariju



irejü hö'elün-üjin-i yisügei-ba'atur delbegedece kötöljü nekün-taisi aqa inu uduritcu daritai-otcigin de'ü inu kiligü dergecejü ayisuqui-tur hö'elün-üjin ügülerün aqa minu ciledü kei ö'ede kegül-iyen keyisümser ke'er qajar-a ke'eli-ben ölösümser büliyi edo'e ker ele qoyar sibülger-iyen niken-te aru de'ere-yen o'orcu niken-te ebür-an de'ere o'orcu niken-te aruqsi-da niken-te qoyinaqsi-da ker ele kijü odumui ke'et onan-müren-ni tolkistala hoi jubur dawuristala yeke dawu-bar uyilaju ayisuqui-tur daritai-o[t] cigin dergecejü yabuju ügülerün teberigü cinu daba'at olon dababa uyila[q] daqu cinu usut olon ketülba qayila'asu qarayiju ülü üjegü cimayi qayibasu qa'ul[u]qa? inu ülü olqu ci sem boli ke'eju itqaba ho'elun-üjin-i yisügei tedüi ger-dür-iyen a[b]ciraba... хэмээн "dolo'an quburi dabatala" алслах орон зайг "гурав"-аас давуулан дүрсэлсэн бол Лувсанданзаны "Алтан товч"-д "qoyina-aca inu doloγan γurbi dabatala nekejü güyicen yadaju qariju ireged... dabaγ-a olan dababa: uyilaqu cin-u: usun olan getülbe..."[13] гэж бас адилхан өгүүлжээ.

"dolo'an quburi dabatala" гэсэн орон зай бол Чилэдүгийн хувьд амь эрсдэх аюулаас ангижрах, эргэж эс ирэхүйн, Есүгэй баатар нарын хувьд нэхэн хөөж үл гүйцэх, бараа туруугүй алга болох болгосны


илрэл юм. Үүнд л "dolo'an" гэсэн тооны утга учир оршино. Ер нь монгол домог зүйн сэтгэлгээгээр долоогийн тоо нь газар дэлхийн олон үе давхаргатай, газар доорхи ертөнцтэй холбогдох нь олонтаа. Үүнтэй уялдаатай гэмээр "Долоон уулын цаагуур, дов шороон доогуур" гэж хон хэрээ дуугарахад эдүгээ шившдэг нь нүдэнд үл үзэгдэх, чихэнд үл сонсдох газарт алга бол хэмээн алслах орон зайг долоотой холбон үздэг байсны ул мөр үлдэц мөн.

Гэтэл "Эрдэнийн товч"-д "...yeke ciledü buruγudun dutaγabai γurban γoul alus üldeged ö'olün üjin-i buliyaju yisügei baγatur beyedegen abuba... γurban γoul getülbe, γurban γurubi dababa..." [14] гэж "долоог" "гурав" болгон "даваат олон давава", "даваа олон давав","усут олон гэтлэв", "усан олон гэтлэв" гэдгийг "гурван гол гэтлэв", "гурван гуруби давав" болгожээ.

Энэ жишээ юу харуулж байна вэ? гэвэл "Монголын нууц товчоо"-нд бас "гурав" дээр "гурав" нэмсэн буюу түүнээс цааших тоогоор илрэх орон зайг алсын алс гэж үздэг байснаас "dolo'an quburi dabatala" гэсэн нь тодорхой байна. Үүнийг зөв ухаарснаас Лувсанданзаны "Алтан товч"-д "Монголын нууц товчоо"-ны бичлэгийг даган давтжээ. Гэтэл "Эрдэнийн товч"-ийн зохиогч "гурав"-аар бүгдийг сольсон нь хэзээ ч эгэж ирэхгүй алс одсон гэдэгт "долоо"-гийн тоог зориуд хэрэглэснийг эс анзаарчээ гэж үзэж болно. Ер нь "гурав" гэсэн тоог цаг хугацааны нэгжтэй холбож "гурван жилийн тэртээ", "гурван сарын газар" гэхчлэн орон зай, цаг хугацааг илэрхийлэх нь монгол үлгэр, баатарлагийн туульс"[15] зэрэг ардын аман зохиолын эртний үүсэл бүхий төрөл зүйлд ихээхэн дэлгэрсэн ажээ. Тэгэхдээ "гурав"-ын тоог баатрын дүрийг улам тод болгоход өргөн хэрэглэдэг байсан уламжлал нь "Монголын нууц товчоо"-ны цөөн бус жишээнд харагддаг билээ.

§ 195. ... sile=melcejü qusi'uraju ayisqun ken buyu ke'en tayang-qan jamuqa-daca asaqcu'u jamuqa ügülerün ene ayisqu temüjin anda minu gü[b]cin beye inu siremü-'er sirekdeksen sibüge-de qatququi-a cölö üge[i]ü temür-iyer dabtaqsan tebene-de qatququi-a cölö üge [i]u temüjin anda minu öyeseksen sibawun metü eyin sile= meljen ayisu-lu üjebe-yü'ü ta naiman nököt mongqol-i

üje'esü esige-yin qodu ülü hüle'ülkü-ece büle'ei ta üjetkün ke'eba ene üge-tür tayang-qan ügülerün amsa'ari a'ula abarin baiya ke'ejü a'ula abariju bayiju'u basa




tayang-qan jamuqa-daca asaqurun basa tere qoyinaca juja'an-a ayisuqun ken buyu ke'en asa[q] ba jamuqa ügülerün hö'elün-eke niken kö'ü-ben gü'ün-ü miqa-bar teji'ejü büle'e qurban alda beyetü qunajin bodo idesitü qurban dabqur quyaq emüscü qurban buqa jitgü'üljü ayisu-je qortu gü'ün-i qotola-yi jalgi'asu qo'olai-dur-iyan ülü tordayu gübcin ere-yi emgü'esü öre ülü jasayu a'urla'asu angqu'a sumu-ban delijü talbi'asu a'ula alus bükün harban qorin haran-i ülgetele qarbuyu gereldüksen nökör-i ke'er ketüs bügün-i keyibür sumu-ban delijü talbi'su kelkitele ülketele qarbuyu yeke-de delijü qarbu'asu yisun ja'ut alda qajar-a qarbuyu tatan delijü qarbu'asu tabun ja'ut alda qajar-a qarbuyu gü'ün gü'ün-nece busu gürölgü mangqus töreksen joci-qasar ke'ekdeyü tere buyu-je ke'ejü'üi tende-ece tayang-



qan ügülerün ele teyin bö'esü a'ula-yin ündür temeceye de'eksi abaritqun ke'ejü a'ula abarin bayiba ...

Өндөр уулын орой дээрээс тулалдааныг харж байхдаа Найманы Таян-ханы "хэн айсуй вэ?" гэсэн асуултад Тэмүжин /Чингис/, түүний хөлөг баатруудыг Жамуха дэс дэсээр танилцуулан хариулж "үгээр үхтэл сүрдүүлж, амаар айтал сандаргаж" байгаа хэсэг энэ. Монгол ардын үлгэр, баатарлагийн туульсад мангасын дүр төрхийг дүрсэлдэг тэрхүү хэтрүүлэл давууллын аргаар Тэмүжин, түүний хөлөг баатруудыг Жамуха дүрслэн өгүүлсэн ажээ. Тэрхүү хэтрүүлэл давууллын арга гэдэг нь уул баатруудыг аваргуу том биетэй /qurban alda beyetü - гурван алд биет/, их ховдог хомхой /qunajin bodo idesitü - гунжин бод идэшт/, тэр ч атугай хүн амьтныг бүхлээр нь залгидаг /qortu gü'ün-i qotola-yi jalgi'asu qo'olai-dur-iyan ülü tordaya gübcin ere-yi emgü'esü öre ülü jasayu.../, маш нүсэр хүнд /qurban buqa jitgü'ulju-гурван бух зүтгүүлж/ гэхчлэн онцлог шинжийг нь хэт товойлгон дүрсэлснийг өгүүлж байгаа болно. Тэдгээр баатар бол Таян-хан, Жамуха нарын үүднээс үзэхэд эсрэг дайсных нь, Чингисийн талаас үзэхэд өөрийнх нь хөлөг баатрууд билээ. Чингэж эсрэг хүчнээр нь нөгөө талын баатруудын сүр хүчийг магтуулах нь их оновч мэргэн арга болой.

§ 80. temüjin siqui dotora qurban qonoju qarsu ke'en mori-yan kötöljü ayisuqui-tur morin-aca eme'e[l] inu mültürejü qocorcu'u qariju üje'esü eme'el kömüldürgelekse'er olangla[q]sa'ar mültürejü qocorcu'u olang-ci boltuqai kömüldürge basa ker mültüregü büle'e tenggeri i [t] qan aqu-yu ke'ejü qariju basa qurban qonoba basa qarcu ayisuqui-tur siqui-yin amasar-a qosili[q]-un tedüi caqan gürü amasar-a bö[k]len unaju'u tenggeri itqan aqu-yu ke'ejü qariju basa qurban



qonoba yisün qonoq i'de'en ügei aju nere ügei ker ükü[k] dekü qarsu ke'ejü tere amasar böklen unaqsan qosiliq-un tedüi caqan gürü horcin qarbasu ülü bolqu modud-i sumuci kituqai-[ba]r-iyan hoqtori'at mori-yan qaltari'ulu'at qarqui-lu'a tayici'ut sakiju aju'u bariju abcu otba...

Эл хэсэгт, Тэмүжин шугуй дотор Тайчуудаас нуугдаж гурвантаа гурав хоносон нь "тэнгэр ятгаж аху юу" гэж зөн совиндоо бат итгэж байснаас болсон болой. Шугуйгаас гарахаар завдаад буцсаны дараа "гурав хоног" болдог нь Тэмүжиний итгэл үнэмшилд "гурав"-ын тоо хичнээн хүчтэй байсныг, бас нэгэн удаагийн тэсвэр алдрах хугацаа "гурав хоног"-оор хязгаарлагдаж байсныг гэрчилнэ.

Дээр ишлэл татсан хэдэн жишээнээс үзэхэд XIII зууны үед буюу түүнээс ч өмнөх үед монголчуудын сарын доторхи цаг хугацааны үндсэн баримжаа нэгж бол "гурав" /хоног/ байжээ гэсэн дүгнэлт хиймээр байгаа юм. Түүний ул мөр, дараачийн зуунуудад хадгалагдаж байснаас нэгийг жишээ болгон татвал ийм буюу. "...Тэрбээр шинийн нэгнээс арван таван хүртэл цагаан зүг...Шинийн нүүр, зүгийн анхан болой. Арван зургаанаас битүүн хүртэл улаан/хар/ зүг хуучины нүүр болой... Хавар, зун, намар, өвөл тэр нижгээд бүр дор эхи, дунд, адаг гурван гурван болой. Цагаан зүг дор огторгуй, хий, гал, усан, шороо нугуд /нууд/ гурван эргэмой. Хар зүг дор шороо, усан, гал, хий, огторгуй нугуд

/нууд/ гурван эргэмүй..."[16] хэмээн "Мэргэд гарахын орон нэрт даяг" /1742/-т дурдсан билээ. Эл дурдсанаар тооцоолон 15-ыг гурван өдрөөр /хоногоор/ хуваахад нэгэн сар буюу 30 хоног нь тав таван /арван/ "гурав-" т болдог ажээ.


2

Хүн зон, байгальтай, түүний элдэв үзэгдэлтэй харилцах явцдаа сүр хүчинд нь автах, итгэх, улмаар шүтэх бишрэх нь олонтаа байжээ. Монгол туургатны хувьд байгалийг шүтэх явдал үлэмжхэн байв. Үүнд гал тахихад "Бэр нь хонины сүүлний өөхнөөс гурван хэрчмийг авч галдаа өргөн гурав мөргөнө"[17], овоо тахихад "дөрвөн талд нь арцаар сан тавиулна. Сангийн тавиурын чулуу нэг зүгт 3х3=9 чулуу байна"[18], "Цацлын дараа бүх харчуул урьд өндрийн тэнд урагш харж хормойгоо дэвсэн суугаад гурав мөргөнө.,. Овоо тахилга дуусмагц бүх хүмүүс овоогоо нар зөв гурав тойроод явцгаана"[19],"Бөө болох хүн өөрийн гэрийн урьд талд хоёр тохой урт гишүү навчтай 3х9=27 ширхэг хус мод авчирч өмнө зүг харуулан 9,9-өөр нь цувуулж суулгана"[20], "Бөө бөөлөхөөсөө өмнө есөн хар, есөн цагаан чулуу усанд хийж буцалгаад нүүр гараа угаадаг нь биеэ ариутгаж олон онгодын бууж ирэхэд саад тотгоргүй, хир буртагтүй цэвэр болгож байгаа хэрэг юм"[21]. Чухам чингэж эрт дээр үеийн уламжлалыг ямар нэгэн хэмжээгээр хадгалсан гал тахих, уул ус овоо тахих зан үйлийг ёслоход болон бөө мөргөлийн ёс горимд "гурав"-ын тоог,"гурав"-ыг хэдэнтээ үелэн давтаж олшруулсан /3х3=9, 3х9=27, 9х9=81 гэх мэт/ тоог эрхэмд тооцон хэрэглэж иржээ. Монголчууд "өвлийн туйл" гэгдэх "өвлийн нар буцсан" өдрөөс /монгол нутагт хамгийн урт шөнө, хамгийн богино өдөр тохиодог 12 дугаар сарын 22-ноос/ эхлэн есөн ес наян нэг хоногийн хүйтэн /балчир гурван ес, идэр гурван ес, хөгшин гурван ес гэж гурав хуваадаг/, "зуны туйл" гэгдэх "зуны нар буцсан" өдрөөс /монгол нутагт хамгийн урт өдөр, хамгийн богино шөнө тохиодог 6 дугаар сарын 22-ноос/ эхлэн есөн ес наян нэгэн хоногийн халуун болдог гэж үзэж, тэдгээрийг "ес"

хэмээн нэрлэсээр ирсэн ажээ. Эдгээр жишээн дээр өмнөх хэсгийн /1/ сүүлчээр иш татсан §80 зүйлд Тэмүжиний шугуйд хоноглосон "qurban qonoju", "qurban qonoba", "qurban qonoba" гэдгийг нэмж "basa yisün qonoq" болсон хугацааг тооцвол "3+3+3=9" гэсэн томъёолол болно.

Дээр дурдсан жишээнээс үзэхэд "гурав"-ын тооны олшруулсан /нэмсэн хийгээд үечлэн давтсан/ хэлбэр "ес" мөн. Тиймээс "ес"-ийн тоонд "гурав"-ын утга бэлгэ хадгалагдахын хамт "ес"-ийн бие даасан шинж ч агуулагдах ажээ. Лувсанданзаны "Алтан товч"-д улирч ирсэн "Гурван зуун тайчуудыг дарсан домог"-т "ejen jarliγ bolurun: yerü aliba jüg-ece dayisun bolquy-a medege ügei yisün sayid manu ta γurban qubi bol gejü jarliγ bolba"[22] гэснээр Зэлмэ, Чуу мэргэн, Шихихутаг гурав нэг хуби, Боорчи, Борохул, Мухулидай /Мухали/ гурав нэг хуби болж, Сүлдүрдайн Торгон шар, Бэсүтэйн Зэбэ, Ойрадын Хар Хиру гурав нэг хуби болж гэрт суусан ажээ. Энд ес нь гурав, гурав гурван хуби болон "9:3=3" задарч байна. Ингэж гурав, гурваар нэгэн хуби болгон дайсан хортноос сэргийлэх баг болгодог байсан нь "Монголын нууц товчоо"-д

§142. ong-qan-ni ire'ülü'et cinggis-qahan ong-qan qoyar qamtutcu jamuqa-yin esergu inu morilaya ke'eldüjü kelüren-müren huru'u morilarun cinggis-qahan altan qucar daritai qurban-i manglai yabu'ulba ong-qan senggüm jaqa-gambu bilge-beki qurban-i manglai yabu'ulba ede manglan-aca uruqsi basa qara'ul ilerün enegen-güiletü-de niken sa'urin qara'ul talbiba te'ün-ü



cinana cekcer-e niken sa'urin qara'ul talbi'ulba te'ün-ü cinana ciqurqu-da niken sa'urin qara'ul talbi'ulba гэж тусгагдсан байжээ. Эл жишээнээс үзэхэд "ес"-ийн тооны хуваагдсан /хуваасан хийгээд үечлэн хассан/ хэлбэр "гурав" болж эргэх нь бий ажээ. Тиймээс "гурав"-ын тоонд "ес"-ийн утга бэлгэ бас хадгалагдахын хамт "гурав"-ын бие даасан шинж бүрнээ агуулагдах нь зүй юм.

"Ес"-ийн тоо монгол хүний нэгэн насны амьдралын зан үйлд бэлгэ тэмдэг болон түгээмэл хэрэглэгдэж байсныг Тэмүжин /Чингис/, түүний ар гэрийн аж төрөлтэй холбоотойгоор "Монголын нууц товчоо"-нд үзүүлжээ. Тэмүжиний есөн настайд /§61,94/ эцэг Есүгэй баатар "охин гуйх"-аар түүнийг аваад Олхонуд иргэн рүү одсон нь монголчуудын дотор эрэгтэй хүүхдийг /хүүг/ ес хүрэхлээр §66 "güreget-te talbiju"/хүргэтэд талбиж/ хожмын эхнэр болох охиныг нь үзүүлж нэгэн дор хамт байлгаж дасгаж өсгөж торниулах ёс байсны жишээ юм.


Энд дурдсан "ес" бол "арав"-ын доторхи тооны хамгийн олонлог нь боловч ураглах ёстой холбон бодохлоор "хүүхэд" насанд багтах төлөөлөл тодотгол юм. "Хүний амьдралын насыг хүүхэд, залуу, хөгшин гэж ерөнхийд нь гурав хуваах боловч нялх, балчир, хүүхэд, өсвөр, залуу, ид /орь Д.Ц./ залуу, идэр, ахимаг /хижээл/, азай буурал гэсэн 9 үе болгон ангилж"[23] үздэг ажээ. Есөн үе болгон ангилсны "хүүхэд" насны хүрээнд хамааруулж болох "yisün nasutu" хэмээх дээрхи тодочлол нь цаанаа утга бэлгэдэл хадгалсан юм. Үүнд: Хүний бие эрхтэн 12 жилийн хүрээнд багтах хамгийн өндөр давтамж есөн жилд нэгэн удаа өөрчлөгддөг гэх нь бий. Тэр ёсоор бол "хүүхэд" насны хүрээний "есөн нас"-д эр бие тэнхээжиж явааг гэрчлэх "цусан чөмөг" суудаг гэх нь бий. Түүнтэй холбоотой ч том болохоор 3 ба 5 настайд нь "даахь үргээх"-д тавьсан "шибэлгэр" "хөхөл"-ийг 9 нас хүрэхлээр нь "гээг" болгодог тохиол Монголын баруун нутагт үлдсэн байжээ. Энэ бүхэнтэй холбон бодвол "yisün nasatu" хэмээсний утга учир, бэлгэ бэлгэдэл эрхбиш тодорно вий. Тэгэхлээр "Есөн нас" нь эрхбиш өөрийн эцэг эхээс холдож худ ураглах айлд очиж

хожмын "бэр"-тэйгээ танилцахад гэрээ бэтгэртэл санах "нялх, балчир"-ийн үе хараахан биш гэдэг нь ойлгомжтой юм.

Есүгэй баатарын оромж шарга агттан есөн морьтой байсан нь "§77... bekter hulqun de'ere sirqa-aqta-tan yisün mori qaraju sa'u büküi-tür..." § 90... niken üdür sirqa aqta-tan naiman mori[t] ger-ün dergede bayiju büküi-yi de'erme irejü üjetele de'ermetcü yorciba yabuqat üjejü qocorba belgütei oqodur dargi qongqor-i unuju tarbaqacilara otcu büle'e... гэж өгүүлснээс тодорхой юм. Энэ хоёр хэсгийн "sirqa aqta-tan"-ы тоо нь "yisün", "naiman" гэж зөрөөтэй мэт харагдана. Гэвч §90-д Есүгэй баатар агсны гэрийн дэргэд байсан



шарга агттан найман морийг дээрэм авахад Бэлгүтэй "oqotur dargi qongqor"-ыг унаж явсан билээ. Тэгэхлээр алдагдсан "шарга найман агттан"-ы дээр үлдсэн "оготор дарги хонгор"-ыг нэмэхэд "есөн" болж байгаа юм. Тийм болохлоор "sirqa aqta-tan naiman" гэдгийг дээрэм авсантай холбогдуулан өгүүлэхээс Тэмүжин /Чингис/ "шарга агттан найман" бүхий байсан гэж үзэж бичихийн үндэслэл нь юу вэ?



Есөн агтыг нийтэд нь зүс нэгтэн хэмээн үзсэн нөхцөлд Бэлгүдэйн унаж явсан "dargi qongqor"-ын зүс нь "sirqa"-ын хүрээнд хамарч болох тал байгааг гаргаж миний бие хоёр зүсийг шингээсэн агтын "sirqa", "qongqor" нь нэн ойр хонгор шарга гэсэн зүс байдаг тухай бичиж тайлбар[24] хийж байсан юм. Энэ нь хонгор шарга зүсний хувьд угтаа үндэслэлтэй билээ. Үүнд: шарга гэдэг нь шар, цагааны хослол, хонгор гэдэг нь шаравтар, цагаан шаргалын хослол, давхар зүс мөн. Шарга нь дотроо ухаа шарга, улаан шарга, загал шарга, шар шарга, цагаан шарга, улбар шарга, шаргал шарга, бор шарга, хүрэн шарга, хул шарга, хулсан шарга, толбот

шарга, халуун шарга, бэлүү шарга, хонгор шарга, хонгор нь дотроо цагаан хонгор, шарга хонгор, ухаа хонгор, халуун хонгор, зээрд хонгор... мэтчилэн бүр нарийвчлан тодотгон хуваагдах нь бий.[25] Үүний хамт "Шарга агттан есөн морь уу?" Есөн шарга агт уу? гэсэн тодотгол асуулт гарна. "Хураангуй алтан товч", Саган сэцэний "Эрдэнийн товч", Жамбын "Асрагч нэртийн түүх", Мэргэн гэгээний "Алтан товч", Жамбадоржийн "Болор толь" зэрэгт болон Ц.Дамдинсүрэн, Мансан нар монголоор бичих хөрвүүлэхдээ, А.С.Козин орос хэлээр, Ф.В.Кливез англи хэлээр П.Пеллио франц хэлээр орчуулахдаа "найман шарга агт", "есөн шарга агт" хэмээн авч үзжээ. Гэтэл "агттан" гэдэг үгэнд түүний "tan" (тэн) дагаварын утга, үүрэгт ач холбогдол өгч Мин улсын эхэн үеийн "Монголын нууц товчоо-ны орчуулгад", мөн эрдэмтэн Цэнд гүн, Баяр, Элдэнтэй, Ардаажав, Иринчин, Ш.Гаадамба, Б.Сумъяабаатар, Д.Цэрэнсодном монголоор тайлбарлах хөрвүүлэхдээ, Ахмет Темир туркээр, В.Хайссиг германаар, С.Калужинский польшоор, Ш.Озава японоор орчуулахдаа "шарга агттай найман морь" гэсэн утга гаргажээ. Дурдсан олон судалгаа орчуулгыг харьцуулж нарийвчлан шинжлээд Ш.Чоймаа "шарга агттан" гэдгийн "шарга"-д олон тооны дагавар залгаагүй байгаа нь "Нэг шарга агт байсны гэрч " гэж үзээд "нэг онгон шарга бүхий найман морь" байсан гэж нотолсон[26] юм. Үүнтэй холбогдуулан өгүүлэхэд малчин монголчууд сүргийн онцгой зүсээр нь, тухайлбал азаргатай адуу бол түүний зүсээр, шинжээр нь, эсвэл содон нэгнээр нь нь цохон нэрлэдэг уламжлалтай. "Хонгор азаргатай адуу", "Алагтай таван морь", "Шаргатай есөн адуу" мэтээр хүний анхааралд өртөхүйц зүсээр нь цохон адуугаа эрж сурагладаг тогтсон зуршилтай. Хэсэг бусаг адуу малтай таарсан малчин хэн нэгэн, тэдгээрийн дотор содон зүс, онцлог шинж юу байна вэ гэдгийг заавал анзаарч "Уулын хярд шаргатай арван морь байна билээ", "Модны захад зүүн талын шийр цагаан хонгортой хэдэн морьд хоцорно билээ" гэхчилэн эрэлчинд хариу хэлэх нь олонтаа. Тийм болохоор "шарга" гэдэг нь тэнгэрийн

хүлгийн содон зүс, нөгөөтэйгүүр "онгон буюу сэтэрлэсэн" байж болох тул бүр ч түүнийг онцлох нь аргагүй. Есөн адууг "хонгор"-ын онцгой содон зүсээр цохон төлөөлүүлээгүйн нь цаад утга учир нь үүнтэй холбоотой байж мэднэ.

Тэмүжин шарга агттан есөн морьтой байсан гэдэг нь тэнгэр язгууртай гэсэн удмын гаралтай нь холбож тэнгэрийн есөн хүлэг байдаг гэсэн домгийн сэтгэлгээний улбаатай уялдаатай гэж үзэж болно.


Үүнтэй холбогдуулан "... ямагт эрдэмт хүлэг морийг 8 хөлтэй гэж тодотгосон байдгаас үзвэл 8 хөлтэй малыг өсөхийн тэмдэг гэж бэлэгтэй тоонд тооцдог байжээ. Найман ес далан хоёр болдог бөгөөд өсөх төлжихийн билэг тэмдэг наймыг тэнгэрлэгийн тоо ёсоор /есөөр Ц.Д/ үржүүлж тэнгэрийн адуун сүргийн тоог далан хоёроор бэлэгддэг байв"[27] гэсэн монгол эрдэмтний ажиглалтыг дурдаж болно. Ийм тооны тод жишээ бол "Цуутын цагаагч гүү" үлгэрт далан хоёр ижил , дархан хул азарга гардаг явдал юм.

Монголчуудын хувьд "ес"-ийн тоо нь тэнгэрийг шүтэн бишрэхтэй холбоотой гэж үзнэ. Монголын бөө мөргөлийн ёсоор бол дээд шүтээн нь тэнгэр юм. Бөө мөргөлийн домогт үздэгээр 99 тэнгэртэй. Барууны 55 тэнгэр, зүүний 44 тэнгэр орчлон ертөнцийг хуваан захирдаг хэмээн бөөгийн мөргөлд үздэг. Тэнгэр бол амьдрал хайрлагч эр эхлэл буюу зайран, газар бол түүнд хэлбэр дүрс хайрлагч эм эхлэл болдог буюу этүгэн эх /удган/ ажээ . Тиймээс Чингис хааны дээд язгуур нь "дээд тэнгэрээс заяат төрсөн" /§1/ ажээ. Түүнийг Чингисийн анд шадар төдийгүй хожим дайсан болж салалцсан Жамуха мэт /§ 201/ нь ч зөвшөөрөн хүлээдэг юм. Ер нь Тэмүжиний /Чингисийн/ мандах буурах бүхий л хувь тавилан тэнгэрийн ивээл, тэнгэрийн хүчээр болдог гэсэн ойлголтыг "Монголын нууц товчоо" олон жишээ баримтаар харуулахыг оролдсон юм. § 80 зүйлд шугуйд бүгж байгаад гарах гэснээ тэнгэрийн ятгалгад орж "ес" хонож байснаа "nere ügei ker ükü[k] dekü qarsu" гэж шийдсэн нь үнэндээ тэнгэрийн

ятгалгыг зөрчсөн хэрэг юм. Чингэж тэнгэрийн зарлигийг зөрчсөнөөр Тэмүжин сайнаа үзсэнгүй Тайчуудад баригдсан юм. Энэ бол Тэмүжинг тэнгэрийн зарлигийг хэзээ ч зөрчиж болохгүй гэдгийг бодитойгоор үзүүлсэн жишээ юм. Тэмүжин, тэнгэрийн тааллыг дагагчдыг өргөж, тэнгэрийн тааллыг сөрөгчдийг гэсгээж байгаа гэж өөрийн хийсэн үйл хэргийг зөвтгөдөг нь бүхий л амьдралын замналаар нь батлагдаж байгаа юм. Чингис, түүний залгамжлагчид бөө мөргөлийг ихэд шүтэж бөө, мэрэг төлөгч, зурхайчдын айлдсаныг гол төлөв үг дуугүй гүйцэтгэдэг байв. Чингисийг улсын хаан болгоход нь их үүрэг гүйцэтгэсэн Хунан, Хөхөчос, Дэгэй, Үсүн өвгөн, Хорчи нарын гавъяаг үнэлж мянгатын ноёдоор өргөмжилж, Үсүн өвгөнийг "beki" болгон /§216/ "дээд сууринд сууж он сарыг олж сонгож байтугай" хэмээн зарлиг болжээ. Чингисийн хөвгүүн Өгэдэй хаан хятад иргэнд байлдаж бүхийд өвчин хүрсэнд "хятадын газар усны эзэд хилэгнэсэн тул ойр төрлийн хүнээс золио болгох"-ыг бөө төлөгчин нар зааж мэргэлж төрсөн дүү Толуйг нь золиосонд гаргуулсан нь бөө нарын ямар их хүчтэй, эрх дархтай байсны гэрч юм. Харин Хөхөчү Тэв-Тэнгэр бөө олон иргэн /есөн хэлтэн/ -ийг өөртөө дагуулж /§ 244, 245/, Хасарыг зодож, Отчигиныг өөртөө сөгдүүлж, бас элчийг нь балбаж, ах дүүсийн хооронд яс хаяж эвдрэлцүүлэх гэсэн учир "тэнгэрийн таалалд эс нийцжээ". Чингис хаан өөрөө бөө мөргөлийг шүтэгч байсан тодийгүй дал шатааж мэргэлдэг байсан билээ. Ер нь Хүннү зэрэг эртний монгол удам угсааны аймгууд бөө мөргөлтэй байж, эзэн хаанаа "тэнгэрийн хөвгүүн" хэмээн өргөмжилдөг байсан нь XIII зууны үед ч гэсэн уламжлагдсаар байсан юм. "Тэнгэрийн ивээлээр суусан", "Тэнгэрийн хүү" /Шаньюй/ гэх тогтмол хэллэг нь чухам Хүннүгийн бөөгийн шашны ганц бурханизмын тод илрэл" [28] гэж үзэж байснаа гүнзгийрүүлж Г.Сүхбаатар "Бөө мөргөлийн үүднээс Тэнгэрийн хүү гэдгийг тайлбарлах аргагүй... үүнийг тайлбарлах сургаал байхгүй" гээд "Алтан гэрэл" зэрэг хөлгөн судар болон бусад эрдэмтдийн үзэл бодолтой санаа нэгдэж "Тэнгэрийн хүү"

гэдэг хэллэг нь бурхны шашны хэллэг мөн болох нь эргэлзээгүй"[29] гэж үзжээ. Энэ бол мэдээжээр нэгэн эрдэмтний өөрийн гэсэн үзэл бодлоо дорно дахины нөлөөтэй холбож гүнзгийрүүлсэн тайллага гаргалгын нэгэн мөн. Үүний зэрэгцээгээр зохиогчоос өөрийн бүтээлдээ "1984 оны сүүлчээр нийтлэгдсэн 6 боть философийн том толины хятадын философийн түүх гэдэг ботид тэнгэрийн хүү /Тяньцзы/ гэдэг ухагдахууныг хятадын философийн аль нэг урсгалын онолын үүднээс тайлбарлаагүй, харин Монгол угсаатны тэнгэр эцэг, дэлхий эх гэдэг хэллэгтэй холбон харин нэгтийн тайлбар толиноос... иш татан Чингис түүний дээдсийг тэнгэрийн хүү гэдэг гэжээ[30] хэмээсэн баримт дээрээ тогтож эрэгцүүлсэн бол өөр ойлголт ухаарал ч төрөх байсан юм биш биз ээ. Монголчуудын үзэл бодлын эртний ул мөрийг ямар нэгэн хэмжээгээр гүн бат хадгалсан аман түүх, аман бүтээл, домог, үлгэр, туульсад "тэнгэр эцэг", "тэнгэр эцгийн хөвгүүн" гэхчлэн гардаг хэллэг ойлголттой холбон авч үзвэл бас нэгэн шинэ дүгнэлтэд хүрч болохгүй гэх магадлал байхгүй билээ! Монголчууд тэнгэр, нар сар, уул ус, ой модоо эзэнтэй гэж үзэж түүнд цацлаа өргөн тахилга үйлдсээр байсныг "Монголын нууц товчоо"-нд хэдэнтээ дурсэлсний нэгийг иш татъя.

§103. temüjin tede qurban merkit maqat geyit-tür-iyen ajiraba-yu bükcü-'ü amui ke'en belgütei bo'orcu jelme qurban-i





merkid-ün qoyinaca uqa'uta qurban qonoq daqa'ulju merkid-i küngke'üljü temüjin burqan de'erece bawuju ebce'ü-ben mö'eletcü ügülerün qo'aqcin-eke-yi solangqa bolju sonosqu-yin tula ünen bolju üjegü-yin tula büdün beye-'en buru'udun bugiya moritu buqu-yin horum horumlaju burqasun ger gerlen burqan de'ere qarula'a burqan-qaldun-a bö'esün-ü tedüi amin-iyan bulji'uldaba bi qaqcaqan amin-iyan qayiralan qaqca moritu qandaqai-yin horum horumlaju qalqasun ger gerlen qaldun de'ere qarula'a bi qaldun-burqan-a qarca-yin tedüi amin-iyan qalqalaqdaba-je bi masi ayu'uldaba bi burqan-qaldun-i manaqar büri maliyasuqai üdür büri öcisügei uruq-un uruq minu uqatuqai ke'en naran esergü büse-ben güjü'ün-dür -iyen erigelejü maqalai-ban qar-tur-iyan se'ejigelejü qar-iyan e[b]ce'ün-dür-iyen mö'ele[t]cü naran [juk] yisün-te sögö[t]cü saculi öci'üli ö[k]ba...

Тэмүжиний сүсэг бишрэлийг их тодорхой зурагласан эл хэсэгт "yisün-te sögö[t]cü saculi öci'üli ö[k]ba" гэсэн хэллэгийн утгыг тодруулбал ийм буюу. Нэгдүгээрт, "yisün-te sögö[t]cü" гэдэг нь гурван үе сөгдөж, сөгдөх тоолон гурвантаа мэхэсхийх мөн гурван үе босох ёслол болой. Хоёрдугаарт, "saculi öci'üli ö[k]ba" гэдэг нь гурав гурваар эгнүүлэн ес цоолсон нүхтэй цацалаар дээжлэн өргөдөг болой. Эл хоёр тодруулгаас үзвэл уул усыг тахиж сөгдөж мөргөх, цацал өргөх зэрэг нь "ес"-ийн тоотой холбоо бүхий монголчуудын эртнээс уламжлал болон тогтсон хэвшил юм.

Тэнгэрээ, байгаль дэлхийгээ тахих шүтэх ёс, ардын зан үйлд олонтаа бэлгэдэл болгодог байсан "ес"-ийн тоог улс гэрийн төрийн ёслол хүндэтгэл мэтэд ч басхүү хэрэглэж байжээ. Аливаа улс гэрийн оршин байх , цэрэг дайчдын сүр хүчийг бадруулах цог хийморь гэж байдаг болой. Эцэг дээдсээс Чингис хаанаас улс гэрээ төвхнүүлэхэд тийм төрийн бэлгэ тэмдэгийн нэг нь сүлд туг байв.

§73 ...hö'elün-üjin gejü newükderün tuqlaju beye-ber morilaju jarimut irgen-i icuqaba...
Есүгэй баатарыг таалал төгссөний дараа хураасан улс нь тарж нүүхэд Чараха өвгөн одогсдыг ятгавч үгэнд нь эс ороод /зоо нуруугаа жадлуулсанд/ Өэлүн-үжин ийнхүү "tuqlaju" /туг барьж/ мордоод орхиж нүүсэн иргэдийн заримыг түр буцааж авчирчээ. Энэ бол эцэг дээдсээс уламжлалтай туг сүлдийн ач аврал юм.







§ 202. tedüi sisgei to'urqatu ulus-i sidurqutqaju bars jil onan-nu teri'ün-e quriju yisün költü caqa'an tuq bayi'ulu'at cinggis-qahan-na qan nere tende ökba гэжээ. Тэрхүү "yisün költü caqa'an tuq" нь хамаг монгол улсын сүлд байсан бөгөөд гал барс жил /1206 онд/ Чингис хаанаас тулгуур төрийг зарлан тунхаглахдаа түүнийг уламжлан өргөн мандуулсан билээ.

Цагаан сүлд туг нь эцэг малын сүр сүлд дэл сүүлэндээ бий гэх тул мянган азарганы /мянган адууны гэлцэх удаа ч бий/ хөхлөөр /дэл сүүлээр гэлцэх удаа ч бий/ манжлага цацаг хийсэн хялгасан туг болно. Монгол улс гэрийн төрийн үйлс ариун гэгээнээр мандан бадрахын бэлгэдэл "Есөн хөлт цагаан туг"-наа шингэсэн болой. "Есөн хөлт цагаан туг"-ийг хааныг ширээнд залах, их хурилтай хуралдах зэрэг төрийн их ёслолд мандуулж байв. Туг сүлдийн тоог "ес"-өөр авсан нь Чингисийн удам "тэнгэр язгуурт" гэж үздэг тул "тэнгэрийн тоо" гэгдэх "ес"-ийг онцолсон авай.

Чингис хаан ширээнд сууж улсын эзэн болуутаа л "өмөг түшиг,нөмөр нөөлөг" болж явсан нөхөддөө ачийг нь бодож соёрхол өгөн "yisün aldal-tur bu aldatuqai", "yisün aldal alda'asu ere'ü-tür bu orotuqai" /§203, 205, 211, 214, 219.../






хэмээн зарлиг болжээ. Чингэж есөн алдаа ослоос хэтрүүлэхийг тохиолдлын тоо хэмээж болохгүй бөгөөд есөнтөө өршөөл үзүүлэх нь "тэнгэрийн ивээл" гэх бэлгэдлийн утга хадгалсан давтамжийн нэг болой. Ер нь Тэмүжинийг хаан ширээнд залах ёслолд "ес"-ийн тооны бэлгэдэл олонтаа давтагдаж байсан гэж хожмын түүхчид, уран бүтээлчид бичиж үлдээжээ. Тухайлбал В.Инжаннаши /1837-1892/ "Хөх судар"-таа: "Уул давшин далай нүүх мэт Онон мөрний эх дор чуулганаа эчих /очих/ их бага улс аймгууд мөн цөм нэгэн ч хоцорлолгүй хамтаар нүүж эчив /очив/... Бас олон аймгуудыг есөн мянга есөн зуун ерэн есөн хүрээ зохион буулгаж... есөн түмэн есөн зуун ерэн есөн цэрэг, есөн өнгийн хуяг дуулга, туг далбаагаар хуваан зогсож..." "есөн манжлагат цагаан тугийг" өргөн гэх мэтээр дүрсэлж "арга үгүй нүүр биеийг ариутган шинэ ариун алтан луугийн хувцад, эрдэнийн бүс халан бүсэлж, тэргүүн дор есөн луут суварга адил оройт титэмт малгай, чихэн дор сувд шигтгэсэн алтан гархи, хүзүүн дор есөн эрдэнэсийн хоолойвч, хөл дор уул усны гутал өмсч залран гарч ирэв... " мэтчилэн "Тэнгэр газарт хүж зул шатааж ёслол мөргөв" [31] гэхчлэн эрдэнийн ширээнд залсан, "тэнгэрийн хүү"-гийн суудалд суулгасан түүхэн ёслолыг түүний дотор төрийн бэлгэдэл, эзэн хааны бэлгэ тэмдэгийг тодруулан бичжээ. Энэ нь хэдийгээр уран сайхны нэмэр чимэг орсон байж болох боловч "тэнгэрийн хөвгүүн" "тэнгэр язгуурт хүн" гэх санааг нь "ес", түүний өсгөн нэмэгдүүлсэн тоонуудтай холбож илтэд гүнзгийрүүлсэн ажээ.


Ийнхүү "гурав", "ес"-ийн тооны утга бэлгэдэл нь "есөн ес наян нэгийн бэлэг","есөн цагааны бэлэг" зэрэг нэртэйгээр хожим хойчийн үед монгол угсаатны дунд өргөн дэлгэрсний үндэс дэвсгэр болсонд түүний цагийг туулан амьдрах чадвартайн нэгэн уг сурвалж оршиж байна.

"Монголын нууц товчоо"-ны дотор олонтаа гардаг тооны нэг нь "тав" болой. Түүнээс зарим жишээ татъя.

§ 19. qabur niken üdür köngsilemel qonin cinaju belgünütei bügünütei buqu-qatagi buqatu-salji bodoncar-mungqaq ede tabun kö'üd-iyen jergelen sa'ulju niji'el müsüt ququlutqun ke'ejü ökba niji'el-i ya'u bayi'ulqun ququciju o'orba basa tabun müsüt qamtu cu[q] laju ququlutqun kejü ökba tabu'ula tabun cuqtai müsüt gü'üleldün bariju bitü'üljü ququqlun yadaba




§ 22. basa alan-qo'a tabun kö'üt-te'en söyü-'er üge ügülerün ta tabun kö'üt minu qaqca ke'eliece töreba ta tuqar-un tabun müsüt metü qaqca qaqca bolu'asu tere niji'el müsüt metü ken-e ber kilbar-a ququldaqun ta tere cuqtai müsüt metü qamtu niken eyeten bolu'asu ken-e ber kilbar-a yekin bolqun ta ke'ebi atala alan-qo'a eke anu ügei bolbi...



Эл хоёр хэсэгт "tabun kö'üd", "tabu'ula" гэх нь Бодончарын эх Алангоогийн хүүхдийн тоо авч 'tabun müsüt" гэсэн хэллэгтэй холбон бодвол учир шалтгааны нарийн уялдаатай зүйрлэл ажээ. Нэгэн нум саадагт "tabun müsün" агсаж явдаг нь монголчуудад дээр үеэс

тогтсон ёс зуршил юм. Түүний үлдэц, монгол угсаатны дотор Баргад шинэ хүргэн "таван сумтай саадаг хийгээд хоромсогтой нум агсаж"[32] хүүхний талд хүрдэг бөгөөд Түмэдэд "зүүн мөрөндөө нум үүрч бүснээсээ таван сум хатгасан саадаг агсаж"[33] явдаг байсныг мөн гэж үзэж болно. Тэгэхлээр "tabun müsün"-өөр үлгэрлэн Алангоогийн хөвгүүдээ сургамжилсан нь нэгэн савных буюу нэгэн эхийн хэвлийнх, нэгэн өрх гэрийн хөвгүүд гэсэн санааг давхар илтгэн зүйрлэсэн нь тод байгаа юм. Үүнийг улам тодосгохын үүднээс "таван хуруу" мэт хүний салшгүй эд эрхтэнтэй бясхүү холбон үзэж болно. Хүний нэгэн гар таван хуруутай нь түүнд эх эцгээс ч юмуу байгалиас заяасан эд эрхтэний цогцлол мөн буюу. Түүнийг монголчууд ухаарч "гарын таван хуруу шиг" хэмээн эв нэгдлийг зүйрлэсээр ирсэн юм. Ер нь монголчууд хүний биеийн эд эрхтэнийг "тавтын цогцлол"[34]-оос бүрдсэн гэж үздэг болохлоороо алив юмны салшгүй нэгдмэл гэдгийг "тав"-аар зүйрлэн хэлэлцсээр иржээ. Эл бүхэнтэй "tabun müsüt" гэдэг ойлголтыг эргэн холбож үзвэл "Монголын нууц товчоо"-нд "тав"-ын тоог бүтэц бүрэлдэхүүний нэгдмэл цул гэсэн бэлгэдлийн утгыг бүрнээ агуулжээ гэж хэлж болно. Хүний гар хуруутай холбогдол бүхий "тав"-ын тооны тийм хэллэг бийг "Монголын нууц товчоо"-ноос иш татвал:


§ 53. buyur-na'ur kölen-na'ur qoyar ja'ura ursi'un-müren-ne bükün ayiri'ut-buiru'ut-tatar irgen-e ambaqai-qahan ökin ökcü ö'esün ökin-iye[n] hüdejü otqu bolun tatar jüyin irgen ambaqai-qahan ni bariju kitad-un altan- qahan-na a[b]cu otqui-tur ambaqai-qahan besütei gü'ün balaqaci e[l]cin-i'er ügülejü ilerün qabul-qahan-nu dolo'an kö'üd-ün dumdatu qutula-da ügülerün harban kö'üd-ün dotora qada'an-taisu-da ügüle ke'en ügülejü ilerün qamuq-un qahan ulus-un ejen bol[u]ju öki-ben ö'esün hüdekü-ben nama-'ar kesetkün tatar irgen-e bariqda'a bi tabun quru'ud-iyan kimul tamutala harban quru'ud-iyan ha'uttala haci minu aburan sori[t]qun ke'ejü ilejü'ü гэжээ. Энэ нь монголын Амбагай-хаан Татар нарт баригдахдаа элч зарж арван хөвгүүний дундах Хадаан тайжид гэрээслэсэн үг юм. Энд гарч байгаа




"qamuq-un qahan ulus-un ejen bol[u]ju öki-ben ö'esün hüdekü-ben nama'ar kesetkün tatar irgen-e bariqda'a bi tabun quru'ud-iyan kimul tamutala harban quru'ud-iyan ha'uttala..." гэснийг "Энэ нь гарын хуруугаа цэврүүшин дуустал нум сумаар байлдагтун гэсэн утгатай захиас юм"[35] хэмээн тодосгон тайлжээ. "tabun quruud-iyan kimul tamutala harban quru'ud-iyan ha'uttalla " гэсэн нь зөвхөн гарын хуруугаа цэврүүшин дуустал нум сумаар байлдагтун" гэснээс илүү өргөн санаатай, "хуруу хумсаа хуйхалж байж" "хуруу хумсаа хугалан байж" гэсэн хэллэг монгол түмний яриан дунд эдүгээ бий нь "бүхий л хүч чадлаараа" хэмээх утгыг илтгэсээр ажээ. Хүчээ нэгтгэж эцсийн чадлаа шавхан миний өсийг авагтун гэсэн утгыг агуулжээ гэж үзэж болохоор байна. § 53-ийн эл хэллэгийг энэ л утгаар ухаарахад "Монголын нууц товчоо"-ны § 19,22 зүйлд хэрэглэсэн "тав"-ын зүйрлэлээс утга бэлгэдэл төдийлөн гажихгүй байна.

§ 193. quluqana jil jun-nu teri'ün sara-yin harban jirwa'an üdür hula'an tergel-e tuq sacu'at morilarun kelüren ö'ede jebe qubilai qoyar-i algincilaju yabu'at sa'ari-ke'er-i gürü'esü qangqarqan-u (?) teri'ü-te naiman-u qara'ul tende aju'u bidan-u qara'ul-a hüldeldüjü bidan-u

qara'ul-aca niken singqula morin mawuqan eme'eltü-yi naiman-u qara'ul-a abtaju'ui naiman-u qara'ul tere morin abcu ügüleldürün mongqol-un aqtas turuqat aju'u ke'eldüjü'üi bidan-u'ai sa'ari-ke'er-i gürcü tende töritcu ker kikün ke'eldü'esü tende dödei-cerbi cinggis-qahan-a durat=qarun bidan-lu cö'en bui cö'en de'ere cilejü ireba eyin-gü töritcü aqtac -iyan cattala ene sa'ari-ke'er-i delgen bawuju amitu ele gü'ün tutum ere-yin tabun anggida qal-nu'ut tülejü qal-iyar oqjatqaya naiman irgen olon ke'ekdemüi qan anu ger-tece ese qaruqsan tanggi ke'ekdemüi qal-iyar hülürige'ültele bidan-u aqtas ber cadumu-je aqtas-iyan catqan naiman-u qara'ul-i hülde'et darucaju qol-tur anu neyile'ülün








tere samawui-tur qatquldu'asu bolqu-yu ke'en duratqa'asu ene üge-yi jöbsiyejü cinggis-qahan jarliq bolurun teyin bö'et qal-nu'ut tüle'ülütkün ke'en ceri'üt-te jasaq tungqaba tedüi sa'ari-ke'er-i delgen bawuju amitu ele gü'ün tabun anggida qal-nu'ut tüle'ülba söni naiman-u qara'ul qangqarqan-u (?) teri'un-ece söni olon qal üjejü mongqol-i cö'eken ese-gü ke'en büle'ei hodun-naca olon qaltan bui ke'en tayang-qan-tur mawuqan eme'eltü singqulaqan morin ökcü ile'et mongqol-un ceri-üt sa'ari-ke'er-i bütetele bawulu'a üdür-tür ündür-ün aqun-u hodun-naca olon qaltan bui ke'ejü ilejü'üi.

Эл хэсгийг нягтлан үзвэл, Чингис хааны "amitu ele gü'ün tabun anggida qal-nu'ut tüle'ülba" гэсэн нь тулалдагч дайснаа хуурсан төдий ерийн нэгэн явдал биш ажээ. Тиймээс "tabun anggida qal" гэсэн хэллэгийн талаар хоёр тодруулга хийе.

Нэгдүгээрт, XII-XIII зууны үед монголчууд "qal"-ыг тахил хүндэтгэл, ариутгал, сүр жавхлангийн бэлгэдэл гэж үзэж байжээ. Түүнийг Жиованни дель Плано Карпини "Монголчуудын түүх" тэмдэглэлдээ: "Гал руу хутгаар чичих, эсвэл ямар нэгэн байдлаар хутгаа галд хүргэх, мөн хутгаар тогооноос мах гаргах, түүнчлэн галын дэргэд түлээ хагалбал тэд галын толгойг тастчихна гэж итгэх болой... Товчхон өгүүлэхэд тэд гал бүх зүйлийг ариутгадаг гэж итгэх тул ирсэн элчин, төлөөлөгч, түшмэд ер хэнийг ч болов авчирсан бэлэг сэлтийнх нь хамт хоёр галын дундуур гарган алив нэг хорлох үйл үйлдэж хор буюу ямар нэг муу зүгийн юм авчруузай хэмээн ариутгах бөлгөө..."[36] гэхчлэн бичсэн нь тодорхой гэрчилнэ. "Монголын нууц товчоо"-нд Dodei-cerbi Чингис хаанд Таян-ханыхныг "qal-iyar oqiatqaya" хэмээн өгүүлж үр дүнд хүрсэн нь Найманы харуул, Ханхарханы тэргүүнээс Таян-ханд "hodun-naca olon qaltan bui" гэж мэдэгдэж байгаагаас илэрхий болжээ. Хоёрдугаарт, монголчууд ан гөрөө хийх, аян жинд явахдаа нэгэн

галыг тойрон сууж, нэгэн тогооноос хооллох бүлэг хүмүүсээ "гал" гэдэг байжээ. Түүнтэй "Монголын нууц товчоо"-ны "tabun anggida qal" гэсэн ойлголтыг холбон үзвэл XIII зууны үед таван хүн нэгдэж "гал" болох зарим тохиол байсан болов уу гэх бодол төрөв. Түүний жишээ болгож "Монголын нууц товчоо"-ноос иш татвал:

§ 224. basa cinggis-qahan kesitken ilqaju oro'ulqu-yi jarliq minqat minqat-ta tungqarun bidan-tur kesikten oro'ulurun tümed-ün minqad-un ja'ud-un ja'ud-un noyad-un kö'üt düri-yin gü'ün-ü kö'üt



ororun erdemü[t] ten (?) sil sayid-i bidan-u dergede yabuqun metüs-i oro'ultuqai minqad-un noyad-un kö'üd-i oro'ulurun harban nököttü niken de'ü inu daqa'ulju iretügei ja'ud-un noyad-un kö'üd-i oro'ulurun tabun nököttü niken de'ü-yi daqa'ulju iretügei harbad-un noyad-un kö'üd-i oro'ulurun düri-yin gü'ün-ü kö'üd-i oro'ulurun qurban nökörtü niken-gü de'ü-yi daqa'ulju huja'ur-aca ula'a gücü jasaju iretügei... гэжээ.

Үүний дотроос "düri-yin gü'ün-ü kö'üd-i oro'ulurun qurban nökörtü niken-gü de'ü-yi daqa'ulju huja'ur-aca ula'a gücü jasaju iretügei..." гэсэн нь тавуул (düri-yin gü'ün-u kö'üd+ qurban nökörtü+ niken-gü de'ü-yi) иртүгэй гэсэн зарлиг юм. Мөн "harbad-un noyad-un kö'üd" ч гэсэн тавуул (harbad-un noyad-un kö'üd+qurban nökörtü+

niken - gü de'ü) иртүгэй гэсэн зарлиг юм. Энэхүү "тавуул" гэдэг нь хэрэгцээтэй цагт "гал" хэмээх нэгчийг бүрдүүлэх тоо мөн буюу. Цэрэг, засаглалын "аравт" гэсэн нэгж хоёр "гал"-аас бүрдэж болохын жишээ мөн буюу. Цэрэг дайны үес "тавт"-аар нэгж болгосон жишээ тодорхойгүй ч гэсэн таван хүн нийлж "гал" болдог гэсэн ойлголт, зөвхөн Чингисийн цэрэгт төдийгүй тэр үеийн Найман болон бусад нүүдэлчин аймгуудын дунд түгээмэл байсан бололтой. Тиймээс "amita ele gü'ün tabun anggida qal-nu'ut tüle'ülba" гэсэн нь Таян-ханыханд "гал бүрийн цаана таван хүн бий" гэх тодорхой ойлгогдох тооны нэгж болох тул "hodun-naca olon qaltan bui" гэж хэлэгдэхээс аргагүй юм.

§ 200. naiman merkid-i muqutqan bara'asu jamuqa naiman-lu'a bürün tende ulus-iyan abda'asu mün tabun nököttü o'orcaq bolju tanglu de'ere qarcu uqulja alaju siraju iderün tende jamuqa nököt-te'en ügülejü'ü ken-ü kö'üt ene üdür uqulja alaju eyin idemü ke'ejü'ü tere uqulja-yin miqa iden bükü ja'ura tabun nököt inu jamuqa-yi qardaju bariju cinggis-qahan-tur



abciraju'u" гэжээ. Эл хэсэгт гарсан "tabun nököttü o'orcaq bolju" гэдэг нь бусдаасаа тасарч салсны санамсаргүй тохиолдлын хэсэг биш юм. "Монголын нууц товчоо"- ны § 224 зүйлд Чингисийн хишигтэн ялгаж авсан нь зөвхөн түүнд хамааралтай бус Жамуха болон бусад нүүдэлчид тэрхүү зарлиг журмыг цөм сайн мэдэж, бас ч өөрсдөө хэрэглэж хэрэгжүүлж байсан байж болно. Тиймээс ч Наймантай цуг байсан Жамуха улсаа алдаж хүмүүс нь бутрахад анх нийлсэн бүрэлдүүнээрээ салсан нь дамжиггүй юм. Тиймээс

салсан нэгэн "гал"-тай Жамуха үлджээ. Тэр "гал" нь таван хүнээс (gü'ünü kö'üd+qurban nökörtü+ niken de'ü-yi) бүрдсэн байжээ. Эл хэсэгт Жамухагийн ядарсныг харуулж байгаа ч гэсэн задрал бутралаас тунаж үлдсэн цөөн атугай ч хүнийг хамаарсан нэгдлийн утгыг хадгалсан хэвээр байгаа болно. Тэрхүү "гал" нь сэтгэлэг нэгтнээс бүрдсэний учир бүлэглэж Жамухаг гардан барьж Чингис хаанд авчирчээ. Гэвч Чингис хаан "qan-dur-iyan qar gürgeksen gü'ün-i ker a'uldaqu teyimün gü'ün ken-tür nökögegü" гээд тэр "гал"-ыг устгуулжээ. Тухайн үеийн "гал" гэсэн ойлголт, зарим нэгэн хувирал үзсэн боловч үндсэн утгаа хадгалж үлдсэн тул "гал утаа бол овог хүйн оршин тогтнож буй бэлгэ тэмдэг, үндсэн шинж гэж үздэг байсны ул улбаагаар эдүгээ ч айл өрх, хэсэг бүлэг хүмүүсийг гал утаа, гэр орноор нь төлөөлүүлэн ойлгох явдал нилээд түгээмэл тархжээ"[37] гэж үзэж болох бөгөөд түүнийг XIX-XX зууны монголын түүх, архивын баримт, ном зохиолын олон жишээ батлан харуулж байна.[38]

Дээрх гурван хэсэгт өгүүлснээс үзэхэд "Монголын нууц товчоо"-ны дотор гарсан жишээнд төлөв тулгуурлан "гурав","тав","ес"-ийн тооны бэлгэдлийн түгээмэл шинжийг авч үзэхэд монголчуудын санах сэтгэх онцлог, уламжлалт зан заншил, цаг тооны мэдлэг, шүтлэг мөргөл тэргүүтнээс үндэс улбаа авч монгол ардын аман зохиол болон бичгийн утга зохиолд тооны бэлгэдэл нэвтэрч, уран дүрслэлийн нь өнгө аясыг тодруулж, хүрээ цараг нь улам баяжуулж ирсэн гэдэг нь тодорхой байна.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1. пер.с персидского Л.А.Хетагурова. Изд. АН СССР. М.-Л., 1952, стр 167
2. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх, Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УХГ, УБ., 1988, 207-р тал
3. Б.Батжаргал. Эртний монголын математика. Тэргүүн дэвтэр. ШУАХ. УБ., 1976
4. Хүний биеийн эрхтэнтэй дүйлгэсэн хэмжээ. а. урт:ямх, хуруу /нэг хуруу, эрхий хуруу, чигчий хуруу, хоёр хуруу, гурид-гурван хуруу, дөрид -дөрвөн хуруу, таван хуруу, алга дарам, үзүүр барим, мухар барим, үзүүр сөөм, мухар сөөм, үзүүр төө, мухар төө, үзүүр тохой, , мухар тохой, үзүүр дэлэм, мухар дэлэм, үзүүр алд, мухар алд, алд дэлэм, бүтэн алхам, хагас алхам, цуваа гишгэм, зэрэгцээ гишгэм, алцам, б. өндөр: шагай, шилбэ, өвдөг, салтаа, бүсэлхий, суга, мөр, хүзүү, толгой /эрүү, хамар, нүд, дух, зулай/
5. Бог, бод малын эрхтэнтэй дүйлгэсэн хэмжээ а. өндөр: туурай /бодын туурай, богийн туурай/, сагаг, шагай, шилбэ, өвдөг, гэдэс, цавь, тамга, ташаа, хондлой, сэрвээ
6. Хүний мэдрэхүйд тусах тусгал: үнэр авах газар, дуу хүрэх газар, хараа тусах газар
7. Айл, саахалт /ойр саахалт, хол саахалт/, үдийн газар, өдрийн газар, хоногийн газар, сарын газар, жилийн газар
8. Малын билчээр: хурганы билчээр, тугалын билчээр, морины аргамжааны газар, хонины билчээр, үхрийн билчээр, адууны билчээр
9. Эдлэл хэрэгслэлээр хэмжсэн хэмжээ: ташуур, уурга, сур /ачилгын сур, аргамжааны сур/, нум газар /их гарын нум, дунд гарын нум, бага гарын нум/, суман тусах газар /зэв он тусах газар/, мод газар, бээр газар, өртөө
10. Дархадад хүү гэрлэж, хүүхэн буулгахад нийлж байгаа хоёрт зориулан хуримын анхны өдөр "оронгийн эцэг овоохой",

"голомтын эцэг гурван чулуу" гэж урц барин, чулуу тулж утаа гарган цай болгодог байж. Ингэсний дараа жинхэнэ гэрийг нь барьж өгдөг заншил байжээ. Тэрчлэн нийт монголчууд аян жин, ав шувуу оролдох зэрэг алив нэг эзгүй хээр одож саатахдаа эл гурван чулууг хэрэглэнэ. Studia Museologica, Tom 1, Fasc 1-8, ШУАХ, УБ., 1968, 122-р тал; "Баруун Монголын мянгадын хуримлах ёсонд хүүгийн тал бэрийг буулгаж авчраад шинэ гэрийн хаяанд гурван модоор урц босгон түүнд шинэ бэрийг оруулж суулгаад гурван чулуун тулга тулан гал түлж тогоонд сүү хөөрүүлж сүүний хусамнаас бэрд амсуулж ёслол үйлдсэний дараа бэрийг шинэ гэрт оруулдаг байна. Энэ бол элэнц хуланцын орогнож явсан ором гэж урцыг бэлэгшээн хүндэлж, гал голомтын үүсэл тулгын гурван чулууг гэж хүндэтгэсэн хэрэг байжээ. /Этнографийн судлал. ШУАХ, УБ., 1969, 84-р тал/

11. Пэрлээ. Гурван өгүүлэл. Studia mongolica instituti Lenguae et Litterarum... Tom III, Fasc 13-15. ШУАХ. УБ., 1962, 34-р тал
12. Цэгцэрийн Шар хээр. /Cekcer-un sira-ke'er-e/ -эдүгээ Монгол улсын Дорнод аймгийн Сэргэлэн, Цагаан-Овоо сумдын заагт Алтачийн хоолой, Галын хөндийг хэлж байгаа болно. О.Сүхбаатар. Монголын нууц товчооны газар усны нэрээр мөшгөхүйд. Үнэн сонин, 1992, № 53
13. Altan Tobci (Hans-Peter Vietze, Gendeng Lubsang) Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von Blo bzan bstan'jun. Text und Index. Tokyo, 1992, p.8
14. Sayang Secen. Erdeni-yin tobciy-a. öbür mongyol-un ündüsüten-ü keblel-ün qoriy-a. Kökeqota, 1987, 67 duyar tal-a
15. Өнчин цагаан ботго...

Гурван жилийн хол газрыг
Гурван сараар товчлон
Гүйлгээд байдаг нь энэ
/гэв гэлээ хө/

Миний хүү
Гурван сар гөрөөлдөгөө
Гурав хоноод
Юунд ирэв гэжээ

Цариг цагаан ингэний
Өнчин цагаан ботго.
Дуутай мөндөр
/Монгол ардын туульс/
Эмхтгэн боловсруулж оршил
бичсэн Б.Катуу, Р.Нарантуяа
БНМАУ.АБЯ-ны Сурах бичиг,
сэтгүүлийн нэгдсэн редакцийн
Газар, УБ., 1989, 98-р тал

Гөшөө чулуун зүрхт
Хүйвэй Буйдар хүү /тууль/
Монгол ардын
баатарлаг туульс
Studia Folclorica
Tom 1, Fasc 7.
Эмхтгэн боловсруулж
өмнөх үг тайлбар сэлт
үйлдсэн Г.Ринчинсамбуу.
УХХЭХ, УБ.,1960,26-р тал

16. Merged yarqu-yin orun. ündüsüten-ü keblel-ün qoriy-a, Begejin, 1988, 1178-1181 düger tal-a
17. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, үн ухааны сэтгэлгээ /Эртнээс XIY зуун хүртэл/ УБ., 1987, 33-р тал
18. Ч.Далай. Монголын бөө мөргөлийн товч түүх. ЭШХ, УБ., 1959, 35-р тал
19. Д.Лхам. Мянгад ардын зан үйл, аман зохиол. УБ., 1991, 67-р тал
20. Ч.Далай. Монголын бөө мөргөлийн товч түүх. ЭШХ, УБ., 1959, 39-р тал
21. С.Дулам. Дархад бөөгийн уламжлал. МУИС-ийн хэвлэл. УБ., 1992, 39-р тал
22. Altan tobci (Hans Peter Vietze, Gendeng Lybsang) Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von Blo bzan bslan'jin. Text und Index, Tokyo, 1992, p.33
23. Монгол ёс заншлын их тайлбар толь. /Зохиогч эмхтгэгч Ч.Аръяасүрэн, Х.Нямбуу/, Тэргүүн боть, "Сүүлэнхүү" хүүхдийн хэвлэлийн газар. 1992, 682-р тал
24. Дожоогийн Цэдэв. Казуюки Окада (орч) "Монголын нууц товчоо"-ны тооны утга бэлгэдлийн асуудалд (Япон хэлээр) Area and culture studies, Tokyo university of foreign studies, 1994 № 49 pp. 67,80

25. Buyantoγtoqu. Tabun qosiγu mal-un neridül. öbür mongqol-un sinjilekü uqaγan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a. 1998.28-29. 35-36, 38-39 düger tal-a
26. Ш.Чоймаа (Монгол) "МНТ"-ны "Sirqa aqta-tan" хэмээх үг хийгээд дундад үеийн монгол хэлний "tan" дагаварын судалгаа. Монгол судлалын мэдээлэл (Bulletin the IAMS. News information on mongol studies. 2001 № 1, 2(27. 28) Ulaanbaatar. pp. 72, 77
27. Ш.Гаадамба. Монгол ардын үлгэр. Аман зохиол судлал. Studia Folclorica... Tom XIY, Fasc 1-10. ШУАХ, 1987/1984/ 106-р тал
28. Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг /Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал/. МЭӨ IY - МЭ II зуун. УБ., 1980, 77-р тал
29. Г.Сүхбаатар. Монгол нирун улс /330-555/. УБ., 1992. 145-р тал
30. Г.Сүхбаатар. Монгол нирун улс /330-555/. УБ., 1992, 145-р тал
31. Injannasi. Köke sudur. Ded debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota, 1957, 1232-1249 düger tal-a
32. Mongγol qubcasu jasal. öbür Mongγol-un sinjilekü uqaγan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a. 1991, 17 duγar tal-a
33. Mongγol qubcasu jasal. öbür mongγol-un sinjilekü uqaγan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a. 1991, 98 duγar tal-a
34. Хүний бие бүхэлдээ суваг буюу судас, яс буюу мөгөөрс, мах буюу өөх, цус буюу ус, арьс "тав"-аас бүрдэнэ гэдэг. Хүний дотор эрхтэн "таван цул"-аас /бөөр, зүрх, элэг, уушиг, дэлүү/ яс /толгой, сээр нуруу, дал /сүүж бол эргүүлсэн дал мэт/, хавирга, чөмөг "тав"-аас бүрдэнэ гэдэг.
35. Чулууны Далай. Монголын түүх. Хамаг монгол улс (1101-1206). Тэргүүн дэвтэр. ШУХ "Эрдэм" компани. УБ. 1996. 50-р тал
36. Жиованни дель Плано Карпини.. Монголчуудын түүх, Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ., 1988, 18-19-р тал
37. А.Очир. "Оуто", "Утку" хэмээх түүхэн нэрийн тухайд. Түүхийн судлал. Studia Historica Instituti Historiae... Tom. XIY, Fasc. 1-16. ШУАХ. УБ., 1979, 43-р тал
38. Доор дурдсан хэдэн ном зохиолд "гал"-ын тухайд тэмдэглэл

үлдээжээ. Үүнд:

а. - "Гал" - название одного очага для каждого десятка- годоли, чтобы отыскать свои гал - кричат род, племя" - Ц.Жамцарано. Об облавах у Ордосцев. Studia Mongolica Instituti Linquae et Litterarum... Tom. 1, Fasc. 6, ЭШХ, УБ., 1960, стр 3

б. - Түшээт хан аймгийн ван Цэрэндоржийн хошууны занги Баянгаас заалдсан Гадаад монголын төрийг засах явдлын яаманд мэдүүлсэн бичигт Сайшаалт ерөөлтийн 13 он /1808

д. "... Хагас хэмээх газраа Баяндай эдгээр гучин гурав гал иргэд гэх боловч нэг бүрд хэдэн иргэн буйг мэдэхгүй" гэжээ. -Монгол улсын түүхийн төв архив. Сайшаалт ерөөлт. 2-22-44; Ардын заргын бичиг. ШУАХ, УБ, 1968, 30-р тал

в. - "Монголчууд аянд явахдаа дадлага туршлагатай аянчийг түшиглэн дагалдаж, нэгэн гал бааз болж, хүч хөдөлмөрөө хамтарч, аялах нөхөрлөлийн хэлбэр эртнээс үүсэж уламжлагдсаар иржээ" - Цэрэнгийн Насанбалжир. Монголын мал аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэтгэл /XIX зууны эцэс XX зууны эхэн/ШУАХ. УБ., 1978, 49-р тал

г. - Монголчууд нэг жинд арван тэмээ оноохоор бодож, хорин тэмээг нэгэн баазын хөсөг болгон хоёр аянчин нэг гал болж явах горимтой. - БНМАУ-ын угсаатны зүй. Гурван боть. Халхын угсаатны зүй. /XIX-XX зууны зааг үе/ 1 боть, УБ., 1987, 61-р тал

д. - "Бас 60 орчим тэмээтэй 4-6 хүн "нэг гал" болж дотроо "хоёр баазад" хуваагддаг ёс байжээ... 4-6 хүнтэй гал нь нэг сууцтай явдаг... Д.Нансалмаа. Халх аян жингийн уламжлалт ёс горимоос. Studia Historica... Tom. XXI, Fasc. 17, 131-р тал


е. Гал-хүмүүс. Аян замд хамт явж цуг тогоолдог бүлэг хүмүүс, нэг гал аян - Sesengcoqtu. Mongγol üges-ün ijaγur-un toli. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota, 1988, 1226 duγar tal-a

ё. 2.Аялах зэрэгт нэг оронд /оромд Д.Ц./ хамт нийлж явах, нэг гал аянчин, галын ах /аяны нэг галын тэргүүлэгч/, Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966, 134-р тал

ж. Манай монголд аянчны түүдэг, гөрөөчдийн буудлыг отог хэмээн нэрлэдэг. Төдөн гал аянчин, төдөн гал гөрөөчин гэх оронд төдөн отог гөрөөчин, төдөн отог аянчин гэх мэт. Ш.Нацагдорж. Сум, хамжлага, шавь ард. ШУАХ, УБ., 1972, 18-р тал

ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ

Байгаль, нийгэм, сэтгэхүйн үзэгдэл хүний мэдрэхүй хүртэхүйд тусах олон сувгийн нэг нь өнгөөр дамжихуй юм. Өнгийг сэрж мэдрэх, хүртэж хүлээж авах хүний загвар нийтлэг, түгээмэл ч гэлээ үндэстэн угсаатны хувьд болохоороо түүнийг ойлгох ухаарахад өвөрмөц ялгарал гарна. Хүн төрлийг олохдоо өдөр, шөнө ээлжлэх орчилд гэрэл гэгээ, сүүдэр харанхуйг эхэлж сэрж мэдэрдэгээс үүдэлтэй гэж болох цагаан хар талын өнгө, түүнийг үзэх үзэл уламжлал болон хадгалагдаж, улам баяжиж ирснийг "Монголын нууц товчоо"-ны олон жишээ харуулж байна.





§ 1. cingges-qahan-nu huja'ur de'ere tenggeri-ece jaya'atu töreksen börte-cino aju'u gergei inu qo'ai-maral aji'ai

Чингис хааны язгуур дээдэс "börte", "qo'ai" гэсэн өнгийг үнэндээ "бараан", "бүгээн" хоёрт хамааруулж болно. "Хар","цагаан" өнгийг эерүүлэн нэрлэвээс "бараан", "бүгээн" болно. Энэ талаас нь авч үзвэл "börte" нь "бараан", "qo'ai" нь "бүгээн" өнгөнд багтах тул цаанаа арга билгийн хослолын ойлголттой уялдаатай болж ирнэ. Учир нь, хар цагаан хоёр өнгийг арга билгийн хос амисхалыг бүтээдэг, "эцэг эх" өнгө гэж үздэг юм. Энэ ойлголтоор бол Чингис хааны язгуур дээдсийн "börte", "qo'ai" хоёр өнгө бол эцэг эх өнгийг заасан нарийн учир утга хадгалжээ гэж үзэж болохоор байна.

"Монголын нууц товчоо"-нд хамгийн олонтаа давтагдсан өнгөний нэг бол цагаан юм. Цагаан өнгө бол сүүнийх мөн.

§ 244... cinggis-qahan qasar-un qancut huyaju maqalai büse inu abcu üge ine asaqun bükü-tür eke-de gürtejü cinggis-qahan geyekcü eke-dece emi'eba eke a'urlaju gürcü tergen-ece bawu'at eke ö'esün qasar-un huyaqsat qancut dalju talbi'at maqalai büse inu qasar-a ökcü eke







kilinglaju a'ur-iyan darun yadan jabilan sa'uju qoyar kököd-iyen qarqaju qoyar ebüdük dege'ün bisari'ulju ügülerün üjebe-yü kökösken köken tanu ene bui ede qadalun da'un qarbisu-'an qajaqsat küi-iyen tasuluqsat qasar yekibe temüjin ene niken kökö minu baraqu büle'e qaci'un otcigin qoya'ula bolju niken kökö ülü baraqu büle'e qasar bürün qoyar büri kököt minu baraju ce'eji minu a'ui boltala amurli'ulju ce'eji a'ui bolqaqu büle'e... edö'e daisun gü'ün-i muqutqaba ke'ejü qasar-i üjen yadamui ta ke'eba eke-yi amurli'ulun baraju cinggis-qahan ügülerün eke-yi kilinglaqdaju

ayun ba ayuba hicen ba hiceba bi ke'ejü icuya bida ke'ejü icuba...


Энд Тэв-Тэнгэрийн ятгалгад орж Хасарыг цээрлүүлэх гэж байхад нь Өүлэн эх яаравчлан очиж Чингис хааныг зэмлэж "üjebe-yü kökösken köken tanu ene bui ... temüjin ene niken kökö minu baraqu büle'e qa'ci'un otcigin qoya'ula bolju niken kökö ülü baraqu bule'e qasar bürün qoyar büri kököt minu baraju ce'eji mini a'ui boltala amurli'ulju..." гэж айлгаж ичээж байна. Хэдийгээр яг үгээр нь нэрлээгүй боловч "kökösken köken", "niken kökö minu", "niken kökö ülü baruqu", "bürün qoyar büri kököt" гэхчлэн эхийн сүүний тухай өгүүлж байгаа нь ил байна. Өэлүн эхийн сэтгэлийг сүүтэй зүйрлэж "§ 254... qadun eke-yü'en tosun duran qoru'ulju sün jürügen e'ede'üljü ügülemüi ci..." гэж Цагаадайд хандан Хөхөчос зэмлэв. Энэ хоёр жишээнээс үзэхэд "хөх", "хөхсөн", "хөхөөд", "сүү" гэсэн үгсийн цаана эхийн цагаан сүү гэсэн, түүнтэй зүйрлэсэн утга хадгалагдаж байна.




Тэмүжин Бурхан халдун дээр бууж § 103 ... naran esergü büse-ben güjü'ün-dür-iyen erigelejü maqalai-ban qar-tur-iyan se'ejigelejü qar-iyan e[b]ce'ün-düre iyen mö'ele[t]cü naran [jük] yisün-te sögö[t]cü saculi öci'üli ö[k]ba хэмээсний "saculi...ö[k]ba" гэдэг нь бас л яг үгээр нь нэрлээгүй ч гэсэн сүү /цагаан сүү, цагаан идээ/ өргөж /цацлаж/ байна гэсэн утга агуулж байна. Ингэж цагаан цацал, эхийн цагаан сүүний тухай хам утгаар илэрхийлсний зэрэгцээ унааны зүс, дээл хувцасны өнгөнд, бэлэг сэлтэд цагаан гэсэн ойлголтыг олонтаа хэргэлж байжээ.




А.§ 244...caqa'an teme'en köljü...
Б.§ 87... aman caqa'an eremük qulaqcin-i unu'ulju...
В. § 169... merkidei-caqa'an amun- caqa'an-keer qoyar-i qoyar aqtas bariju... А-гийн Өэлүн эхийн унаа, Б-гийн Тэмүжинд Сорхан шар барьж өгсөн унаа, В-гийн агтач Бадай, Хишилиг хоёрын унаж Чингист хэл мэдээ хүргэсэн хүлгүүд нь цагаан буюу ам цагаан зүстэй нь тохиолдлын гэж үзэж болмооргүй байна. Цагаан зүсмийн мал нь харьцангуй урт насладаг ажээ. "...Цагаан саарал адуу жаран хэдэн жил /адууны насыг тогтоохдоо хоёр жилийг нэг нас гэж тооцдог Д.Ц/ наслана. Цагаан үхэр дөчин хэдэн жил, цагаан тэмээ тавин хэдэн жил, бусад өнгөтэй үхэр адуу гучин хэдэн жил... тус тус наслана".[1] Нөгөөтэйгүүр цагаан зүсмийн малыг монголчууд бэлгэ дэмбэрэлтэйд тооцож байжээ. Цагаан зүсмийн унааг хүндэтгэлийн дээд болгож байсныг Өэлүн эхийн "цагаан тэмээн хөлжү" гэж дээр өгүүлснээс мэдэж болно. Ялангуяа ам цагаан /amun caqa'an/ гэдгийг монгол домог зүйд долоон бурхан - ам цагаан бяруу[2] , арван хоёр жилийн анхдагч ам цагаан хулгана[3] мэтээр бусдад тус буян үйлдэгч анхдагч мэтээр дүрсэлдэг юм. Ам цагаан морины хувьд гэвэл хишиг буяны бэлгэдэл, унасан эзний итгэл хүслийг хангагчийн бэлгэдэл гэж үздэг байжээ. Энэхүү бэлгэдэл хэрхэн биелэснийг ам цагаан эрмэг хулагчинг унасан Тэмүжин Тайчуудад баригдалгүй гэртээ очсон, Мэргэдийн цагаан, аман цагаан хээр хоёрыг унасан Бадай Хишилиг санасандаа хүрч Чингис хаанд "таныг бүсэлж барьяа хэмээн үг барилдав" гэж хэл өгснөөс ойлгож болно.



§ 147. basa cinggis-qahan ügülerün köyiten bayilduju iquriqaldun jibsiyerülcen bükü-tür tede niru'un de'erece sumun irejü minu jebelegü aman caqan qula-yin aman niri'u inu ququ ken qarbula'a a'ula de'erece ke'eba tere üge-tür jebe ügülerün a'ula de'erece bi qarbula'a... cinggis-




qahan ügülerün dayisun yabuqsan gü'ün alaqsan-iyan dayisurqaqsan-iyan beye-'en ni'uju kele-ben bucaju ayu[yu] ene bürün ke'esü munda alaqsan-iyan dayisurqaqsan-iyan ülü buca[?] munda ji'an buyu nökö celtü gü'ün buyu jirqo'adai neretü aju'u mün jebelegü aman caqan qula'yi minu aman niru'u qarbuqsan-u tula jebe nereyi[t]cü jebeleye imayi ke'en jebe nereyitcü dergede minu yabu ke'en jarliq bolba jebe tayici'ud-aca irejü nökö ceksen yosun teyimü




Энэ хэсэгт Чингисийн унаж явсан ам цагаан хул морины хүзүү харвагдсан байж болох боловч түүнтэй өөрийн хүзүү шархадсаныг давхар холбон эзэн хаан өгүүлж байгаа нь тодорхой байна.

§ 145. cinggis-qahan tere qatquldu'an-tur sujiyasu-ban silürtejü cisun töritge'esü ülü bolun amuriqdarun... билээ. Ийм хэцүү бэрх үед Зэлмэ "bökleksen cisun-i ... simin simin ama'an cisudaju... busu

gü'ün ülü itegen sakilduju sa'uju söni düli boltala bökleksen sisun-i ama-'ar dü'üreng jalki'at as'qa'at...""niken yeke börti'etei taraq tergen-ece inu abuat" ундаассан Чингист өгч амийг нь аварсан юм. Тэгвэл Чингис §145-д өөрийн "sijiyasu-ban silürtejü"-



ийг эерүүлэн §147-д "ам цагаан хул морины аман нуруу /хүзүү Ц.Д/ сүвлэж харвалаа" болгон өгүүлжээ. Энэ нь эрхэмд тооцож хүлгээ болгосон ам цагаан хул мориор өөрийгөө төлөөлүүлэн ёгтоор жишин утга далдласан хэрэг болно. Ер нь өөрийгөө




итгэлт хүлгээрээ, итгэлт хүлгээ өөрөөрөө ёгтлон төлөөлүүлдэг монголчуудын дунд үе дамжсан уламжлал энэ § 147 хэсэгт туссан гэж үзэж болно.

§ 216. basa cinggis-qahan üsün-ebügen-e ügülerün...beki mör bidan-u dotora de'ere-ece beki üsün-ebügen boltuqai beki ergü'et caqa'an de'el emüscü caqan aqta unu'ulju sa'uri de'ere sa'ulju takiju basa hon sara sataju teyin atuqai ke'en jarlig bolba

Энд Чингис хаан Үсүн-өвгөнийг "beki"-д өргөмжлөж "caqa'an de'el emüscü caqan aqta unu'ulji" явахыг зарлиг болсон нь цагаан морийг хэрхэн дээдэлж байсны бүр тодорхой жишээ мөн. Тэрчлэн Чингис хаан Үсүн-өвгөнийг "цагаан дээл өмсөж" явахыг басхүү зарлиг болсон нь төр ёсны хувцасыг заасан хэрэг юм. Цагаан дээлийг зөвхөн төр ёсны өмсгөл гэж үзвэл утгыг

явцууруулсан мэт болно. Тэр үеийн монголчууд цагаан сарыг /2 дугаар сард/ тэмдэглэн ёслохдоо хүртэл цагаан хувцас өмсдөг байсныг Марко Пологийн аяны тэмдэглэлд "Тэд бүгд заншил ёсоор эрэгтэй, эмэгтэй ялгалгүй чадах чинээнийхээ хэрээр цагаан хувцас өмсдөг. Цагаан хувцасыг аз жаргалын бэлгэ тэмдэг хэмээх тул түүнийг их хийдэг. Тэр нэгэн жилдээ аз жаргалтай амар төвшин байхын тул тийнхүү цагаан хувцас өмсөх ажээ... Түүнчлэн ноёд тайж, баатар эрсээс эхлээд энгийн харц ардууд хүртэл цөм бие биедээ цагаан өнгийн эд харилцан бэлэглэж, золголдон цэнгэлдэж, хөлтэй их найр хийхийн учир бол тэд бүгдээр тэр нэгэн ондоо аз жаргалтай амар түвшин аж төрөхийн бэлгэдэл болно"[4] гэж бичсэнээс ойлгоход хангалттай юм.

Энд өгүүлсэн "... цөм бие биедээ цагаан өнгийн эд харилцан бэлэглэж" гэсэн хэллэгээс монголчуудын бэлэг сэлтдээ цагаан өнгийг дээдэлдэг байсныг басхүү мэдэж болно.



§ 239... kirgisud-un noyat yedi-inal aldi-er örebek-digin kirgisud-un noyat elsen oroju caqa'an-nu'ut singqot caqa'a-nu'ut aqtas qara-nu'ut buluqat abu'at irejü joci-da a'uljaba...cinggis-qahan-tur caq'a-nu'ut singqod-iyar caqa'a nu'ut aqtas-iyar qara-nu'ut buluqad-iyar a'ulja'ulba... гэсэн хэсэгт ойн иргэдээс Чингис хаанд болон Зүчид "-цагаан шонхорууд","цагаан агтас", "хар булган дах" бэлэглэсэн нь Чингисийнхний цагаан өнгийг дээдэлдгийг давхар илтгэсэн тодотгол юм. Тухайн үеийн төр




ёсонд цагаан өнгө хүндтэй байр суурь эзэлж байсны хамгийн тод гэрч бол есөн хөлт цагаан туг /§ 202 ... yisün költü caqa'an tuq/ билээ. Төрийг засч тохинуулахын ухаан нь олон овог аймгийн эв нэгдэлд

оршдог учраас төрийн төлөв төвшнийг зөгнөх бэлгэдэл нь сүлд туг байдаг ажээ. Эсгий туургат улсыг нэгтгэж гал барс жил /1206/ Онон мөрний эхэнд хурж байгуулсан есөн хөлт цагаан туг нь монголчуудын хувьд улс орны үндэсний эв нэгдлийн бэлгэдэл, бадрал мандлын баталгаа юм.

Энэ бүх жишээ баримтаас үзэхэд цагаан өнгө бол монгол угсаатны хувьд хамгийн хүндэтгэлтэй бөгөөд эрхэмлэдэг бүхнийх нь бэлгэ тэмдгийн илэрхийлэл байжээ.

Цагааны эсрэгцэл нь хар өнгө юм. Дээр өгүүлсэн /§239/ хэсгийн бэлгийн дунд "Хар булган дах" багтаж байгаа нь монголчууд түүнийг эрхэмлэж, хүндэтгэлийн эд өлөгт оруулж тооцож байсны баримт юм. Булганы үндсэн гол өнгө нь хар бөгөөд "хар булган дах" хэмээх нь аль ч үеийн үнэт эд агуурсны нэг болно. Үүгээрээ ч "хар булган дах" нь ураглах зан үйлийн бэлэг сэлтийн тоонд багтаж байсан ажээ.


§ 96. senggür-qoroqan-aca newüjü kelüren-müren-ü teri'ün bürgi-ergi-de nuntuqlan bawuju cotan eke-yin sitkül ke'en qara buluqan daqu abciraju büle'e tere qaqu-yi temüjin qasar belgütei qurban a[b]cu otcu erte üdür yisügei-qan ecige-lü'e kereyit irgen-ü ong-qan and ke'eldüksen aju'u ecige-lü'e minu anda ke'eldüksen ecige metü bui-je ke'en ong-qan-i tu'ula-yin qara tün-ne buyu ke'en medejü otba ong-qan-tur temüjin



gürcü ügülerün erte üdür ecige-lü'e minu and ke'el=düksen aju'u ecige-gü metü buyu-je ke'ejü gergei bawulju emüsgel cimada a[b] ciraba ke'en buluqan daqu ökba ong-qan masi bayascu ügülerün qara buluqan daqu-yin qari'u qaqacaqsan ulus-i cinu qamtutqaju öksü buluqan qaqu-yin qari'u butaraqsan ulus-i cinu bügütke[l] düjü öksü bököre-yin bökse-tur cekere-yin ce'eji-tur aduqai ke'eba...


Энэ хэсгээс

1. Ургийн бэлэгт охины талаас "хар булган дах" оруулж өгч байсан



2. Ургийн үнэтэй цайтай бэлгээсээ хамгийн ойр гэгдсэн ачийг бодсон нэгэндээ / ахмад/ бэлэг болгодог байсан хоёр өгүүлэмж харагдана. hodutai tenggeri horiju büle'e olon ulus bulqa büle'e oron-dur-iyan ülü oron oljalaldun büle'e körisütei etügen körbejü büle'e gür ulus bulqa büle'e könjile-de'en ülü geblen qörüleldün büle'e teyimü caq-tur güsejü ese yabuba'je gürülcekü-tür bolba-je buru'utcu ese yabuba /§ 254/ гэж дүрслэж болохуйц цагт хар өнгө бол хүчин төгсийг илтгэх бэлгэдэл болж байжээ.

§ 106. jamuqa basa ügülerün temüjin anda to'oril-qan aqa qoyar-a ügüle ke'en ügülerün bi bürün qara'atu tuk-iyan sacuba bi qara buqa-yin arasun-niyar bürüksen bürkiren bükü dawutu kö'ürge-ben deletba bi qara qurdun-iyan unuba bi...



Энд "qara buqa-yin arasun-niyar bürüksen", "qara qurdun-iyan unuba" гэхчлэн гарч байгаа "qara"гэсэн өнгө тодотгол нь Жамуха дайн тулаанд мордохын шинжийг агуулжээ.

Ер нь хар өнгө бол дайн тулаанд догшин сүр хүчийг үзүүлж бусдын зүрхэнд шар ус хуруулах бэлгэдлийн өнгө юм. Үүнтэй

холбогдуулан Чингисийн "дөрвөн хөлт хар сүлд"-ийг тодруулж болно.

"Хараа ихэт хар сүлдийн өчил"-д

"Дөчин түмэн дэгэн сүлд бологсон

Дөрвөн хөлт хар сүлд"

"Хар азарганы гөхлөөр холбоо бологсон

Хараа ихт хар сүлд"[5] гэхчлэн дурдсан бол


Лувсанданзаны "Алтан товч"-д

"keger ajirγan-u kököl-iyer kigsen tuγ sulde cine"[6] хэмээн Сөнөдийн Гилүгэдэй баатар Чингисийн шарилыг залж явахдаа айлдсан айлтгалд өгүүлдэг билээ. Чингисийн хар сүлдийн үүсэлтэй холбогдсон олон домог байдгийн нэгд ийн өгүүлжээ. [Чингис хаан нэгэн удаа дайнд ялагдахад унасан морины хөлстэй эмээлээ авч дээш хандуулан тавьж "Тэнгэр эцэг ээ! Намайгаа тэтгэж авна уу үгүй юу?" хэмээн мөргөхөд агаар тэнгэрт маш их дуун гарч хар хурмаст тэнгэр дээрээс хар сүлд бууж ирснийг Чингис хаан Мухулайг /Мухали/ тосч ав гэж зарлиг болгосонд Мухулай /Мухали/ тосч хээр азарганы онгон мундаан дээр залж аваад тайш тахих тухай асуусанд Чингис хаан "Мянган олноо базааж, түмэн өтгөөр сахисугай" гэж тангараг өргөөд есөн ес наян нэгэн хээр азарганы дэлийг навсалзуулан чимж түмэн отго бүрдэж үл амжвал ес ес наян нэгэн хонины нэг нэг сээртэй зүлдээр тахилга өргөөд үлдсэн дутуу тоог нь манай монголын мал сүргээс тэнгэрийн чинь гүйцэтгэн барьтугай хэмээн тайш тахиад дайны сүлд болгосон учраас эдүгээ болтол луу жил тохиолдмогц мянган өтгөөр тахисаар ирсэн байна].[7]

Чингисийн "дөрвөн хөлт хар сүлд"-ийг хурмастаас бууж ирсэн гэх тул орон гэрт оруулалгүй мөнх тэнгэрийг бараадуулан гадаа тахидаг нь ч домгийн утга гарвалтай учир холбогдолтой юм.


"Дөрвөн хөлт хар сүлд"-д дайсны зоригийг мохоох, омог сүрийг дарах догшин зүс хар өнгийг сонгосон нь угтаа мөнх хөх тэнгэрийг бэлгэдсэн хэрэг байлаа. Мөнх тэнгэрийг "Монголын нууц товчоо"-ны олон хэсэг бүлэгт /§ 1,80, 125, 149, 163, 167, 177,

187, 189, 197, 199, 201, 203, 207, 208, 224, 240, 246, 256, 260, 268, 275 гэх мэт/ байгаа нь тухайн үеийн нүүдэлчин омог аймгууд, түүний дотор монгол угсаатан нь "тэнгэр шүтлэг"-тэй байсантай холбоотой юм.




§ 199... bidan-i ecine ber bö'esü ile metü qolo ber bö'esü oyira metü setkijü yabu'asu de'ere tenggeri-de ber ihe'ekdemüi-je ta ke'en jarliq bolba...

§ 224... edö'e möngke tenggeri-yin güsün-tür tenggeri qajar-a gücü auqa nemekdejü gür ulus-i sidurqutqaju qaqca jilu'a-dur-iyan oro'uluqsan-




tur edö'e nadar kesikten turqaq minqat minqad-aca ilqaju oro'ulurunkebteül qorcin turqaq oro'ulurun tümen du'urgen oro'ulutqun ke'en jarliq bolba... Эл хоёр хэсэгт "de'ere tenggeri-de ber ine'ekdemüi-je", "möngke tenggeri-yin güsün-tür", "tenggeri qajar-a gücü auda nemekdejü" хэмээснээс үзвэл мөнх тэнгэрийг дангаар нь зарим тохиолдолд "мөнх тэнгэр"-ийг газрын хүчтэй хамтад дурдсан нь тодорхой байна. "Монголын нууц товчоо"-нд тэнгэрүүдийг ялган хэрэглээгүй ч гэсэн дээд тэнгэр, өвөг тэнгэр гэгдэх "Мөнх тэнгэр"[8]-тэй холбоо бүхий Чингис хааны "тэнгэр шүтлэг" нь "Чухамхүү тэнгэр, газар, хүн гурвын эе эвийг маш сайтар зохицуулсан хосгүй шүтлэг мөн"[9]. Мөнх тэнгэр гэсэн хэллэгийн цаана "хөх" хэмээх өнгийн тодотгол ойлголт бий. Мөнх тэнгэрийн хүчин дор оршдог гэж үздэгээс аж төрөхийн үйлээс аваад төр ёсны явдлыг ч түүнтэй холбон үзсээр байжээ.



§ 203... basa gür irgen-ü qubi qubila-qsan-i jarqu jarqulaqsan-i kökö debter bicik bicijü debterlejü uruq-un uruq-a gürtele sigi-qutuqu-yin natur eyetüjü yosulaju kökö bicik caqa'an ca'alsun-tur debterleksen-i bu ye'ütketügei yeütkekün haran aldaltan boltuqai ke'en jarliq bolba...

Чингис хаан монгол омог аймгийг нэгтгээд урьдын гавьяат нөхдөө өргөмжлөхдөө Шихихутагийг "улсын дээд заргач" болгохдоо "kökö debter bicik bicijü debterlejü" "kökö bicik caqa'an ca'alsun-tur debterleksen-i" гэхчлэн "хөх дэвтэр", "хөх бичиг"-ийг цохон тэмдэглэжээ. Ингэж хөх өнгийг цохсон нь Чингис хаан мөнх тэнгэрийн ивээлээр улс гүрнийг тохижуулсан гэх тул үүх түүхийг бичих нь бас л түүний зарлигаар гүйцэтгэх үйл хэмээн үзсэний гэрч юм.



§ 179. basa cinggis-qahan jamuqa anda da ügüle ke'en ügülerün qan ecige-dece mini üjen yadaju qaqaca'ulba ci urida bosuqsan bidan-u qan ecige-yin kökö cung u'uqu büle'e nada urida boscu uqdarun nayidaba-je ci edö-e qan ecige-yin kökö cung baratqun kedüi-je qoroqun ta ke'ejü ileba Энэ жишээний дотроос "kökö cung" (хөх цун) хэмээх хэллэг анхаарал татах ажээ. Хажуугийн хятад орчуулгад "жүн" гэж бичсэнийг авиа, утгыг ижилсүүлсэнээр үзвэл эртний хятад хэлнээ "хонх"-оос гадна "архины сав" гэсэн утга хадгалагджээ. Харин орчин цагийн хятад хэлнээ "хонх"гэсэн утгатай юм. Хятад хэлний "ерөнхий орчуулга"-д "хөх жүн" хэмээжээ.

Элдэнтэй, Ардаажав нар [цүн хэмээх нь" архины сав хэрэглүүр болой. Эртний монгол дор хаан, ван, жич ван гүн язгууртан хэн алин боловч архины хурим хийх үе дор цөм нэгэн зүйлийн "цөм нэгэн зүйлийн архи хадгалах сав" -ыг бэлтгэж байдаг болой. Энэхүү "архины сав" нь эсхүл арьсан тулам, шаазан вааран сав, модон сав буюу эсхүл алт мөнгө, хаш чулуу тэргүүтнээр үйлдсэн байдаг. Түүний нэр нь эрэн цаг, газар орны адилгүйгээс өөр байжухуй. Хэрэйд аймгийнхан "цүн" буюу "төрөгэ" хэмээмүй. Монгол аймгийнхан "түсүргэ" буюу "хөхүүр" хэмээв...][10] гэсэн бол Мансан [... эртний Хэрэйд аймгийн "цүн" нь орчин цагийн монгол хэлний "хөхүүр" болно. "Их түсэргэ" гэдэг нь энгийн "хөхүүр" буюу анхан Хэрэйд аймгийн хэрэглэж байсан "цүн", "төрөгэ"-ээс их байж мэднэ. Өвөрмонголын баруун болон Хөх нуур, Гансу мужийн Сүби монголд өвтэгш их хурим чуулган найр наадам болбол сөн "sun" гэдэг хүнд ёслол явуулж "Сөнгийн ерөөл" хэлдэг. Сөн гэж найрын голд тавьсан том савтай архийг хэлдэг буй. Энэ "сөн нь" эртний Хэрэйдийн "цүн"-гийн авианы хувирал байж болох юм... Тус бичгийн уул эхэд өгүүлж бүхий "түсүргэ" гэдэг нь одоох дээд монголын найрын ёслолын сөн буюу][11] гэжээ. Д.Цэрэнсодном."... Энэ нь орчин цагийн монгол хэлний цомоо гэдэг үгийн хуучин хэлбэр бололтой. Нууц товчооны эдүгээгийн монгол хэлээр буулгасан хүмүүсийн дотроос Бөххишиг (1941,152) эн тэргүүнээ чуму гэж хөрвүүлсэн билээ. Бидний бодвол Чингис хааны Жамухад хэлүүлсэн эл ёгт уттатай үгэнд хааны хайр хишгийг түүний хөх цомоо буюу айргийн аягаар төлөөлүүлж хэлсэн бололтой байна."[12] хэмээн тайлбарлажээ. "kökö cung" гэсэн хэллэгийг С.Козин "Бывало тому из нас, кто вставал раньше, полагалось пить из синей чаши хана и отца... Осушайте же теперь отцову-ханскую синюю чашу"[13] хэмээн орос хэлээр, Ф.Кливез

§ 179.[34] ... mhe one of which rose up first was wont to drink [from] the blue goblet of the father the Qan[41]... Now, empty [ye] the blue goblet of the father the Qan..."[14] хэмээн англи хэлээр тус тус орчуулжээ. Эдгээр жишээ тайлбараас үзэхэд "kökö cung" гэдэг нь

1. Арьс, шаазан ваар, мод, алт, мөнгө, хаш чулуу зэргээр үйлдсэн архины сав.

2. Эртний монголын ихэс дээдсийн архины хурим хийх үедээ хэрэглэдэг архи хадгалах том сав

3. "түсүргэ", "хөхүүр", "гөрөгэ", "сөн", "цомоо" мэтээр нутаг нутагт янз янзаар нэрлэж ирсэн сав, түүний дотор Хэрэйд аймгийнхны "цүн" хэмээн нэрлэж хэрэглэдэг савыг хэлсэн аж. Эдгээр тайлбарт сэтгэл ханалгүй "qan esige-yin kökö cung" гэж чухам юугаар хийсэн сав бол хэмээн төсөөлөн бодож аман түүхийн эрэлд миний бие мордов. Тэр эрлийн явц дундаа Монгол Улсын их сургуулийн багш, манж, хятад, япон хэлийг эзэмшсэн галзууд овгийн Ядамсүрэнгийн Шаарийбуу (1909 онд төрсөн) авгайгаас [хирсний хамар дээрх эврэн суулгыг ихэс дээдсийн дээдэлдэг "хөх цүн" гэдэг гэж хуучцуул ярьдагсан] (1988.8.15) гэсэн үг сонсов. Үүний мөрөөр ном хэвлэл шүүрдэж, эртний хятадад хирсний хэлбэрт сав буюу хундага байсан [15] төдийгүй хирстэй төсөө бүхий "Ши" гэх амьтны ганц эврээр архины сав[16] хийдэг уламжлалтай байжээ гэдгийг мэдэв.

Хирсний эвэр нь дорно дахины "найман эрдэнэ"[17]-ийн нэг бөгөөд лууны сувд, алтан зоос, "чулуун цаг", ном судар зэрэгтэй нэгэн хүрээнд эрхэмлэгддэг ажээ. Түүгээр ч үл барам "хирсний эврээр янз янзын гоёл чимэглэлийн дүрс сийлдэг. Эвэр нь бас шингэн хадгалдаг сав болдог. Эвэр нь хөлөрч дотор буй шингэнд хор бүхийг илрүүлдэг. Эврийг үрж, зорж, үйрмэг болгон эмнэлгийн зориулалтаар эдүгээ ч хэрэглэдэг бөгөөд хар, алаг эвэр нь сэргээх үйлчлэлээр илүүтэй сайн"[18] ажээ. Хожмын монгол эх сурвалжуудад ч гэсэн [...эвэр нь хятад аягыг хөмөрсөн мэт бөгөөд ихэнхдээ хамрын үзүүрт гагцаар ургадаг... Цагаан, алаг, хараар нь дээд, доод буюу сайн мууг ялгана... "Тодруулагч зул"-д цагаан нь хорын халууныг арилган үйлдэнэ... Алаг нь хорыг сахина (хороос хамгаална). Хар нь идээ, цус, шар усыг хатаан үйлдэх болон...][19] хэмээжээ.

Эдгээрээс үзвэл дээр үед хан дээдэс, хорт шингэнийг хийхэд хөлөрч мэдэгддэг хирсний эврэн суулгатай байсан нь тухайн цагийн амьдрал ахуйн шаардлагатай амин холбоотой байсан гэж хэлж болно.

Учир нь Тэмүжиний эцэг Есүгэй баатарт татар иргэн "qoro qoliju ökci'üi" хийгээд тухайн цагт тэгж хорлох нь цөөн бус байсан нь мэдээж. Тийм нөхцөлд "kökö cung" хэмээх хирсний эврээр хийсэн суулга нь айраг, архи хийх зориулалттай төдийгүй элдэв муу санаатны хорлолыг мэдэх, түүнээс сэргийлэх аргыг давхар хадгалсан байжээ. Үүгээр үзвэл "qan ecige-yin kökö cung " хэмээн нэршсэн нь Мөнх хөх тэнгэрийн хүчийг бишрэн шүтэгч удам угсаа бүхий дээдсийн хүндэтгэлийн бэлгэдэл болсонтой нь холбоотой гэж үзэж болно. Үүний дээр "Хааны хайр хишгийг түүний хөх цомоо буюу айргийн аягаар төлөөлүүлж хэлсэн бололтой" гэсэн тайллыг нэмж дурдахад илүүдэхгүй.

Эдгээрээс үзэхэд цагаан, хар, хөх өнгө нь эгэл ардын ёс заншлаас эхлээд төр ёсны хүндэтгэл үйлдэлд хүртээл түгээл болж байсан бэлгэдлийн өнгө юм. Өнгөний бэлгэдэл нь хүн зоны юмс үзэгдэлд бодитой хандахаас эхлээд хийсвэрлэн ойлгох, хийсвэрлэхээс аваад бодитойгоор ухаарахын хэлхээг илэрхийлснээр ёс заншил, сэтгэхүйг шинжлэх бусад салбарын гүнд нэвтрэх мөн чанарыг танихад нэгэн тулгуур болно.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ /Эртнээс XIY зуун хүртэл/ УБ., 1987, 64-р тал
2. Д.Цэрэнсодном. Монгол ардын домог үлгэр. УХГ. УБ., 1989. 9-р тал. /Уг номын 67-70-р талд нийтлэгдсэн "Ам цагаан бяруу" домог үлгэрийн утгыг хураан өгүүлбэл ийм буюу.


"Эрт цагт нэгэн өвгөний үнээнээс цээжин бие нь хүн шиг бөгсөн бие нь үхэр шиг сонин тугал гарч торнисон нь ам цагаан бяруу юмсанжээ. Ам цагаан бяруу баатарлаг үйл олныг хийж хүн амьтанд тус хүргэсний ачаар тэнгэрт гарч тэнгэрийн цагаан хаантай золгожээ. Ам цагаан бяруу тэнгэрийн хааны хүсэлтээр шуламсын хааныг хорложээ. Энэ явдлыг шуламсын хааны эх эмгэн мэдээд ам цагаан бярууны хойноос шидэт төмөр хэдрэгээ шидэж долоо хуваасаас тэнгэрт долоон бурхан бий болсон гэлцдэг".

3. Arban qoyar jil-ün maytayal. Irügel maytayal-un tegüburi. öbür mongyul-un soyul-un keblel-ün qoriy-a, 1983, 502 duyar tal-a
4. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин /Аяны тэмдэглэл/, УХГ. УБ., 1987, 103-р тал
5. Х.Нямбуу. Хүндлэхийн дээд Хөх монголын төрийн ёслол Чингисийн тахилга. "Алтан үсэгт" компани /ББХК/. Өндөрхаан. 1992, 146-147-р тал
6. Altan tobci /Hans-Peter Vietze, Gendeng Lubsang). Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von Blo bzan bstan'jin. Text und Index. Tokyo, 1992, p. 89
7. Х.Нямбуу. Хүндлэхийн дээд Хөх монголын төрийн ёслол Чингисийн тахилга. "Алтан үсэгт" компани /ББХК/, Өндөрхаан, 1992, 138-р тал
8. Арван гурван Алтайн ариун сангууд оршивай. (Хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо) УБ., 1999, XX тал
9. Норовын Шаралдай. Чингис хааны тэнгэр шүтлэг. "Ил товчоо" сонин. 1996.7.1-10. №19 (203)

10. Eldentei, Ardajab seyiregülün tayilburilaba. Mongyol-un niyuca tobciyan seyeirgülül taiylburi. öbür mongyol-un suryan künüjil-ün keblel-ün qoriy-a . 1986 536 duryar tal-a
11. Mansang. Sin-e-ber orciyulju taylburilaysan. Mongyol-un niyuca tobciyan. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. 1985. 195, 290-291 düryar tal-a.
12. Д.Цэрэнсодном. Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар. Мөнхийн үсэг хэвлэлийн газар. УБ. 2000. 290-р тал
13. С.А.Козин. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г под названием "Mongyol-un niyuca tobciyan. Юань чао би ши-монгольский обыденный изборник. Т-I. Изд. АН СССР М-Л 1941. стр. 136-137
14. The secret History of the Mongols. Translated and edited by F.W.-Cleaves, London. 1982. p. 107
15. Ци хай (Үгсийн далай). "Шан үг" хэвлэлийн газар. 1988. 1079-р тал (хятад хэлээр)
16. Жүн үн да ци дян (Хятад утгын их толь бичиг). Тайваны хятадын дээд сургуулийн Хятад соёл судлах газрын хэвлэл. 1968. 391-392-р тал (хятад хэлээр)
17. Восемь сокровищ. Энциклопедия китайских символов. (Восточный символизм). сост. К.А.Вильямс. Серия "Символы". Книга YI. Изд. В.П Царёва. М. 2000. стр. 69-70
18. Рога носорога. Энциклопедия китайских символов. (Восточный символизм). сост. К.А.Вильямс. Серия "Символы". Книга YI. Изд. В.П Царёва. М. 2000. стр. 304
19. Найманы Жамбалдоржийн зохиосон (XIX зуун)"Анагаан үйлдэгч рашааны эндүүрэлгүй танин барих урлах ухааны толинд сайтар ургасан гайхамшигтай үзэсгэлэнт нүдний чимэг хэмээгдэх оршибай." 117-р хуудасны Б тал (Төвд хэлнээс Ш.Чоймаагийн монгол хэлнээ орчуулснаар иш татав.)

ЗӨН СОВИНГИЙН БЭЛГЭДЭЛ

Алив хүн, сав шимийн ертөнц дэх нүднээ үзэгдэх, үл үзэгдэх бум түмэн сүлжээн дунд аж төрөхдөө байгаль орчинтойгоо, биестэйгээ, хэрэглэж байгаа эд агуурстайгаа харьцахдаа тэдгээрийн утга учрыг өөрийн үзэл бодол, итгэл бишрэлийн үүднээс тайлбарлах, ухаарахыг эрмэлзэх нь зүй юм. Ямар нэгэн сайн хийгээд саар үйлийг урьдчилан мэдэх, түүний элдэв шинж тэмдэг, дохио зангааг улбаалан таних нь хүний оюун мэдрэхүйн эмзэг нарийн увидас мөн. Чухам ийм л увидасыг, нэгэнтэйгүүр тэмдэглэхүүн /онохуй/, нөгөөтэйгүүр тэмдэглэгдэхүүн /оногдохуй/ хоёрын зааг шүтэлцээг болзолт байдлаар дүрслэн үлдээснийг "Монголын нууц товчоо"-ны хэд хэдэн хэсэг, бүлэг тодорхойлж байгаа юм.




§ 80. temüjin siqui dotora qurban qonoju qarsu ke'en moriyan kötöljü ayisuqui-tur morin-aca eme'e[l] inu mültürejü qocorcu'u qariju üje'esü eme'el kömüldürgelekse'er olangla[q] sa'ar mültürejü qocorcu'u olang-ci boltuqai kömüldürge basa ker mültüregü büle'e tenggeri i[t]qan aqu-yu ke'ejü qariju basa qurban qonoba basa qarcu ayisuqui-tur siqui-yin amasar-a qosili[q]-un tedüi caqan gürü amasar-a bö[k]len unaju'u tenggeri itqan aqu-yu ke'ejü qariju basa qurban qonoba

basa yisun qonoq ude'en ügei aju nere ügei ker ükü[k] dekü qarsu ke'ejü tere amasar böklen unaqsan qosiliq-un tedüi caqan gürü horcin qarbasu ülü bolqu modud-i sumuci kitaqai-[ba]r-iyan hoqtori'at mori-yan qaltari'ulu'at qarqui-lu'a tayici'ut sakiju aju'u bariju abcu otba

Энэхүү хэсэгт хоёр өгүүлэмж гарч байгаагийн нэг нь Тэмүжинг шугуйгаас гарахаар морио хөтлөж явахад эмээл нь мултран хоцорсон явдал юм. Энэ нь жирийн амьдрал дунд учирч болох тохиолдол билээ. Гэвч нягтлан үзвэл, олом суларч, хөмөлдөргө мултраагүй нөхцлийн дунд "morin-aca eme'e[l] mültürejü qocorcu'u" учиргүй юм. Энэ тохиолдолд эмээл мултарч байгаа нь зүйн дагуу болсон явдал гэж үзэхэд эргэлзээтэй ээдрээтэй болж, Тэмүжинд "тэнгэр ятган аху..." гэх сэтгэгдэл төрүүлжээ.

Ийм л сэтгэлэг бишрэлийн үүднээс Тэмүжин шугуйдаа буцан гурав хоноглохоос өөр аргагүйд хүрчээ. Үүнд морины эмээл хар зөндөө унасан нь цаанаа сайны бус саарын ёр зөн совин татаж байгаа бэлгэ тэмдэг юм. Мориноос мултран хоцорсон эмээл /онохуй/ нь, түүнээс Тэмүжиний сэтгэхүйд өгч байгаа ёр дохио /оногдохуй/ хоёр харилцан хүртэлцэн авалцсаны дунд зөн совингийн бэлгэдэл тод болжээ. Чухам ийм зөн совингийн тодрол "Монголын нууц товчоо"-нд хэдэнтээ давтагдаж гарсан болно.



§ 101. tede ceri'üt tedüi qataraba qo'aqcin-emegen bö'ere alaq hüker-iyen deledü'et öterlen ne'ügü bolun tergen-ü tenggeli ququs otba tenggeli-ben ququra[q] daju yabuqad-iyar hoi-tur güyijü oroya ke'eldün bükü-tür daruca müt ceri'üt belgütei-yin eke-yi sundula'ul(du)ju qoyar köt(?) inu cerbegelje'üljü qadaraju gürcü ire'e[t] ene tergen dotora ya'un te'ejü amu ke'eba qo'aqcin-emegen ügülerün ungqasun te'ejü amu ke'ebi tede ceri'ud-un aqa-nar inu ügülerün de'ü-ner kö'üd-iyen bawuju üjetkün ke'eba de'ü-ner kö'üt inu bawuju qa'atai tergen-ü qa'alqa abqui-lu'a dotora qatuqje(?) gü'ün sa'uju imayi tergen-ece circü bawulju qo'aqcin jifin-i sundula'ulju abu'at temüjin-ü qoyinaca ebesün-ü alurqai-bar mö[c] gijü burqan jük qarba

Тайчуудын цэргийн хөлөөс дайжин Түнхэлэг горхин өөд яаран мэгдэн зуттаж явах зам гудас Хуагчин эмгэний хөллөсөн "tergen-u tenggeli ququs" одож байгаа нь эдэлгээ цаг нь болоод эвдэрч хуґарч байгаад уттын гол ноогдсон нь бус. Тэнхлэг хугарна гэдэг тэрэгний цааш явах зам мухардалд орж, эзний хувь заяа бүтэлгүйгээр эргэхийн зөн дохио мөн. Тиймээс ч Тайчуудын гарт Өэлүн-үжин орох, Тэмүжинг цааш мөрдөн мөшгөхийн зангилаа нь "tergen-ü tenggeli ququs" одсон нь болно. Ийм саад тотгор, түүнийг ёрлосон зөн бэлгэ Тэмүжинд төдийгүй өрсөлдөгч дайсагнагч нарт нь хүртэл учирч байжээ.



§ 158 ... yedi-tubluq neretü noyan inu qara'ul yabuju bidan-u qara'ul-a hüldekdejü a'ula ö'ede tuta'aqu bolun olang-niyan tasuraqdaju tende bariqdalu'a... Энэ хэсэгт Еди Тоблуг "olang-niyan tasuragdaju"- нь түүний баригдах, үйлс нурах, Найман сөнөхийн үүдэл болжээ. Тиймд энэ явдлын "зангилаа" олон/олом/-аа тасрагдаж байгаа өгүүлэмж нь муу ёрын зөн болсон нь илт байна. "Эмээл мултарч", "тэнхлэг хугарч", "олом тасарч" байгаа нь бүслэгдэж хоригдсон хийгээд зуттаж мэгдсэн тухайн цаг нөхцлийн

дунд таарсан нь бүгд л аюул занал уттаж, муу явдал болохын ёр, зөн совинг давхар нөхцөлдүүлсэн байна. Чингэж хүний эдлэж хэрэглэж байсан /байгаа/ зүйлс /эд өлөг/ мултарч, тасарч, хугарч байгаа нь цааш өрнөх үйлс буруугаар эргэж, зам мөр нь хаагдаж байна гэсэн үг. Дээрхи өгүүлэмжүүдээс харахад Тэмүжин, Хуагчин эмгэн, Өэлүн-үжин нар Тайчуудад олзлогдож Еди Тоблуг Чингис /Тэмүжин/ хаанд баригдах нь зайлшгүй боловч уг "эмээл мултарч", "олом тасарч", "тэнхлэг хугарч" байгаа тохиолдол санамсаргүй мэт дүрслэгджээ. Үүнээс зөн совингийн бэлгэдэл санамсаргүй шинжээр илрэх авч зайлшгүйд хүрэх үүдэл болдог гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Аливаа болох зүйлийг зөн совингоор урьдчилан мэдрэхүйн өнгө аяс нь Монгол ардын аман зохиол, домог, үлгэр туульсад олонтаа тусгагдан үлдсэн байдаг юм.

"Даньхүрэл" туульд Даньхүрэлийг найман түмэн мангастай тулалдаж байхад

Гомтын /Гонто - ховдог/ улаан жад нь
Голоороо хугараад ойчив"[1]
Энэ явдалд Даньхүрэл их эмзэглэж
"Над болшгүй
Юм болжээ
Иршгүй юм
Иржээ" гэж хэлдэг.

Энэ зөн ёр нь дайсны далан жад Даньхүрэлийн дүү Заан Буйдангийн чээжинд орсноор тайлагдаж байна.

"Гөшөө чулуун зүрхт Хүвэй сайн Буйдар хүү" туульд аав ээж хоёрыг нь төмөр шилбүүрээр ороолгоод аваад явсан Үхэр улаан мангастай тулалдахаар одох замд нь Хүвэй сайн Буйдар хүүгийн өмнө цагаан хад тулгарахад ухаант морь нь "Мангасын хортой цагаан хад" гэж хэлж өгч "тас харваад гарах"-ыг зөвлөдөг юм. Түүнээс хэдэн бадгийг сийрүүлэх ийм буюу:


1150 Мангасын хорт цагаан
Хаданд тулж

Хар хархан хатирч
Хангинатал исгэрээд явтал
Алхуйн сайн хул морь
Цусаар шээгээд явахыг байжээ
Хөшөө чулуун зүрхт
Эрдэнэт хүлэг байтал
Эзнээ явгалах гэдэг
Энэ үү! гэсэнд,
Нүүрэндээ үсгүй хүний
Үр байтал
Нүүрэндээ үстэй
Адгуус надаас дор уу?
Дээгүүр яваа шувуу жигүүртэн
Доогуур яваа
Улаан хөлт амьтан хорддог
Мангасын цахир цагаан
Хад энэ байна!
Энэ хадыг дээгүүр нь
Давж гарч болохгүй
Хажуугаар нь тойрч гарч болохгүй
Гоо сайхан бэргэн
Авхай чинь хэлсэн биш үү?
Чи сайн эр бол
Энэ хадыг харваад гар!
Муу эрсэн юм бол
Энэ биенийхээ мэнд дээр
Эмээл хазаарынхаа бүтэн дээр
Эргэж нутагтаа буц! гэжээ. [2]

Итгэлт хүлэг мориноос аваад эцэг эх нь хүртэл далдыг мэдэж аюулын дохиог зөнгөөрөө урьдчилан хэлж өгдөг нь "Бүжин Даваа хаан" туульд ч бас дэлгэрэнгүй дүрслэгдсэн байдаг юм.


Монгол ардын үлгэр, туульсын алив болох үйл зөн совинд урьдчилан мэдэгдэх түгээмэл дүрслэгдэхүүнтэй холбон ярьж болох жишээ § 80 зүйлийн "шугуйн амсарт бөглөн унасан хошилигийн төдий цагаан гүр /чулуу/-ийн тухай хоёр дахь өгүүлэмж юм. Цагаан гүр /чулуу/ угаас байсан ч гэлээ Тэмүжингийн морио хөтлөн шугуйгаас гарах гэж явах замд таарсан нь зориуд л шугуйн амсар бөглөн унасан мэт түүнд нэгийг санагдуулжээ. Энэ нь Эргүнэ-Кунгийн домог, түүнд гарах "сүрхий хавцал, уулын давчуу сүв"-ийг сэтгэлд оруулах дүрслэл юм. "...Одоогоос хоёр мянган жилийн тэртээ эрт цагт монгол хэмээн нэрийдэж агсан тэр аймаг бусад түрэг аймагтай зөрчил тэмцээн болж, тэр нь дайн тулалдаанаар төгсжээ. Бусад аймаг нь монголчуудыг ялан дарж, хядахад нь хошоод эр эмээс илүүгүй хүн амьд үлдсэн хэмээн хүндэт итгэмжтэй хүмүүсийн ярьдаг өгүүлэл буй. Тэр хоёр өрх айл дайснаас айн тийшээ нэвтрэн очиход бэрх бартаатай ганц нарийн зөргөөс өөр хаанаасаа ч орох замгүй уул хад, их ой л хүрээлсэн хэцүү нутагт очжээ. Тэр нь уул хадны дундуур элбэг өвстэй эрүүл тал нутаг байжээ. Тэр нутгийн нэр нь Эргүнэ Кун... Тэр хоёр хүний нэр нь Никуз, Хиан байжээ... Төрж олширсоор тэдний овог олон болжээ... Тэр угсаатан нь тэр уулс, ойн дунд үржин өргөжөөд, нутгийн зай нь давчдан, хүрэлцэхгүй болохоор тэр сүрхий хавцал, уулсын давчуу сүвээс ямар сайн арга, хялбар замаар гарахыг бие биеэсээ зөвшин асуулцжээ. Чингээд тэд төмөр байнга хайлуулдаг байсан төмрийн хүдрийн орд нэгэн газрыг олжээ. Тэд бүгдээр цуглаж, ойд их түлээ зэхэж, бүхэл бүтэн тулмаар нүүрс бэлтгэж, далан морь, шар нядалж, ширий нь бүхэл өвчин, төмөрчний хөөрөг хийгээд, түлээ нүүрсийг тэр хэвгий уулын хормойд зэрэглэж, далан хөөргөөр уулын бэлийг хайлан урстал нэгэн зэрэг хөөрөгдөж байхаар зэхжээ. Тэгээд хэмжээлшгүй их төмөр авч, уулын сүвийг онгойлгожээ. Тэд нар хавцлаас цөм цуг нүүдэллэж, уудам, том нутагт гарцгаажээ...[3] Эргүнэ-Кунгийн домгийн "ганц нарийн

зөргөөс өөр хаанаасаа ч орох замгүй уул хад, их ой мод л хүрээлсэн хэцүү нутаг, "Монголын нууц товчоо"-ны



§ 102 ... ümbü sibar berke hoi inu catqulang moqai-ya sirqu'asu ülü bolqu berke siqui... хоёр, мөн домгийн олон он жилийн дараа хүдрий нь хайлуулан гарч байгаа хадан хавцал, § 102 хэсэг дэх шугуйн амсар бөглөн унасан цагаан гүр /чулуу/ нь дүрслэлийн хувьд яах аргагүй уламжлалын холбоотой гэж үзмээр байна. Хад чулуу хэн нэгний явах гарах замыг хаадаг, тэр нь сэрэмж дохио болдог мэтчилэнгийн ийм дүрслэл бол, чулууг эрхэмлэх, дээдлэх, шүтэх бишрэх ёстой холбоотой гэж үзнэ.

Хад чулууг эрхэмлэн шүтэхийн ул мөр "Монголын нууц товчоо"-нд хэдэнтээ дүрслэгдсэний нэгийг иш татвал ийм буюу.



§ 143 manaqarsi yabu'ulju gürülcejü köyiten bayi[l]duju doroqsi de'eksi iquriqaldun jibsi'erülcen büküi-tür müt buyiruqqan quduqa qoyar jada medekün aju'ui jadalaqun bolun jada hurbaju müt anu de'ere jada bolju'u müt yabun yadaju nurastur quladu'at tenggeri-de ese ta'alaqdaba bida ke'eldü'et butaraju'ui


Энэ хэсэгт Чингис хаан, Ван хан хоёрын хамтарсан хүч Хүйтэн хэмээх газарт Жамухагийн цэрэгтэй тулалдаж "doroqsi de'eksi iquriqaldun jibsi'erülcen" бүхийд Найманы Буйраг, Ойрадын Хадуга нар зад мэдэх учир задлах болсонд өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр, хараал хар толгой дээр гэдгийн үлгэрээр нөгөөх /зад/ нь урваж /эргэж/ дээр нь /өөрсдийн толгой дээр/ зад бууснаас нуранхайд гулсан хөдлөх аргагүйд хүрч "тэнгэрт эс

таалагдав бид" гээд бутарсныг өгүүлжээ. "jada medekün", "jadalaqun bolun", "Jada hurbaju", "de'ere jada bolju'u" гэсэн хэллэгийн цаана Төв Азийн улс үндэстний дотор өргөн дэлгэрсэн "Зад", "задлах"-ын түгээмэл ойлголтоор бол хур бороо, салхи шуурга мэт байгалийн үзэгдэл урсгалтай холбогдуулж дутуудсаныг нь урьж буулгах, илүүдсэнийг нь хариулж зайлуулах увидас мөн."Задын чулуу" /чулуун зэвсгийн үеийн үлдэгдэл буюу гөрөөс, хойлог, загас, үхрийн бөөр цөсөнд байдаг гэлцэх талст/, "зад өвс" /алтан тэвнэ, мэргэн гүнж нэртэй ургамал/-ийг ашиглан зад задладаг / зад барьдаг, зад тавьдаг/ байжээ.

Дээрхи өгүүлэмжид бурууг үйлдсэнээс /зад задлах болсноос/ болж уршиг нь өөрсдийн толгойд буусантай холбогдуулж "tenggeri-de ese ta'alaqdaba bida" хэмээсэн нь "задлах" үйл тэнгэрт хамааралтай гэх ойлголтыг давхар агуулж байгаа болно.

Эдгээр жишээ баримтаас үзэхэд үйл явдалтай уялдуулж "tenggeri i[t]qan aqu'yu","tenggeri-de ese ta'alaqdaba bida" хэмээн хэдэнтээ давтаж байгаа нь болох үйлдлийг урьдчилан харж, хэн нэгнийг аварч ачлах, хэн нэгэнд гэсгээл шийтгэл үзүүлэхийн тулд ямар зөн бэлгэ, ёр совин угтуулахыг "тэнгэрийн таалал"-тай холбосон байна. Ингэж тэнгэрийг хүний итгэл бишрэлийн дээд, бүхнийг мэдэгч заагч болгон өргөмжилж, "тэнгэрийн таалал"-д эс нийцвэл, түүний ятгалганд эс орвол аюул сүйрэлд учирна гэдгийг дүрсэлсэн нь монголчуудын бөө мөргөлийн шүтлэг ёстой холбогдоно.

§ 121. qorci irejü ügülerün bodoncar boqdo-yin bariju abuqsan eme-dece töreksen ba jamuqa-lu'a ke'eli niketen keke qaqcatan büle'ei ba jamuqa-daca ülü qaqacaqun büle'e ba ja'arin irejü nadur nidündür-iyen üje'ülba qo'aqcin üni'en irejü jamuqa-yi horciju yabuju ger tergen inu mürgüle'et jamuqa-yi mürgüjü öre'ele eber-iyen ququraju so[l] jir ebertü bolju eber minu aca ke'en ke'en jamuqa-yin jü[k] mö'ören mö'ören siro'ai sacun sacun bayimu muqular qo'a hüker yeke gerlüge de'ere ergüjü köljü jitküjü temüjin-ü qoyinaca yeke terge'ür-iyer mö'ören mö'ören ayisurun tenggiri qajar eyetü[l] düjü temüjin-i ulus-un ejen



boltuqai ke'en ulus te'ejü a[b]cu ayisu ke'en ja'arit nidün-tür üje'ü[1]jü nadur ji'amui, temüjin ci ulus-un ejen bolu'asu namayi ji'a[q]san-u tula ker jirqa'u[1]qu ci ke'eba temüjin ügü=lerün ünen teyin ulus mede'ülü'esü tümen-ü noyan bolqasu ke'eba ele edü törö-yi ji'aqsan gü'ün-ni namayi tümen-ü noyan bolu'asu ya'un jirqalang bui tümen-ü noyan bolqa'at ulus-un qo'as sayit ökit darqalan abqa'ulju qucin ba emestü bolqa basa ya'u ba keleleksen-i minu esergü sonos ke'eba Заарин ирж зааж өгүүлсэн гэх Хорчийн өгүүлэмжээс юуны өмнө "ke'eli niketen keke qaqcatan büle'ei ba" хэмээсний "niketen"(nike), "qaqcatan" (qaqca)

гэдэг нь "ke'eli","keke" гэсэн үгстэй хослохлоороо салшгүй нэгдмэл, хагацаж болохгүй гэсэн утгыг агуулж байна. Үүнд "нэг"-ийн тооны "nike", "qaqca" гэсэн хоёр хэлбэр зөвхөн тэмдэг төдий бус эхийн умайг эрхэмлэх, эхийн талаар хамаархах бэлгэдлийн утгыг илэрхийлснээрээ Хорчоос Жамухад хандах ураг төрлийн хандлага, түүнээс салж сарниж болохгүй гэсэн санааг илтгэв. Гэвч "Бодончар богдын барьж авсан эмээс төрцгөөсөн /§ 38, 40, 41/ Жажирдай хийгээд Баарин удмын холбоо хэлхээг Хорчид гагцхүү заарин л эвдлэж /зөрчиж/ чадна. Үнэхээр заарин ямар нэгийг зааж өгүүлсний учир Баарингийн Хорчи ... нар Жамухагаас салж, Тэмүжинд нэгэн хүрээ болон нийлсэн ажээ. Ингэж нэгээс салгаж, нөгөөд нийлүүлэх хүчин төгс ямар зүйлийг заарин, Хорчид нүдэнд нь зааж үзүүлсэн бэ гэвэл

Нэгдүгээрт, "qo'aqcin üni'en" Жамухаг орчин явж гэр тэргийг нь мөргөж, өрөөсөн эврээ хугалж солжир болоод "эврий минь ац" гэж түүний зүг мөөрөн мөөрөн шороо цацан цацан явсан нь юм. Жамухаг ээрч мөргөж, орон гэрийг сүйдлэн, эврээ хугалж, нэхэл дагал болж байгаа зэрэг нь түүнийг заарин таалахгүйн шинж юм. Ялангуяа ухаагчин үнээ "эврий минь ац" хэмээн Жамухагийн зүг мөөрөн мөөрөн шороо цацлан цацлан яваа нь муу ёр зөгнөсний илрэл юм. Жамухагийн өөдөөс шороо цацална гэдэг нь /хэдийгээр үнээ ч гэлээ/ түүний үйлсийг баллах булах гэсний дохио. Нэгэнт Жамухагийн хувь заяа ийм болох ёр зөнтэй байгааг Хорчи мэдэж түүнээс салах үндэслэл болгосон байна.

Хоёрдугаарт, "muqular qo'a hüker" Тэмүжиний хойноос зүтгэж их тэргүүрээр /замаар/ "тэнгэр газар эетүжү. . . улсын эзэн болтугай" хэмээн мөөрөн мөөрөн явсан нь юм. Мухулар ухаа үхэр "улсын эзэн болтугай" хэмээн Тэмүжиний хойноос мөөрч байгаа нь түүнийг заарин таалсны бэлгэ шинж юм. Нэгэнт Тэмүжиний зураг тавилан ийм болох зөн совинтой нь Хорчи түүн рүү ирж нийлэхийн үндэслэл болсон байна. "Монголын нууц товчоо"-ны энэ өгүүлэмж нь Монголын нүүдэлчний мал амьтны этгээд авир араншингаас үүдэлтэй ёр билгийн үзэлтийн чухал дурсгал болох

"Алив муу ёрыг үзэх бичиг оршвой" (aliba mayui iru-yi üjekü bicig orosibai) хэмээх 22х8,2 см цаасны хэмжээтэй бичмэл сударт "Үхэр, бус адгуусны дуугаар хайлан мөргөн гэр тэргийг тойрон явбаас гэрийн эзэнд үхэл учрах, хэл ам болох (2b) гэх буюу "нүүж явтал үхэр газар малтан мөргөвөөс хүмүүн егүүтгэх. Үтэр бүрэлгэ... Хүмүүний дэргэд үхэр хайлваас өлзийтэй болох" (3a)[4] гэсэн санаатай шууд нийлж байгаа нь сонирхол татаж байна. Ийм ёр бэлгэ XII-XIII зуунд төдийгүй энэ судар зохиогдсон байж болох XVII зуунаас хойш үед ч уламжилж байсны нэгэн баталгаа юм. Дээр дурдсан хоёр өгүүлэмжээс үзэхэд Жамухагийн хувь заяаг муугаар ёрлосон нь ухаагчин үнээ, Тэмүжиний хувь заяаг сайнаар зөгнөгч нь мухулар ухаа үхэр байгаа нь тэрхүү заарины онгон сахиус үхэр байсных бололтой гэж үзнэ. Үүнийг Монголчууд болон монголчуудтай удам гарал нэгтэй овог аймгийн онгон шүтээний дотор үхэр багтаж байсан баримт ч гэрчлэнэ. "Онгон шүтэх ёс бол монголчуудын хамгийн эртний шүтлэг бөгөөд юуны өмнө адгуус амьтныг шүтэхээс эхэлжээ. Чухам Хүннү, Сяньби, Кидан, Монгол болон тэдний салбар аймгууд буга, морь, үхэр, чоно зэрэг адгуус амьтныг онгон болгон шүтэж байсан явдал үүний нэг тод баталгаа мөн".[5]

Урин дулаан цаг ирж, мал төллөж эхлэх үеэр ууган төлийн эх /хонь, үнээ, ингэ, гүү/-ээс саасан ариун цагаан сүүнээс дээжлэн авч "цацал өргөх ёс" үйлдэж ерэн есөн тэнгэр, далан долоон идээний эзэн уул усанд өргөж ирсэн нь монголчуудын эртний уламжлалт зан үйлийн нэг юм. "Үхрийн үрс гаргах ёсон оршибай" сударт:

"...Анхлан тугалласан үнээний сүүг
Ариун сав дор амсалгүй хадгалан авч...
Эмүгийн дээд
Эрхт хөх тэнгэр
Эл этүгэн эх
Хамгийн дээд
Хан мөнх тэнгэр

Хан газар усан
Түмэн одод
Өдрийн сайныг эрэн
Цагаан үнээний сүүгээр
Газар усны эзэд
Цагаан өвгөн дор
Есөн ес цацан өргөмүү..." гэж өгүүлжээ. Эл сударт:
"Цагаан өвгөн дор
Есөн ес цацан өргөмүү"
гэснийгээ тодосгож
"Хайнаг сарлаг үхэр өсгөгч
Мянган нүдэт мялзангийн хаан
Хамаг газар дэлхийн усыг эзлэгч
Цагаан өвгөн нэгэн чанар буй" [6]


хэмээн дурджээ. Чингэж Цагаан өвгөнийг уул усны эзэн хэмээхийн зэрэгцээ үхрийг өсгөгч тэнгэр гэж үзэж онгон сахиусанд цацал өргөж байсныг харуулж байгаа юм. Заарины "ухаагчин үнээ", "мухулар ухаа үхэр"-ийн үйлдлээр зааж үзүүлсэн зөн совин ёсоор болж байгааг /§ 123/ Хүрэлх доторхи Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нуурт Тэмүжиний улсын эзэн болсон хийгээд Жамухагийн түрэгдэж шахагдаж яваа хувь заяа илтгэж байгаа болно. Үүнээс үзэхэд заарины зааж үзүүлсэн бүхэн нь бөөгийн мөргөлд үндэс салаатай, тэнгэр шүтлэгт тулгуурласан гэдэг нь тодорхой болж ирж байна. Тэнгэр шүтлэг бол монгол зөн бэлгийн гол тэмдэглэгдэхүүн, аливааг урнаар өгүүлэхийн нэг дүрслэгдэхүүн юм.

Зөн совингийн бэлгэдлийн нэгэн эд эс нь зүүдний бэлгэдэл мөн. "Ухамсаргүй" сэтгэлгээний шинж тэмдэгийг ашиглан, "далд ухамсар"-ын гүнд нэвтрэх нэгэн түлхүүр нь зүүд, түүний бэлгэдэл мөн. Зүүд бол хүний ухамсар сэтгэхүй мэдрэхүйн битүүлэг нууцлаг шинжийг хадгалж ирсэн ухагдахуун юм. Тиймээс зүүдний талаар өрнө, дорнын эрдэмтдийн хийсэн туршлага, тайлбар хэдийгээр олон бий боловч нэгэн мөр

томъёололд нийтгэгдсэн нь одоо хир үгүй юм. Тэдний дотроос Зигмунд Фрейд /1856-1939/-ийн зүүдний шинжлэл тайлбар нь[7] уг сэтгэхүйн үзэгдлийг гүнзгийрүүлэн судлах шинэ төлөвийг нээж өгсөн юм. З.Фрейд, хүн унтсаны дараа өөрийгөө хязгаарлах хяналт нь сулардаг болохоор түүний саатаж байсан "далд ухамсар"-"хүсэл эрмэлзлэл" нь голлох үйлдэл үзүүлж зүүд үүсгэдэг иймэрхүү хүсэл эрмэлзлэлийн биелэл нь зүүднээ шууд буюу дам эсвэл эсрэг хэлбэрийг авч илэрдэг хэмээн үзсэн юм. З.Фрейд далд утга санааг ухамсаргүй гэдэг, ухамсаргүй мэдлэгийг ухамсартай болгох нь зүүдний тайллын мөн чанар гэж үзэж, зүүд тайллаар "илт агуулгаас далд санааг олно" хэмээн томъёолсон юм. Зүүд тайлбарласан олон жилийн туршлагатаа тулгуурлан З.Фрейд зүүдний бэлгэдлийг гарган ирж "шууд батлах баримтгүй практик хүчин зүйлс", "Энэ нь ямар нэгэн хам сэтгэгдэл олох хэрэггүй тогтмол утгатай бэлгэдлийн /symbol/ чанартай юм" гэжээ. З.Фрейдийн сэтгэц судлал, түүний дотор зүүд шинжлэлийг хөгжүүлэгчдийн дотор К.Г.Юнг /1875-1961/[8] "Зүүд бол хамтын далд ухамсарын бүтээгдүүн мөн" гэдгийг цохон тодорхойлсон юм. Зүүдний тухай шинжлэх ухааны тогтолцоот судлалын эхийг өрнө дахинд тавьсан З.Фрейдийн онол, түүнийг залгамжлагчдын бүтээл бидний шинжлэлд арга зүйн ач холбогдолтой гэж үзнэ. Дорно дахиныхан, түүний дотор монголчууд зүүдний хувьд эрт үеэс тодорхой ойлголттой байсан бөгөөд "зүүд өгөх" /бусдад зүүд гүйлгэн өгөх/, "зүүд төөрөх" /Зүүд бодит гэгдэх зүйлээс хэт зөрөх/, "зүүд манах" /сэрсэн үедээ зүүдээ мартахгүй нэхэн санах/, "зүүд тайлах" /зүүдний сайн муух тайлбарлах/ гэх мэтийн хэл хэллэг хэдийнээ тогтож амьдралд хэвшил болсон юм.Зүүдний бэлгэдэл түүнийг тайлах эрмэлзлэл монголчуудын дунд түгээмэл байсны нэгэн жишээ "Монголын нууц товчоо"-нд хадгалагдан үлджээ.

§ 63. yisügei quda bi ene söni jewüdün jewüdüleba bi caqan singqor naran sara qoyar-i atqun nisju irejü qar de'ere minu tu'uba ene jewüdün-niyen gü'ün-e ügülerün naran sara-yi qaraju üjekden büle'e edö'e ene singqor atquju abciraju qar-tur minu tu'uba caqan bawuba

yambar ele sayi üje'ülümü ke'ejü yisügei quda ene jewüdün minu cimayi ele kö'ü-be'en uduritcu iregüi-e üjeksen aju'u jewüdün sayin jewüdüleba ya'un jewüdün aqu ta kiyat irgen-ü sülder irejü ja'aqaqsan aju'u



Энэ хэсэг, зүүд хэмээх цогц ойлголтыг бүрэн бүтнээр нь тусган харуулж чадсан юм. Үүнийг Дэй сэцэн зүүдлэсэн, зүүднийхээ ямарт эргэлзсэн ч зүүд нь бэлгэ дэмбэрэлтэй байсан гэдэг нь эцэстээ тайлагдаж, бодит амьдралд хэрэгжсэнээс ухаарч болохоор байна. Ийм нарийн шатлал бүхий зүүдийг авч үзэхдээ болсон явдлын түүхийг улбаалан судлах аргаар уу? Эсвэл зүүдийг шинжлэх аргаар уу? гэсэн асуулт гарч ирэх нь зүй юм. Уг өгүүлэмж нэгэнтэйгүүр болсон явдал, нөгөөтэйгүүр зүүд, түүний тайлал мөн учраас аль алиныг харгалзан дор дурдсанаар шинжлэх нь илүү үр дүнд хүрэх боломжтой болов уу хэмээн бодно. Үүнд:

1. Зүүд гэдэг тэр аяараа зөн бэлгэдэл мөн. Гэвч тухайлсан дээрхи зүүдний хувьд юу нь сайны бэлгэ, юу нь муугийн ёр вэ? гэсэн бэлгэдлийн доторхи бэлгэдэл түүний дэс дарааллаар тодорхойлогдох болж байна.

"naran sara qoyar..." гэдэг монголчуудын хувьд ямар бэлгэдэл агуулж ирсэн бэ? Монгол домог сэтгэлгээнд "Алтан наран гэрэлт, алман саран туяат мөнх хөх тэнгэр..." хэмээн эрхэмлэн хүндэтгэж байжээ. Үүнийг нарийвчлан судласан С.Дулам "Юутай ч гэсэн нар сар хоёр бол монголчуудын эртний


домгийн эцэг эх, эр эм хос тэнгэр, арга билэг хоёр болдог байна"[9] гэсэн дүгнэлтэд хүрсэн юм.


Монголчуудын өвөг гэх Хүннү, Сюнну нарын үед ч тахилга үйлдэж нар, сарыг шүтдэг байсныг "Тавдугаар луу сард луу сууринд их хурилтайд цугларч аваад, тэнгэр дэлхий, онгон хайрхдад тахилга үйлдэнэ... Шаньюй өглөө ордноосоо гарч, ургах наранд, орой саранд мөргөнө"[10] гэсэн жишээнээс үзэж болно. Монголчууд нар сарыг сүсэглэн шүтдэг тухай монгол нутгаар аялаж явсан жуулчид олонтаа тэмдэглэн үлдээсний нэг нь Жиовани дель Плано Карпини "Монголчуудын түүх"-дээ "Тэд аливаа ажил үйлс эхлэхдээ заавал сарын шинийн нэгэнд юм уу эсвэл тэр сартай үед эхлэх бөгөөд сарыг Их эзэн хэмээн шүтэж сөгдөн мөргөх болой. Сар, нарнаас гэрлээ авдаг болохоор тэр нарыг сарны эх хэмээн нэрлэх ажгуу"[11] хэмээн бичсэн нь болой.

Эдгээр жишээ нь нар, сарыг үзэх монголчуудын үзэл бодол, бэлгэдэл ямархан байсныг харуулж байна. Үүнийг зүүдний нар сартай холбон тодруулахад ч гол төлөв эерэг утга бүхий бэлгэдлийг уламжлан хадгалагдаж байгааг "Jegüden-ü sayin mayu-yi tayilbari kemekü sudur orsibai"-ын дотор "нар гэр дотор орон зүүдэлбээс тэр улсын хаан нь улсаан энхжүүлэх", "сар гэгээн ургасныг үзэн зүүдэлбээс хамаг улс иргэн энхжин амар болох", "сарыг үзэн өөрийн суух гэрт орон зүүдэлбээс тэр хүмүүн хаан язгууртай бөгөөд үүрд энхжин суух, харцас хүмүүн бөгөөс баян болох"[12] гэх мэтчлэн өгүүлсэн баримт гэрчилж байна.

2. "caqan singqor" шувууг монголчууд ан гөрөөндөө хэрэглэж дээдэлж ирсэн уламжлалтай юм. Анч шонхруудыг эрхэмлэдэг учраас бусад улс иргэн монголчуудад тэдгээрийг бэлэг болгох явдал ч их байжээ.

239. ta'ulai jil joci-yi bara'un qar-un ceri'üd-iyer hoi-yin irgen-tür morila'ulba buqa qajarcilaju otba... joci oyirat buriyat barqun ursut qabqanas qangqas tubas-i oro'ulu'at tümen-kirgisut-tur gürü'esü kirgisud-un noyat yedi-inal aldi-er örebek-digin kirgisud-un noyat elsen oroju caqa'a-nu'ut singqot caqa'a-nu'ut aqtas qara-nu'ut buluqat abu'at irejü





joci-da a'uljaba sibir kesdim bayit tuqas tenlek tö'eles tas bajigid-aca inaqsi hoi-yin irgen-i joci oro'ulju kirgisud-un tümed-ün minqad-un noyad-i hoi-yin irgen-ü noyad-i abu'at ireju cinggis-qahan-tur caqa'anu'ut singqod-iyar caqa'a-nu'ut aqtas-iyar qara-nu'ut buluqad-iyar a'ulja'ulba...

Энэ жишээ бол, нэгэнтэйгүүр ан гөрөөгөөр амь зуудаг ойн аймгууд шонхор шувууг дээдлэн шүтдэг, нөгөөтэйгүүр монголчууд ч шонхорыг дээдлэн бэлэг сэлтэд оруулдаг ёс заншил байсантай холбон үзэж болохыг харуулж байна. Эс тэгвээс хүндэтгэлгүй ёсон бус хэмээн үзэж болох бэлэг сэлтийг Чингист, Зүчид бэлэглэхгүй нь мэдээж. Алив улс аймгаас нөгөөдөө өгөх бэлэг сэлт нь нэгэн талаар өөрийн ёс заншил уламжлалыг хадгалахын хамт, бэлэглэх омог иргэнийхээ юуг эрхэмлэдэг, юуг цээрлэдэг жигшдэгийг эрхбиш мэдэж тооцсон нь зайлшгүй юм.

Монголчуудын эртнээс уламжлалтай "Эрийн гурван наадам"-ын яруу найраг "Морины магтаал /цол/"-д

"Товцог тарган туулайн зоот
Тод шонхор энэ магад мөн" [13]


гэсэн нь хүлгийг нисэх жигүүртэн мэт хурдтай гэдгийг,

"Хан гарьд шиг дэвээд

Харцага шонхор шиг
Халин дүүлэн барилдаж,


Хамаг олноо баярлуулагч"[14] гэсэн нь бөхийн хүч тамир ихтэй, уран барилдаантай гэдгийг тус тус илэрхийлжээ. Энэ бүхнээс үзэхэд шонхор шувууг эрчит хурдан эр зоригтны бэлгэ тэмдэг болгож байсан нь тодорхой байна. Марко Пологийн "Орчлонгийн элдэв сонин" аяны тэмдэглэлд "Мөн их хаан зарим их ноёдыг элч мэдээчээр илгээхдээ шонхор шувууны дүрс бүхий пайз /гэрэгэ/ олгон, чингэснээрээ тэднийг өөртэйгээ адил эрх бүхий болгон хааны агт морьдоос ч хэрэглэж болно хэмээжээ. Хааны агтнаас хэрэглэнэ гэдэг бол бусад бүх хүний унаа морьдыг дураар эдэлж болно гэсэн үг"[15] гэж бичсэн юм. Өгүүлж байгаа "шонхор шувууны дүрс" бол хүчтэн эрхтэний бэлгэдэл, хурданы бэлгэдлийг хослуулсны илэрхийлэл гэж болмоор байгаа юм. Чухам үүнийг 1289 онд Арагун хаанаас Гоо Филиппэд илгээсэн захидлын дотор "ji-gür-e aγulγan" гэсэн яаралтай захидлын тухайд холбогдсон үг байдаг, хожим яаралтай захидалд шувууны өд наах, хошуундаа бичиг зуусан шувуу зураад "Энэ мэт нис нис"[16] хэмээн бичдэг болсон зэрэгтэй үндэс сурвалж нэг гэж үзэж болно.

3. Монгол хэлээр байгаа миний үзсэн зүүдний дөрвөн сударт /"Нууц зарлигийн муу зүүдийг хариулах бичиг", "Зүүдний сайн муу тайлах судар оршив","Зүүдээр төлөгдөх судар оршив","Сайн муу зүүдний тайлбар буй"/ "Од ургасныг үзэн зүүдэлбээс...", "Хурыг нүдээр үзэн зүүдэлбээс","Зулыг гартаа барин шатаан зүүдэлбээс..." гэхчлэн товч тодорхой, бараг дан гэмээр хэллэгээр өгүүлсэн байх юм. Гэтэл "Монголын нууц товчоо"-нд /§ 63/ "caqan singqor naran sara qoyar-i atqun nisju irejü qar de'ere minu tu'uba" хэмээсэн нь нар, сар, шонхор шувууг дан дангаар бус давхар үйл хөдөлгөөнд оруулан үзүүлсний хувьд содон соргог зүүд юм. Дан ч бай, давхар ч бай үйл явдлыг, түүний ил далд утгыг илэрхийлэхдээ, товч тодорхой цөөн үгийн



бэлгэдлээр мэдээлэл өгдөг "зүүдний хэл" /хэлмэр/ байдаг ажээ.

4. Хэдийгээр "зүүдний хэл" /хэлмэр/ нь тогтсон ойлголт боловч тэр нь сайны зөн бэлгэ үү? Муугийн ёр уу? гэдэг нь оньсого таавар мэт нууцлаг юм. Тиймээс зүүдэлсэн хэн боловч түүнийгээ эрэгцүүлнэ. Эргэлзээтэй байх ахул бусдаас асуух лавлахад хүрдэг билээ. Тийм лавлагаанд хариу өгөх чадварыг эзэмдсэн хүмүүс монгол угсаатанд цөөнгүй байжээ. Доссон "Монголын түүх" номдоо "Тэр нь /бөө Д.Ц./ сүнс мөр заах, зүүд тайлбарлах, заяа бодох, төлөг үзэх, зурхай бодох, өвчин засах зэргийг үйлддэг юм"[17] гэж өгүүлсэн. Ч.Далай "XII-XIY зууны үед монголд зүүд тайлах ёс бөө удган нараар дамжин их дэлгэрсэн байжээ"[18] гэж бичсэнээс үзэхэд тухайн үес "зүүд тайлах"-д мэрэгжсэн гэмээр бөө удган, бусад хүмүүс байжээ. Тийм хүмүүст Дэй сэцэн хандаж "зүүдээ тайлуулах"-ыг хүссэн үү? үгүй юу? Дэй сэцэн "ene jewüdün-niyen gü'ün-e ügülerün naran sara-yi qaraju üjekden büle'e edö'e ene singqor atquju abciraju qar-tur minu tu'uba caqan bawuba yambar ele sayi üje'ülümü ke'ejü" гэсэн нь түүний зүүдэндээ эргэлзэж хүн амьтнаас асууж лавлаж явсны жишээ гэмээр. Гэтэл Лувсанданзаны "Алтан товч"-д "ene jegüdü-ben kümün-e ülü ögülen ajuqu..."[19] хэмээсэн нь Дэй сэцэн зүүдээ хүнээс үл асууж лавласны жишээ гэмээр. Монголчуудын дунд тайлбар шаардахгүй зүүдийг хэн нэгнээс асуудаггүй, "тайлуулах" зүүдийг бусдаас асууж лавладаг ёсон байсан юм. Уг зүүд сайны бэлгэ бол зүүдлэгчийн юм уу түүний холбогдогчийн хувьд сайн үйл өрнөн дэлгэрэх, уул зүүд муугийн ёр бол зүүдлэгчийн сэтгэлд сэв хутаг суулгаж, түүнийг арилгах ариутгах арга замыг хайлгахад хүрнэ. Монголчуудын хувьд уул зүүд хэрэв бэлгэ муутай бол хүн амьтнаас асууж, түүний хариулга шившлэг, засал сэлбэг хийлгэх учиртай аж. [Хэрвээ сүрхий муухай хар зүүд буюу муу зүүд зүүдэлбэл өглөө эрт босмогц бусад хүмүүстэй ямар ч үг



дуугаралгүйгээр гэрээсээ зүүн хойш явж, зүүн хойш хандсан нар үл тусах хулганын нүхэнд муу зүүдийн учраа өөр морин хомоолд хэлээд гурав нулиман хийчихээд "муу зүүдний ёр шор тайлж хайрла" гэж гурав мөргөөд харьж ирдэг байна][20]. Үүнтэй холбон бодож үзвэл Дэй сэцэний зүүд 'kümün-e ülü ögülen" байж болох мэт. Учир нь нар, сар, цагаан шонхор гэсэн тус тус сайны бэлгэдэл болон Дэй сэцэнд зүүдлэгдсэн нь өмнө тайлснаас тодорхой байгаа билээ.

Нэгэнт Дэй сэцэний уг зүүд сайны бэлгэдэл байсан учир "зүүд хàриулах" зэрэг дом шившлэгт хүрэх учир шалтгаангүй байжээ. Хэдийгээр сайны бэлгэдэл нь тодорхой боловч ер бусын шинжийг агуулсан зүүд бол "gü'ün-e ügülerün" байхыг үгүйсгэж бас үл болно. Тэгэхлээр утга илтгэх үг бүрийг нарийвчлан мэдэж байж гэмээнэ уг зүйлийн учрыг тайлахаас өөр замгүй. Гэсэн ч уул сайны бэлгэдэлийн утга учир вэ? гэсэн асуулт хариу нэхэх болно.

5. "edo'e ene singqor atquju abciraju qar-tur minu tu'uba caqan bawuba yambar ele sayi üje'ülümü ke'ejü..." гэсний "caqan bawuba" гэсэн ямар утгатай вэ? Хажуугийн хятад орчуулгад "caqan"-ыг өнгөний цагаанаар буулгажээ. Ф.В.Кливез "... Now this gerfalcon, holding and bringing [them hither], is lighted into my hand. It is descended [all] white [21]. [Одоо энэ шонхор атгаж авчраад /тэднийг наашаа/ миний гар дээр буув, энэ бол буухдаа /бүгд/ цагаан] гэсэн утгаар орчуулжээ. Жагчид сэчин "тус үг, өгүүлбэрийн утга дээрээс үзвээс цагаан жич буув хоёр үгийн хооронд shingkhur... хэмээх үг сугарав. "Алтан товч" /нүүр 29 зургадугаар мөр/ дор /гар дор минь гэгээн цагаан болгов/ хэмээн буй. Үүнийг түлхэн бодвоос тус үг бараг гэрэл /gerel/ гэсэн үг болох бололтой. Гэтэл тус зүйлийн утгаас үзэхүл шонхор... гэсэн үг нэмвээс зохимуй гэв" [22] гэснийг мэдээлсэн Элдэнтэй, Ардаажав "Цагаан буув гэвэл сайн бэлгэ тэмдэг буув ирэв гэсэн утга буюу"[23] хэмээн үзэжээ. Д.Цэрэнсодном "цагаан /гэрэл/ буув" [24] хэмээн хөрвүүлэг хийсэн бол П.Пеллио "Энэ нь цагаан /төлөг/ тавив", [25] Ш.Гаадамба "Энэ

цагаан буув гэсэн нь бидний бодлоор бол "мэргэ төлөг цайв" гэсэн утгатай үг бололтой..."[26] гэжээ. Эдгээр саналаас үзвэл "caqan bawuba" гэдгийг

1. Цагаан /шонхор/ буув
2. /Сайн бэлгэ тэмдэг/ буув
3. Цагаан /гэрэл/ буув
4. Цагаан /төлөг/ тавив
5. Мэрэг төлөг цайв гэхчлэн янз янзаар тайлсаар иржээ.

П.Пеллио, Ш.Гаадамба нарын тайлбар В.Инжаннашийн "Хөх сударˮ-т "Өчигдөр шөнө миний зүүдэн дор нэгэн их цагаан шонхор шувуу амандаа улаан нарыг зууж ирээд миний өргөө гэрийн тоонын дээр суув хэмээн зүүдэлсэн бүлгээ. Би энэ өглөө төлгөө татаж үзвээс энэ өдөр хиюуд ястан хад /?/ буянтан миний гэрт буух бэлгэ болсон тул тухайлан төлгийн зөнгөөр угтан үзээр ирэв. Лав та мөн яв, миний гэрт бүрхсэн эсгийг нэвт гэрэлтэж төрсөн Бөртгэлжин нэртэй нэгэн сонин хүүхэн байнам"[27] гэж Дэй сэцэний зүүдний тухайд өгүүлснээс иш үндэс авсан бололтой. Дээрхи санал тайлбарууд нь төлөв "caqan bawuba" гэдгийг өмнөх хойдох үг хэллэгийн алинтай нь илүү холбон үзсэнээс шалтгаалсан мэт санагдана. Үүнтэй уялдуулан бодвол "caqan bawuba" гэх нь үг хурааж утга балархайшсан хэллэг болох тул байрлалаас үүдэн тодотгол тайлбар шаардах нь зүй юм. Уг хэллэг өмнөх үгстэй байрлалын төдийгүй утгын нарийн уялдаатай гэж үзвэл "caqan singqor","naran sara"-ыг "atquju abciraju" гар тур буусан гэх тул "caqan" гэдэг нь "caqan singqor"-ыг төлөөлсөн ч цагаан шонхорын атгасан наран сарны гэрэл гэгээг бэлгэдсэн ч байж болох давхар утга хадгалжээ. Харин "caqan bawuba" гэдгийг хойдох "yambar ele sayi üje'ülümü ke'ejü" гэсэн хэллэгтэй нь холбон үзвэл "sayi"-ийг үзүүлж зөгнөсөн бэлгэдэл болно. Тиймээс "caqan bawuba" гэдгийг байрлалын хувьд өмнөх үгстэй ч, хойнох хэллэгтэй ч нарийн холбоотой, утгын зангилаа гэж үзвэл зохино. Чухам ингэж үзэх аваас "caqan bawuba" гэдэг нь цагаан шонхорыг ч, түүний атгаж авчирсан наран сарны гэрэл гэгээг ч

төлөөлснөөрөө, ямар сайныг үзүүлсэн гэх бэлгэдэлийн утга хадгалж чадсан гэж болмоор байна.

Зүүдийг тайлахад

1. Зүүдэнд орсон /өгөгдсөн/ юмны бэлгэ шинжийг дагуулах

2. Зүүдэнд орсон юмны бэлгэ шинжийг урвуулах хоёр арга монголчуудад байсан бололтой юм. Энэ юу гэсэн үг вэ гэдгийг доор дурдсан жишээгээр тодруулахад илүү ойлгомжтой болох болов уу? Үүнд "Сайн морь унаж өөрийн дураар явж зүүдэлбээс үйл нь сэтгэлээр бүтэх, хэрэв муу морь унан яван ядаж айж явбаас сэтгэл зовох" гэсэн нь зүүдний морь сайн бол түүний шинжээр, зүүдний морь муу бол бас л түүний шинжийг дагуулан тайлж байна. Гэтэл "Хүмүүн үхэх гэж гиншин уйлан зүүдэлбээс амь насан урт болох" гэсэн нь "үхэх"-ийг "амь нас урт болох"-оор урвуулан тайлж байна. Дэй сэцэний зүүдний сайн сайхныг бэлгэдсэн үйлийг бэлгэ шинжийн дагууд тайлсан нь уг зохиолын хэсгээс тодорхой тул "cimayi ele kö'ü-be'en uduritcu iregüi-e üjeksen aju'u jewüdün sayin jewüdüleba ya'un jewüdün aqu ta-kiyat irgen-ü sülder irejü ja'aqaqsan aju'u" гэсний утгаар хөөн үзвэл нар сар хоёр нь Тэмүжин, Бөртө хоёр, тэдгээрийг атган нисч ирсэн цагаан шонхор нь Есүгэй баатар, Есүгэй нь хиад иргэний сүлдэр мөн гэсэн тайлал гарч байна. Үүнээс үндэслэн, уг хэсгийг учир зүйн дагууд нарийвчлан шинжвэл цагаан шонхорыг хиад иргэний сүлдэр гэж шууд үзээгүй нь тодрох бөгөөд Есүгэй баатарыг "ta kiyat irgen-ü sülder" гэж заасан нь мэдэгдэх болно. "Та хияад иргэний сүлдэр" гэж Дэй сэцэний Есүгэй баатарт хэлсэн үг зүүд биш, түүний тайлалтай холбогдон гарч ирсэн гэдэг нь тодорхой. Үүнээс "kiyat", "sülder" хэмээх хоёр үг дор бүрийдээ утга бэлгэдэл хадгалсан болой. Үүнд:

1. "Эргүнэ кунгийн домог"-т "Барагцаалбал одоогоос хоёр мянган жилийн тэртээ эрт цагт монгол хэмээн нэрийдэж агсан тэр аймаг бусад түрэг аймагтай зөрчил тэмцээн болж... Бусад аймаг нь монголчуудыг ялан дарж, хядахад нь хошоод эр эмээс

илүүгүй хүн амьд үлдсэн хэмээн хүндэт итгэмжтэй хүмүүсийн ярьдаг өгүүлэл буй... Тэр хоёр хүний нэр нь Никуз, Хиан байжээ. Тэр хоёр, тэдний удам олон жил тэр нутагтаа сууж, өнөржин үржжээ... Эл угсаатны угсаа гарвал нь Эргүнэ Кунд очсон тэр хоёр хүнээс эхэн авсан нь мэдээж билээ. Чингээд тэнгэр ивээсэн учир дөрвөн зуугаад жил болоход тэд нар олон салбар болоод, тоогоороо буздаасаа давамгайлжээ..."[28] гэж өгүүлснээс үзвэл "хиан" /хияад/ нь эрт дээр цагийн улбаатай нэр ажээ.

Эл домгийг "Хүндэт итгэмжтэй хүмүүсийн ярьдаг өгүүлэл" гэж Рашид-ад-дин үзсэнээс ч тэр үү "Эргүнэ-Кунд очсон хоёр хүн өсөж үржээд овог нь олон болсоор бүхэл бүтэн улс түмэн үүсчээ.... Язгуур монголчууд яваандаа хоёр салбар болсон юм... Эргүнэ-Кунд байсан жинхэнэ монгол угсаатнуудаас салаа үүсээд, тус бүрдээ тусгай нэр хочтой болжээ... Монголоор нь хиан нь уулнаас доош урсагч түргэн ширүүн хүчтэй том урсгал гэх утгатай. Хианчууд зоригтой зүрхтэй, маш эрэлхэг учир энэ үгээр тэднийг нэрлэсэн байна. Хиад нь хиан гэдгийн олны тоо юм. Хоёрдугаар дэд салбар нь мөн хиад гэж нэрлэгддэг Нирунчууд юм. Тэдгээр нь хоёр салаа, ер нь хиадууд гэх утгаараа: юркин чаншиут, хиад-ясар, хиад боржигин, энэ нь хөх нүдтэн гэсэн үг, тэдгээрийн салаа нь Чингис хааны эцгээс гарсан учир Чингис хаан түүний эцгийн овогтой төрлийн холбоотой юм... Гуравдугаар нь нирун хиад аймгаас, Алангоогийн ариун овгоос гарсан, Алангоогийн зургадугаар үеийн Хабул хааны шууд удмаас үүссэн боловч хиад боржигин гэж нэрлэдэг. Тэдний гарал гэвэл Хабул хааны ач, Чингис хааны эцэг Есүгэй баатараас төрөгсөд юм... Чингис хаан, түүний өвөг дээдэс, ах дүү нар дээр дурдсан нэр алдараар хиад аймагт харъяалагддаг боловч Чингис хааны эцэг байсан Есүгэй баатарын хүүхдүүд хиад Боржигин нэртэй болов. Тэд хиад ч мөн, боржигин ч мөн..."[29] гэхчлэн бичсэн нь бий. Үүнээс үзвэл Эргүнэ Кунгийн домгийн тэр үеэс эхлээд Есүгэй баатарын үе хүртэл хиад Боржигины удам тасралтгүй үргэлжилж ирсэн ажээ. Үүнтэй холбогдуулж Дэй сэцэн Есүгэй баатарыг 'ta kiyat irgen-ü..." хэмээн

овог яс удам судраар нь дуудаж нэрлэсэн нь чухамхүү хүндэтгэл илэрхийлсний бэлгэ тэмдэг юм."Алтан ургийн дээдэс хиад ястаны тухай "Монголын нууц товчоонд "хиа" гэдэг хүний нэрээр эхлэн гардаг. Энэхүү "хиа" буюу "хиад" ясыг "цагаан яс" буюу "алтан яс" хэмээдэг гэж зарим монгол сурвалжид бичсэн байдаг"[30] хэмээн Ч.Далай бичжээ. Эрт урьдын хэв заншил, хэл хэллэгийн ул мөр дом шившлэгт үе дамжин улирч үлдсэний дотор тэнгэр дуугарахад

"Хан цагаан ястай билээ

Хариад буриад ястай билээ" хэмээн хариад шарнууд овгийн хүн,

"Хан цагаан ястай билээ...

Хан тэнгэр язгууртай билээ"[31] гэж боржигин шарнууд овгийн хүн хашгирдаг ажээ. Энэ нь байгалийн сүр хүчинд авахдаа "Хан цагаан яс" хэмээн өндөр дээдсээ нэрлэн дуудаж аврал эрж байсны жишээ юм. Үүнээс "хиад яс"-ыг яагаад "цагаан яс" гэх болов? хэмээсэн асуулт гарах болно.

"Олон түрэг хэл аялгуунаа "ак, ах, аг, агы, ахар, акча, акчӓ, акша, ahчы, окса, ахча, ахчы, акчыл, аксыл, акчил, акца", манжид sanyan. Гаргалга. Солонгос хэлний "цагаан" гэсэн уттатай язгуур нь түрэг хэлнийхээс хол, монгол манж хэлний язгуурт тохирч байна... Зохиогчийн саналаар бол дээрхи үгийн /хиюд, хуян, хиян, хияд, хиад Д.Ц./... "х" бүхий бүтээвэр нь өвөг алтайн хэлний цагаан гэсэн утгатай язгуур бололтой. Үүнд Солонгос хэлний hi /цагаан/ гэсэн язгуур нь..."ki", "gi" /хя, гя/ хэлбэрээр хадгалагдан үлдсэн байна. Иймд "хиюд яс" гэдэг нь "цагаан яс" гэсэн үг байж болох юм"[32] хэмээн Б.Сумъяабаатар үзсэн ажээ. Энэ санал бас ч үндэслэлтэй гэдэг нь:

а. Түрэг хэлнүүдэд ак[33] язгууртай үгс "цагаан" гэсэн утгыг зонхилон илтгэдэг нь өвөг алтайн хэл аялгуунаас ондоо гэдэг нь

б. Өвөг алтайн хэл, ялангуяа монгол хэлнээ хиад /хиюд, хияд гэх мэт/ нь цагаан хэмээх утга хадгалдагийг В.Инжаннашийн олж тогтоосонтой тохирч байна. В.Инжаннаши "Хөх судар"-таа

"Алтан ураг таны ... түүх дор хиюуд /хияад/ хэмээгч cigen /чигэн/ яс хэмээжүхүй. Чигэн хэмээгч хуучин ci ü ben ... болжухай. Энэ нь манай монгол улсын уг үүсгэл үг цагааныг өгүүлжүхүй"[34] гэж өгүүлснийг Булаг үгийн тайлбартаа иш татжээ. Тиймээс "Монголын нууц товчоо"-ны "kiyat" гэсэн үг иргэний нэр тодотголоор төдийгүй цаанаа өнгөний хийгээд овог ясны гүн утга бэлгэдэл агуулж оржээ гэмээр байна.

2. "sülder" хэмээх үгийг Ф.В.Кливез "A good omen of you kiyad people is come and hath [tore] told[that thou wast coming hither]"[35] /кияад хүмүүс та нарт сайны зөн совин ирж байна гэсэн утгатай/, А.С.Козин "Не иначе, что это вы духом своего киятского племени - являлись во сне моем и предрекали"[36] /Энэ та өөрийн хияат овгийн сүнс болон миний зүүдэнд ирж урьдчилан хэлснээс зайлахгүй гэсэн утгатай/, Элдэнтэй,,, Ардаажав "сүлдэр-сайн бэлгэ, дээдсийн буян, сод мэргэнийг хэлэв" [37] гэхчлэн судлаачид өөр өөрийн ойлголтоор орчуулж тайлбарлажээ. Эдгээр жишээнээс үзэхэд "sülder" гэсэн үг нь "omen" /зөн совин/, "духа" /сүнс/, "сайн бэлгэ, дээдсийн буян" мэтчлэн олон утга илэрхийлснээр ухаарчээ. "sülder" нь хэдийгээр "sülde, suu jali, gegegen sünesün" гэсэн гурван томъёололтой язгуур нэгтэй [38] боловч утга яг ижил биш юм. "sülder" нь § 201 хэсэгт anda-yin sülder-e daruqdaba-je bu...", § 249 хэсэгт "edo'e süldertü beye cinu qurcü erekdejü sülder-ece ayuba..." гэж давтагдахдаа уттын хувьд ижил шахуу мөртлөө нарийвчилбал бага зэрэг ялгаа байгаа билээ. Хэрэглэсэн байрлалаас шалтгаалж утгын өөрчлөлт байх нь мэдээж боловч "Монголын нууц товчоо"-нд гарснаар нь үзэхэд эдүгээгийн ойролцоо агуулга илэрхийлэх ямар ч үгээр орлууламгүй "sülder" гэсэн утгын нэгдэл, бэлгэдлийн цогцлол гэж ухаармаар байна. Үүнээс улбаалж "kiyat", "sülder" гэсэн хоёр үгийг Есүгэй баатар руу юу? Цагаан шонхор руу юу? Чухам хааш нь холбож үзсэнээс Дэй сэцэний зүүд, түүний тайллын утга учир улам тодрох болно. Энэ хоёр үг, ойлголтыг зүүдний цагаан шонхортой шууд холбох явдал хожмын сурвалж бичиг

Лувсанданзаны "Алтан товч"-д "songqor anu tan-u kivad irgen-ü sülde irejü jivasun (javasan) ajuqu"[39] "Хураангуй Алтан товч"-д "Тэрхүү зүүдэн минь хиюүд /хияад/ яст, боржигин омогт таны хү/хо/ сүлд ажгуу..."[40], "Эрдэнийн товч"-д "Дэй сэцэн энэ шөнө нэгэн цагаан шонхор шувуун гар дээр минь сууж зүүдэлвээ би. Үзвээс Боржигин таны сүлд агсан ажгуу"[41] хэмээн гарчээ. Эдгээрээс санаа авснаас ч болсон уу? "Монголын нууц товчоо"-ны § 63 зүйлийг Лувсанданзаны "Алтан товч", "Хураангуй Алтан товч", Саган сэцэний "Эрдэнийн товч"-д тодотгол хийснээс ч болсон уу? ямар ч л гэсэн XX зууны сүүлч үеийн судлаачид тухайлбал Сайшаал "Шонхор шувуу бол таны хиад иргэний сүлд болох тул Есүгэй худ та хөвгүүнээ дагуулж ирсэн нь энэхүү бэлгэ болов"[42] гэх буюу Д.Гонгор[43], Ч.Далай [44] Г.Сүхбаатар[45] зэрэг олон эрдэмтэн "Хиад боржигин овог цагаан шонхор шувуун онго /сүлдэр/", "Хиад Боржигин овгийн гол шүтээн "цагаан шонхор", "Монголын нууц товчоо"-ны мэдээгээр кияд овгийн тотем нь цагаан шонхор /Falco cherrung/ хэмээжээ. Ийм үзэл бодол газар авч XX зууны сүүлч, XXI зууны эхэн үеийн Монгол улсын сүлдийг цагаан шонхороор дүрслэх гэсэн хандлага оролдлого "Үндсэн хууль" батлах төвшинд хүртэл өндөр авч хурцаар тавигдаж байв[46]. Үүний хамт "Цагаан шонхор түрэг угсааны шүтээн"[47] гэх өгүүлэл яриа ч дэгдэж байв. Үүний үндэс нь, бүх түрэгийн өвөг дээдэс Огузын хүү Кун-хан дөрвөн хүүтэй байж, тэднүүд бүгд тус тусын тамгатай байсны дээр сүлд шүтээн амьтан нь шонхор байсан тухай[48] Рашид-ад-дины бичсэнд оршиж байв. Тийм болохоор Дэй сэцэний зүүд, түүнтэй холбоо бүхий §63 зүйлээс үүдэлтэй элдэв дүгнэлт гаргалга хийхдээ олон талаас ул суурьтай нягталбаас зохимой. Миний хувьд "kiyat", "sülder" хоёр үгийг Есүгэй баатар руу холбон ойлгож байгааг дээр нэгэнт өгүүлсэн билээ. § 63 зүйлийг учир зүйн дагууд тунгаан бодвол хиад иргэний сүлдэр нь цагаан шонхор бус, харин Есүгэй баатар мөнөөс мөн. Цагаан шонхор бол зүүдний хүрээнд эргэлдэн гарч байгаа бол Дэй сэцэний Есүгэй худад хандаж хэлсэн үг зүүдэн дунд болсон биш.

Энэ бол зүүд, зүүд бусын хүрээг ялгаж, бас залгаж ойлгохын чухлыг харуулж байна. Үүгээр нягталбал Дэй сэцэний "ta kiyat irgen-ü sülder" гэж Есүгэй баатарт хандаж хэлсэн нь уг ойлголтыг тайлах оньс мөн.

Дэй сэцэний зүүд, болох үйлийг урьдчилан мэдсэн мэргэн зүүд болой. Зүүдний мэргэн байх эсэх нь зүүдлэгчийн сэтгэж, мэдрэхүйн гаднын дохио давтамжийг хүлээн авах чадвар, түүний нөхцөл бололцоо, биеийн эрүүл зовиуртай эсэх, нас хүйсний ялгамж, орон зай цагийн байршил зэрэгтэй холбоотой нь мэдээж.

Дорно дахины ойлголтоор орон зай, цаг хугацааны ялгамж зүүдийг тайлахад нөлөөтэйг Төвдийн Лондол ламын "Зүүдээр үзэгдсэн элдэв зүйлийг шинжлэх арга" сударт "шөнийн зүүдийг үдэш шөнийн зүүд, шөнө дүлийн зүүд, үүр шөнийн зүүд" гэж цагийн утгаар гурав хуваж, тухайн зүүд бүрт юуг голлон зүүдлэхийг айлджээ. Үүнд, Үдэш шөнийн гурван хувийн зүүдний их зонхийг урьд өмнөхийн үйлдсэн үйл, амссан дур хүсэл, явсан газар орон, уулзсан нөхөр садан, идсэн хоол унд, өгүүлсэн зүйлийн хэсэг бусаг, ялангуяа гурван өдрөөс цаашид болсон юмны сэтгэлд үлдсэн үйлдэлгэ мөн тул түүнийг үнэнд барьж, магадтайд итгэх аргагүй элдэв зүйл гарсан болно. Шөнө дөлийн цагийн гурван хувийн зүүд нь чөтгөр хийгээд мангас, тэнгэр бус, шулам тэргүүтэн тэр цагаар гүйхийн тул сайн муу алин гарсан ч тэдгээрийн нэгэн үзүүрт сэтгэлийг хямруулсан, үймүүлгийн олон зүйл хувилал тул түүнийг магадтайд бүү итгэ гэж мэргэд айлдсан болно.

Үүр шөнийн гурван хувийн зүүдэнд үзэгдсэний сайн муу үрийг шинжлэхийг эрхэмлэх хэрэгтэй"[49] гэжээ. Монголчууд ч гэсэн хоолны дараахны зүүд буюу шөнийн эхний зүүдийг олонхдоо "Идэштний мунхаг зүүд" гээд анхаардаггүй, шөнө дундаас хойших ялангуяа үүрийн үеэрхи зүүдийг "онц сэцэн ёртой зүүд"[50] хэмээн чухалчилж үздэг байсан ажээ. Үүгээр улбаалан хөөвөл Дэй сэцэний зүүд нь үдэш шөнийн гурван

хувийн буюу "идэштний мунхаг зүүд" хараахан бус, шөнө дүлийн цагийн гурван хувийн зүүд ч бас бус, харин үүр шөнийн гурван хувийг хийгээд "шөнө дөлөөс үүр шөнөд шилжих цаг"-ийн буюу үүрийн үеэрхи "онц сэцэн ёртой зүүд" хэмээн үзэж болно. Ойртон яваа үйлийг урьдчилан харж чадсанд, тэр нь дорхноо бодитой болон хэрэгжсэнд Дэй сэцэний зүүдний мэргэн шинж оршино.

Дээр дурдсанаас үзэхэд, "Монголын нууц товчоо"-ны зөн совингийн бэлгэдэл нь уг зохиолын агуулгыг гүнзгийрүүлэх, хэлбэр бүтцийг баялаг олон өнгө аястай болгох, урлах эрдмийг өндөр төвшинд хүргэхэд уран яруу хэрэглүүр болж чадсан байна.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Даньхүрэл /Тууль/ хэвлэлд бэлтгэсэн Б.Катуу. БНМАУ. Ардын боловсролын яамны Сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцын төв. УБ., 1986, 116-р тал
2. Монгол ардын баатарлаг туульс. Studia Folclorica... Tom. 1, fasc. 7 /Эмхтгэж боловсруулж өмнөх үг тайлбар сэлт үйлдсэн Г.Ринчинсамбуу/, УХХЭХ, УБ., 1960, 41-42-р тал
3. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1 пер. с персидского Л.А.Хетагурова. Изд. АН СССР. М-Л. 1952. стр. 153-154
4. Лхамсүрэнгийн Хүрэлбаатар. Судар шаштирын билиг. (Лондон дахь Төвдийн фондтой хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд гаргав.) "Интерпресс" хэвлэлийн компани. УБ. 2002. 363-р тал.
5. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр, гүн ухааны сэтгэлгээ /Эртнээс XIY зуун хүртэл/, УБ., 1987, 31-р тал
6. Les materiaux pour l'etude du chamanisme Mongol. Rec. par Rintchen. (Asiatische Forschungen, Band 8), Wiesbaden, 1961, s.37
7. Зигмунд Фрейд. Введение в психоанализ. Лекции. Издание подготовил М.Г.Ярошевский. М., Нуака, 1989.
8. Краткая литературная энциклопедия. 8. Изд. Советская энциклопедия. М., 1975, стр. 1019
9. С.Дулам. Монгол домог зүйн дүр. УХГ, УБ., 1989, 90-р тал
10. Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. Тэргүүн дэвтэр, Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн тасаг. УБ., 1992, 24-р тал
11. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ., 1988, 19-р тал
12. Монгол улсын Улаанбаатар хотноо орших Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн монгол бичмэл. Л.Ж.2, 263, Зүүдний сайн мууг тайлах судар оршив. /Кирилл үсэгт буулган хэвлэлд бэлтгэсэн Л.Хүрэлбаатар/ Монголжингоо сонин. 1992, № 4, Зүүд сайн мууг тайлах судар оршвой. Дал.

сонин/Эрхлэн нийтлэгч Л.Түдэв/.XYII жарны гал үхэр жилийн хаврын дунд харагчин туулай сарын шинийн наймны наран цогт улаагчин могой өдөр. № 09
13. Irügel maytayal-un tegübüri. (Bayan-a, Qou-a emkidkebe). öbür mongyol-un soyul-un keblel-ün qoriy-a. 1983, 311 düger tal-a
14. Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном. Монгол аман зохиолын дээж бичиг. УБ., 1957, 119-р тал
15. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. /Аяны тэмдэглэл/ УХГ, УБ., 1987, 90-91-р тал
16. Ц.Шагдарсүрэн. Монголчуудын утга соёлын товчоон. УБ., 1991, 165-р тал
17. Dosson-u Mongyol-un teüke. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. 1988, 61 düger tal-a
18. Чулууны Далай. Монголын түүх. Хамаг монгол улс /1101-1206/. Тэргүүн дэвтэр, ШУХ "Эрдэм" компани, УБ., 1996.23-р тал
19. Altan Tobci (Hans-Peter Vietze, Gendeng Lubsang) Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von BLO dzan bstan'jin. Text und Index. Tokyo, 1992, p.10
20. Khurcabayatur, üjüm-e. Mongyol-un böge mörgül-ün tayily-a takily-a-yin soyul. öbür mongyol-un soyul-un keblel-ün qoriy-a. 1991. 358 duyar tal-a
21. F.W.Cleaves. The Secret History of the Mongols. Vol I (Translation), Harvard University Press. 1982. s.15
22. Eldengtei, Ardajab seyiregülün tayilburilaba. Mongyol-un niyuca tobciyan seyiregülül tayilburi. öbür mongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a. 1986. 118 duyar tal-a
23. Eldengtei, Ardajab seyiregülün tayilburilaba. Mongyol-un niyuca tobciyan seyiregülül tayilburi. öbür mongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a. 1986. 118-119 düger tal-a
24. Dalantai-yin Cerinsodnam. Mongyol-un niyuca tobciyan. Orciyuly-a tayilburi. öbür mongyol-un ündüsün-ü keblel-ün qoriy-a, 1993. 50 duyar tal-a
25. Paul Pelliot. Histoire secrete des Mongols, Paris, 1949. p. 131

26. Mongyol-un niyuca tobciyan /Монголын нууц товчоо/. Худам монгол үсгээр сийрүүлсэн Ш.Гаадамба. Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр. УБ., 1990. 254-р тал
27. Injannasi. Köke sudur. Terigün debter. öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota. 1957. 113 duyar tal-a
28. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1, пер. с персидского Л.А.Хетагурова. Изд. АН СССР. М-Л. ,1952, стр 153-154
29. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1, пер. с персидского Л.А.Хетагурова. Изд. АН СССР. М-Л. , 1952, стр. 153-155
30. Чулууны Далай. Монголын түүх. Хамаг Монгол Улс /1101-1206/. Тэргүүн дэвтэр. ШУХ "Эрдэм" компани. УБ., 1996. 25-р тал
31. Монгол ардын зан үйлийн аман зохиол. УХГ. УБ., 1987. 17-18-р тал
32. Б.Сумъяабаатар. Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд. ШУАХ. УБ., 1975, 183-184-р тал
33. А.Н.Кононов. Семантика цветнообозначений в тюркских языках. Тюркологический сборник. 1975. Изд. Наука. М. 1975, стр. 159, 170-172
34. Khad-un ündüsün quriyangyui altan tobci (Bulay qaryuyulju tayilburilaba). öbür mongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a. 1989, 277-279 düger tal-a
35. F.W.Cleaves. The Secret History of the Mongols. Vol 1 (Translation) Harvard University Press. 1982, p. 15
36. С.А.Козин. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г под названием "Mongyol-un niyuca tobciyan. Юань чао би ши-монгольский обыденный изборник. Том 1, Изд. АН СССР. Москва-Ленинград. 1941, стр 86
37. Eldengtei, Ardajab. Seiregülün tayilburilaba. Mongyol-un niyuca tobciyan seyiregülül tayilburi. öbür mongyol-un suryan kümüjil-ün keblel-ün qoriy-a. 1986. 119 düger tal-a
38. Т.Д.Скрынникова. Идеи "Сокровенного сказания" о власти в летописях XYII в. Mongolica. (К 750-летию "Сокровенного сказания").Наука. изд-во. фирма. "Восточная литература",

1993. стр 166
39. Altan tobci (Hans-Peter Vietze, Gendeng Lubsang) Eine mongolische chronik des XYII. Jahrhunderts von BlO dzan bstan'jin. Text und Index. Tokyo. 1992. p.10
40. Qad-un ündüsün quriyangγui altan tobci (Bulaq qarγuγulju tayilburilaba). öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a. 1989. 17-18 duγar tal-a
41. Saγang-secen. Erdeni-yin tobciy-a. öbür mongγol-un ündüsün-ü keblel-ün qoriy-a. 1987. 69 düger tal-a
42. Cinggis Kaγan-u tobciyan (Sayisiyal jokiyaba) Degedü debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1991 (1987). 69-70 duγar tal-a
43. Д.Гонгор. Халх товчоон. II. 1978. ШУАХ. УБ., 9-р тал
44. Чулууны Далай. Монголын түүх. Хамаг Монгол улс /1101-1206/. Тэргүүн дэвтэр. ШУХ "Эрдэм" компани. УБ., 1996. 23-р тал
45. Г.Сүхбаатар. Монголчуудын эртний өвөг хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл, угсаа гарвал /МЭӨ IY-МЭ II зуун/. /Нэн эртнээс манай эриний дөрөвдүгээр зуун/. УБ., 1980. 75-р тал
46. Төрийн сүлд, далбаа ямар байх вэ? Ардын эрх сонин. 1991.№0.5. № 172. О.Пүрэв. Цагаан шонхор. "Монголын дуу хоолой" сонин. 1991. № 10, С.Дулам. Цагаан шонхор... ирж заасан ажуу. Ардын эрх. 1991. № 194. Д.Чулуунжав. Зүүдний цагаан шонхор сүлд мөн үү. Ардын эрх сонин. 1991. № 194
47. С.Харжаубай. Өвөг дээдсийн онгон шүтээн олдов. /Мөн үү? биш үү?/ Ил товчоо. 1992. № 17 /50/
48. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1 /пер. с персидского Л.А.Хетагурова/. Изд. АН СССР. М-Л., 1960. стр 87-88
49. Л.Хүрэлбаатар. Зүүдний шинж. "Монголжингоо" сонин. 1992. № 4
50. Khas. Mongγolcud-un jegüdü sobilta-yin tuqai. öbür mongγol-un neyigem-ün sinjilekü uqaγan. 1994. No 5. 94-95 duγar tal-a

ГУТГААР БҮЛЭГ

"МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО"-НЫ БЭЛГЭДЛИЙН ЦОГЦОЛБОР, ЧУУЛБАР



Ямар нэгэн ойлголтыг тодорхой томъёололд хамааруулан ангилж болох авч тэрхүү хүрээнд оршихын зэрэгцээ эс орших нь бас бий. Бэлгэдлийн хувьд айд хамааруулж болох боловч тэрхүү хүрээнд багтахын зэрэгцээ эс багтах нь ч бас бий. Энэ нь амьдрал түүний дотор оюун санааны амьдрал хашигдах, эс хашигдахын савслагад сүлэлдсэн байдгийн гэрч мөн. Бэлгэдэл нь нэгэн утгад нийтгэгдэхийн хамт олон утгад зангилагдах нь бий билээ. Тооны айд хамаарах нэгэн нь цагийн хийгээд өнгөний айд, цагийн айд багтах нөгөө нь тооны хийгээд зөн совин айд хамаарах мэтчлэн хослох нь бий билээ. Тиймээс олон төрөл бэлгэдлийн хослолыг цогцолбор /комплект/, нэгэн төрлийн бэлгэдлийн доторхи хослолыг чуулбар /ансамбль/ хэмээх томъёололд хамааруулан үзэж болно. Монгол бэлгэдлийн баялаг, олон талыг айн хүрээнд төдийгүй цогцолбор, чуулбарын сүлжээнд авч үзэх өргөн боломжтой юм. "Монголын нууц товчоо"-ноо хадгалагдаж үлдсэн монгол бэлгэдлийн жишээнээс үзэхэд аль нэгэн айд хамаарахаас илүү цогцолбор, чуулбар шинжтэй нь ч цөөнгүй бий. Ялангуяа олон төрлийн бэлгэдлийн хослол эд өлөгт, тухайлбал хүний өмсгөл хувцас зэрэгт илүүтэй хамаарсан нь бий билээ. Бэлгэдлийн утга нь эд өлөгт төдийгүй уран үгийн дүрд, түүний олон өнгө аясад илэрсэн нь "Монголын нууц товчоо"-ны нээвэл зохих эрдэнэсийн сан билээ. Тиймээс "Монголын нууц товчоо"-ны бэлгэдлийн цогцолбор, чуулбарын жишээг монгол хувцасны хийгээд уран үгийн дүрийн бэлгэдлээр төлөөлөл болгон тодотгон авч үзэхийг эрмэлзсэн болно.

ХУВЦАСНЫ БЭЛГЭДЭЛ

Хувцас гэдэг нь хэн нэгний санаан зоргын бус, өвгөд дээдсийн үеэс тогтсон хийц загвар, түүнийг хэрэглэх нарийн ёс дэгтэй зүйл юм.

Үеэс үед дамжин уламжилж, мөн ч цаг үеийн хувьслын дагууд хөгжиж баяжиж ирсэн хүн зоны хувцас нь тухайн ард түмний аж төрөх ёс, эрхэлсэн аж ахуй, түүнээс гарах бүтээгдэхүүнийг боловсруулах арга, урлан бүтээх ухааны чадвар, зан заншил, гоо сайхны таашаал сонирхлыг ямар нэгэн хэмжээгээр шингээсэн байдгийн хувьд эд өлгийн соёлын тогтвортой зүйл мөний төдийгүй оюуны соёлын төвшинг тогтоон илэрхийлэгч юм.

Төв Азид үе уламжлан амьдарч ирсэн нүүдэлчин монгол угсаатны олон үеийн туршид бүтээн боловсруулсан хувцас, хувцасны соёл нь тэднээс хүн төрөлхтөний соёлын их сан хөмрөгт оруулсан хувь нэмрийн нэгэн мөн. Төв Азид эрт дээр цагт амьдарч байсан Хүннү, Сяньби, Кидан зэрэг монголчуудтай удам холбоотой гэгддэг улс гүрний хүн зоны эдэлж хэрэглэж байсан хувцас хунар хийгээд тэдгээртэй уламжлалын учир холбогдолтойгоор бүтээн бий болгосон монгол угсаатны олон төрлийн хувцасны ул мөр нь хад чулууны сүг зураг, эртний булш бунханы олдвор, аман мэдээ домог яриа, түүхийн сурвалж бичгээр дамжин өнөөгийн бидэнд иржээ.

Монгол угсаатны хувцас нь зориулалтаар /эрэгтэй, эмэгтэй хүний, хүүхдийн болон өдөр тутмын, гоёлын, тусгай зориулалтын гэх мэт/, хүмүүсийн нийгэмд эзлэх байр сууриар /ихэс язгуурtны болон эгэл ардын/ ялгамж бүхий, эргэх дөрвөн улирлын агаар амьсгалд зохицсоноор олон янз байх боловч толгойн өмсгөл /алчуур, малгай/, их биеийн өмсгөл нь дотроо гадуур хувцас /дээл, бүс, хантааз, хүрэм/, дотуур хувцас /цамц, өмд/, хөлийн өмсгөл /гутал, жийрэг/ хэмээх тоотойхон хэдэн ерөнхий нэрийтгэлд хураан нэрлэсээр ирсэн юм. Эдгээр хувцсыг


бүрэн өмсөөд, морь уначихсан яваа монгол хүнийг өмсөх хувцастайгаа ч, унтаж амрах хучлага дэвсгэртэйгээ ч байна гэж үзэж болно. Учир нь, гэгээн цагаан өдрөөр малаа маллаж юм уу ан гөрөөнд явж байсан монгол хүн харанхуй бүрэнхий болоход хээр гадаа амрах унтах болбоос унаагаа чөдөрлөж тогтоогоод эмээлийг авч салхи жавраас нөмөр хийж, тохмоор дэвсгэр болгож, дээлээ тайлан нөмөрч хучлага болгоод дэр толгойнхоо дэргэд малгай бүсээ тавьж хэвтдэг юм. Цагийн шалгарлыг туулан олон үеийг улирааж ирсэн толгой, их бие, хөлийн өмсгөл хувцас "Монголын нууц товчоо"-ны дотор 30-аар нэрлэгдэн дурдагдсан болой. Тэдгээрийн дотроос "Монголын нууц товчоо"-нд дүрслэгдсэн малгай, бүс, цамцны ямар утга учир, бэлгэдэл илэрхийлсэн талаар өгүүлье.


1.


Монголчуудын хувцас нь хүний бие эрхтний бүтэц, түүний эрхэмлэл хүндэтгэлтэй холбоотойгоор уламжилж ирсэн болой. Монгол хүн, тэргүүнээ /толгойгоо/ сэтгэх бодохуйн цөм болох уураг тархины оршихуйн орон гэж үздэг. Тиймээс тэргүүндээ өмсгөх малгайг зөвхөн халуун хүйтнээс, гаднын элдэв нөлөөллөөс халхлах, хамгаалах эгэл үүрэг бүхий эд эдлэл гэхээсээ хүний оюун санаа, сүлд хийморийн бэлгэдэл хэмээн үзэх нь үлэмж. Тухайн тэр цагийн заншлаар монгол хүн өөрийн гэрээс гарч гадагш явах, хүн зонтой уулзаж учрах, баяр ёслол, уй гашуудалд оролцох зэрэгт заавал бүрэн хувцасладаг байсан ажээ. Плано Карпини /1182-1251/-ийн "Монголчуудын түүх" зохиолд бичсэнээр "Эрд гарсан хүүхнүүд нь урдууraa задгай энгэртэй их л өргөн, газар шүргэсэн ууж өмсөнө. Тэд толгой дээрээ дугуй богтаг хэмээх нэгэн зүйл малгай тавина... Эхнэрүүд ийм богтаггүйгээр хүний өмнө гарна гэж байхгүй бөгөөд түүгээр ч бусад эмэгтэйчүүдээс ялгаж таних ажгуу"[1]."Богтаггүйгээр хүний өмнө гарна гэж байхгүй" хэмээх нь хүний эхнэр болсон эмэгтэйд холбогдуулан түүний олны өмнө явахдаа заавал бүрэн

хувцасладаг байсныг тодорхой өгүүлсэн ажээ.Монгол эр хүний бүрэн хувцаслах нь дээлээ өмсөж, товч бүчээ нэгд нэгэнгүй товчилж, бүсээ зөв ороон бүсэлж, толгойдоо малгайгаа /алчууpаа/ тэгш тавьснаар илэрмүй.Бүрэн бүтэн хувцасласан монгол хүн бол ёстой төртэй, бие даасан хэмээгдэж бусдын нүднээ үзэгдэмүй.Чухам ингэж бүрэн хувцаслахад "малгай бүс хоёр бол монгол хүнд чөлөөт байдлын бэлгэ тэмдэг"[2]-ийг илэрхийлдэг болой.Монгол хүн эрэгтэй, эмэгтэй алин боловч малгайдаа бусдын гар хүргэхээс цэрвэдэгийн жишээг, 1221-1224 оны үес Монголоор хийгээд Дундад Азиар аялсан Чан чүн Бумба "Барууншш зорчсон тэмдэглэл"-дээ "Эмэгтэйчүүд нь хус модны хальсаар үйлдсэн малгайг өмсдөг... Хүний гар хүрэхүйг ихэд цээрлэж өргөө гэр дор орохдоо бөхийж ормуй"[3] гэж бичсэнээс мэдэж болно. Монгол хүн малгайдаа чөлөө зөвшөөрөлгүйгээр өрөөл бусдын гар хүргэх, малгайгаа газарт унагуулах, дээгүүр нь алхуулах зэргийг чөлөөт байдлын бэлгэ тэмдгээ эвдүүлсэн, өөрийгөө бузартуулж доромжлуулсан хэрэг мэт үзэж хамгийн цээртэй юмны нэгэнд тооцдог байсан ажээ.

§ 245. te'ün-ü qoyina yisün keleten irgen teb-tenggeri-tür quriju cinggis-qa'an-u kirü'e-dece olon teb-tenggeri-tür quriqun bolba teyin quriqui-tur temüge-otcigin-a qariyatan irgen teb-tenggeri-tür otcu'ui... irge-ben ba ese öktejü otcigin manaqarsi erte cinggis - qa'an-i bosu'ai üdü'üi-e oron dotora bükü-tür oroju uyila'at sögötcü ügülerün yisün








keleten irgen teb-tenggeri-tür ci'uldaju nada qariyatan irge-ben teb-tenggeri-dece quyura soqor neretü elci ilelü'e soqor elci-yi minu asgiju yabuqan eme'el ürgejü ilekdejü bi ö'esün quyira odu'asu dolo'an qongqotan-a endece tendece qa'aju namancila'ulju teb-tenggeri-yin qoyinaca sögötke'üldeba ke'et uyilaba cinggis-qa'an-i dongqodu'ai üdü'üi-e börte-üjin... nilbusu alda'at ügülerün yekikset qongqotan tede öcigen qasar-i ömörejü janciju-gü büle'ei edö'e basa ene otcigin-i yekin qoyinaca-'an sögötgemüi yambar yosun bolumui...yekikset qongqotan büle'e tede de'ü-ner-iyen teden-e teyin ki'üljü ker üjejü amu ci ke'e'et börte-üjin nilbusun aldaba börte-üjin-ü ene üge-tür cinggis-qahan otcigin-a ügülerün teb-tenggeri edö'e iregü cidaqui-aca ker ba üyiletdü'esü ci mede ke'eba te'ün-tür otcigin bosu'at nilbusu-'an arci'at qarcu qurban bökös-i beletcü bayiba qurumut atala mönglik-ecige dolo'an kö'üt-lü'e-ben irejü dolo'an büri oroju teb-tenggeri tüsürge-yin bara'un ete'et sa'uqui-lu'a otcigin teb-tenggeri-yin jaqa inu bariju öcigen üdür namayi namancilan büle'e ci sorilduya ke'ejü jaqa inu bariju e'üten jük cirba teb-tenggeri otcikin-u esergü jaqa bariju e'üten jük cirba teb-tenggeri otcikin-u esergü jaqa bariju barilduba te[b]-

tenggeri-yin (yin) maqalai barilduqui-tur qolu[m]ta teri'ün-e unaba mönglik-ecige maqalai inu abcu hünüscü ebür-tür-iyen talbiba cinggis-qahan ügülerün qarcu bökö gücü temeceldütkün ke'eba.

Үүний дотроос "te[b]-tenggeri-yin (yin) maqalai barilduqui-tür qolu [m]ta teri'ün-e unaba mönglik-ecige maqalai inu abcu hünüscü ebür-tür-iyen talbiba" гэсэн хэллэг бидэнд ихийг хэлж өгч байгаа юм. Хөхөчү Тэв-Тэнгэр бөөгийн малгай бусдын хүчээр унах, тэр тусмаа өөр айлын голомтны дээр унах гэдэг нь түүний хувь заяа буруугаар эргэж малгай төдийгүй толгой өнхрөх болсны бэлгэ шинжийг илтгэсэн ажээ. Эл ёр зөнг гадарласан Мэнлиг эцэг "унасан малгайг нь авч үнсэж өвөртөө талбив" гэдэг нь хүү Тэв-Тэнгэр бөөг өрөвдөж халагласны илрэл юм. Тэрхүү зөн ёр чухам үнэн болохыг хэдхэн хурмын дараах" otcigin teb-tenggeri-yi circü qarurun e'üten bosoqa ja'ura urida beledüksen qurban bökös esergü teb-tenggeri-yi bari'at circü qarcu niru'u inu ququlju jewün ete'ed-ün terged-ün üjü'ür o['o] rcu..." гэсэн үйл явдал харуулав.


§ 246. teb-i talbiqsan qosiliq-un erüge tülijü e'üten daruju hara saki'ulu'asu qutu'ar söni üdür sira-da ger-ün erüge ne'ejü beye selte qarcu'u bolqa'asu... cinggis qahan ügülerün teb-tenggeri de'ü-ner-tür minu qar köl gürgeksen-ü tula de'ü-ner-ün minu ja'ura oro ügei jinggügü-yin tula tenggeri-de ese ta'alaqdaju ami-yan beye selte abcu otdaba-je ke'eba ..." гэсэн нь үүнтэй эрх булаалдсан Тэв-Тэнгэрийн малгай бусдын голомтны дээр унасны учир утгыг бүрэн тайлж байгаа болно.




"de'ü-ner-tür minu qar köl gürgeksen-ü tula de'ü-ner-ün minu ja'ura oro ügei jinggügü-yin tula" хэмээн Тэв-Тэнгэрийн тухайт холбогдуулан

Чингис хааны хэлсэн үг зөвхөн Отчигинд төдийгүй Хасарт ч, тэр ч бүү хэл өөрт нь хамааралтай юм.

§ 244. ... tende teb-tenggeri cinggis-qa'an-a ügülerün möngke tenggeri-yin jarliq qan ja'arit ügülemü niken-te temüjin ulus barituqai ke'emü niken-te qasar-i ke'emü qasar-i ese nende'esü mede'e ügei bui-je ke'ekdejü cinggis-qahan mün söni morilaju qasar-i barira odu'asu gücü kökücü qoyar qasar-i barira otba ke'en eke-de ja'aju'u eke mede'et söni bö'et uda'aran caqa'an teme'en köljü qara'utai tergetei söni-de dülin yorciju naran






urququi-lu'a gürü'esü cinggis-qahan qasar-un qancut huyaju maqalai büse inu abcu üge inu asaqun bükü-tür eke-de gürtejü cinggis-qahan geyekcü eke-dece emi'eba eke a'urlaju gürcü tergen-ece bawu'at eke ö'esün qasar-un huyaqsat qancut dalju talbi'at maqalai büse inu qasar-a ökcü eke kilinglaju a'ur-iyan darun yadan jabilan sa'uju qoyar köködiyen qarqaju qoyar ebüdük dege'ün bisari'ulju ügülerün üjebe-yü kököksen köken tanu ene bui ede qadalun da'un qarbisu-'an qajaqsat kü-iyen tasuluqsat qasar yekibe ... edö'e daisun gü'ün-i muqutqaba ke'ejü qasar-i üjen yadamui ta ke'eba eke-yi amurli'ulun baraju cinggis-qahan ügülerün eke-yi kilinglaqdaju ayun ba ayuba hicen ba hiceba bi ke'ejü icuya bida ke'ejü icuba ...


Энэ хэсгийн "qasar-un... maqalai büse inu abcu..." гэсэн нь "qasar-i ese nende'esü mede'e ügei bui-je" гэсэн Тэв-Тэнгэрийн ятгалганд орсон Чингис хаан дүүгээ засгийн эрх булаалдах нь гэмээн сэжиглэн гэсгээн цээрлүүлэх гэж байгаа үеийн дүрслэл юм. Хэрэв Өэлүн эх яаравчлан очоогүй бол Чингис хаан Хасарыг хэрхэн цээрлүүлэх байсныг урьдчилан хэлэхүйеэ бэрх. Эл жишээг тэр л үес бүрэн эрх дархыг нь эвдэж цээрлүүлэх цаазлах хүний малгай бүсэд халдан авдаг байсан, түүний бэлгэ шинж гэж үзэж болохоор байгаа юм. Эл санааг батлах бас нэгэн жишээг § 145-аас мэдэж болно. Түүнд Чингис хаан Тайчуудтай хатгалдахдаа хүзүүний судас, шархдаж цус тогтохгүй байхад Зэлмэ холдолгүй сахиж бөглөрсөн цусыг амраараа шимэн асгасаар байв. Шөнө дөл нөхцөхөд /өнгөрөхөд/ Чингис хаан дотор сэргэж "Цусан хатаж барав. Ундаасав би" гэжээ. Зэлмэ махалай /малгай/ гудусан /гутал/ дээл хувцсаа бүгдийг тайлж гагц дотуужтай чармай нүцгэнээр дайсны дотор орж эсүг /эсэг/ олдохгүй тул бүрээтэй тараг тэргэн дээрээс аваад бас ус авчирч, түүнийг зуурч Чингис хаанд уулгаж дотрыг нь саруул болгожээ. Чингис хаан "Намайг ийм болж хэвтэн байтал чи нүцгэн гүйж одов. Чи баригдваас намайг энд иймийг заасан байсан биш үү?" гэхэд Зэлмэ "Би танд орох дуртай билээ. Ухаж /мэдэж/ барьж алъяа гэж хувцсыг бүгдийг тайлж, гагц дотуужийг тайлаагүй байтал мултарч танд

дутааж ирэв гэж би хэлнэ. Намайг үнэн болгож тэд хувцас өгч асрана. Тэгэхэд би морь олж унаад хүрч ирж чадах биш үү? гэжээ.

Үүнээс үзэхэд "барьж алъяа" гэхэд малгай хувцыг мултлалж тайлж авдаг ёс байсныг харуулж байгаа биш үү? Бас үүнийг Чингисийн гаргасан хууль зарлигийн "... to'a asaquqsan gü'ün-i kebte'ül tere gü'ün-i tere-gü üdür-ün unuqsan aqta eme'eltu qadartu-yi emüsüksen qubcasun selte kebte'ül abtuqai" гэсэн заалт /§ 229/ батлаж байгаа юм. Харин өрөөл бусдын хүчинд автахдаа бус өөрөө малгайгаа гартаа авч, бүсээ тайлж хүзүүндээ өлгөх нь монгол хүний чин сүсэглэл, хүндэтгэл бишрэхүйн бэлгэдэлийг илэрхийлж байжээ.



§103 . . .temüjin burqan de'erece bawuju ebce'ü-ben mö'eletcü ügülerün qo'aqcin-eke-yi solangqa bolju sonosqu-yin tula ünen bolju üjegü-yin tula büdün beye-'en buru'udun bugiya moritu buqu-yin horum horumlaju burqasun ger gerlen burqan de'ere qarula'a burqan-qaldun-a bö'esün-ü tedüi amin-iyan bulji'uldaba bi qaqcaqan amin-iyan qayiralan qaqca moritu qandaqai-yin horum horumlaju qalqasun ger gerlen qaldun de'ere qarula'a bi qaldun-i -burqan-a qarca-yin tedüi amin-iyan qaldalaqdaba-je bi masi ayu'uldaba bi burqan-qaldun-i manaqar büri maliyasuqai üdür



büri öcisügei uruq-un uruq minu uqatuqai ke'en naran esergü büse-ben güjü'ün-dür-iyen erigelejü maqalai-ban qar-tur-iyan se'ejigelejü qar-iyan e[b]ce'ün-dür-iyen mö'ele [t]cü naran [jük] yisün-te sögö[t]cü saculi öci'üli ö[k]ba.

Энэ жишээ бол Тэмүжинээс уул ус тахихуйд үйлдсэн эрхэм дээд хүндэтгэл, ёс бэлгэдэл юм. Ийм хүндэтгэлийг Тэмүжин "бүсээ хүзүүндээ өлгөж, махалай /малгай/-гаа гартаа сэгэлдэрч" (büse-ben güjü'ün-dür-iyen erigelejü maqalai-ban qar-tur-iyan se'ejitgelejü) илэрхийлж байгаа нь уул усны тахилгад төдийгүй эцэг тэнгэрт мөргөхөд ч нэгэн адил хамааралтай байжээ.

Үүний жишээ "... эзэн /Чингис хаан Д.Ц/ дээр тэнгэр эцэгтээ мөргөе гэж, өндөр довцог дээр гарч, тохмоо дэлгэж, бүсээ хүзүүндээ өлгөж залбиран өчив"[4] хэмээн XIII зууны түүхэн үйл явдлаас эх үндэс авч уран сэтгэмжээр баяжуулан өгүүлсэн нь "Гурван зуун Тайчуудыг дарсан домог"-т үлджээ.

Чингис хааны үйлдэж байсан ийм эрхэм хүндэтгэл ёслолыг түүний хөвгүүд, залгамжлагчид уламжлал болгосон нь "Хичээнгүйлэн ятгаж гуйсны эцэст Өгэдэй хаан, эцгийн зарлигийг дагаж, ах дүү авга нарын хэлж заасныг хүлээн зөвшөөрчээ. Бүгд малгайгаа авч, бүсээ мөрөн дээгүүрээ тохлоо. Өгэдэй хааны баруун гараас нь Цагадай-хан, зүүн гараас нь Толуй-хан, бүслэхийнээс нь авга ах Отчигин түшин 616 оны үхэр жилд түүнийг хаан ширээнээ залав"[5] гэсэн жишээнээс илэрхий ажээ.

2.

Малгайтай эн зэрэгцэх төвшинд монгол угсаатан бүслэдэг бүсээ эрхэмлэн үздэг байсан нь нарийн утга учиртай билээ. Цээжин бие, бөгсөн бие хоёрын нийлэх уулзвар, бас тэдгээрийг зааглах заагт монгол хүн их төлөв бүсээ бүсэлдэг болой. Дорно дахины түүний дотор монголчуудын уламжлалт гүн ухааны ёсоор цээжин биеийг арга, бөгсөн биеийг бэлгэ хэмээн үзвэл арга бэлгэ нийлэх, бас ч салах тэр л заагт бүс /бүслэлт/ таармуй. Чухам тэрхүү бүслэхийн шугамд хүний гол төв эрхтэн гэж монголчуудын

үзсээр ирсэн хүйс оршино. Дорно дахины тухайлбал энэтхэг, хятад, төвдийн эмнэлгийн ухаантай уялдаа холбоотой хөгжиж ирсэн Монголын уламжлалт анагаах ухаанд "Эхийн умайд үр хөврөл тогтох ёсоо дагаж эхлээд хүйсний судал бий болно. Хүүхдийн хүй нь усандаа биеийг тогтоох гурван их судлыг үүсгэнэ"[6] гэх буюу "Эцгийн цагаан дусал, эхийн улаан дусал нэгдэж хүүхэн хэвтэшинд оршин тогтоод аажмаар бойжихын дагуу өндөглөн хэлбэртэй болж хүний биеийн хүйсний ором бий болдог гэдэг. Тиймээс хүйс бол хүний биеийн бүтцийн хамаг анхны хэлбэр болох бөгөөд хүний биеийн бусад эрхтний бойжилтын үндсэн хэлбэр мөн"[7] гэж үздэг ажээ.


Үүнээс үүдээд ч тэр үү Монголчуудын дунд "Хүний биеийн хамаг анхны хэлбэр... биеийн гол төв" хүйсээр хүйгээр дамжин хүүхдэд амь ордог гэх ойлголтоос түүнийг гадар талаас нь дарж халхалж хамгаалдаг болохоор нь бүсэнд амь, сүлд, сүнс шингэсэн гэсэн төсөөлөл төрсөн байж ч болно.

"Эрт цагт байлдаанаас эмэгтэйчүүд хэвлий дэх хүүхдээ хамгаалж, бүсээрээ харвуулын хаалт хийх болсон"[8] гэх домог ч монгол угсаатны дунд улиран үлджээ. Хүйг огтолж, эх үр хоёрыг салгаж, хүүхдийг эх барьж авсан хүнийг "авсан ээж", "хүйсний ээж", "хүйний ээж" гэхчлэн нэрлэж, насан туршдаа хүндэтгэдэг ёс ч уламжилсаар бий.

Монгол хүн бүсэн дээр гишгэдэггүй, алхдаггүй бүсээ тайлж унтах үедээ "Аман хүзүү" гогцоо гарган зангидаж, хүний хөл хүрэхээргүй газарт дэрнийхээ буюу толгойныхоо дэргэд дээдлэн тавьдаг, эзэн нь зангилаагүй байхад ээдэрч зангирсан тохиол гарвал ахмад хүнд очиж "бүсний зангилаа тайлуулдаг"[9] ёс ч олон үеийг дамжжээ. Чухам энэ бүхэнд бүсийг эрхэмлэн дээдлэхийн утга учир оршсоор иржээ.

"Тулгар байгуулсан гавъяатан бөгөөд тайши Гоо ван [...] өргөмжлөгдсөн Му хү ли [...] арван оноос нааш зүүнш баруунш дайлалдаж нэр сүр нь дундад гадаадад алдаршсан байна. Аливаа дайлах ба бáйлдах их явдлыг бүр өөрөө шийдвэрлэх

тул орлосон хаан хэмээн дуудагдмуй. Хувцас хунар ёс дүрэм бүр хааны янзаар явмуй" [10] гэж "Монгол татарын тухай бүрэн тэмдэглэл"-ийн тайлбарлан гэрчилсэн бичигт бичиж үлдээжээ. Үүнээс "хувцас хунар ёс дүрэм бүр хааны янзаар явмуй" хэмээсэн нь Му хү ли /Мухалийн/-ийн хаан нь "хувцас хунар ёс дүрэм"-тэй байсан гэсэн санаа урган гарч байна. Тэр хаан нь мэдээжээр зарлигаараа Мухалийг "Гоо ван" болгосон Чингис хаан мөн. Чингис хааныг их хааны сууринд залсан тухайд, олон судар түүх цөлбөн уншиж, түүнийг ашиглаж бичсэн В.Инжаннаши /1837-1892/ " Их Юань улсын мандсан төрийн хөх судар" хэмээх түүхэн романдаа: "Тайзуг төр дор гар хэмээн залахуй дор Тайзу лав улс төрийн чухал хэрэг байхыг мэдэж яаран луугийн хувцас, эрдэнийн бүс, титэмт малгай, улаан гутал өмсч гадна төр дор гарваас /хаан суудалд залрах төрийн их ёслол дор гарваас Д.Ц./...[11] гэж бичжээ.



Энд их хааны сууринд өргөмжилсөн Чингис хааны ёслолын хувцас сэлтийг тодорхой өгүүлжээ.

§ 238. ... cinggis-qahan soyurqa'asu altan büse-yin qorgi-daca al de'ele-ün hürtesün-ece olu'asu dabtu'ar kö'ün cinu bolju gücü öksü хэмээн Чингис хаанд Уйгурын Идүүт /idü'üt/ хаан элч илгээж хэлүүлсэн нь бий. Энэ хэсэгт Чингис хааны "алтан бүсийн гархи"-ийг дээлийн хамт цохон нэрлэсэн нь хэдийгээр "бэр гуйх" ёсны утга хэллэгийг илтэд санагдуулж байгаа ч эрхэмлэн дээдэлдэг хувцсыг нь давхар



онцолж тодосгосон хэрэг юм. Тэрхүү хувцсаа өмсөх ёс журам Чингис хаанд лавтайяа байсан /дээр дурдсан Мухалийн тухайт бичсэнд/ хэмээн үзвээс зохилтой.


Эзэн хааны "хувцас хунар ёс дүрэмтэй" байж гэмээнэ бусад эрхтэн дархтаныхаа дээл дэвээг тогтоох журамлах нь зүй.

§ 216. basa cinggis-qahan üsün-ebügen-e

ügülerün... beki mör bidan-u dotora de'ere-ece beki üsün-ebügen boltuqai beki ergü'et caqa'an de'el emüscü caqan aqta unu'ulju sa'uri de'ere sa'ulju takiju basa hon sara sataju teyin atugai ke'en jarliq bolba.

Эл хэсэгт "beki"-д өргөмжлөгдсөн Үсүн-өвгөний унах морины зүс, өмсөх дээлийн өнгийг хуртэл Чингис хаан зарлигаараа заасан нь тухайн үес албаны хувцас дэг журам тун нарийн байсныг илтгэх биш үү. Тиймээс Чингис хааны эзэнт улсын үеийн ёслолын болон албаны хувцасны дэг журмыг цаашид боловсронгуй болгож Мөнх хаан 1252 онд, Хубилай хаан 1275 онд тус тус хувцасны хууль гаргаж байсан гэж үзвээс зохино. XIII зууны үеийн хаант төрийн үзэл санааг тодорхой тусгасан "Арван буянт номын цагаан түүх"-д "Есөн их бэлгэ" гэж нэрлэсний дотор "7. Төр тогтоох эхил/ээл/ ихт хүнд бүс"[12] хэмээн өгүүлсэн нь хаан хүний олноос онцгойлох бэлгийн нэг-бүсийг задарсныг битүүлж тогтоох бүтээхийн бэлгэдэл гэж үзэж ээл ихтэйд тооцсон утга учрыг агуулсных ажээ. Чингис хаан болон залгамжлагчдынх нь хувцасны тухай товч хийгээд дэлгэрэнгүй өгүүлсэн бүхэнд бүсний талаар дурдсан нь түүнийг дээдэлж байсны илрэл болой.

§ 117. uridus ötögüs-ün üge sonoscu anda gü'ün amin niken ülü tebcildün amin-u arici boluyu ke'en amaralduqui yosun teyimü edö'e basa anda tungqulduju amaraya ke'eldüjü temüjin merkid-ün togto'a-yi arbilaju abuqsan altan büse jamuqa anda-da büsele'ülba toqto'a-yin esgel



qali'un-i jamuqa anda-da unu'ulba jamuqa uwas-merkid-ün dayir-usun-i arbilaju abuqsan altan büse temüjin anda-da büsele'ülba dayir-usun-u-gü ebertü ünügün caqa-an-i temüjin-e unu'ulba qorqonaq-jubur-un quldaqar-qun-nu ebür-e saqlaqar-mudun-a anda ke'eldüjü amaralduju qurimlan toyilan jirqalduju söni könjile-de'en qaqca qonolduqum büle'e.

Эл хэсэгт Тэмүжин /Чингис хаан/, Жамухатай гуравдахь удаагаа анд болохдоо /Үүний урьд Тэмүжин арван нэгэн настайдаа Жамухатай "si'a"-г солилцож, түүний хойт хавар арц магнайт годил, дуут сум солилцож хоёр ч удаа анд бололцсон Д.Ц./ бие биедээ алтан бүс бүслүүлж, морьд солилцон унасаныг өгүүлжээ. Тэр л үеийн алтан бүс ямар байсан бэ? гэдэгт Монгол улсын Улаанбаатар хотын дэргэдэх Сонгино хайрханы орчмын булшнаас 1981 онд монгол эрдэмтний малтаж олсон "алтан чимэг бүхий бүс"[13] үзүүлэлт болж байгаа юм.

Тэмүжин, Жамуха хоёрын харилцан бие биедээ алтан бүс бүслүүлснийг /бас морьд солилцон унасан/ доор дурдсанаар тодосгон тайлбарлаяа.

Марко Поло /1257-1324/ "Их хаан төрсөн өдрөө алтан утсаар хээлэн оёсон үзэсгэлэнт сайхан цэмбэн дээл өмсөх ба нэгэн түм хоёр мянган ноёд /жанжин/ баатар эрс мөн их хааны адил хувцас өмсөх аж... Хүн бүр том алтан бүс бүслэдэг. Энэ хувцсыг тэдэнд их хаан бэлэг болгон барьжээ...", "Их хаан хүн бүрд /хишигтэнд Д.Ц./ янз янзын сувд, тана хийгээд бусад эрдэнийн чулуу шигтгэн хээлсэн өнгө өнгийн үнэт сайхан арван гурван хувцас /дээл/ нэг нэг эрхэм сайхан алтан бүс, мөн мөнгөн утсаар оёсон үнэт бөгөөд үнэхээр сайхан тэмээний ширэн гутал бэлэглэдэг аж...", "Татарын ёсонд шинэ он хоёрдугаар сард эхэлдэг... Тэд бүгд заншил ёсоор эрэгтэй эмэгтэй ялгалгүй чадах чинээнийхээ хирээр цагаан хувцас өмсдөг. Цагаан хувцсыг аз жаргалын бэлгэ тэмдэг хэмээх тул түүнийг их хийдэг... Энэ өдөр их хааны харъяат засаглалын доторхи бүх ард олон, орон дэлхий муж салбар хийгээд улс даяар цөм их хаанд арвин их бэлэг сэлт алт мөнгө, сувд, тана эрдэнийн чулуу хийгээд үнэт цагаан бүс

арвин ихээр бэлэглэн барих ажгуу"[14] гэж бичжээ. Их хаанаас ингэж төрсөн мэндэлсэн өдрөөрөө их найр хийхдээ ноёд, баатар эрс, хишигтэн нартаа үнэт сайхан хувцас /дээл/ алтан бүс бэлэглэдэг бол шинэ он /цагаан сар/ гарахад их хаандаа муж салбар хийгээд ард олон нь үнэт алт эрдэнэс чулуу, үнэт цагаан бүсээр бэлэг барьдаг байжээ. Үүнээс үзэхэд XIII зууны үед Монголчууд хүндэтгэлийн бэлэгт шинэ бүсийг дээдлэн оруулдаг байжээ. Харин бэлгийн дээж дотор хүндэтгэлийн өмсгөл хирнээ малгай байхгүй байдаг нь түүнийг уруугаа /дорогш/ харсан амсартай сав гэж үзэж ирсэнтэй холбоотой юм. Бэлэглэх ёсны эртний уламжлалыг монгол угсаатны хурим тойн зан үйл өнө удаан хадгалсаар байгаа юм. "Монголын зарим нутагт хүргэндээ малгайнаас бусад дээл, бүс, гутал тэргүүтнийг бэлэглэж өгөн ерөөдөг бөгөөд малгайг уруу харсан сав гэж бэлгэ муутай хэмээн өгдөггүй ажээ"[15].

Монголчуудын ийм ёс заншил нь малгайн төрөл зүйлийн хийц загварыг хүртэл бэлгэ дэмбэрэл бодож хийдэг[16] ,малгайг нэгэнтээгүүр өмссөн эзэндээ ээлтэй, эрхэм хүндэтгэл гэхийн хамт, нөгөөтэйгүүр өрөөл бусдад зэтгэртэй /бузартай/ бэлгэ муутай гэж хоёр талтайгаар үзэж ирснийг харуулж байна. Малгайг уруугаа /дорогш/ харсан амсартай сав гэж үзсэнээс үүдсэн, "малгайг бусад хүнтэй соливоос сүлд хийморио сольсноос өөрцгүй... хүний хөлстэй малгай өмсвөөс бузартана"[17] "Зам дээр хөдөө хээр гээгдэж орхигдсон малгайг... нисгэлэн зайлуулна... Малгай хэрвээ дээш хандаад байвал дотор нь шээгээд орхих ёстой"[18], хэн нэгний малгайг зайлшгүй өмсөх тохиол гарах аваас "Миний малгай биш, хүний малгай" хэмээн дотор тал руу нь нулимлан шившиж хэлээд толгой дээрээ тавьдаг /өмсдөг/ зэрэг олон цээр ёс монгол угсаатны дотор уламжлал болон улирсаар иржээ. Тиймээс монголчуудад малгай солилцож өмсөх бэлэглэх ёсон байсангүй ажээ.


Харин Тэмүжин, Жамуха нар бие биедээ харилцан бүс бүслүүлэн /бас нэг нэгэндээ морь унуулах/ ч гэсэн тэдний өөрсдийнх нь эдэлж хэрэглэж байсан угийн бүс биш гэдэгт нэгэн

утга хадгалагдаж байна. Тэрхүү бүсийг Тэмүжин Удуйд мэргэдийн Тогтоагаас, Жамуха Увас мэргэдийн Дайр-үсүнээс тус тус олзолж авсан /хүлэг морь нь ч бас адил/ билээ. Цэрэг дайны үеийн эрэлхэг, баатарлаг эрсийн хувьд сүлд хийморь, цог жавхлан нь нэг нэгнээс салган ухаарч болохгүй нь бүсэлсэн бүс, унасан ажнай агт хүлэг гарцаагүй мөн. Тэдгээр алтан бүс, агт хүлэг нь Тэмүжин, Жамуха нарын хувьд өстөнөө сүр хүчээрээ давамгайлан дийлсний бэлгэдэл, Тогтоа, Дайр-үсүн нарын хувьд бусдын хүчинд автаж ялагдаж сөнөсний баталгаа мөн. Тэгэхлээр Төмүжин, Жамуха нар олзны алтан бүс, агт морийг солилцож анд бололцож байгаа явдал "Бид дайсан нэгтэй, тэднийг хамтын хүчээр ялсны хувьд сүр хүчин чадал нэгтэй /адил/, олз омог ч нэгтэй "хэмээх утгыг илтгэхийн хамт "эв эеэсээ няцахгүй амь нэгтэйгээр амраглан явъя" гэж андгайлсны бэлгэдэл болжээ.


Бусдаас олзлон авсан гэдэг нь хувцасны хувьд өөртөө өмсгөл болгож, хүлгийг өөрөө унана гэсэн ойлголт хараахан бус. Өөрсдөө тэдгээрийг авч болохын хамт нэгээс олзолсноо нөгөөд шилжүүлэн дурсгах, шагналд өгч болохыг үгүйсгэх аргагүй. Тэмүжин, Жамуха нар олзны бүс, морийг зөвхөн солилцсон бус нэг нь нөгөөдөө алтан бүсийг бүслүүлж, морийг унуулсанд учир байна. Энэ нь өөрсдийн угийн бүс, унасан агт байлаа ч гэсэн түүний зэрэгцээгээр Тэмүжин, Жамуха нар анд бололцох ёсыг гүйцэтгэсэн гэсэн үг юм. Тэгэхлээр өөрсдийн эдлэж хэргэлж, сүлд хиймор эрх дархны бэлгэдэл болгосон бүсийг бусдад шилжүүлдэггүй, хэн нэгэнтэй сольдоггүй хатуу чанад тогтсон монгол ёс журмыг Тэмүжин, Жамуха нар мэддэггүй, түүнийг огтхон ч хайхраагүй гэж үзэж боломгүй мэт. Тэгвэл тэр хоёрын бие биедээ бүслүүлсэн олзны алтан бүсийг өөрсдийнх нь эдлэж хэрэглэж ирсэн угийн бүсийн төвшинд үзэж болохгүй ээ. Унаган /угийн/ бүс хүндэтгэл бэлгэдлийн их утга учиртай гэдгийг, шинэ бүс бүслэхдээ хуучинтайгаа давхар бүслэж, түүнд шингэсэн сүлд хийморoo шинэд шилжүүлэн авдаг ёс ч монголчуудын дунд цагийг эзлэн уламжилсаар байсан жишээ ч харуулж иржээ.

XII-XIII зууны үед монгол угсаатны эм хүн бүс бүслэдэг байсан уу? үгүй юү? Энэ асуултад яаж хариулахаас шалтгаалж бүстэй, бүсгүй гэж эр, эм хүнийг нэрлэх ёс гарсан уу? гэсэн ойлголтыг тодруулъя.

Гильом де Рубрук "Дорно этгээдэд зорчсон минь" тэмдэглэлдээ: "Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил бас морийг сандайлах биш мордож унана. Морь унахдаа хөх торгон бүс бүсэлж, цээжээ даруулан, нүднийхээ доогуур цагаан өнгийн бүс уяж доош унжуулсан байна"[19] гэж бичжээ. Чингэж эм хүний бүс бүсэлж байсан тухай мэдээ дүрслэл гадаадын элч жуулчдын тэмдэглэлд төдийгүй "Монголын нууц товчоо"-нд бийг иш татъя.



§ 74. tayici'ut aqa de'ü hö'elün-üjin-ni belbisün-ni kö'üt ücüget ekes kö'üd-i nuntuq-tur gejü newükdejü hö'elün-üjin eme mergen törejü ücüget kö'üd-iyen teji'erün ukitala boqtalaju hojitala büselejü onan-müren ö'ede irada güyijü ölirsün moyilsun temgüjü üdür söni qo'olai teji'eba...



§ 254 ... eke tanu qamtu-bar joboldurun horaitala boqtalaju ho'ojitala büselejü niyitaitala boqtolaju niduratala büselejü tan-iyan ösgerün jalgiqui ja'ura jarim-iyan ökcü qo'olai-yan quciju qotola-iyan ökcü qo'osun yabuqui büle'ei...

Эл хоёр хэсгийн эхнийхэд /§ 74/ зохиолчийн үгээр Өэлүн эхийн, дараагийнхад /§ 254/ Хөхөчосийн үгээр Бөртө-үжингийн зүдэрч явж хөвгүүдээ өсгөснийг илэрхийлэн дүрсэлжээ. Эл хоёр хэсэг тухайн үед эм хүн бүс бүслэдэг байсныг лав гэрчлэх баримт мөн. Гэхдээ "ukitala boqtalaju hojitala büselejü" /§74/ "horaitala boqtalaju ho'ojutala büselejü niyitaitala boqtolaju niduratala büselejü" /§ 254/

гэсэн утга ойр хэллэгийг Өэлүн эх, Бөртө-үжин хоёрт юунд адилхан хамааруулан хэрэглээ вэ?

Есүгэй баатар Татар нарт хорлогдсон тул түүний харьяат нар сарнин бударч Өэлүн эхийг гадуурхан нутаг дээр нь орхисон учир хөвгүүдээ тэжээх гэж зовж зүдэрч явжээ. Олон улс орондоо үл орон олзлолдон бүхий цаг тул Чингис хаан үргэлжийн аян дайнд явсан учир Бөртө-үжин хүүхдүүдээ өсгөх гэж өлсөж ядарч явжээ. Гэсэн ч Өэлүн эх "oilrsün moyilsun temgüjü", Бөртө-үжин "jalgiqui ja'ura jarim-iyan ökcü" байгаагаар хэдийгээр ялгаатай дүрслэгдсэн боловч үр хүүхдээ өсгөдөг эх хүнийх нь хувьд дээр ишлэсэн утга ойр дүрслэлийг хэргэлжээ хэмээж болно.

Бэлбэсэн Өэлүн эх, хань нөхөртэй /эхнэр болсон/ Бөртө- үжин хоёрт "boqtalaju, büselejü" гэсэн адил үгийг хэрэглэсэн нь тэдэнд бүс бүслэх, бүслэхгүйн ялгаа байгаагүйнх болов уу? Гэсэн ч дээр ишлэд авсан хоёр хэсгийн "ukitala boqtalaju ho'ojitala büselejü niyitaitala boqtolaju niduratala büselejü /§ 254/ гэсэн дүрсэлгээ, дор дурдсан утгасыг агуулсан мэт санагдана. Үүнд:

а. Гэдэс дундуур бүс чанга мөчиг тачиг зовж зүдэрч амьдарсан

б. Гадаа гарахлаар эр хүний хийх ажлыг хийж, гэртээ байхлаар эм хүний хийх ажлыг хийж толгой даан үр хүүхдээ өсгөсөн

в. Эм /эх/ хүний хувьд бат журмыг сахисан /бэлбэсэн нь бусдын эхнэр болж очоогүй, нөхөртэй нь шудрага журамтай байсан/ гэсэн давхар утгыг илэрхийлсэн болой. Эдгээр утга Өэлүн эхийн холбогдолтой хэсэгт бүр ч илүү хамааралтай юм.

Чухам тийм ойлголтуудыг "бүсээ чанга бүслэх" гэсэн монгол хэллэг эдүгээ ч гэсэн илэрхийлсээр байгаа болой.

XIII зууны үес эм хүн бүс бүслэдэг байсан гэх баримт нэгэнт байгаа тул "Монголын нууц товчоо"-нд "бүс үгүй", "бүсгүй" гэсэн үг тааралдахгүй байна. Харин XIII зууны үеийн монголчуудын хуримлах ёс, эхнэр болж байгаа хүүхний өмсгөл хувцастай холбогдуулж "Харин эмэгтэйчүүд нь хүнтэй сууж

хуримласны маргаашаас эхлэн магнайныхаа шанх үсийг хяргана. Эмэгтэйчүүд гэлэнмаагийн өмсгөл шиг өргөн, тэгэхдээ түүнээс ч арай урт бөгөөд өргөн, энгэр нь задгай, зөв талдаа бүчилдэг дээл өмсөнө... Түүнээс гадна эмэгтэйчүүд нь богтаг хэмээх толгойн боолт зүүж гоёно... Гөрсөн гэзгээ араас нь өөд хумьж нэгэн зангилаа болгож, түүн дотор хийгээд малгай өмсөж сагалдаргална. Тийнхүү толгойн боолттой, морь унаж яваа олон хатдыг алсаас харахад дуулга өмсөн жадаа гозолзуулсан морьт цэрэг мэт харагдана"[20] гэхчлэн бичиж үлдээсэн нь гадаадын элч төлөөлөгч, аялагч жуулчлагчдын тэмдэглэлд цөөнгүй бий билээ.

Монголчуудын тийм л ураглах хуримлах ёстой холбоотойгоор монгол хэлний үгсийн санд "бүсгүй", "бүстэй" гэсэн эр, эмийн хүйсний ялгавар заасан үгс нэмэгдэж орсон гэж үзмээр ажээ. Монголчуудын дунд "эхнэр хүнд бүс бүслүүлэхгүй байх, хүргэнд бүс бүслүүлэх" [21] заншил байжээ. Тэр нь ямар утга учиртай ёс заншил байж вэ? Эрд гарч, эхнэр болоогүй хүүхэн бүс бүслэдэг нь түүний хэн хамаагүй хүнд өврөө нээхгүй, бат журмыг сахина гэсэн бэлгэдлийн утгатай юмсанжээ. Харин эрд гарч, эхнэр болно гэдэг хүүхэн хүний хувьд ханилах ханьдаа бүсээ тайлж, өврөө нээж өглөө гэсэн үг юм. Тийм болохлоор эхнэр болсон хүн бүс үгүй дээл өмсөж, бүс бүслэдэггүй нь "би нөхөртэй хүн шүү" гэдгээ бусдад шууд мэдэгдэх, хань нөхөртөө үнэнч явна гэдгээ харуулах утга бэлгэдлийг давхар илтгэж байгаа ажээ.

Монгол угсаатны дотор түгээмэл байсан тийм ёсноос "Хүүхний эцэг эх, охиноо өөрийн гэрээс гаргахдаа хүний хүн хэмээн нэрийдэж, охиныхоо хуучин бүсийг тайлж түүгээр хишиг авахаар хурайлан хоцрох ёс"[22] халхчуудын дунд, "сэвгэр /охин/ нөхөрт гарч хурим ёслолын өмсгөл өмсөх өдөр өөрийн бүсэлж байсан бүсээ дүүдээ бэлэглэж айлын бэр болоод бүсгүй явах" ёс /баяд/,[23] "эмэгтэйчүүдийн өмсдөг дээлийг бүсгүй өмсөнө. Морь унаж гадагш явбал түр бүс бүсэлдэг боловч айлд орохоос өмнө эрхбиш бүсээ тайлж, орох айлын монгол гэрийн баруун талын бүслүүрт өлгөдөг" ёс /торгууд/[24] ойрадчуудын дунд, "басган хамган гэсэн


үгүй цөм бүс бүслэх үгүй" /буриад/ "Бэр болох гэж байгаа хүүхэн .../д/ бүс үгүй авгай дээл өмсүүлэх" /барга/ ёс Буриад зоны дунд[25], "Харьд мордвол бүс үгүй болж, бүсээ бүслэхээ больдог"[26] заншил /ордос/, урагласан эмэгтэйчүүд "бүс бүслэхгүй", "бүсгүй дээл өмсөх" ёс цахар, түмэд, авга, сөнөд, үзэмчин, дархад зэрэг өвөрлөгчдийн дунд [27] хадгалагдаж үлдэж байжээ.

Түүнчлэн монголчуудын дунд байсан "Хүргэн хүү үзэгдэх"[28] ёсонд хүргэн болох хүнд цамц өмсгөх буюу бүс бүслүүлж, таргийн хөрөнгө амсуулдаг нь түүнийг өөрийн гэсэн ам бүлийн хүрээнд оруулан авч байгаагийн бэлгэдэл ажээ. "Хүргэн хүүд бүс бүслүүлэх" ёс бас ч түгээмэл байсныг "охины эцэг хүргэн хүүд дээлийн бүс өгч, түүнийг охины эх бүслүүлж, баруун ташаанд нь цагаан өнгийн бөс зүүж ташаа цайлгах ёс гүйцэтгэдэг"[29] /Баяд/ гэх буюу "Хадам нь шинэ хүргэндээ өвч өмсгөл өмсүүлнэ. Үүнд хүүхний талын бэргэдээс шинэ хүргэнд бүс бүслүүлсний дараа хоёр тохой урт, гурван ямх өргөн цагаан бөс дээр улаан утсаар хатгасан хас тамгатай дайлан зүүлгэнэ"[30] /цахар/ гэсэн тодорхой жишээнээс үзэж болохоор байжээ.

Чингэж монголчуудын ураглах хуримлах ёс заншилтай холбогдож бүсгүй, бүстэй гэсэн ойлголт гарч, ураглагч хосын эмийг "бүсгүй", эрийг "бүстэй" хэмээн ялгаварлан нэрлэж байжээ. Тэдгээр үгс анхны түүхэн утгаа яваа яваандаа гээж, эмэгтэйг бүсгүй, эрэгтэйг бүстэй гэж нэрлэх ойлголт болон хувирахад хүрчээ. Түүний нэгэн жишээ нь "Эхнэр дээл нь мөртэй бөгөөд бүс үгүй байдаг... төр ёсоор хадамд очсон эмэгтэйчүүд нь эхнэр үстэй бөгөөд эхнэр дээл өмсдөг байсан ажээ. Эхнэр хүний дээлийн энэ шинж нь яван явсаар нийт эмэгтэйчүүдийн /төр ёсоор хадамд очсон болон очоогүй эмэгтэйчүүд, эмэгтэй хүүхдийн/ нэр болсон түүхтэй юм.

Эрэгтэйчүүд нь дээл өмсөн бүс бүслэх тул энэ тэмдгээр нь бүстэй буюу бүсгүйчүүд гэж нэрлэн заншжээ"[31] гэсэн тайлбараас илэрхий байна.

"Монголын нууц товчоо"-ны хувцасны бэлгэдлийн талаар өгүүлэхэд "camca"-ийн тухай орхигдуулж яавч үл болно.



§ 55...hünür minu hünüscü yabu ke'en camca-ban mültüljü гэсэн нь цамцаа мултлан "үнэрийг минь үнсч яв" гэж нөхөр Чилэдүдээ Өэлүн-үжиний хэлсэн үг.Энэ бол хайрт Чилэдүгийн амь насанд аюул учрах эгзэгтэй мөчид Өэлүн-үжиний гаргасан мэргэн ухаан ч монгол угсаатны дунд уламжилж ирсэн утга бэлгэдлийг харгалзан үзсэн нь байжээ.Үүний жишээг монгол ардын баатарлаг туульсын дүрслэлээс харж болно.Үүнд:

"Урангуа дагинаа хар мангасын гарт алдах цаг болжээ гээд өдөр өмсдөг улаан цамцаа тайлж Дайрт хар түшмэлдээ өгөөд,

- Миний улаан торгон цамцыг хадгалж байгаарай ! Сайн явбал улаан торгон цамц улам өнгө ороод тодроод байна. Муу явбал өгөрч хувхайраад байна ... гэж хэлээд наран шингэх зүгийг чиглээд гараад өгчээ ("Хаан Чингэл баатар" туульд)[32],

Өөрийн нь хатан Цэцэн гоо дагина

- Эр хүн хол юманд явахад эхийн чинь хувцас хэрэгтэй байдаг шүү гээд ганц дан ягаан цамц өгөв гэнэ... ("Алтан гургалдай" туульд)[33]


гэхчлэн монгол ардын хэд хэдэн туульд амраг ханьдаа, ачит эхдээ, анддаа цамц өгч байгаагаар дүрслэгдсэн нь монгол түмний дотор байсан зан үйл уран сайхны сэтгэлгээнд үлдсэний илрэл биз ээ. XII-XIII зууны үеийн ойлголтоор цамц нь хүний биеийн үнэр шингэсэн дотуур хувцасны нэгэн мөн байж. Тиймээс ч уг эзнийхээ биеийг ,биеийн үнэрийг төлөөлөх утга учрыг цамц хадгалж байжээ гэж болно. Үүний учрыг сайтар ухаарсан Өэлүн-үжин Чилэдүдээ цамцаа дурсгал болгон үлдээсэн нь хагацсан боловч бие сэтгэлээр хамтдаа шүү гэсэн утга бэлгэдлийг илэрхийлжээ.

"Монголын нууц товчоо"-нд ганц удаа гарч байгаа боловч Өэлүн-үжиний үнэр шингэсэн цамцаа мөрнөөсөө мултлан өгсөн нь хайрын сэтгэлээ ханьдаа яаж үлдээхийг охор давч хугацаанд

уламжлалыг сэргээн ухаж олсон, морин дээрээс цамцыг аваад алслан одох чин зоригийг Чилэдуд нэмсэн зэрэг ухааран бодвол олныг нэмэн өгүүлж болохоор байна.


5.

Малгай, бүс, түүний учир бэлгэдлийн тухайд холбогдуулан "Монголын нууц товчоо"-д гарсан дүрвэж дутаасан иргэдийн нутаг дээрээс олдсон хөвгүүд, тэдний хувцасны талаар тоВч өгүүлье.



§ 114. uduyit-merkit dürberün buluqan maqalaitu maral-un qodun qudusutu ilkin jarqaq usun-u buluqan jalqaqsan de'eltü tabun nasutu kücü neretü nidün-dür-iyen qaltu kö'üken-i bidan-u ceri'üt nuntuq-tur qocoruqsan-i olju abciraju hö'elün-eke-de sauqa abcu otcu ökba.

§ 135. tatar-un qorqalaqsan naratu-sitü'en-e bawuqsan nuntug-tur talaqui-tur niken ücügen kö'üken-i ge [k]



sen-i bidan-u ceri'üt nuntuq-aca olju'ui altan e'emek dörebcitü dasi torqan buluqa'ar dotorlaqsan helige [b] citü ücü'ügen kö'üken-i a[b] ciraju cinggis-

qahan hö'elün-eke-de sauqa ke'en ökba hö'elün-eke ügülerün sayin gü'ün-ü kö'ün aju'u-je huja'ur sayitu gü'ün-ü urug buyu-je tabun kö'üd-iyen de'ü jirqodu'ar kö'ün bolqan sikiken - qutuqu ke'en nereyitcü eke asaraba.

Басхүү Тайчуудын Бэсүдийн нутаг дээр Хөхөчү нэртэй нэгэн өчүүхэн хөвгүүн хоцорсныг /§ 119/, мөн Журхиний нутгаас Борохул нэрт хөвгүүнийг олж авснаа /§ 137/ Өэлүн эхэд уулзуулж өгсөн нь бий.

Эдгээрээс Удуйд мэргэд нь ойн иргэн байсан учир төлөв ан гөрөө эрхэлж, буга гөрөөс, булганы арьсаар хувцас хийж өмсдөг байсныг, татар нь хээр талын иргэд учир бас ч нутаг бүстээ тохируулж өөрөөр хувцасладаг байсныг хүүхдийн өмсгөл зүүлтээр нь дамжуулан мэдэж болохоор байна. "buluqan maqalaitu maral-un qodun qudusutu ilkin jarqaq usun-u buluqan jalqaqsan de'eltü" /§ 114/, "altan e'emek dörebcitü dasi torqan buluqa'ar dotorlaqsan helige /b/ citü" /§ 135/ гэсэн өмссөн зүүснээс нь үзвэл нутагт үлдсэн /үлдээсэн/ хүүхэд удам угсаатай, бас ч эрх дарх бүхий хүмүүсийн үр сад болох нь илэрхий байна. Эл жишээнээс ойн ба талын иргэдийн, ялангуяа сурвалжит хүмүүсийн зан заншил, хувцас хунарын ялгаа, үр хүүхэддээ хандах хандлага тэргүүтнийг зурвасхан боловч мэдэж болно.


Чингэж бусдад хүч түрэгдэн дийлдэж дутаахдаа хоргодож байсан буюу нутаглаж байсан нутаг буурь дээрээ бяцхан хөвгүүдийг орхидог ямар ёс нүүдэлчин аймгуудад байсан бэ? Дайсан гэнэт довтлон ирэхэд сандарч тэвдэхдээ юугаа ч авч чадалгүй /хүүхдээ ч/ орхиж болох юм гэж бодож болох авч үүгээр уг асуудлыг тайлбарлахад мөлт мөчид болох нь эргэлзээгүй. Дутаах дүрвэхдээ буудал дээрээ мөрдөн мөшгөгч, уулгалан дайрагчдад юу үлдээе, орхие, олзлуулъя гэснээ орхих нь мэдээж хэмээн үзэж, түүнээс ургуулан бодвол бас учир утгыг тайлахад оньс түлхүүр гарч юун магад. Тэгэхэд нутагт үлдсэн /үлдээсэн/ хүүхдүүд эрүүл саруул, цовоо сэргэлэн "нүдэндээ галтай, нүүртээ цогтой", хэн хүний анхаарлыг татахуйц байгаад бас ч утга учир байна.

Тэгэхлээр тодорхой зорилго агуулж хөвгүүдээ нутаг дээрээ орхидог үлдээдэг байсан биш байгаа.

Тэгж үзэх аваас ямар зорилго агуулж байж таарах вэ? гэсэн асуулт гарна.



"eme'el-iyen toqu'ul e'üde'-en neqü'ül" /Жарчиудай/ "bosoqa-yin cinu bo'ol boltugai bosoqa-daca cinu bulji'asu borbi inu hoqtol" /Гүн гуа/ gü'ün-u'a "örgen e'üten ergüjü öktügei ke'en ökba bi örgen e'üten-nece cinu ö'ere odu'asu öre inu miderijü getkün..." / Чулуун/cila'un гэхчлэн хэлж хөвгүүдээ Тэмүжинд авчирч өгөх явдал тэр үес түгээмэл байсныг § 97, 137-ооc үзэж болно. Харин тулалдаж, дутааж мэгдэж яваа нөхцлийн дунд хэн нэгэн нь хүссэн ч гэлээ хөвгүүдээ Тэмүжинд өгөх боломжгүй юм. Тэмүжиний нэр сүр өөрсдийнх нь дунд төдийгүй тэмцэгсэдийнх нь дотор ч илэрхий өссөн тул тэдний дунд Чингис хааныг хүндэтгэсэд, хүчээ өгөхийг хүсэгчид байх нь мэдээж. Тиймээс хөвгүүдээ авчирч өгөхдөө дээрхи хүмүүсийн хэлсэн үгийг Чингис хаанд нүүр тулан хэлээгүй ч гэсэн хүүхдээ нутаг дээр үлдээж байгаа нь нэгэн бодлын дээрхийн адил үгсийг хэлэн үрээ өгч байгаагаас өөрцгүй мэт.




Тэгэхдээ их дайн тулааны хөлд олон омог сөнөх нь сөнөж, устах нь устаж байсан нөхцөлд гал голомтоо унтраахгүй, удам угсаагаа таслахгүйн найдвар найдлага нь нүүдэлчин аймаг угсаатанд нуган хүүхэд /хөвгүүн/ байсан байж болно. Үүнтэй холбогдуулан нэгэн бяцхан домгийг сонссоноо сийрүүлбээс ийм буюу:


"Эрт урьд цагт юмсанжээ. Хар сүүл гэдэг голын хөндийгөөр дүүрэн тарвагатай юм байжээ. Гэтэл тэр нутагт тахал

гарч айл хотлоороо сүйрэхэд хүрчээ. Зуу нас наслаж зургаадай таяг тулсан өвгөн үр ач нарынхаа үхэж байгааг нүдээр үзэж гол харлавч аврах хүчгүйд цөхөрч нулимсаа асгаруулан хэвтжээ. Гэтэл олон он жилийн өмнө хөвчийн хар гөрөөчин "тахлын ганц аранга" гэж хойлогийн мах авчирч өгснийг борцлоод авдрын ёроолд хийж ор тас мартсаныгаа өвгөн гэнэт санажээ. Хар авдраа төнхөж, түүнээ олоод өвгөн "хэнд өгвөл дээр вэ?" гэж бодол болсны эцэст "дөрвөн настай дөч маань халдвар авч амжаагүй байж мэднэ. Ганц аврал энэ маань болж мэднэ" гээд түүнд борцоо идүүлжээ. Тэгээд "малгайтай хүүхэд рүү шувуу дайрдаггүй юм" гэсэн хуучны үгийг санаж малгай өмсгөн бүчий нь бөх гэгч уяад өвгөн амьсгал хураажээ. Хар нутаг сахиж үлдсэн хүү ганцаар амьд мэнд гарч эрийн цээнд хүрч айл хотлын голомтын галыг унтраалгүй асааж залган авч үлдсэн юм гэдэг"[34].

XII-XIII зууны үес /gara-se'ül/ /§159/ хэмээж байснаар нь нэрлэж /эдүгээ "Загийн гол" нэртэй/ өгүүлсэн эл домгоос миний сонирхсон нь, хөвгүүнийг хар нутаг дээрээ амьд үлдээж, гэр хотлоороо устахаас аврахыг бодож олсон зуун настай өвгөний арга ухаан юм. Олон улс орондоо үл орон олзлолдон бүхий их дайн тулааны үес нүүдэлчин овог аймгийн хэн боловч тийм арга ухааныг сийлсэн байхыг үгүйсгэх аргагүй юм. Хэрэйдтэй нийлж явсан гэж Да'аритайг "nidün-ü ecine ecitgeya" гэхэд нь "ö'er-ün qal-iyan sönö'egü metü ö'er-ün ger-i'e[n] ebdegü metü sayin ecige-yin cinu geri'es qaqca abaqa cinu qocorcu amu ker tebcigü inu ese uqaqsan-tur bütügei sayin ecige-yin cinu nilqa nuntuq hüni butara'ulcaju atuqai /§ 242/ хэмээн Чингис хааныг ятгаж үгэндээ оруулсан Боорчи, Мухали, Шихихутаг нарын "qabar-aca hüni qangsitala qaqas" хэлсэн нь монголчуудын "өөрийн галаа



сөнөөхгүй, сайн эцгийн багын /нялхын/ нутагт утаа гаргаж явтугай" гэсэн өвөг дээдсийн үеэс ам дамжсан хууль, удам дамжсан гэрээс юм. "Голомтоо мөхөөхгүй, удам угсаа таслахгүй" гэх бодол санаа, нутаг дээр хөвгүүнээ орхиж үлдээгсдэд байсан гэж үзэх юм бол тэдний бодол шийдэл үнэхээр сэтгэлчлэн бүтсэн ажээ.



Үүнийг Өэлүн эх "üdür üjegü -yin nidün söni sonosqu-yin cèkin" /§138/ болгон Чингис хаанд хүмүүжүүлж өгсөн учраас тэдгээр улс иргэнийг эргэж захирахад ч хэрэгтэй байж Хөхөчү, Хүчи нар мянганы ноёд болж, Шихихутаг, Борохул нар "есөн осол гаргавч яллахгүй болгоё" гэсэн өршөөл хүртэж, эзэнт улсад өндөр сууринд сууж хүчин зүтгэж байгаагаас мэдэж болно. "Гурван зуун Тайчуудыг дарсан домог"-т эзэн зургаан сайдаа магтахдаа "Татарын Шихихутаг минь", "Хушины сайн Борохул минь" гэх'члэн тэднийг удам угсаагаар нь нэрлэн дуудаж байгаа нь Чингис хаанд ирж хүчээ өгсөн хүмүүс аймаг угсаагаа залган авч, гал голомтоо бадрааж яваг тодотгон харуулсаны жишээ гэж үзэж болохоор байна.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон нь УХГ. УБ., 1988, 14-р тал
2. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ /Эртнээс XIY зуун хүртэл/. УБ., 1987, 48-р тал
3. Cang cün bumbu baraγunsi jorciγsan temdeglel. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. Ulaγanqada, 1993ғ47 duγar tal-a
4. Лувсанданзан. Алтан товч /Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршибай/ УХГ. УБ., 1990, 57-р тал
5. Рашид-ад-дин. Сборник летописей. Том II, пер. с персидского Ю.П.Верховского. Изд. АН СССР, М-Л.,1960, стр 19
6. Ч.Баавгай, Б.Болдсайхан. Монголын уламжлалт анагаах ухаан. УХГ. УБ., 1990, 79-80-р тал
7. Maγsarjab [sha tai Lu]. Mongγol anaγaqu uqaγan deki "küyisü" gedeg ner-e-yin tuqai. öbür mongγol-un neyigem-ün sinjilekü uqaγan, 1991, No 72, 64 düger tal-a
8. Kh.Nimbuu. Mongγol qubcasun-u teüke. öbür mongγol-un neyigem-ün sinjilekü uqaγan, 1994, No 72, 112 duγar tal-a
9. БНМАУ-ын угсаатны зүй. I боть, Халхын угсаатны зүй /XIX-XX зууны заг үе/. Ред. С.Бадамхатан. УБ., 1987, 153-р тал /Монгол хүн бүс зангирахыг цээрлэх бөгөөд хэрэв хүний бүс аяндаа зангирсан байвал гурав хонуулаад хамгийн ахмад хүнд очин миний бүсийг тайлна уу гэж хүсдэг. Ахмад хүн уг эзнээс юу олсон үзсэнийг асуухад бүс зангирсан хүн гурав хоногийн хугацаанд юу үзсэн олсноо хэлдэг ёстой. Мөн ахмад хүн эхлээд тэр хүний үзсэн олсон юмны сайн муу хоёр талын аль бэлгэтэйг тайлбарлаж, уул зангирсан бүсийг тайлж өгдөг байжээ/
10. "Mongγol-tatar-un tuqai bürin temdeglel-ün tayilburilan gerecilegsen bicig. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. Khayilar. 1985, 117-118 duγar tal-a

11. Injannasi.Köke sudur. Ded debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota, 1957, 1228-1229 düger tal-a.
12. Dörben törü-yin arban buyantu nom-un caγan teüke. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota, 1981, 85-86 duγar tal-a
13. Д.Наваан. Д/Ц/. Ойдов. Эртний монголчуудын бүс эрхэмлэх ёсон. Олон улсын монголч эрдэмтний IY их хурал. III боть. УБ., 1986 /1984/, 181-182-р талд 1981 онд Улаанбаатарын дүүрэг Сонгино хайрханы Дадарт уулын бие энгэрт нэгэн нууцлагдсан булш /2 м 30см гүн/ олж малтаад нас барагчийг дагалдуулсан эд өлгийн дотор "алтан чимэг бүхий бүс" тавьсныг шинжилснээ өгүүлжээ. Үүнд:

"Бүсний алтан чимэг нь: зургаан дэлбээт цэцэг хэлбэрт, тав бүхий 2 хадаасаар бүсэнд бэхлэгдэж байсан, зарим нь оломны нүх орох зайгүй, 26 ширхэг товруу, эвэр угалз хээтэй цутгамал олом /горхи/ хэлний сэнжийг битүү гагнасан, угалз хээтэй том хавчаар, хээгүй угийн хавчаар , нас барагчийн баруун ташаанд таарч зүүгдэж байсан уул, усны долгион, ургамлын хээтэй, ар талдаа бат бэх сэнжтэй, дороо сэнж бүхий цох хэлбэрийн алтан чимэг, түүний дор унжиж байсан мөн уул, усны долгион хээтэй, дундуураа тасруутан хос маягтай гонзгой чимэг эдгээр бүгд 31 ширхэг бүхий том жижиг, алтан чимэглэлээс уул бүс бүрдэж байжээ...

Бүх алтан чимгүүдийн дотроос хамгийн их хэмжээний материал оруулсан нь 49,0737 грамм буюу дэнсний хэмжээгээр 1 лан 15,0737 цэн... хамгийн бага хэмжээний алт орсон гэж үзэхэд бараг бүх товруу адил шахам 0,6361-0,77664 грам..." гэжээ.
14. Марко Поло. Орчлонгийн элдэв сонин. /Аяны тэмдэглэл/. УХГ, УБ., 1987, 102, 103, 105-р тал
15. Д.Дашдорж. Монголчуудын гэрлэх хуримын шүлэглэн харилцах ёсон. Аман зохиол судлал. Studia Folclorica, Tom XY. Fasc 1-9, ШУАХ, УБ., 1986, 137-р тал
16. а. Эсгий туургат гэрийнхээ хэв төрхийг малгайдаа өвлөн тусгаж "төгөрцөг" буюу бидний хэлж заншсанаар тоорцог малгайг хийхдээ эрт цагийн "бүрх-гэр"-ийг бодолцсон байдаг. "Бүрх гэр" гэдэг нь утаа, очоос гадна гэрийн доторхи элдэв муу агаар гаргах "галаас" /тооно/ хэмээх дээш өндөрлөсөн хүзүүтэй байжээ. Галын дөл, оч, утас тэнгэр өөд тэмүүлэн одох нь айл гэр, малгайн эзний сүлд хийморь галын дөл шиг байхыг бэлгэднэ." /М.Амгалан. Малгай "Үнэн" сонин. 1990.12.21, № 288/
б. "Монгол малгайн бөмбөгөр оройг сүмбэр уулыг дүрсэлсэн гэх түүний тойрсон гучин хоёр ширээсийг сүмбэр уулыг бүчин суусан 32 хөх монгол хэмээгээд 32 хөх монголыг гийгүүлж буй улаан нарны туяа сацрах байгааг нь оройгоос унжсан улаан залаа гэж тайлбарлана..." /Kh.Nimbuu. Mongγol qubcasun-u teüke. "öbür mongγol-un neyigem-ün sinjilekü uqaγan/, 1995,№ 74, 108 duγar tal-a
в. "Буриад монгол овог холбоогоо хүндэтгэж түүнийг дурсан тэмдэглэхдээ малгайн тавгаар нарыг төлөөлүүлж, улаан залаагаар нарны сацрагыг төлөөлүүлнэ. Хори буриадын малгайд арван нэг буюу арван гурван хөндлөн оёостой, тэр нь арван нэгэн эцгийн буюу арван гурван эцгийн овгийг төлөөлүүлнэ гэж үзнэ. Агаг /Агийн/ буриад малгайд найман хөндлөн оёос байдгийг найман эцгийн овгийг төлөөлүүлсэн гэж үзнэ. Зарим малгайд гучин хоёр хөндлөн оёос байдаг, тэр нь хорь хоридай буриадын ах дүү угсаа гучин хоёр эцгийн овгийг төлөөлүүлсэн гэдэг. Ийм учраас буриад монголчууд малгайн хөндлөн оёосыг зөрүү оёхыг цээрлэнэ.
Mongγol qubcasu jasal. öbür mongγol-un sinjilekü uqaγan-teknig (?) mergejil-ün keblel-un qoriy-a. 1991, 73 duγar tal-a
17. Х.Нямбуу, Ц.Нацагдорж. Монголчуудын цээрлэх ёсны хураангуй толь. УБ., 1993, 30-р тал
18. S.Sampilnorbu. Mongγol malaγai ba mongγol soyul. "Mongγol kele utγ–a jokiyal", 1994, № 4, 103-104-düger tal-a
19. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильом де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ., 1988, 114-р тал
20. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильом

де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ., 1988, 114-р тал
21. Л.Сономцэрэн. Монголын эртний соёл урлаг, УХГ. УБ., 1989, 25-р тал
22. БНМАУ-ын угсаатны зүй. I боть. Халхын угсаатны зүй /XIX-XX зууны заг үе/. Ред. С.Бадамхатан. УБ., 1987, 265-р тал
23. Г.Батнасан. Монгол ардын хувцас. МЭДН. УХГ, УБ., 1989, 35-р тал
24. Mongγol qubcasu jasal. öbur mongγol-un sinjilekü uqaγan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a, 1991, 115 duγar tal-a
25. Mongγol qubcasu jasal. öbür mongγol-un sinjilekü uqaγan tekniq (?) mergejil-ün keblel-ün qoriy-a, 1991, 71, 74 düger tal-a
26. Ordos jang üyile-yin tobci. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. Khayilar, 1992, 283 duγar tal-a
27. Mongγol qubcasu jasal. öbür mongγol-un sinjilekü uqaγan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a, 1991,
28. БНМАУ-ын угсаатны зүй. I боть. Халхын угсаатны зүй. /XIX-XX зууны заг үе/. Ред. С.Бадамхатан. УБ., 1987, 265-р тал
29. Г.Батнасан. Монгол ардын хувцас. МЭДН. УХГ, УБ., 1989, 35-р тал
30. Mongγol qubcasu jasal. öbür mongγol-un sinjilekü uqaγan teknig mergejil-ün keblel-ün qoriy-a, 1991, 95 duγar tal-a
31. Х.Лувсанбалдан, Ц.Шагдарсүрэн. Монголчуудын үсэг бичиг, үг хэллэгийн түүх гарлаас. БНМАУ-ын Ардын Боловсролын Яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар. УБ., 1986, 43-р тал
32. Монгол ардын баатарлаг тууль. Эмхтгэж хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо. УХГ. УБ.1982 77-78-р тал
33. Халх ардын тууль.Эмхтгэгч Р.Нарантуяа УХГ. УБ.1991 40,41,42,47,48-р тал
34. Эл домгийг Монгол улсын Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошуу, эдүгээ Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын харъяат, 80 настай (1878 онд төрсөн) Жамбалын Өлзий-Очироос 1958 онд Д.Цэдэв тэмдэглэн авчээ.

УРАН ҮГИЙН ДҮРИЙН БЭЛГЭДЭЛ

Байгаль, нийгэм, сэтгэхүйн алив үзэгдлийг таних, мэдрэх уран сайхны нэгэн түлхүүр нь уран үгийн дүр юм. Уран үгийн дүр нь мэдээжээр дүрслэн бодохуйн үр шим болон тодрох боловч тэмдэглэхүүн тэмдэглэгдэхүүний харилцан шүтэлцээг тусгалцах нарийн төвөгтэй үйл явц, тогтолцоо юм.Уран үгийн дүр, түүнтэй жишиж харьцуулсны үндсэнд нээгдэх гоо зүйн нэгэн ай нь бэлгэдэл болно.Тэгэхлээр уран үгийн дүр /дүрс/ бэлгэдэл хоёрын харилцаа шүтэлцээ ямар төвшинд байх вэ? гэдэг асуулт зүй ёсоор анхаарал татна.Үүнд С.С.Аверинцевын "дүр дүрс бэлгэдэлд хувилан байж гэмээнэ нэвт саруулшина", "учир нь дүр дүрсийн дундуур чанадасын утга гэрэлтэнэ"[1] гэсэн утгатай дүгнэлт хариу болно. Энэ нь уран үгийн дүр болгонд бэлгэдэл тусгагдаж, бэлгэдэл бүхэнд уран үгийн дүр /дүрслэл/ оршино гэсэн үг юм.

Уран үгийн дүрийн агуулгын гүнийг нээх, хэлбэр хийцийн баялаг өргөнийг тодруулах нэгэн эд эс нь мэдээж уран яруу дүрслэхүйн зүйрлэсэн, утга шилжүүлсэн далдалсан зүйрлэл, төлөөлөл, ёгтлол тэргүүтэн болсныг, түүндээ бэлгэдлийн агуулга шингээснийг "Монголын нууц товчоо"-ны олон зүйл хэсэг харуулж байна.Энэ бол оочин цоочин тасрах тохиолдлын бус тухайн үеийн уран сайхны сэтгэлгээнд түгээмэл байсан үзэгдлийн илрэл юм.Үүний тодорхой жишээ нь Рашид-ад-дин "Тухайн үед тэд /Монголчууд Д.Ц./ ойлгоход бэрхтэй толгой холбосон хүүрнэл үг, оньсого таавар мэтээр ярилцах заншилтай болгов. Тэдний элчээр хэлүүлсэн хэл нь чухам тийм төрлийн яриа байлаа"[2] гэж "Судрын чуулган"-даа бичсэн нь болно.Чухам ийм онцлог шинж нь нэгэн өгүүлэмж, нэгэн дүр, нэгэн дүрслэлд яаж тодорсныг "Монголын нууц товчоо"-ны доор дурдсан жишээнд тулгуурлан авч үзье.

§ 255 ...ögödei ügülerün qahan ece soyurqaju ügüle ke'ekde'esü ya'uban ügülegü bi ülü cidaqu ke'en ker ügülegü cidaqui-bar qata'ucisuqaigü ke'emü-je mona qoyina maqa uruqtur minu öleng-tür quci'asu hüker-e ülü idekdegü e'ükün-tür qцci'asu noqai-a ülü idekdegü töre'esü qandaqai ketüs quluqana cöles aldaqu-yu'u edüiyü'en-je ke'emü busu ya'u ügülegü bi ke'eba




ene üge-tür cinggis-qahan larliq bolurun ögödei eyimün üges ügülegü bö'esü bolu-je ke'eba...

Эл хэсгээс үзэхэд Өгөдэйн хэлсэн үгэнд Чингис хаан сэтгэл ханамжтай байгаа нь илт байна.Хаан эцгийнхээ соёрхсоны хариуд өгүүлсэний дотор "Өлөн дор хучиваас үхэр үл идэгдэх, өөхөн дор хучиваас нохой үл идэгдэх", "хандгай хэтүс хулгана цөлэс" хэмээсэн хоёр зүйр үг гарч байгаа юм.

Хажуугийн хятад орчуулгад "urug -tur minu öleng-tür qaci'asu hüker-e ülü idekdegü e'ükün -tür quci'asu noqai-a ülü idekdegü töreèsü qandaqai ketüs quluqana cöles aldaqu-yu'u..." гэхийг "үр хүүхэд дотор миний хөх өвс дотор баглаваас үхэр үл хазагдах өөхөн дотор баглаваас нохойд үл зуугдах төрвөөс хандгай (амьтны нэр) хөндлөн огтолж хулгана дагалдаж алдах биш үү?", ерөнхий орчуулгад "зөвхөн хойч үе-үр ач чадваргүйгээс болж үйлсийг залгамжилж чадахгүйгээс аймуй" гэсэн утгыг гаргажээ.

Эхний зүйр үг манай тооллын III зуунд бичигдсэн "Бө үжи" хэмээх хятад номд хүн жирэмслэж өндөг төрүүлэхүйеэ өлзий бус гэж үзэж хаясныг нохой туслаж эхэд нь буцаан өгөхөд тэрхүү өндөг хүн болсон тухай, V зууны эхэнд бичигдсэн "Хойт Хан улсын бичиг, дорнод харийн намтрууд"-д аянд мордсоных нь хойно тахианы

өндөгний чинээ хий үзэгдэж биед бууснаас жирэмсэлсэн зарцаа ван гянданд хориход түүнээс нь хүү төрсөн тухай, 554 онд бичигдэж дууссан хятадын "Вэй улсын бичиг"-т Дү мингийн эх туяанаас жирэмслэж өндөг төрүүлснийг ван нохойд өгч нохой идэх үгүй, гахайд өгч гахай идэх үгүй. Зам дээр хаяулаад үхэр, морь зайллаа" гэж дурдсан тухай Дү мингийн домогтой судлагч Төгсбаяр холбож улмаар түүний гарал үүслийнх нь загварыг



хэмээн гаргажээ.[3] Үүгээр үзвэл хятадын эртний сурвалж бичигт тэмдэглэгдсэн Дү мингийн домог нь угтаа Алтай язгуурын домгийн гаралтай, хожим хойчдоо монгол домгоор дамжин "Монголын нууц товчоо"-нд үлдсэн гэсэн ойлголт төрүүлж байна.

Эл холбооны ямархан үндэслэлтэйг хойчийн нягтлалд үлдээн ямар ч болов "Монголын нууц товчоо"-ны үеэс эхний зүйр үг олон зууныг дамжиж өнөөдрийн бидэнтэй золгохдоо "Өвсөнд ороовч /хучивч/ үхэр идэхгүй, өөхөнд ороовч /хучивч/ нохой шиншлэхгүй /идэхгүй/[4]." Өөхөөр ороовол нохой идэх, өвсөөр ороовол үхэр /мал/ идэх"[5] гэхчлэн хувилбартай байгаагаас үзэхэд утгын хийгээд хэлбэрийн өөрчлөлт төдий л орсонгүй хэмээж болно.Хоёр дахь зүйрлэсэн үгийн хувьд "хананд харваад оготно онох"[6] мэтчилэн ойролцоо хэллэг өнөөгийн үгсийн санд үлдсэн ч "Монголын нууц товчоо"-нд гарсан утга нь тайлбар шаардахуйц байгаа юм.

А.С.Козин "... Не выйдет ли тогда дело по-пословице: "Лося-сохатого пропустил, а за мышью догнался"[7] /Бүдүүн хандгайг өнгөрөөчихөөд хулганын хойноос хөөцөлдөв" гэж зүйр үгэнд гардаг шиг тийм юм болчих юм биш бизээ гэсэн утгатай/,

Ф.В.Кливез " ...will they [not] miss an elk [which appeareth] breadthwise [as well as] a rat which appeareth] lengthwise?..."[8] (Хандгай /гэгдэж байгаа/-г томын /бүдүүний/ хувьд алдахын /адил/ хулгана /гэгдэж байгаа/-ыг бяцханы хувьд ч алдахгүй /үгүй/ юм биш үү? гэсэн утгатай), Элдэнтэй,,, Ардаажав "§ 255 дор ан гөрөөсний мөрийг анчин мөрдөх үе дор мөрөөр нь аяыг дагаж явахыг заан өгүүлжүхүй"[9], Д.Цэрэнсодном "хандгай хэтэргэж /өнгөрөөж/ хулгана цүлэж алдана гэсэн утгатай аж"[10] хэмээн тус тус орчуулж тайлбарлажээ. Эдгээрээс уг зүйр үгийн утга санааг тодосгох, ухаарах бололцоо нээгдэж байна. Эдгээр хоёр зүйр үгийг багцлан ойлгоход хүний аж төрөлд сургамж сэрэмж болгох үүднээс нийгэм олны туршлагыг зүйрлэн жиших аргаар нэгтгэн дүгнэж цөөн үгэнд гүн агаад өргөн утга шингээсэн нь эргэлзээгүй байна. Зүйр үг тус бүрийн агуулга, түүнийг илэрхийлсэн хэлбэр хийц нь үнэнийг уран дүрийн аргаар тодруулж чадсан байна. Үүнд эхний зүйр үг, "гологдол"-ыг үхэрт идүүлэх гэхдээ өлөн /өвс/-д хучсан, нохойд өгөх гэхдээ өөхөнд бүрсэн гэсэнд нь уг амьтадын амин тэжээлтэй холбож жам ёсны дагуу болгосонд түүний үнэмшүүлэх чадал оршиж байна. Ямар нэгийг өлөн /өвс/ хэмээн үхэр, ямар нэгийг өөх хэмээн нохой идэх /идүүлэх/ гэж завдаж байгаа боловч тэр нь дүрсээр ч юм уу үнэрээр ч юмуу мэдэгдэж гологдож байгаа тодорч байна. Үхрээр ч юм уу нохойгоор ч юм уу аль нэгнээр нь бус хоёулангаар нь уг үйлд давтаж өгүүлсний учир нь, хэн нэгэнд бус хэнд ч /юунд ч/ тоогдохгүй гэсэн утга санааг уран дүр илтгэж байгаа юм. Хоёрдахь зүйр үгэнд хандгайг мөрдөх гэж байгаад амжилгүй хулганатай хөөцөлдөж байгаа бүтэл муутай анчины дүр зураг тодорч байна.


Гэтэл энэ хоёр зүйр үг тус тусдаа бие дааж орсонгүйд, "töre'esü" хэмээх үгээр холбогдож нэгэн утгыг илэрхийлэх болсонд гол учир оршино. Энэ үүднээс авч үзэхэд эхний зүйр үгэнд "quci'asu" хэмээх үг хоёронтаа давтагдахдаа нуух далдлах гэсэн утгыг илтгэж "юуг?" /хэнийг/ гэсэн асуултыг нэхэх болно. "öleng-tür", "e'ükün-tür" хучаад ч тоогддоггүй (nüker-e ülü idekdegü, noqai-a ülü idekdegü) тэр юм нь юу вэ? Дээр өгүүлснээр бол Өгөдэйн хувьд "mona qoyina

maqa uruq-tur minu" /миний хойно магад ураг дор минь/ хамааралтай болой. Тэгэхлээр хожим хойчийн ураг удмын дотор яаж өнгөлж даллаж додомдлоо ч хэнд ч юунд ч үл тоогдох нь /хүн ч юм уу муу үйл ч юм уу/ төрвөл яанаа гэж Өгөдэйн сэтгэлийн эмзэглэл юм. Тийм нь төрөх аваас "qandaqai ketüs quluqana cöles aldaqu-yu'u edüi-yüen-eje" гэсэн болгоомжлолын үргэлжлэл юм. Энэ нь санаа их байвч сачий хүрэхгүй юм уу ихийг /томыг/ сэдээд өчүүхэнийг /жижгийг/ үйлдэх вий гэсэн эргэлзлэл юм. Тодруулбал, дээрхи хослол зүйрлэлийн утга нь хаан аваас улс монголоо уламжилж аваад төр барихдаа хойчдоо дордуулж доройтуулах вий гэсэн Өгөдэйн айдас болгоомжлол билээ. Үүнийг ил мэт атлаа далд, далд атлаа ил мэт, дан мэт атлаа давхар, давхар атлаа дан мэт утгын сүлжээ, уран зүйрлэлийн холбоогоор илэрхийлжээ.

2

"Монголын нууц товчоо"-нд гарсан зарим уран дүр, дүрслэлийг тодосгон эс тайлбарлаваас тэдгээрийн гүн утга, уламжлалт бэлгэдэлт чанар тэр бүр үл танигдана.

§ 199... dawu bari'ulurun toqto'a-yin qudu qal cila'un teri'üten



kö'üt inu odun oqjatcu qarin qarbucaju uqurqatu qulan sumutu buqu bolju otba teden-i ji'ürtü bolju niscu tenggeri-tür qaru'asu ci sübe'etei singqor bolju niscu ülü'ü bari'ujiyi tarbaqan bolju kimusu'ar-iyan maltaju qajar-tur oro'asu calir bolju cokiju erijü ülü'ü güyicegü ci jiqasun bolju tenggis dalai-tur oro'asu ci sübe'etei gölmi qubci'ur bolju si'üjü qubciju ül'ü'ü abqu ci ..."

Чингис хаанаас Мэргэдийн Тогтоагийн хөвгүүдийг ямар арга мэх ид шид хэрэглэсэн ч заавал барьж ир гэсэн утга бүхий ийм зарлигийг Сүбээдэйд өгсөн ажээ. Зарлигийн дотор "жигүүртэн болон нисч тэнгэрт гаравч шонхор болж хөөх, тарвага болон хумсаараа малтаж газар оровч цалир /царил/ болж цохих, загас болон тэнгис далайд оровч гувчуур болж нэхэх" хувилахуйн уран сэтгэлэг дүрслэл тод харагдаж байна.

Ийм дүрслэх уран чадварын "хувилдаг" шинжийг монгол ардын аман зохиол, түүний дотор үлгэр, туульс илүүтэй хадгалж иржээ.

Хэнээс /юунаас/ хэнд? юунд? хувилж байгааг хурц тод илэрхийлсэн ийм уран сэтгэмж бас сав, шимийн ертөнц, түүний харилцааны тухай анчин, нүүдэлчдийн элэр балар үеийн ойлголт, түүнтэй холбоотойгоор хожим үүссэн бөө мөргөлийн "онгодын хувилгаан" мэтстэй холбоотой гэж үзэж болмоор ажээ. Тэрхүү ойлголтоор бол орчлонгийн алив бүхэн цаанаа эзэнтэй, түүний урьдаар өөр биед /эд юмсад/ хувилж харагддаг буюу ямар нэгэн хүн, эсвэл ид шидтэн үхвэл сүнс нь амьд, тэр ч атугай онгон болж хувирч үлддэг болой. Тийм ойлголтыг монгол ардын баатарлаг туульс ямар нэгэн хэмжээгээр тусгасан байдаг гэж болно.

"Ерэнсэй" гэдэг баатарлаг туульд /§ 6655-6685/ Ерэнсэй өвгөний Ханхан Согто хөвгүүн мянга найман толгойтой мангас /Митуурайн шар мангад ахай/-тай тэмцэлдэхдээ түүний арван гурван бүдүнэ шувуунд хувилгаад алт-мөнгөн хайрцагт хийсэн сүнсээс арвыг нь барин авч гурвыг нь зугтаалгажээ. Ханхан Согто хөвгүүн харцага болон хөөж хоёрыг нь барив. Үлдсэн нэг нь улаан

будаа тариа болоход Ханхан Согто есөн тахиа болон түүжээ. Тэгэхэд нь сүнс гурван улаан гөрөөс болон зугтаахад Хонхон Согто гурван өлөн чоно болон нэхэж хоёрыг нь барив...

6680 hүнхэн шара далайдаала
Шахалдажа ерэлсэбэ.
Шара бүрүн далайдала
Ираахай загаһан боложо
Атхаража унабадаа.
6685. Мэтэр гэсэн бэеэрээ:
Юһүн сурхай болоболдаа,
Эндэ тэндэһээн орожо,
Эблүүлхэжэ зальяба [11]

Туульсын баатарын иймэрхүү төстэй "хувилал" нь "Зул алдар хаан" /Дөрөвдүгээр бүлэг. XY, XYI/[12], "Бум Эрдэнэ" зэрэг туульд ч бас өргөн дүрслэгддэг юм.

"Бум эрдэнэ" туульд
"... Мангас эмгэнийг
Алаад ирэхийн үед
Аливан /догшин Д.Ц/ цагаан
Загас болоход
Балчир Бум эрдэнэ
Хул эрээн
Загас болон хөөцөлдөөд...
Бор эрээн
Болжмор болоод
Жиргэн жиргээд
Ирэхийн үед
Балчир Бум эрдэнэ
Хүрэн эрээн
Харцага болж хөөгөөд...
Дунд замбатэвийн
Тарвага болоход
Балчир Бум эрдэнэ

Аман хүзүүгий нь
Тас цохиод алав гэлээ..." [13] хэмээн өгүүлжээ.

Ингэж хувилах шид монгол ардын баатарлагийн туульсын гол баатруудад төдийгүй тэдгээрийн итгэлт сайн хань хүлэг морьд бас эзэндээ үг зааж өгдөг, аюулаас гарах аргыг сүвэгчилдэг, цөм хүний хэлээр ярьдаг. Нэгэн ёсондоо хүлэг морьд хүн шиг, хүнээс ч илүү ухаантай /аргатай/ самбаатай болж гардаг юм.

Тиймээс монгол ардын баатарлаг туульсын хүлэг морьдыг адгуус амьтны төдийгөөр ухаарч үл болно. "Аргил цагаан өвгөн" хэмээх монгол ардын баатарлаг туульд Төмөр хаан нь Алтан шат, Хар хавчил хоёр баатартай тулалдаж дийлээд буцах замдаа "эцэнхий зээрд үрээ"-тэй таарч ид шидтэйг нь шинжиж мэдээд, түүнийг аваачиж чөдөрлөн гурван давхар байшинд цоожилжээ. Гэтэл зээрд үрээ хувилан очиж хожим Төмөр хааны охины зүүдэнд орсон учир /зүүд өгсөн/ "би тэр морийг жимс түүхээр явахдаа уһая" хэмээн охин нь хаан эцгээсээ гуйжээ. Охины хүсэлт биелэхэд шидэт морь түүнийг авч хурдлан нутагтаа ирэхэд Алтан хөвч нэрт эзэн нь алга байв. Тиймд өвгөн эмгэн хоёрт охиныг харгалзуулан үлдээгээд эзнээ олж ирэхээр явахдаа хааны охинд хандаж гунан зээрд морь ийм үг хэлсэн ажээ.

Илбэтэй хүүхэн
Илбээн гаргаж
Шидтэй хүүхэн
Шидээ гаргаж
Тас болоод нисээд гарлаа ч
Би чамайг олно.
Тарвага болоод
Газарт орлоо ч

Би чамайг олнов! гээд...[14] гэсэн уран хэллэг байдаг бол "Хүдэр мөнгөн тэвнэ" туульд Хүдэр мөнгөн тэвнэ, Ган хар тэвэгийн ид шидтэй хар хээр морийг алахаар очсонд тэр хүлэг хий агаарын хүчээр

"Тас болоод

Тэнгэрт гарсан ч мэдэгдэхгүй
Тарвага болоод

Газарт орсон ч мэдэгдэхгүй" алга болжээ. Хар хээр морь эзнийхээ багшийн зүг жаварт хувилаад явсан байхад Хүдэр мөнгөн тэвнэ хойноос нь жаварт хувилан хөөжээ. Хар хээр морь найман гахайн мэгжид хувилаад зугтахад Хүдэр мөнгөн тэвнэ хөх чоно болон нэхжээ. Хар хээр морь найман бялзуухайд хувилаад зугдахад Хүдэр мөнгөн тэвнэ харцага болон хөөж цохижээ [15]. Дурдсан туульсын баатрууд болон хүлэг морьд нь хамгийн эгзэгтэй мөчдөө буюу хэн нэгэндээ дийлдэх, эсвэл баригдахын даваан дээр "амь тавих" шахсан үедээ л өөр бусдад хувилж байна. Тэмцэлдэгч хоёрын нэг нь тэгж хувилангуут нөгөө нь түүнээс ч хүч ихтэй буюу ихэнх тохиолдолд түүнийг хөнөөдөг зүйлд хувирч тэмцлээ үргэлжлүүлдэг байна. Ийнхүү монгол ардын баатарлагийн туульсад гардагтай утга учир ижил дүрслэл "Монголын нууц товчоо"-ны арга барилын дагууд хожмын үед бичигдсэн түүхийн сурвалж бичгүүдэд тухайлбал XYII зууны үеийн "Шар тууж"-д Чингис хаан, Тангутын Шударга хааныг хүчээр давамгайлж ялсан гэдэг санааг

Sidurγu qaγan moγai bolun qubilbai.
Ejen γarudi bolun qubilbai.
Sidurγu qaγan bars bolun qubiraqui-dur inu
Ejen arslang bolun
Sidurγu qaγan köbegün bolun qubiraquu-dur inu
Ejen qurmusta bolun qubiraju
Sidurγu qaγan-i baribai [16] гэж уран сэтгэмжтэйгээр дүрслэн бичсэн бий билээ.

Дээр дурдсан монгол ардын баатарлаг туульс болон "Монголын нууц товчоо"-ны доторхи ийм нэгэн "хувилах" уран сэтгэмжийн учир утга, уялдаа холбоо нь тун нарийн ажээ. Тодруулбал: нэг нь хувилан бий болсны /жигүүртэн, болжмор, бялзуухай, тарвага, загас, мэгж, согоо, тариа/ үндсэнд нөгөө нь үүдэн бий болох /шонхор, харцага, царил, гувчуур, чоно, тахиа/

зэргээр биесээ нэхэж хөөх амьдралын жам зүйтэй нь уялдаа бүхий гүн санааг агуулжээ. Гүн ухааны шалтгаан, үр дагаврын үрийг хадгалсан уттын сүлжээ бүхий ийм уран сэтгэлэг нь нүүдэлчдийн ахуй амьдралын уран сэтгэлгээний тусгал болж монгол түмний дунд үе дамжин байсан эртний ойлголтын ул мөр гэж үзэж болмоор байна. "Монголын нууц товчоо"-ны доторхи дээр өгүүлсэн дүрслэлээс Тогтоагийн хөвгүүд /Худу, Гал, Чулуун нар/ тэнгэрт нислээ ч, газарт шургалаа ч, усанд орлоо ч гэсэн амьд мэнд гарч чадах зам мөргүй болго гэснийг амьдралын жам зүйгээр нэг нь нөгөөгөө хөнөөдөг амьтнаар төлөөлүүлэн зүйрлэж өгүүлжээ. Энд тарвага болон хумсаараа малтаж газар оровч цалир /царил/ болж цохих тухайд хэдийгээр эд өлгийн нэр гарч байгаа ч түүнийг барьж цохих хүний /эзний/ төлөөлөл гэж үзвэл зохино.


Тиймээс энд дурдагдаж байгаа амьтад тухайлбал тэнгэрийн төлөөлөл жигүүртэн шонхор, газрын төлөөлөл тарвага, хүн /ца-рил/, усны төлөөлөл загас гувчуур болж бэлгэдлийн шинжийг агуулсан байна.

Энэ бол бэлгэдэл хэдийгээр уран яруу дүрслэлийн хэрэглүүрээс илүү өргөн агуулга утгыг илэрхийлдэг ч гэлээ чухамхүү түүний уран сайхны олон талт бүтцэд ёгтлол, зүйрлэл, төлөөллийн ямархан үүрэгтэй гэдгийг тодорхойлж байна. Үүнтэй холбогдуулан "Монголын нууц товчоо"-ны дээр иш татсан "tarbaqan bolju kimusu'ar-iyan maltaju qajar-tur oro'asu..." гэсэн хэллэгтэй ямар нэгэн шижмээр уялдаатай гэж болмоор жишээг үргэлжлүүлэн авч тодруулъя.

§ 254 дүгээр зүйлд Чингис хааныг сартаул /sarta'ul/ иргэнтэй байлдахаар мордоход Есүй /yisui/ хатан "төрсөн дөрвөн хүүгээс чинь хэн төр барих юм бэ?" асуужээ. Тэгэхэд Чингис хаан "Есүйн хэлсэн үг зөвөөс зөв... Үхэл надаас тойрох мэт үнэхээр түүнийг санасангүй" гээд "Хөвгүүдийн ах Зүчи мөн. Чи юу хэлнэ" гэхэд Цагадай түүнийг эсэргүүцжээ. Тэгэхлээр Зүчи босоод Цагадайн энгэрээс шүүрэн авч ийн өгүүлжээ:

§ 254 ... qan ecige-de busu ese ke'ekdelü'e ci namayi ker ilqamui

yambar erdem-iyer hüle'ü ci qaqca kecewü-ber-iyen maqa hüle'ü ele ci hontucaju cimada qarda'asu heregei-yen hoqtolju o'orsuqai..." Энэ жишээ бол монгол ардын баатарлаг туульд, түүнтэй уламжлалын холбоо бүхий бичгийн уран зохиолд ч, тухайлбал домог үлгэрийн үүсэлтэй уялдаатай ойлголтыг тусгасан уран хэллэг цөөнгүй байдгийн бас нэгэн баримт мөн.



Эл жишээгээр ул мөрийг тодотгохын үүднээс Төв Азийн нүүдэлчдийн дунд нэн ялангуяа монгол туургатны дотор өргөн дэлгэрсэн "Эрхий мэргэн" [17] домог-үлгэрийн утгыг авч үзье.

Эрт цагт энэ дэлхийд долоон нар гараад, ган гачиг болоход тэр нутагт Эрхий мэргэн гэдэг харснаа харвадаг, харваснаа онодог мэргэн харваач байжээ. Олны гуйхаар "Долоон нарыг би нэг нэг харваад онохгүй бол эрхий хуруугаа огтлоод, эр хүнээ байгаад, хар ус уухгүй хагд өвс идэхгүй амьтан тарвага болоод харанхуй нүхэнд амьдарна" гэж андгай тавьжээ.

Зургаан сумаар зургаан нарыг устгаад долоо дахийг харвахаар шагайж шинжиж байтал нь хараацай шувуу хоорондуур нь орон халхалж сүүлээ сэт харвуулж хоёр салаа болгуулчихжээ. Харин өнөөх сүүлчийн нар харваачаас айгаад баруун уулын цаагуур далд орчихож гэнэ. Эрхий мэргэн хараацайг садаа боллоо гэж алаг мориороо хөөгөөд гүйцэхийн даваан дээр хараацай шувуу булт үсрэн зугтаасаар үүрийн харуй бүрий хүргэчихэж гэнэ.

Эрхий мэргэн өөрөө эр хүний ам тангаргийн ёсоороо эрхий хуруугаа огтолж хаяад, эр хүнээ байгаад, хар ус уудаггүй, хагд өвс иддэггүй тарвага болоод харанхуй нүхэнд амьдардаг болсон гэнэ. Тарваганы хөлийн сарвуу дөрөв байдаг нь үүнээс болсон гэнэ.

Ам тангаргаа өгч нум сум харваад алдах юм бол эрхий

хуруугаа огтолж хаядаг эртний хатуухан зан үйлийг тусгасан "эрхий мэргэн" домог-үлгэрийн гол санаа нь ган гачигт өртдөг нүүдэлчдийн амьдрал ахуйгаас үндэслэсэн уран сэтгэлгээ мөн гэдэг нь ил байна.

"Хан Харангуй" туульд Хан Харангуйд Наран Саран Тулай бөх тулалдаж ялагдах үестээ
"Иймд би эр бярдаа найдаж
Эрийн дор орох юм бол
Эрхий хуруунаасаа аваад
Амь биеэ ална гэж

Андгай тангараг өргөсөн юм"[18] гэж хэлдэг бол "Даньхүрэл" туульд дөрвөн чонотой таарсан Даньхүрэл:


"Чамайг есөн хар далайд хүргэлгүй
Эс алдаг болох нь
Эгэм далаа тайраад
Эрхий хуруугаа

Таслаад хоцорно"[19] гэж андгайлдаг ажээ. Эртний нүүдэлчин хүмүүсийн ан гөрөө хийх, атаатан дайсантай тулалдахад гол зэвсэг нь нум сум байсан нь мэдээж. Нум сум харвагч хүний эрдэм чадал нь "эрхий хуруундаа" байдаг гэж монголчууд үзэж байснаас үйл хэргээ заавал бүтээхүйн баталгаагаа эрхий хуруугаар дэнчин тавьж байжээ гэж үзэж болмоор ажээ. Тийм андгай тавьсан хэллэг "Монголын нууц товчоо"-ны дээрх дүрслэл /§254/-тэй амин холбоотойн гэрч мөн.

Ялангуяа "домог-үлгэрийн Эрхий мэргэний андгай, XIII зууны түүхэн хүн Зүчийн бардаж эрдэж ам гарсан үгтэй их төстэй"[20] байгаа нь "heregei-yen hoqtolju o'orsuqai" гэсэн хэллэг домог-үлгэрийн сангаас үлдэж хоцорсон уттын ханд мөний учир билээ.

Дээр өгүүлсэн хоёр жишээнээс үзэхэд "Монголын нууц товчоо" нь монгол ардын аман зохиол, түүний уран сэтгэлгээний дүр, дүрслэлтэй олон шижмийн холбоотойг илтгэхийн хамт битүүлэг агаад нууцлаг утга учрыг улируулан хадгалсаар ирсний гэрч болой.

§ 118. temüjin jamuqa qoyar amaraldurun niken hon nökö'e hon-u jarim amaralduju tere aqsan nuntuq-aca niken üdür newüye ke'eldüjü newürün jun-nu teri'ün sara-yin harban jirqo'an-a hula'an tergel üdür newüba temüjin jamuqa qoyar qamtu terged-ün urida yabuju ayisurun jamuqa ügülerün temüjin anda anda a'ula siqan bawuya adu'ucin bidan-u alacuq-a gür=tügei qol-tur siqan bawuya qoni(n)cit quriqacit bidan-u qo'olai-a gürtügei ke'eba temüjin jamuqa-yin ene üge-yi uqan yadaju






sem-iyer bayiju qocorcu[ne]'üri dumda terget gülicejü ne'üri bö'et temujin hö'elün-eke-de jamuqa anda ügülemü a'ula-tur siqan bawuya adu'ucin bidan-u alacuq-a gürtügei qol-tur siqan bawuya qoni(n)cit quriqacit bidan-u qo'olai-a gürtügei ke'en ügülemü bi ene üge inu uqan yadaju qari'u inu ya'u ba ese ügüleba bi eke-dece asaqsu ke'en ireba bi ke'eba hö'elün-eke-yi dongqodu'a üdü'üi-e börte-üjin ügülerün jamuqa anda uyidangqa ke'ekden büle'e edö'e bidan-aca uyitqu caq bolba tuqar-un jamuqa anda-yin keleleksen kelen bida-tur bö'et jesigü üge buyu bida bu bawuya ene gödölükse'er sili'ui-a qaqacan söni dülin gödölüya bö'et ke'eba...

Энэ хэсгийн доторхи "a'ula siqan bawuya adu'ucin bidan-u alacuq-a gür=tügei qol-tur siqan bawuya qoni(n)cit quriqacit bidan-u qo'olai-a gürtügei" хэмээснийг хажуугийн хятад орчуулгад "Уул шахан бууяа, адуучин бидний эсгий гэрт хүртүгэй. Гол дор шахан бууяа, хоньчдын хургачид бидний хоолой дор хүртүгэй", ерөнхий орчуулгад "Бид одоо уул шахан бууяа. Адуучин эсгий гэр олж суунаа. Гол шахан бууяа. Хоньчин хургачны хоолой дор залгих юм олдтугай" гэсэн утгыг гаргажээ. Энэ үгсийг хэн хэн яаж хүлээж авав?

Энэ хэсгээс Жамухагийн өгүүлснийг Тэмүжин ухаж ядсан, түүнийгээ Өэлүн эхээс асууж, хариу сонсож амжаагүй байтал Бөртө-үжин дэргэдээс шуудхан тайлбарлаж байгаа нь илт харагдаж байна. "jamuqa anda uyidangqa ke'ekden büle'e edö'e bida-aca uyitqu caq bolba tuqar-un jamuqa anda-yin keleleksen kelen bida-tur bö'et jesigü üge buyu" гэсэн Бөртө-үжиний тайлбарыг Тэмүжин зөвшөөн үзсэн нь, зам зуур буулгүй шөнө дөл явж гурвантаа анд бололцсон Жамухагаас холдож байгаагаар тодорхойлогдож байна. Жамуха ч гэсэн дээрхи үгийг зориуд санаатайгаар хэлсэн нь Тэмүжиний салж нүүхэд нэхэл дагал болсонгүйгээр давхар илэрч байна.

[Энэ бол нүүдэлчин малчин ардын дуу... Жамуха чухам юу гэж энэ дууны үгийг хэлсэн гэдгийг хоёр талаар бүр таамаглаж болно. Нэг бол Жамуха малчин ардын энэ дуугаар үнэхээр "Уул

шахан бууяа, гол дор шахан бууяа" гэсэн санаагаа мэдэгдсэн төдий л өөр санаа үгүй магад. Нэг бол үнэхээр хонь адуу шиг хувь хувьдаа явах гэсэн далд санаагаа энэ дуугаар Тэмүжинд мэдүүлсэн байж мэднэ. Жамухад ийм авьяас билиг байдаг...] [21] гэж Булаг бичсэн нь бий. Дурдсан хэллэг дуу байж ч, үгүй байж ч болно. Учир нь тодорхой баталгаа үгүй. Дуу байлаа гэхэд Жамухагийн сэтгэл санааг бүрэн илэрхийлсэн болой. Дуу биш байлаа гэхэд Жамуха өөрийн сэтгэгдэлийг товч тод урнаар илэрхийлж чаджээ. Ямар ч байлаа гэсэн сонссон бүхэн ухан ядаж хэрдхийн сочиж эмзэглэж байгааг бодоход ардын дуу гэхэд эргэлзээтэй мэт.



Тэмүжин, Жамуха хоёрын зам салж байгаа төдийгүй тэдгээрийн харьяаны олон овог аймаг хоёр хуваагдсанд уул үгийн утга учир далд атлаа хичнээн хүчтэйг харуулж байна. Энэхүү санааг Жамуха хожим "qaljirqu-da qatqu=qdaju qaqasan baraju qadaqatu üges ügüleldüle'e... arbin emegetü büle'e bi and-aca alus-i setkigü bolun alji'as boldaba bi..." /§ 201/ гэж хажуугийн хүний хатгах үг, арвин /үгт/ эмээс /эмэгэтү/ болсон хэмээн гэмшин өгүүлсэн нь бүр ч тодорхой болгож байгаа билээ.

Үүнийг В. Инжаннаши "Хөх сударʺтаа:

"Авралт эзэн уур үл төрмү. Ашид хол алгуур хүлээвээс мэдмүй. Уулыг хашиж бууяа би. Адуучин малчнаа амруулъя би. Голыг хашиж бууяа би. Гоонь биеэ тэжээеэ би хэмээсэн дор Тайзу ундуунтай тул: - Олон үг хэрэггүй, учир ёстойгоор ухамжлан явагтун хэмээн зандан /зандран/ өгүүлж, ордон цагаан гэртээ залран бууж Үжин эмээ дор /Өэлүн эхэд Д./ эдгээр учрыг мэдүүлэхүйд Бөртэгэлжин Зүсүн Сэцэн хатан сонсоод сул үг дор болон Тайзуд мэдүүлрүүн: - Горлодын Жамухагийн тэр хэдэн үг эзэн чамд уйдаж урван хагацах үг болой. Ойр байлгаж үл болох олиг голиг мэт ойртсон бүхнийг идэж учирсан хүнийг хажигч

хүн байнам. Удаан дор байж эзэн чи үзэгдэхүй,удалгүй дайсан болж ирнэм зээ хэмээсэнд Тайзу өгүүлрүүн: - Би мөн тийн сэжиглэвч ялгүй яллаж буруугүй буруутгах болвоос эр хүний явдал бус хэмээв"[22] гэж тайлан өгүүлжээ. Энэ бол зам зууpаа Мэргэдийг дайлах талаар маргаж Жамуха "Эзэн чи надад нэгэн түмэн цэрэг өг. Би Мэргэдийн зүүн гарыг булаан авч миний болгосугай" хэмээсэнд "Учир уршиг дэгдээн өшгүй өө дэгдээн хоёр улсын сайныг хутгуур болгон эвдэнэ" гэж Тайзу донгодон өгүүлсний дараа /Жамуха Тайзугийн хилэн төрөхийг үзээд яаран гарч сөгдөн/ хэлсэн үг юм. Энд Жамухагийн хэлсэн үг хэдийгээр "Монголын нууц товчоо"-ныхтой /§ 188/ ойролцоо мэт боловч ижил биш байгаа юм. Үүнд:

"Уулыг хашиж бууя би
Адуучин малчнаа амруулъя би
Голыг хашиж бууя би
Гоонь биеэ тэжээе" гэсэн утгаар зам зуурtаа салж үлдээе гэх санааг илэрхийлснээр тайлжээ.

Тэмүжин, Жамуха хоёрын салж байгаад уул үгсийн утга учир битүүлэг далд атлаа салгах чадалтайг харуулж байна. Тиймээс ч Жамухагийн үгийг эрдэмтэд зөв ухаарахын үүднээс олон янз тайлбар өгчээ. В.В.Бартольд "Адуучин гэдэг нь тал нутгийн язгууртан, зөвхөн хоолойдоо залгих юм л санаж явдаг "хоньчин хургачин" гэдэг нь эгэл иргэд. Жамуха бол Тэмүжинтэй эсэргээр эгэл иргэдийн талд зогссон аж..."гээд тайлбартаа "Уул ба голын зүйрлэлийн талаар хэлбэл Тэмүжин үнэндээ уулан хавчилд хаан ор сууснаа тунхагласан байв... Жамуха бол харин Эргүнэ голд хан өргөмжлөгдсөн юм. Олны мэдээжээр одоо ч гээд бүхий л баялаг шиг малчид зундаа цөм ууланд хол гарсан байхад хамгийн ядуу суугал /суугуул/ ард л жилийн турш голын хөвөөнд суудаг" [23] гэж өгүүлжээ.

В.В.Бартольдын энэхүү саналыг Б.Я.Владимирцов эхэн үедээ бүрэн дэмжиж байгаад сүүлдээ эргэлзэж "Одоо би өөрийн үзэлтээ нилээд өөрчлөх хэрэгтэй болов" гээд Тэмүжин, Жамуха

хоёул язгууртан бөгөөд язгууртан нарын эрх ашгийн төлөө зүтгэсэн хүмүүс. Жамухад зарим ардач чанар байсан байж болох боловч тэр угаасаа тууштай хүн биш байнга гуйвж дайвж байсан[24] гэжээ. В.В.Бартольдын саналыг дэмжигч нар тухайлбал А.Якубовский "Владимирцовыг зөв баримтлалаасаа алхам хойш ухарсан гэж[25] тэмдэглэж байв. Гэвч В.В.Бартольдтой санал нийлэхгүйгээ олон эрдэмтэн өгүүлсний дотор Ш.Нацагдорж "Тэмүжин, Жамуха нар бараг нэг жил шахам хамт байсан тул тэдгээрийн муудалцах шалтгаан тэр нэгэн өглөөний билчээрийн тухай яриа үнэндээ биш байсан нь мэдээж юм... Жамухагийн хатан, Чингисийн хатан Бөртэ хоёрын харилцаа сайн биш байсан нь дээрхи билчээрийн тухай ярианы үеэр Бөртэ, Өүлэн хатанг хэлэхээс урьсан Жамухайн тухай хэлж байснаас үзэхэд тэр хоёр эмэгтэйн харьцаа сайн биш байсан нь мэдээжээр үнэн биз. Гэвч тэр нь зөвхөн шалтаг бөгөөд чухамдаа гол нь Жамухад өөрт нь байсан нь маргаангүй юм... Жамуха бол ардач үзэлтэй ч хүн биш, Чингисийн туршуул тагнуул ч биш /Л.Гумилев "Жамуха бол үнэн хэрэг дээрээ Чингисийн тагнуул төлөөлөгч гэж үзжээ Д.Ц/ харин юуны урьд жинхэнэ феодал язгууртан байжээ. Тэр Чингисийн анд боловч түүний аюулт дайсан өрсөлдөгч нь юм"[26] гэж үзжээ.

В.В.Бартольдын саналыг Ямакуча Ошима шүүмжлээд "Түүний адуучин болон хоньчин хүмүүсийг харгалзаж явдаг нь аль эсвэл овгийнхоо олонтой үргэлж хамт амьдарч, бүх овгийн хувь заяаг төлөөлөгч ноён гэдгээ илтгэсэн хэрэг байж мэдэх юм"[27] гэсэн бол Хишигтогтох "Монголчууд 13 дугаар зуун буюу нэн эрт үеэс адуугаа уул дагуулан хонио гол дагуулан билчээдэг туршлагатай болсон нь үнэн. Гэтэл ... уул дагадаг нь баяд язгууртан, ус дагадаг нь ядуу ард гэж дүн өгөх нь их л хэлбийх дүн болох юм..." гээд " ... Жамуха Тэмүжин андаасаа уйдсан болохоор өөр итгэж түшиж болмоор анд нөхдийг эрж сонгох чухалтай болжээ.

Тэдгээр эрж сонгож байгаа анд нөхдөө уул усаар зүйрлэсэн бөгөөд өөрийгөө адуучин хоньчин хургачнаар нэг үгээр

хэлбэл малчнаар зүйрлэсэн байв. Тиймээс Жамухагийн үг Тэмүжин андаа, Тэмүжин анд! Уул шиг нөхөр олж үзьеэ. Надад гэр тэрэм мэт хамгаалал болтугай. Ус шиг нөхөр олж үзнэ. Надад умд мэт тэжээл болтугай гэж орчуулан ойлговол зохих юм"[28] гэжээ. Ш.Нацагдорж, Ямакүчи Ошима, Хишиггогтох зэрэг эрдэмтдийн эдгээр санал нь Жамухагийн үгийг тайлахад бас нэг нэгэн түлхүүр мөн. Гэвч Жамухагийн үг ганц нэгэн түлхүүрээр тайлагдах дан өргөст цоож биш бололтой юм.

Адуучинд алачуга болох уулс шахан буух, хоньчин хүргачинд хоол болох гол ус шахан буух хэмээсэнд хэргийн учир орших төдий бус Жамухагийн өгүүлсний учрыг тайлахад эрт үеэс монголчууд утга далдалсан ёгт үгээр амины хийгээд албаны харьцааг илэрхийлдэг байсан уламжлалыг эрхбиш бодолцвол зохино. Энэ уламжлал, монгол аман зохиолын оньсого, үлгэр /Цэцэн бэрийн үлгэр/ домог /Аргасун хорчийн домог/, бичгийн зохиол /Дээд мэргэдийн зохиосон олон ёгтосын мөхөс товцогийг байгуулсугай/, В.Инжаннашийн "Битүү толийг тайлах", С.Буяннэмэхийн "Асуулт хариултын шүлэг" гэх мэт/[29], хуримын зан үйл дэх бэр гуйх үг, монгол ардын баатарлаг туульс дахь гэрлэлтийн холбогдол бүхий зүйлс мэтэд ул мөрөө үлдээжээ. Тийм уламжлалын нэгэн тод жишээ нь монгол угсаатны дотор төдийгүй Төв Азийн нүүдэлч овог аймгийн дунд өргөн дэлгэрсэн "Цэцэн бэр" баатар бүхий үлгэр болой. Монгол ардын аман зохиолд уламжлагдаж ирсэн "Цэцэн гэргий /бэр/"-ийн хэлбэрийн зохиол хоёр төрлөөр ангилагддагийг Х.Хасуми ажиглаж[30], А төрөлд эр нь хүчир төвөгтэй тулгарсанд эхнэр нь арга ухаан зааж, түүнээс гаргаж, улмаар нөхрөө хаан буюу ноён суулгаж байгааг, В төрөлд эзэн хаан тэнэг хүүдээ шалгаруулан эхнэр авч өгөөд байх үедээ ан хийж яваад дайсанд баригдахдаа далд үгээр захидал илгээснийг цэцэн бэр зөв ухаарч тайлснаар аврагддагийг багтаан оруулжээ. А төрлийн үлгэр § 118-т гардагтай тун ойр төсөөтэй ч гэсэн үйл явдлын хувьд хос гэж болохоор В төрлийн үлгэрийг харьцуулахад ч бас болохгүй гэхийн газаргүй.

Түүний нэгэн хувилбарт ан гөрөө хийж яваад харийн гүрэнд баригдаж хар гэрт суусан хаан

"Цэнхэр торгон хөнжлөөр хучлага хийсэн
Ногоон торгон хөнжлөөр дэвсгэр хийсэн
Өдөр шөнөд хоёр улаан жинтүүгээр дэр хийсэн
Та нар миний нэг адил жаргахыг хүсвэл ирж болно.

Гэхдээ хэн түрүүнд ирсэн хүн

Эвэртэй малаа түрүүнд нь
Эвэргүй малаа сүүлд нь
Аваад ирэх хэрэгтэй
Эд хөрөнгө хэрэгтэй шүү
Адууны дотор бий
Хамуутай бор унага гүү хоёрыг
Орхих биз
Хамуугаа халдааж
Нэр хугалах магадгүй
Миний алт мөнгөн салаа
Зандан модыг нэгийг нь орхиод
Нэгийг нь авчрахыг бодоорой
Тахир бол орхих биз... гэхчлэн ар гэртээ захидал өгүүлжээ. Үүнийг үзсэн харийн хаан "Олон мал хүн ирэх нь овоо алт мөнгө ирэх нь" хэмээн бодоод "захидлыг эзэнд нь хаана л байвал аваачиж өгөөд хариуг нь аваад, хамаг мал хөрөнгийг нь авчрах хэрэгтэй" гээд явуулжээ. Эцгийн захиаг үзсэн хаан хүү, хамаг түшмэл зарц нартайгаа үзэж "одоо хаан аавын хойноос нүүж аав шиг жаргаж албат иргэдийг захирах завшаан болж байна.

Эвэртэй малаа нэг
Эвэргүй малаа нэг болгож ялга
Хоёр зандан модны нэгийг ав
Хожим нэгийг авна
Адуу авчирч хамуутай
Бор гүү унага хоёрыг ялга" гэжээ.

Энэ явдлыг мэдээгүй байсан хаан хүүгийн авгай юу болж

байгааг хадам ээжээсээ дуулжээ. Тэгээд хаан эцгийн захианы утгыг


"Тэнгэр харж
Дэлхий дэвсэж
Хоёр гараа
Ээлжлэн дэрлэж байдаг гэнэ...
Та нарт би хэрэгтэй бол
Ирнэ үү гэжээ. Ирэхдээ
Зэвсэгтэй цэргээ урдаа
Зэвсэггүй цэргээ хойноо авч
Очсон хоёр түшмэлийн нэгийг алж
Нэгийг газарчлан дагуулаад
Сэтгэл буруу бол
Замдаа алах хэрэгтэй
Миний нөхөр /хаан хүү/ хатан ээж хоёрыг
Орон нутагтаа орхи гэжээ" хэмээн цэцэн бэр тайлжээ [31].

Бөртэ-үжиний тайлбарыг "Цэцэн бэр"-ийн утга тайлсантай харьцуулан үзэж ургуулан бодвол Жамуха андын өгүүлсэн нь хааны захианы үгтэй төстэй ёгт утгыг хадгалсан нь тодорхой юм. Тэр үгсийн утгыг Бөртө-үжин тайлсан нь "Цэцэн бэр"-ийг арга буюу санагдуулж байна. "Аргасун хорчийн домог"-т харь нутагт гурван жил суусан Чингис хаанд элчээр очсон Аргасун хорчи

"Сал модонд
Салбар шувуу
Өндөглөв гэлээ. Мөн
Сал модонд
Итгэж суусаар
Сар муу шувуу үүрийг эвдэж
Өндөг зулзага идэгдэв гэлээ гэж өчихөд түүний хэлсэн үгийн утгыг
Сал модон гэгч нөхөд минь буюу
Салбар шувуун гэгч миний бие буюу

Сар шувуун гэгч Солонгодын улс буюу
Өндөг зулзага гэгч хатад хөвгүүд минь буюу
Үүр гэгч энх их төр буюу..."[32] гэхчлэн хаан тайлдаг билээ.Цэцэн бэрийн "зүгээр биш, зүгээргүй юм байна" гэж үзэж ёгт далд утгыг тайлсан тэр аргаар Аргасун хорчийн үгийг Чингис хааны ухаж мэдсэнээр улбаалан бодвол "... a'ula siqan bawuya adu'ucin bidan-u alacuq-a gür=tügei qol-tur siqan bawuya qoni(n)cit quriqacit bidan-u qo'olai-a gürtügei" гэсэн Жамухагийн өгүүлсэнтэй холбогдуулж өнгөн талаас гүн тийш чиглэсэн хэдэн шатлал бүхий доор дурдсан хэдэн санааг өгүүлэн тодосгож болмоор ажээ. "a'ula","qol" хоёрыг яагаад заавал сонгоо вэ? Ургадаг ургамлаар нь, цаг агаарын аясаар нь "a'ula", "qol"-ыг малчид сонгодог билээ. Тэд мал сүргээрээ дамжуулж, өвсний соргог, усны тунгалагийг даган билчээр шилэн нүүдэллэдэг юм. Уулыг зөвхөн адууны, голыг зөвхөн хонины билчээр гэж хэт зааглаж болохгүй ч гэсэн адууны идээшлэхэд уул, хонины билчээрлэхэд гол усны хөвөө илүү тохиромжтой гэдгийг бас үгүйсгэж үл болно. Үүгээр үзэх юм малчид "a'ula", "qol"-ыг билчээрийн үүднээс нэгэн нутаг усны шүтэлцсэн хоёр тал, бүр тодосговол арга бэлгэ хэмээж болно. Тэгвэл "a'ula siqan bawuya", "qol siqan bawuya" гэсэн нь юуны төсөөлөл болж таарах вэ? Ямар ч атугай нэгэн дор бус өөр өөр газарт бууяа гэсэн утга хадгалсан нь эргэлзээгүй юм. Гэхдээ энэ бол ганц шөнө бууж хоноглох тухайд хамаатай бус билээ. Тэдгээрийг дагаж харьяаны нь олон овог хүрээ хуваагдах билээ. Үүнийг "adu'ucin bidan-u alacuq-a gür=tügei","qoni(n)cit quriqacit bidan-u qo'olai-a gürtügei" гэсэнтэй холбон үзэх хэрэгтэй юм. Хэдийгээр хоёуланд нь "бидний" гэсэн хамаарал илэрхийлсэн боловч "адуучин", "хоньчид хургачид" хэмээн хэнийг төлөөлүүлнэ вэ? Хэрэв хэн нэгнийг төлөөлүүлсэн гэж үзэх аваас "адуучин" нь Жамуха "хоньчид хургачид" нь Тэмүүжин болох биш үү? Учир нь "a'ula siqan bawuya" гэдэг нь хараацтай өндөрлөг өөд өгсөх, "qol-tur siqan bawuya" гэдэг нь нам бэл рүү уруудах гэсэн нэгэн санаа. Түүний цаана "адуучин" нь алсын урт хөлтэй, "хоньчид

хургачид" нь ойрын богино хөлтэй гэсэн нөгөө нэгэн санаа. Бас адуу малтай ноцолдох /маллах/ нь чадал тэнхээ заах эр хүний ажил, хонь хурга маллах нь гарын доор эм хүний хийгээд хүүхэд багачуудын хийх ажил гэх ойлголт ч монголчуудын дунд эрт дээр үеэс байсан бас нэгэн санаа. Тиймээс Жамуха яавч "хоньчид хургачид" хэмээн өөрийгөө /өөрсдийгөө/ тооцож, богино хөлт малтай ноцолдох их төлөв "эм хүн, хүүхдийн ажлыг хийх" гэмээн үзэхгүй нь лав. Үүнийг Жамуха, Тэмүжин нарын тухайн нүүдлийн үес хэн нь хэн байсан бэ? гэдэгтэй шууд холбон бодох ёстой. "Тэр үед Тэмүжинд өөрийн цэрэг гэж гавиатай юм байсангүй, гагцхүү Тоорил, Жамуха нарын их цэргийн хүчийг түшиж ялалт байгуулжээ. Жамуха, мөн Тэмүжиний адил их санаа агуулж байсны дээр овжин эр байсан учир аль хэдийнээ Тоорилын дэмжлэгийг олж өөрийн цэрэг сэлттэй хүчирхэг сурвалжтан болсон байв. Тэмүжин тэр талаар хожимдсон боловч Жамухатай нөхөрлөлөө сэргээж бэхжүүлэх нэрийдлээр Мэргэдийн дайны дараа бүтэн хагас жил хамт байх зуур найзынхаа нэр хүндийг олны өмнө сэм унагаж, нөхдийг нь талдаа нууцаар татан оруулах талаар сүрхий явууртай ажил зохиожээ... Хамаг монголд хаан болохыг эрмэлзэгч олон сурвалжтан, түүний дотор мөн тэр хоёр байжээ... Жамуха, Тэмүжин хоёрын хэн хэн нь хаан болох санаатай байсан боловч түүнийхээ төлөө хэтэрхий илэн далангүй хөөцөлдөж бас болохгүй байв... тэдний аль ч гэсэн биеэ хан өргөмжлүүлэх бэлтгэлийг сэм хийж, олны санаа сэтгэлийг түүнд дасгахыг оролдон байв..."[33]. Байдал нэгэнт ийм байхад адуучинд "alacuq-a gür=tügei", хоньчин хургачдад "qo'olai-a gürtügei" гэснийг Жамухагийн талаас бодвол хоёр дахь ойлголтод өөрийгөө багтаан аваачихгүй нь мэдээж. Гэтэл байдал ямраар эргэв? Жамухагийн хэлсэн үг Тэмүжин Жамуха хоёрыг салгасны дараа утга үргэлжилж үү үгүй юу?



§174.Ван хан хүү Сэнгүмээ шархдсанд ихэд уурсаж "Хөвгүүний амь өрсөн довтолъё" гэхэд Түмэн Түбэгэний Ачиг ширүн баатар "одоо хүүгээ асаръя, Монголыг эзлэх амархан" гэж Ван ханыг тайтгаруулан хэлсэн үгэнд : temüjin-lü'e dayijiju qaru=qsan mongqol qa'a otqun tede morin unu'atan modun nemü=reten bolba tede ani ese ire'esu otcu morin-u junda'ul metü qormailaju a[b] cirat-je bida tebe'er-i ke'ebe гэжээ.)Үүний дотор" morin unu'atan,modun nemüreten bolba tede "гэсэн үг "a'ula siqan bawuya adu'ucin bidan-u alacuq-a gür-tügei" гэсэн Жамухагийн хэлсэнтэй утга холбогдохгүй гэж үү.

[Тэмүжин, Жамуха хоёрын "хагацалт"-ийг зөвхөн л Жамухагийн ганц хүний "уйданги хэмээгдэн" гэх зангаар тайлбарлаж үл болох юм. Учир нь Жамуха Тэмүжин хоёрын "хагацалт"-д гуравдугаар этгээдийн мэдэж болох үгүй нууц байх юм. Энэхүү нууцыг илрүүлэх түлхүүр бол даруй "умартснан дурдатгалдаж, унтарсанаа сэргүүлэлцэж", үнэн үхэлдэхүй өдөр өр зүрхээ өвтгөх билээ чи... алалдахуй өдөр уушиг зүрхээ өвтгөх билээ чи... 12 гэсэн ба "үл умардах үгс өгүүлэлдэж", "хатгат үгс өгүүлэлдлээ" гэсэн үгс болох юм.


Иймээс миний бие Жамуха бол Тэмүжиний тулгуур төр нээж нэгдсэн Их монгол улсыг байгуулж агуу их үйлсэд алд бие, алдар нэр, амь насаа харам үгүй зориулсан, хүлцэн тэсвэрлэж алсыг бодолхийлсэн ба доромжлолыг хүлээж хүнд үргигийг үүрэглэсэн эмгэнэлт жүжгийн дүр болсноос уншигчдыг олон тийш холбон бодуулах олон хариугийн төвлөрөл бүхий гоо таашаалын өндөр өртөнтэй нарийн будилаант уран дүр болов гэж үзсэн байна.][34]

гэж ["Монголын нууц товчоо"-нд дахь Жамухагийн эмгэнэлт жүжгийн дүрийн гоо сайхны онцлог ба түхэн ач холбогдолыг өгүүлэх нь] өгүүлэлдээ Хархүү үзсэн байна. Тэгэхлээр Жамуха "Уйданг" уу?, Бөртэ-үжин "арвин эмэгэтү"үү? мэтчилэн хүн хүний дүр төрхийг, тэдгээрийн хийсэн үйлдэл бүхнийг нэхэн хөөж даралгүй, даврууллалгүй нарийвчлан задлан үзвээс эрх биш нэгэн

үзүүрт зангилагдан гарч ирнэ вий. Үүнийгээ ер нь монголчуудын дунд үгийн оньсийг тайлдаг уламжлалын дагуу ялангуяа "Цэцэн бэр"-ийн тайллаар, Аргасун хорчийн үгийг хааны ухаарснаар үзэх аваас Жамухагийн хэлсэн үг зам замаа дагаж, мөр мөрөө хөөж, нутаг нутгаа бараадаж бие даана салж орших тухай агуулга утгад бүрэн зангилагджээ гэж үзмээр байна. Ингэж үзэхийн уг сурвалж Тэмүжин, Жамуха хоёрын харилцаан дунд алгуурханаар ярган төлөвшиж тухайн нүүдлийн үес мөнөөхөн үгээр илэрч оргил цэгтээ хүрсэнд оршино.

4

§ 167 ... basa senggüm ügülejü ilerün amatu keletü qü'ün ügülen bö'etele yekin ülü büsirekdegü ke'en jici quci ügülejü ile'et yadaju ö'esün be'en gedun otcu ügülerün bel cimayi edüi bükü caq-tur bidan-i ya'un-a ber ülü bolqan buyu ünen ber qan esige-yen cimayi caqa'an-a saca'asu qara-da qaqa'asu qurcaqus-buyiruq-qan ecige-yin cinu joban edüi quriyaju aqsan ulus-i cinu man-a-'u mede'ülgü ken-e ...



Жамуха тэргүүтний ятгалгаар "Чингис хаантай байлдая" хэмээн хан эцэгтээ хэдэнтээ хэлүүлж эс зөвшөөрсөнд Сэнгүм биеэр ирж өгүүлсний дотор "qan ecige-yen cimayi caqa'an-a saca'asu qara-da qaqa'asu" гэсэн хэллэг анхаарал татаж байгаа юм.

Хажуугийн хятад орчуулгад "цагааная цацваас хард хахваас", ерөнхий орчуулгад "хэрэв эцэг та өтөлвөөс" гэсэн утга тус тус гаргажээ. Үүний дагууд цөөнгүй эрдэмтэд (Е.Хэниш, А.Мостэрт, Ф.Кливез, И.Рахевильц...)[35] "Өтөл насанд хүрэхлээр,

"Туйлын өтөл насанд хүрэхлээр" гэсэн утгын дор тайлбарлаж, мөн орчуулжээ.

Нөгөө зарим нь (Элдэнтэй,, Ардаажав, Н.П.Шастина, М.Гаадамба)[36] "Тус үгс хүний идээ идэж чадахгүй болж үхэхийг зүйрлэн өгүүлэв", "Хэрэв чамайг үхвэл "гэхийн оронд" "цагааная цацваас, хард хахваас" гэж хэлсэн хэмээх утгын дор тайлбарлаж, бас орчуулжээ.

Галиглах хийгээд олон хэлээр орчуулах, тайлбарлах зэрэгт "Цагааная цацваас, хард хахваас" гэхийн хамт "эцэг чамайг цагаан идээнд цацаж хар маханд хахвал", "цагаан идээ уухдаа цацдаг, хар маханд хахдаг мэт өтөл насанд хүрэхлээр", "цагаан /идээнд/ цацваас хар /маханд/ хахваас" гэхчлэн (Ц.Дамдинсүрэн, Элдэнтэй,, Оюундалай, Асралт, А.Мостэрт, Е.Хэниш, И.Рахевильц, Н.П.Шастина, Д.Цэрэнсодном...) цагаан, харыг тодотгосон үгс нэмжээ.

Энэ бүхнээс үзэхэд "цагааная цацваас, хард хахваас" гэдгийг

1. Идэж уусандаа хахаж цацдаг болтлоо өтөлвөөс

2. Хахаж цацаж үхвээс гэсэн хоёр утгаар ухаарч ирсэн нь тодорхой байна. Энэ бүхнийг харьцуулан үзэж хоёр дахь ухаарлыг зөвтгөж баталсан Д.Ёндон "Хахаж цацахыг нүгэлд тооцож, хахсан хүнийг цээрлүүлэхээс гадна өтөлсөн хүнийг зориуд хахаах, үе сүүл үнхүүлж, хонготой шаантаар гудран цааш харуулах ёс бас байсан билээ" гэдэгтэй холбон тайлбарлаж [Монголд дэлхийн бусад орны нэг адил эрт цагт хөгшдийг "нөгөө ертөнцөд явуулах ёс" байсан бөгөөд сайн мөшгөвөл түүний ор улбааг аман зохиол, ардын зан үйл, угсаатны зүйн хэрэглэгдэхүүнээс олж үзэж болно[37]] гэжээ.

Нэгэн зүйл. Энд дурдсан "хахаж цацахыг нүгэлд тооцож, хахсан хүнийг цээрлүүлэхээс гадна.. " ["Хахаж цацахыг эрт үед үхүүлэн шийдвэрлэдэг байсан ба ил тодорхой заншлыг хуулийн аргаар шийтгэж байсан"] гэсэн нь угтаа Жиованни дель Плано Карпини "Монголын түүх"-д "Хүн идэж байсан юмаа хоолойдоо тээглүүлэн хахаад гаргаж чадахгүйд хүрэхээр гэрийн ханаа өргөн завсраар нь чирч

гаргаад хайр найргүй хороон цээрлүүлнэ", "хүн ууж идэхээс болж үхэхийг тэд туйлын их нүгэлд тооцох..."[38] хэмээн тэмдэглэснийг, мөн Сүн улсын "Хар татарын товч тэмдэглэл"-ийн "улсын цааз" гэсэн хэсэгт "Идэхүйд зангирсан ба ам хаврын (хамрын) цусдагсадын сэтгэл нь ариун үгүй гэж ялламуй"[39] хэмээн бичигдсэн зэргийг иш татан өгүүлсэн хэрэг юм. Үүний зэрэгцээ монголд хэрэгтэн ялтны аманд шороо, чулуу чихэж хороох цааз байж түүнийг хэрэгжүүлж байсныг Рашид-ад-дины "Судрын чуулган"[40]-ы хэд хэдэн хуудаснаас үзэж болно.

Нэгэн зүйл. Энд дурдсан "Өтөл хүнийг зориуд хахаах, үе сүүл үнхүүлэн хонготой шантаар гудран цааш харуулах ёс бас байсан билээ" гэсэн нь монгол угсаатны дундах аман яриа, үлгэр домог тэргүүтэнд тусгагдан үлджээ. Үүнд Лувсанчойндон[41], Г.Р.Галданова[42], Ш.Гаадамба[43], Д.Цэрэнсодном[44], Д.Ёндон[45], Х.Сампилдэндэв[46] нарын товч боловч тэмдэглэн үлдээснийг дурдвал зохино.

Үүний дотроос буриад зоны дунд үлдсэн "толтын ёс", "толтдох ёс" хамгийн тодорхой жишээ болно. "Айн тэвдэн дүрвэхийн цагт нутаг дээрээ хөгшин хөвөө, бүл чадалгүй нь орхигдвол, дайсан харь этгээд тэднийг тарчлаан тамлана. Учир иймд л өтөс буурайгаа хайрлахын үүднээс толтдох ёс бий болж дээ... Дөчөө үзсэн өтөст зориулан цагаан эсгийн ширмэл дэвсэж, түүн дээр өөд болох учиртай өтөсийг хэвтүүлж аманд нь өрөм тос, цагаан идээ, сүүлний өөх хийж шаант чөмгөөр тагладаг байжээ. Хэрэв дөч хүү нь нялх балчир бол том хүн илбэлцэх бөгөөд толт чөмөгний ясанд хүүхдийн гар хүрсэн төдийд ёсыг гүйцэтгэгч нь толт чөмгийг хүчтэй цохин өтөс нэгнийг сүүлчийн замд нь үддэг байжээ. Үүнийгээ хорь буриад нар "цагаан идээнд цацаан хар маханд хахаах" гэж нэрлэдэг байжээ."[47] Энд "Дөч хүү" гэж гарч байгаа ч гэсэн "амь барих ачтай боллоо"[48] гэдгээс үүдэлтэй "ач хүү" олонтаа давтагдан гардаг юм. Ийм монгол ёсны үхэл байдгийг Сэнгүм эцэгтээ сануулсан нь үгэнд эс орсонд бухимдсанаас болсон нь лавтай. Тиймээс "цагаанаа цацах, хард хахах" гэдэг нь хүссэн ч эс хүссэн ч өтөл нас болохлоор "толтын ёсыг" гүйцэтгэх болно гэсэн ширүүн аяс давхар байгаа юм. Тухайн тэр үеийн ийм ёсны тусгал болж "гахсан дээр нь нудрах, гажсан дээр нь

түлхэх"[49], "хазайсан дээр нь түлхэх, хахсан дээр нь чихэх"[50] гэсэн үг одоо ч ардын ярианд үлдсэн байдаг билээ.

"Толтын ёс" гүйцэтгэх нь "нөгөө ертөнцөд илгээх" гэсэн санаа тодорхой ч "цагаанд цацаж, хард хахваас" хэмээсний цаад утга учир бэлгэдлийн үнэ цэнд өгөх ач холбогдлыг бууруулж болно.

Үүнтэй уялдуулж [Үхэх нь "цацах хахахтай" л холбоотой байснаас биш чухам ямар юманд цацах хахах гэдэгтэй харин онцын холбоогүй юм... "цагаан хар" гэдэг үг энэхүү өвөрмөц хэллэгт орсны учир бол "цацах хахах" гэдэг үг лүгэ толгой холбох онцгой шаардлагад зохицсоны эрхэнд л шилэгдэн хэрэглэгдсэн байгаа юм][51] хэмээн үзэж боломгүй мэт. Миний бодлоор "цагааная" гэдэг үгийн цаана ундаа буюу шингэн, "хард" гэдэг үгийн цаана идээн буюу хатуу гэсэн утга агуулагдсан болов уу? Энэ санааг лавшруулахад "цацваас" гэсэн нь шингэнийг "хахваас" гэдэг нь хатууг дагаж утга нэгдэх нь, нэгдсэн нь эргэлзээгүй гэж үзнэ.

"Монголын нууц товчоо"-ны холбогдох хэсэгтэй монгол аман зохиол түүний дотор үлгэр, домог, баатарлаг туульсын зарим уран дүрслэлийг мөн угсаатны зүй, монголын уламжлалт зан заншлыг харьцуулсан дээрхи хэдэн жишээ юуг харуулж байна вэ? гэвэл Монгол ардын аман зохиол болон бичгийн уран зохиолын төрөл зүйлийн харилцаа холбоог гүнзгийрүүлэн судлахад уран дүрийн хийгээд уран дүрслэлийн хувьд бэлгэдлийн нээгдээгүй нөөц жишээгээр баян гэдгийг батлаж байна.

Монгол ардын аман зохиолын эртний гарал үүсэл бүхий төрөл зүйлс нь бичгийн зохиол, түүний доторхи бэлгэдэл хэлбэржин төлөвшиж хөгжихөд гол нэгэн язгуур үндэс гэдгийг аман зохиолын олон төрлийг шингээсэн монгол ардын баатарлагийн туульс, уран зохиолын олон төрлийг цогцлоосон "Монголын нууц товчоо" хоёрын харилцаа холбоо тодорхой гэрчлэж байна.

Үгийн өнгө, гэрэл сүүдэр, ёр зөнгөөс аваад дүрслэгдэхүүний бүхэл бүтэн ойлголт ухагдахууныг илэрхийлэх бэлгэдэл нь монгол ардын аман болон бичгийн уран зохиолын урлах эрдмийн нэгэн гайхамшиг, тулгуур мөн.

ЗҮҮЛТ, ТАЙЛБАР

1. С.С.Аверинцев. Большая советская энцеклопедия. Том 23, 1976, стр 385
2. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1, II Книга, пер. с. персидского Изд. АН СССР. М-Л. 1945, стр 117
3. Tegüsbayar. " ölön dur qucibasu üker-e ülü idekdegü-yin-ucir. öbür mongqol-un yike surγaγuli-yin erdem cinjilegen-ü setgül. 1990 №3. 55-61 düger-tal-a
4. Ж.Дашдорж, Г.Рэнчинсамбуу. Монгол цэцэн үгийн далай. Studia Folclorica... Том II-I,I ШУАХ, УБ., 1964, 62-р тал
5. Ж.Дашдорж. Монгол цэцэн үгийн далай. Studia Folclorica... Том YI-I, II ШУАХ, УБ., 1966, 57-р тал
6. Ж.Дашдорж, Г.Рэнчинсамбуу. Монгол цэцэн үгийн далай. Studia Folclorica... Том II-I,I ШУАХ, УБ., 1964, 97-р тал
7. С.А.Козин. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г под названием "Mongγol-un niγuca tobciyan. Юань чао би ши-монгольский обыденный изборник. Том 1, Изд. АН СССР, М-Л., , 1941, стр 186
8. F.W.Cleaves. The Secret History of the Mongols. Vol I, (Translation) Harvord University Press, 1982, p. 196
9. Eldengtei, Ardajab. Seyiregülün tayilburilaba, Mongγol-un niγuca tobciyan seyiregülül tayilburi. öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a, 1986, 851 düger tal-a.
10. Dalangtai-yin Ceringsodnam."Mongγol-un niγuca tobciyan"-u orciγulγa tayilburi. ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 1993, 478 duγar tal-a.
11. Ерэнсэй /оршуулагша ба тайлбарилагша М.П.Хомонов/ Буряадай номой хэблэл. Улаан-Үщдэ. 1968, стр 142.

6655 Арбан гурбан бүдүнө
Гаралсаһан бэеэрээ
Дэбэрхэлнэ бэлэйлдаа.
Хабхагшалан барихадаа
Арбан бүдүнүйн баряадла

6655 тринадцать перепелок
вылетели оттуда
и начали кружиться
Бросившись ловить,
он поймал

6660 Гурбан бүдүнүй үлеэжэ,
Огторгойн боро хүхэ харасага
Нашин ханай боложо,

Үлдэжин арилаба.

Мэтэр гэсэн бэеэрээ:
6665 Хоёриин хани барилсабал

Нэгэйн хани үлеэжэ,
Үлдэжэ мэнэ болжо ерхэдээ
Гурбан ханай дүшүнүг
Улаан будаа таряан болобо,
6670 Атхарашин унаба,

Юһүн тахяа боложо,

Юһүн тээһээн орожо,
Түүлдэжэ идебэ.
Мэнэ түүжэ ойро болон ерхэдээ

6675 Гурбан улаан гүрөөһөн
болоно бэлэйлдаа.

Гүйлдэжэ н-арилабал.

Гурбан хүхү шоно боложо,

Үлдэлдэжэ арилаба,

лишь десять из них,
6660 остались три.
Превратившись
в серого сокола
небесного,
Он пустился им
вдогонку.
Вслед за тем

6665 двух он поймал
одна лишь осталась.
Уж догонял ее,
а она, превратившись
в просовые зерна,
6670 рассыпалась на
трех десятинах
[земли].
Он, в девять куриц
превратившись,
с девяти сторон
стал их клевать.
Уже почти кончил
клевать,
6675 [как] она
превратилась
в трех красных
косуль.
А он в трех сивых
волков превратился

и вдогонку пустился.
Двух /косуль/ он
поймал,

Хоёриин хани барилдаба -
6680 hүнхэн шара далайдаала
Шахалдажа ерэлсэбэ.

Шара бүрүн далайдала
Ираахай загаһан боложо
Атхаража унабадаа.

6685 Мэтэр гэсэн бэеэрээ:

Юhүн сурхай болоболдаа,

Эндэ тэндэhээн орожо,
Эблүүлхэжэ зальяба...

6680 а третью прижал
к желтому
молочному морю.
Она, превратившись
в рыбок, нырнула
в желтое бурунное
море.

6685. Вслед за тем
он в девять щук
превратился
и с разных сторон,
собирая, [стал]
проглатывать [их]...

12. Зул Алдар хаан /тууль/ Арван гурван хүлгийн дуун /Ойрд аман зохиолын цоморлог/ Эмхтгэж удиртгал, тайлбар бичсэн Ж.Цолоо. УХГ. УБ., 1987, 465-479-р тал
13. Бум эрдэнэ. /Монгол ардын баатарлаг тууль/. Хэвлэлд бэлтгэж боловсруулсан Б.Катуу. БНМАУ. Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. УБ., 1985, 57-61-65, 76-77-р тал
14. Аргил цагаан өвгөн. Мөчлөг тууль /Эмхтгэн боловсруулсан Р.Нарантуяа/ , БНМАУ. Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. УБ., 1985, 52-р тал
15. Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиолын фонд, товъёог 1, данс № 1, хадгаламжийн нэгж 1.
16. Шара-туджи - Монгольская летопись XYII века. Сводный текст перевод, введение, примечания Н.П.Шастиной, М-Л., 1957, стр 33-34
17. Монгол ардын домог үлгэр. Эмхэтгэж, удиртгал тайлбар бичсэн Д.Цэрэнсодном. УХГ. УБ. 1989. 45-р тал.

18. Халх ардын тууль. Хэвлэлд бэлтгэсэн С.Лувсанвандан, У.Загдсүрэн, Д.Цэдэв, Ж.Цолоо. ШУАХ, УБ., 1967, 40-р тал.
19. Даньхүрэл /тууль/. Хэвлэлд бэлтгэсэн Б.Катуу. БНМАУ. Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар. УБ., 1986, 111-р тал
20. Ш.Гаадамба. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. УХГ, УБ., 1990, 124-р тал
21. Bulaγ. Mongγol-un niγuca tobciyan-u ündüsüten-ü kelberi. öbür mongγol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a. Köke qota. 1983, 163-164 düger tal-a
22. Injannaci. Köke sudur. Terigün debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. Köke qota. 1957. 236-237 duγar tal-a
23. В.В.Бартольд. Образование империи Чингиз хана /Пробная лекция, читанная в с Петербургском университете 8 апреля 1896г. Записки Восточного отделения /ИМП/ Русского археологического общества. СП., 1897. Том X, стр. 111
24. Б.Я.Владимирцов. Общественный строй монголов. /Монгольский кочевой феодализм/ Ленинград, 1934, стр 7
25. А.Якубовский. Книга Б.Я.Владимирцова "Общественный строй монголов" и перспективы дальнейшего изучения Золотой Орды- "Исторический сборник", том Y, М-Л., 1936, стр. 310
26. Шагдаржавын Нацагдорж. Монголын Феодализмын үндсэн замнал /түүхэн найруулал/, УХГ, УБ., 1978, 70-74-р тал.
27. C.Kesigtoγtaqu. Mongγol-un erten-ü utγ-a jokiyal-un sudulul. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. Khailar. 1988. 100 duγar tal-a
28. C.Kesigtoγtaqu. Mongγol-un erten-c utγ-a jokiyal-un sudulul. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. Khayilar, 1988, 101 düger tal-a
29. Д.Цэдэв. Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл I /тэргүүн дэвтэр/, ШУАХ, УБ., 1974/1973/, 94-97-р тал
30. Khasumi Kharau. Temüjin ba jamuqa-yin qaγacal. öbür mongγol-un bagsi-yin yike surγaγuli-yin erdem sinjilegen-ü setgul. 1994, No 2.

21-27 duγar tal-a
31. Х.Сампилдэндэв. Аман яруу найраг ёгтлолыг ашигласан нь. Аман зохиол судлал /Studia Folclorica.../ Том X, Fasc 1, ШУАХ 1977 /1976/ 55-66-р тал
32. Богд Чингис хааны цэдэг. Хөхөгчин үхэр жилийн /1927/ хаврын тэргүүн сарын арван таванд анх удаа дармалав. Монгол бичгийн хороо. 28-р тал
33. Н.Ишжамц. Монгол нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэж тогтсон нь. ШУАХ, УБ., 42-43-р тал
34. Mongγol kel-e jokiyal sudulul. öbür mongqol-un soyul-un keblel-ün qoriy-a. 1997.196 duγar tal-a
35. Antoine Mostaert. Sur quelques passages de l Histoire secrete des Mongols.HJAS.Vol. 13 pp. 358-361; F.W.Eleaves.The secret History of the Mongols,London.1982.pp.91; Pachewilts.The secret history of the Mongols-Papers on For Eastern history. №13 Candera 1979 13.pp 55-56
36. Eldengtei, Ardajab seyiregülün tayilburilaba. Mongγol-un niγuca tobciyan seyiregülül tayilburi.öbür mongγol-un suryan kümüjül-ün keblel-ün qoriy-a 1986.486 duγar tal-a; Лувсанданзан. Алтан товч (Золотое сказание) пер.с .мон, введение, комментарий и приложения Н.П.Шастиной М.1973 стр.342;
Ш.Гаадамба. Некоторые художественные особенности "Сокровенного сказания"-Монгол судлал. Том. VI. вып. 27. УБ. 1968. 110-р тал
37. Д.Ёндон (Монгол). "Монголын нууц товчоо"- н дахь үгсийн өнгийг тодруулах асуудалд.Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал.II.УБ 2000 38-39-р тал
38. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильом де Рубрук.Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ.1988. 18, 24-р тал
39. Khara tatar-un tuqai kereg-ün tobci"-yin tayilburilan gerecilegsen bicig. Boγda baγatur beye-ber dayilaγsan temdeglel. öbür Mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a 1985 203 duγar tal-a
40. Рашид-ад-дин. Сборник летописей.Том I. Книга первая. пер. с персидского. Л.А.Хетагурова. Изд. АН СССР. М-Л 1952. стр.142; Рашид-ад-дин. Сборник летописей.Том II пер.с персидского. Ю.П.Верховского Изд. АН СССР. М-Л. 1960. стр.137
41. Mongγol-un jang aγali-yin oyilbori. Lubsangcoyidan jokiyaba.öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1981.136-137 duγar tal-a
42. Г.Р.Галданова.Доламаистские верования бурят. Изд. Наука. Сибирские отделение. Новосибирск. 1987. стр. 75-76
43. Ш.Гаадамба,Х.Сампилдэндэв.Монгол ардын аман зохиол УБ.1988.198-р тал
44. Д.Цэрэнсодном. Монгол ардын домог үлгэр. УХГ. УБ. 1989. 176-р тал
45. Д.Ёндон(монгол) "Монголын нууц товчоо"-н дахь үгсийн өнгийг тодруулах асуудалд. "Монголын нууц товчоо"-ны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал. II. УБ. 2000. 38-р тал.
46. Х.Сампилдэндэв.Монгол домгийн чуулган (Эмхэтгэн боловсруулсан доктор,профессор Х.Сампилдэндэв) УБ. 1999.30-р тал
47. Худанц Шарайд Тойсомын Галсан. Буриадын язгуур домгийн товчоон . "Эрдэм" компани. УБ. 1998. 33-34-р тал
48. Ш. Гаадамба. Зүйр цэцэн үг. Аман зохиол судлал (Studia Folclorica ... Том XVI. Fasc. 1-9). ШУАХ. УБ. 1987. 51-52 -р тал

[... "Ам барих
Ачтай" гэдэгт маш эртний овгийн аж төрлийн хүчин чадал нэн дорой, насан өтөл болсон хүмүүсээ асрах эдийн боловсрол хүрэлцээгүй нөхцөлд 70 настанг үе сүүл үмхүүлж хонготой шаантаар гудран цааш харуулдаг ёс байсныг харуулж байна. Өвгөд дээдсийгээ 70 нас хүрмэгц шаантаар гударч алдаг нь одоогийн бидний бодоход туйлын харгис ёс мэт санагдавч овгийн аль нэг гишүүн нь овогтоо ямар ч хөдөлмөрийн нэмэр тус байхгүй, харин энэрүүлэх сувилуулах илүү яршигаас өөр

юмгүй дарамт болоход хэрэв түүнийг тэжээж тэтгэх гэж оролдвол овог нь нийтээрээ тэр нэг өтөл хүнээс болж сүйрч мөхөхөд ч хүрч болох учраас овог нийтийн эрх ашгийн үүднээс хөгшин хөвөөгөө тийнхүү "ёс үзүүлэхээс"өөр гарцаа байгаагүй тэр эрт балар цагийн нөхцөл байдалын үүднээс энэ ёс бүрэн ойлгомжтой бөгөөд хэр чинээний дотор хүнлэг энэрэнгүй "ёс" гэж үзэгддэг байжээ. Энд 70 настанд ийнхүү ёс үзүүлэхдээ төрүүлсэн эцгээ хүү нь биш, хүүгийн хүү ач нь амыг барьдаг нь ч мөн нэг ёсны "өрөвч" ёс байсан тул овогтоо тээр саад болох насандаа хүрсэн өтөл өвгөд хөгшид нь ч ийнхүү алагдахаа "орчлонгийн жам" гэж ухамсарлан хэрэв ач хүүтэй бол "ам барих ачтай" гэж бахирхах янзтай энэ цэцэн үгийг хэлдэг байжээ...]

49. Ж.Дашдорж. Монгол цэцэн үгийн далай. II Studia Folclorica ... Tom V-II. ШУАХ. УБ. 1966. 22-р тал
50. Ж.Дашдорж. Г.Рэнчинсамбуу. Монгол цэцэн үгийн далай. I Studia Folclorica ... Tom II-I. ШУАХ. УБ. 1964. 95-р тал
51. Bürinbatu "Mongγol-un niγuca tobciyan" daki "ükükü"-yi. jiγaγsan qoyar öbermice kelelge-yi sinjilekü ni . öbür mongγol-un yike suryaγuli-yin erdem sinjilegen-ü setgül.1990. 64 düger tal-a

ДҮГНЭЛТ

Хүмүүсээс өөрийгөө болон бусдыгаа, цаашилбал сав шимийн ертөнц, нийгэм орчныг үзэх үзэл санаа, бодол сэтгэлгээний ээдрээ сүлжээг тайлж танин мэдэх сэтгэхүй, мэдрэхүйн хур цогцсын ил атлаа далд, далд атлаа ил болзолт харьцааны нэгэн эд эс нь бэлгэдэл мөн. Бэлгэдэл нь хэл шинжлэл, хүмүүнлэгийн ухаан, түүх, соёл, утга зохиол, угсаатны зүй зэрэг олон салбар тийш сүлжээлсэн утгын зангилаа юм. Монгол түмний оюуны соёлын хамгийн тод дурсгал "Монголын нууц товчоо"-нд тусгагдсан бэлгэдэл нь сав шим мандал, хүний амьдралын гол мөчлөг хийгээд нийгмийн харилцааг өргөн хамарч чадсан нь уг зохиолын цар хүрээ, гүн агуулга, урлах эрдмийн илэрхийлэл болно. Олон өнгө аяс, хувилбартай, давтамжийн хувьд харилцан адилгүй ч гэсэн хэв шинжийг агуулсны хувьд бэлгэдлийн төвшин харьцангуй тогтвортой атлаа хувьсангуй, хувьсангуй атлаа тогтвортой нь хүн зоны зан үйлд үл мөрөө үлдээж хожмын сурвалж бичиг туурвилд улирч хоцорсон нь түүний урт удаан амьдрах чадвартайг гэрчилж байна.

Үүгээр "Монголын нууц товчоо" нь аман зохиол, бичгийн уран зохиолд идээшсэн бэлгэдлийн охь хандыг шингээн авч тухайн цаг үеийн өнгө болж тодорсон шинэ аястай нэгтгэн хослуулж чадсаны хувьд уламжлах залгамжлахын шүтэлцэл холбооны үлгэр жишээг үзүүлсэн билээ. Гэвч уг зохиолоос үзэхэд бэлгэдэл бол ягштал тогтсон хэв загвар ч бус, сүлжээ тогтолцоогүй зүйвэр цуглуулга ч биш билээ. Тэгэхлээр юуг юугаар бэлгэдэж ямар утга илэрхийлээ вэ? гэсэн асуултад "Монголын нууц товчоо" яаж хариулсныг хэд хэдэн чиглэлээр авч үзсэний дүнд доор дурдсан дүгнэлтийг хийж болохоор байна.

1. Тоо бүхэн тодорхой тэмдэг, утга хадгалсан бие даасан нэгж болохын хамт холбогдох нэгэнтэйгээ харилцаа уялдаатай байгаа нь "Есийн хасагдан хуваагдах хэлбэр бол гурав, гурвын нэмэгдэн үржих хэлбэр бол ес мөн" гэсэн эгэл томъёололд

илэрч байжээ. Ийм загвараар бусад бололцоо бүхий тоог цөөлөн бууруулах, олшруулан ихэсгэх замаар давтахад нэгж солигдохын хамт язгуур утгаа хадгалахын зэрэгцээ шинэ агуулгаар сэлбэгддэг ажээ. Тооны тэрхүү хосломол утга нь ёс заншил, шүтлэг тахилга тэргүүтэнтэй нягт уялдсанаараа тэдгээрийн өнгө аясыг ямар нэг хэмжээгээр илэрхийлэх бэлгэ тэмдэг болж чаддаг байна. Үүнд тоо, түүний бэлгэдлийн нийтлэг шинж, өвөрмөц онцлогийн шүтэлцэл оршино.

2. "Таван мөс", "Таван хуруу", "Гал" гэдгээс тооны тодотголтой эсэхээс үл хамааран "Тав" гэсэн ойлголт, "Хөх","Хөхсөн", "Хөхөөд" гэсэн үгнээс "Цагаан", "Сүү" гэсэн ухаарал, "Мөнх тэнгэр", "Дээд тэнгэр"-ээс "хөх" гэсэн утга илэрдэг нь алив үг хэллэг тухайн байдал хам нөхцөлөөс шалтгаалан өөртөө бэлгэдлийг /Тоо, өнгө гэх мэт/ шингээсэн байдаг нь, тэрхүү бэлгэдэл үг хэллэгээр амьдрал дунд хэвшмэл болдог гэдгийг харуулж байна.
3. Өнгө бол зөвхөн зүсийг заагаад зогсохгүй цагаан бол хүндэтгэл, ариуны, хар бол догшин, сүр хүчний, хөх бол Мөнх тэнгэрийн бэлгэдэл байсан нь давамгайлах шинжийн жишээ болохоос бусад утга бэлгэ илтгэхийг үгүйсгэсэн баримт биш юм. Тиймээс унаган байгалийн өнгө, нүгэл буянт хорвоогийн өнгө, хүний сэтгэлийн өнгө сүлэлдэн байдагт бэлгэдлийн нэг болон олон тал, нэг болон олон хэмжээсний шүтэлцэл оршино.
4. Зөн совин гэдэг нь хувь заяаг урьдчилан мэдэх, түүгээр дамжуулан санамж сэрэмж өгөх элч дохио мөн. Зөн совинг гүнзгий ухаарч түүний нэгэн эс болсон зүүдийг зөв тайлснаар хүн байгалийн харьцаа шүтэлцээний болон хүний дотоод сэтгэхүй мэдрэхүйн тайлагдах атлаа тайлагдашгүй, тайлагдашгүй атлаа тайлагдах нууцыг танихад нэгэн ямх ч атугай дөтлөх болно гэдгийг "Монголын нууц товчоо"-ны жишээ харуулж байна.

Дан утгыг илэрхийлсний зэрэгцээ давхар санаа бодролыг

хослуулсан нь нэгэн бэлгэдэлд нөгөөгийн агуулгыг шингээх, нөгөөд нь нэгэн хоёрын утгыг шүтэлцүүлсэн нь бэлгэдлийн олон талтайн онцлог шинж мөн. Олон төрлийн бэлгэдэл болон нэгэн төрлийн доторх хэд хэдэн бичил бэлгэдэл нэгэнтээ нэгдэж цогцолсон нь "Монголын нууц товчоо"-г цогцолбор, чуулбарын өргөн хүрээнд ярьж болох боломжийг бүрдүүлж байна. Бэлгэдлийн аль нэгэн айд дагнан багтамгүй хувцасны хийгээд уран үгийн дүрийн бэлгэдлийн олон салаа салбар утгатай өргөн цартай ойлголт нь "Монголын нууц товчоо"-ны агуулгын гүнийг нээх түлхүүр, хэлбэрийн баян дэлгэрийг харуулах оньс болж чадна.

Монгол хүний хувцас нь малгай, бүс, зэрэг дотоод төрлөөрөө, өнгө зүсээрээ, зориулалтаараа, хэрэглэх ёс горимоороо /өмсөх, бүрэн өмсөх, тайлах, бэлэглэх, дурсгах гэх мэт/ гүн гүнзгий утга бэлгэдэл агуулсны хувьд тэр аяараа бэлгэдлийн ай ч, цогцолбор ч, чуулбар ч мөн.

"Монголын нууц товчоо"-ны ёгтлол, зүйрлэл, төлөөллийн солонгорон гэрэлтэх талст бүхий дүр дүрслэл нь утга далдалсан, утга шилжүүлсний хувьд бэлгэдэлтэй гүнзгий холбогдсон болох тул тэдгээрийг ул үндэстэйгээр зөв тайлахгүйгээр үгсийн эрдэнэсийн орд болсон уг туурвилын нууцыг нээж бүрэн бүтнээр нь задлан шинжилж нэгтгэн дүгнэж чадахгүйд хүрнэ. Тиймээс зохиол туурвилын эд эс болсон үг, хэллэг бүрийн ил далд утга, түүний бэлгэдлийн сүлжээг нарийн нягт тодруулан судлах нь "Монголын нууц товчоо" судлалд анхаарлаас холтгож болохгүй асуудлын нэг юм. Монголчуудын сэтгэлгээний баян дэлгэр өв уламжлалд тулгуурлан утга, соёлын олон төрөл зүйлийг зааг ялгавар нь мэдэгдэхгүй болтол нэгэн хайлш урсгал болгон шингээж чадсан нь "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл, түүний судалгаанаас тод харагдаж байна.

Энэ нь уг туурвилын бэлгэдлийн ай, цогцолбор, чуулбар бүрийн жишээ, арга билгийн харьцааг гүнзгий илэрхийлж байгаатай холбогдоно. Арга билгийн харилцаанд, тэмдэглэхүүн

тэмдэглэгдэхүүн хоёрын зааг ялгаа хийгээд шүтэлцэл холбоон дунд бэлгэдлийг нэгэн бүтээлийн дотор ингэж хурж цогцлуулна гэдэг монголчуудын оюуны соёлын цар хүрээ, түүний дотор түүх бичлэгийн чанарын төвшин XII, XIII зууны үед ямар байсны тод жишээ мөн.

"Монголын нууц товчоо" нь XII, XIII зууны монголын нэгдсэн төр улс байгуулах хийгээд байгуулсан тодорхой нэгэн үеийн угсаатан хам олны сэтгэлийн дотоод нууцад нэвтэрч бэлгэдлийн сэтгэлгээг төлөөлж чадсанд уг бүтээлийн үнэ цэнэ, ач холбогдол оршиж байна.

"Монголын нууц товчоо"-ны бэлгэдлээр жишээлсэн судалгаа нь аль нэгэн зохиол, тодорхой сурвалж бичгийг бэлгэдлийн үүднээс шинжлэх арга зүйн туршлага, туршиц болно. Энэ нь монгол бэлгэдлийг бусад бичгийн зохиолын жишээнд хамааруулан өргөтгөн судлахад ч нэгэн эхлэл үүдэн юмаа. Тиймээс "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл зүйн судалгаа нэг талаас язгуур монгол бэлгэдлийг тогтоох эх ундарга, нөгөө талаас монголын түүх соёлтой холбогдол бүхий улс үндэстний бэлгэдэлтэй холбон үзэх эх сурвалж мөн. Монгол нь олон аймаг, ханлигуудаас бүрдсэн тул тэдгээрийн хэв заншил, ёс горимын цогцолбор байсан төдийгүй түүх соёлын хэлхээтэй бусад ард түмэнтэй, ялангуяа Азийнхантай харилцаатай байсныг холбогдох ёс заншилтай уялдуулж өргөтгөн үзвэл бэлгэдлийн судлалд шинэ нэмэр нөхвөр болох нь эргэлзээгүй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

Нэг. Монгол хэлээр гарсан сурвалж бичиг, судалгааны зохиол

1. Абай Гэсэр хүбүүн. Согсолон найруулагша Намжил Балдано. Бурядай номой хэблэл. Улан-Удэ. 1959. 525 хууд.
2. Altan kürdün mingγan kekesütü. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1987 498 niγur.
3. (Алтан-Очир) Mongγol-un niγuca tobciy-a. Orciγuluγsan kümün qarcin baraγun qusiγun-u Altan wcir-un jüng cing. Boγda Cinggis qaγan-doluγan jaγun γucin jirγuduγar on-u arban sar-a-yin arban tabun-a. Terigün noyan-u ordun-u darumal-un γajar
4. Altan tobci. Coyiji tulgan qaricaγulju tayilburilaba. Kökeqota. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1984 (1983). 672 niγur.
5. Amur A. Mongol-un tobci teüke. Terigün debter. Ulaγanbaγatur 24 (1934). 338 niγur.
6. Аргил цагаан өвгөн. Эмхэтгэн боловсруулсан Р.Нарантуяа. БНМАУ. Ардын Боловсролын Яамны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. УБ. 1985. 96 хууд.
7. Asaraγci neretü-yin teüke. (Baγan-a...baγulγaju tayilburi kibe). ündüsün-ü keblel-ün qoriy-a 1984. 319 niγur.
8. Баруун монголын баатарлаг туульс. Хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо, У.Загдсүрэн. ШУАХ. УБ. 1966. 172 хууд.
9. Bayar. Mongol-un niγuca tobciyan. Terigün, ded, γudaγar debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. 1981. 1467+233 niγur.
10. Бира.Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. Ази, Африкийн хэл, соёлын судлалын хүрээлэн. Токио. 1994. 439 хууд.
11. Бира. Ш. Монголын түүх соёл, түүх бичлэгийн судалгаа (Бүтээлийн эмхтгэл) III. УБ, 2001. 528 хууд
12. Бум-Эрдэнэ. Хэвлэлд бэлтгэж боловсруулсан Б.Катуу. БНМАУ Ардын Боловсролын Яамны сурах бичиг сэтгүүлийн

нэгдсэн редакцийн газар. УБ.1985, 144 хууд.
13.Bulaγ jokiyaba. Mongγol-un niγuca tobciyan-u ündüsüten-ü kelberi. öbür Mongol-un surγan kümüjil-ün keblel-ün qoriy-a Kökeqota. 1983. 434 niγur.
14. БНМАУ-ын түүх (Нэн эртнээс XYII зуун) Тэргүүн боть, УХХЭХ. УБ. 1966. 499 хууд.
15. БНМАУ-ын угсаатны зүй. Гурван боть, XIX-XX зууны зааг үе. 1 боть. Халхын угсаатны зүй. Ред. С.Бадамхатан. УХГ. УБ. 1987. 432 хууд.
16.(Бөх хишиг) Mongγol-un niγuca tuγuji. Mongγolcilaγsan kümün Bökekesig. Darumallan γarγaγsan anu mongγol utγ-a-yin surγal-un qural. Engke erdemtü-yin naumaduγar on, γurban sara-a-yin qorin-a
17. Boγda baγatur bey-e-ber daiylaγsan temdeglel. (Asaraltu, Köke-ündür nar qarγuγulun orciγulba). öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a 1985. 380 niγur.
18. Гаадамба Ш. Монголын нууц товчооны судлалын зарим асуудал. УХГ. УБ. 1990. 254 хууд.
19. Гаадамба Ш, Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. УХГ. УБ. 1978. 303 хууд.
20. Гаадамба Ш. Монголын нууц товчоо. Худам монгол үсгээр сийрүүлсэн Ш.Гаадамба. Армийн СХ-ийн Хэвлэх үйлдвэр. УБ. 1990. 422 хууд.
21. Гонгор Д. Халх товчоон I ШУАХ. УБ. 1970. 339 хууд.
22. Гонгор Д. Халх товчоон II ШУАХ. УБ. 1978. 397 хууд.
23. Gereltü. Mongγol jokiyal-un onul-un cimeg. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a 1975. 244 niγur.
24. Гэсэр. Сонгомол эхийг боловсруулж удиртгал, тайлбар бичсэн акад. Ц.Дамдинсүрэн. УХГ.УБ. 1987. 222 хууд.
25. Далай Ч. Монголын бөө мөргөлийн товч түүх. ЭШХ. УБ., 1959. 49 хууд.
26. Далай Чулууны. Монголын түүх. Хамаг монгол улс (1101-1200).Тэргүүн дэвтэр. ШУХ "Эрдэм" компани. УБ., 1996, 107 хууд.

27. Далай Чулууны. Монголын түүх (1260-1388). Гутгаар дэвтэр. Хэвлэлийн "Эрдэм"пүүс. УБ., 1992. 217 хууд.
28. Damdinsürüng. Mongγol-un niγuca tobciyan. qaγucin mongγol kelen-ece odu-yin mongγol bicig-ün kele-ber Cengdü-yin Damdinsürüng orciγulba. Ulaγanbaγatur. 1947. 283 niγur.
29. Ce. Damdinsürüng. Mongγol uran jokiyal-un degeji jaγun bilig orusibai MCMLIX 599 niγur.
30. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. Нэгдүгээр дэвтэр УХГ. УБ. 1957. 159 хууд.
31. Даньхүрэл. (Тууль) Б.Катуу хэвлэлд бэлтгэв. БНМАУ. Ардын Боловсролын Яамны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. УБ. 1986, 174 хууд.
32. (Дашцэдэн) Монголын нууц товчоо. Галиглан хэвлүүлсэн Т.Дашцэдэн. ШУАХ. УБ. 1985. 208 хууд.
33. Dossun-u Mongγol-un teüke (nike). öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1988. 197 niγur.
34. (Дугаржав) Mongγol-un niγuca tobciyan-u qarγuγulun kinaγsan debter. Baγulγaγsan ni quγasai Duγarjab. öbür mongγul -un soyul-un keblel-ün goriy-a 1984.
35. Дулам С. Дархад бөөгийн уламжлал /латин галиг, удиртгал тайлбартай/ Эрхэлсэн О.Пүрэв. МУИС-ийн хэвлэл. УБ. 1992, 200 хууд.
36. Дулам С. Монгол домог зүйн дүр. УХГ. УБ. 1989. 192 хууд.
37. Дулам Сэндэнжавын Монгол аман зохиол, утга зохиол дахь бэлгэдэл зүйн тогтолцоо. Хэлбичгийн ухааны докторын зэрэг горилсон зохиол. Улаан-Үд. 1997./цохимол 488 хууд/
38. Дуутай мөндөр. Эмхэтгэн боловсруулж, оршил бичсэн Б.Катуу, Р.Нарантуяа. БНМАУ. Ардын Боловсролын Яамны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. УБ. 1989. 101 хууд.
39. Jambadorji jokiyaba. Bolur toli. ündüsün-ü keblel-ün qoriy-a 1984. 589 niγur.
40. Жиованни дель Плано Карпини. Монголчуудын түүх, Гильом

де Рубрук. Дорно этгээдэд зорчсон минь. УХГ. УБ. 1988. 253 хууд.
41. Жүгдэр Ч. Монголд феодализм тогтох үеийн нийгэм улс төр гүн ухааны сэтгэлгээ (Эртнээс X1Y зуун хүртэл) УБ. 1987, 216 хууд.
42. Injannasi. Köke sudur. Terigün, ded, γudγar debter. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. Kökeqota. 1957. 2161 niγur.
43. (Иринчин) Mongγol-un niγuca tobciyan. Kökeqota. 1987.
44. Ишжамц Н. Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэж тогтсон нь. ШУАХ. УБ. 1974. 274 хууд.
45. Катуу Б. Монгол туульсын бэлгэдэл. УБ. 1996. 131 хууд.
46. Лувсанданзан. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан Алтан товч хэмээх оршивай. Оршил бичиж нийтлүүлсэн Ш.Бира. УХГ. УБ. 1990. 177 хууд.
47. Lubsangcoyidan. Mongγol-un jang aγali-yin oyilburi. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. 1981. 369 niγur.
48. (Лю Жин-Сүэ) Arban buyantu nom-un caγan teüke. öbür mongγol-un keblel-ün qoriy-a. 1981. 151 niγur.
49. Монгол ардын баатарлаг тууль. Эмхэтгэж удиртгал тайлбар бичсэн Ж.Цолоо. УХГ. УБ. 1982. 166 хууд.
50. Монгол ардын баатарлаг туульс. Эмхтгэн боловсруулж, өмнөх үг, тайлбар сэлт үйлдсэн Г.Ринчинсамбуу. Studia Folclorica... Tom 1, Fasc 7. УХХЭХ. УБ. 1960. 155 хууд.
51. Монгол ардын домог үлгэр. Эмхэтгэж, удиртгал, тайлбар бичсэн Д.Цэрэнсодном. УХГ. УБ. 1989. 240 хууд.
52. Монгол ардын зан үйлийн аман зохиол. Эмхэтгэж, удиртгал, тайлбар бичсэн Х.Сампилдэндэв. УХГ. УБ. 1987. 343 хууд.
53. Монгол улсын угсаатны зүй. XIX-XX зууны зааг үе. Ойрадын угсаатны зүй. 2 боть. эрхэлсэн С.Бадамхатан. УБ., 1996. 437 хууд.
54. Монгол улсын угсаатны зүй. XIX-XX зууны зааг үе. Буриад, Барга, Үзэмчин, Дарьганга, Хотон, Тува-цаатан, Тува-малчин, Хамниган ястнуудын угсаатны зүй. 3 боть. Эрхэлсэн С.Бадамхатан. УБ. 1996. 386 хууд.

55. Монголын уран зохиолын тойм. Хоёрдугаар дэвтэр. (XYII-XYIII зууны үе) ШУАХ. УБ. 1976. 670 хууд.
56. (Мансан) Mongγol-un niγuca tobciyan. Sin-e-ber orciγulju tayilburilaγsan Mansang. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1985. 492 niγur.
57. Монголын нууц товчооны 750 жилийн ойд зориулсан олон улсын бага хурал. 1. УБ. 1995. 307 хууд.
58. Mongγol-un niγuca tobciyan-u sudulγan. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1991. 737 niγur.
59. Монгол ардын үлгэр. Д.Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УХГ. УБ. 1982. 343 хууд
60. Монгол домог. Эмхэтгэн боловсруулж удиртгал тайлбар бичсэн Х.Сампилдэндэв. УХГ. УБ. 1984. 238 хууд
61. Монгол цэцэн үгийн далай. Ж.Дашдорж, Г.Рэнчинсамбуу нар удиртгал бичиж, эмхэтгэн хэвлүүлэв. Studia Folclorica. Tom II-I ШУАХ. УБ. 1964. 133 хууд.
62. Монгол цэцэн үгийн далай. (Ж.Дашдорж) Studia Folclorica. Tom Y-II, ШУАХ. 1966. 140 хууд.
63. Монголын нууц товчоо. Удиртгал бичиж хэвлүүлсэн Ц.Дамдинсүрэн. УХГ. УБ. 1976. 239 хууд.
64. Монгол ёс заншлын их тайлбар толь. (Зохиогч эмхтгэгч Ч.Арьяасүрэн, Х.Нямбуу) "Сүүлэнхүү" ХХГ. УБ. 1992. 927 хууд.
65. Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал (түүхэн найруулал) УХГ. УБ. 1978, 436 хууд.
66. Нямбуу Х. Монголын бэлэгдэл. УХГ. УБ. 1979. 109 хууд.
67. Нямбуу Х. Өнөөгийн монгол ёс. ШУАХ. УБ. 1976. 238 хууд.
68. Нямбуу Х. Хүндлэхийн дээд Хөх Монголын төрийн ёсон. "Алтан үсэгт" ХК. УБ. 1992. 155 хууд.
69. Пэрлээ Х. Хятан нар тэдний монголчуудтай холбогдсон нь УХ. УБ. 1959. 116 хууд.
70. Пэрлээ. Гурван өгүүлэл. Studia Mongolica Instituti Linguae et Litterarum ... Tom. III, Fasc. 13-15 ШУАХ. УБ. 1962. 47 хууд.
71. Rasipungcuγ. Bolur erike.öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a 1985. 952 niγur.

72. Ринчен. Монгол бичгийн хэлний зүй. Тэргүүн дэвтэр. ШУАХ. УБ.1964. 245 хууд.
73. Saγang secen. Erdeni-yin tobciy-a.ündüsün-ü keblel-ün qoriy-a 1987, 494 niγur.
74. Sayisiyal jokiyaba Cinggis gaγan-u tobciyan. öbür monggol-un arad-un keblel-ün qoriy-a 1987. 1377 nigur.
75. Сампилдэндэв Х. Монгол хуримын яруу найргийн төрөл зүйл. УБ. 1981. 150 хууд.
76. Сампилдэндэв Х. Малчин ардын зан үйлийн уламжлал. УХГ. УБ. 1985. 190 хууд.
77. Сумъяабаатар Б. Монгол Солонгос туургатны угсаа гарал, хэлний холбооны асуудалд. ШУАХ. УБ. 1975.
78. Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг: Хүннү нарын аж ахуй, нийгмийн байгуулал, соёл угсаа гарвал /МЭӨ IY-МЭ II зуун/ ШУАХ. УБ. 1980. 288 хууд.
79. Сүхбаатар Г. Монгол Нирун улс. /330 орчим-555 он/ Шинжлэх ухааны хэвлэлийн "Эрдэм" пүүс. УБ. 1992. 278 хууд
80. Secengcoγtu. Mongγol-üges-ün ijaγur-un toli. öbür mongγol-un arad-un keblel-un qoriy-a. Kökeqota. 1988. 1205 niγur.
81. Сэр-Оджав Н. Эртний Түрэгүүд /YI-YIII зуун/ ШУАХ. УБ. 1970. 115 хууд.
82. Түдэв Л. Монголын уран зохиолын үндэсний болоод нийтлэг шинж. УХГ. УБ. 1975. 186 хууд.
83. Халх ардын тууль. Хэвлэлд бэлтгэсэн С.Лувсанвандан, У.Загдсүрэн, Д.Цэдэв, Ж.Цолоо. ШУАХ. УБ. 1967. 253 хууд.
84. Халх ардын тууль. Р.Нарантуяа эмхэтгэж, удиртгал тайлбар бичив. УХГ. УБ. 1991. 172 хууд.
85. Хандсүрэн Цэндийн. Цэнд гүн ба Монголын нууц товчоо. УБ. 1996. 646 хууд.
86. Kesigbatu-yin orciγulaγsan juwan ulus-un niγuca tobciyan. Terigün noyan-u ordun-a darumal-un γajar (CiγulultuqaγulY-a) 1940-1941
87. Kesigtoγtaqu. Mongγol-un erten-ü utY-a jokiyal-un sudulul. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. 1988. 487 niγur.

88. Хорлоо П. Монгол ардын ерөөл. ШУАХ. УБ. 1969. 92 хууд.
89. Хорлоо П. Ард түмэн аман зохиол. УБ. 1987. 192 хууд.
90. Хүрэлбаатар Л. Сонгодог уламжлал, монгол яруу найраг. УХГ. УБ. 1989. 119 хууд.
91. Хүрэлбаатар Лхамсүрэнгийн. Судар шаштирын билиг. "Интерпресс" хэвлэлийн компани. УБ. 2002. 471 хууд
92. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УХХЭХ. УБ. 1966, 911 хууд.
93. Цэдэв. Д Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. ШУАХ. УБ., 1973. 168 хууд.
94. Цэрэнсодном Д. Монгол уран зохиол. /XIII-XX зууны эх/ БНМАУ Ардын Боловсролын Яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар.УБ. 1987. 438 хууд.
95. Cerinsodnam Dalangtai-yin. Mongγol-un niγuca tobciyan-u orciγulY-a tayilburi. ündüsün-ü keblel-ün qoriy-a. 1993 543 niγur.
96. Cang cun bumbu. Baraγunsijorciγsantemdeglel. öbür mongγol-un soyul-un keblel-ün qoriy-a. UlaγanqadaL 1993. 194 niγur.
97. Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон. ШУАХ. УБ. 1991. 170 хууд.
98. Sagja Mongγol üsüg-ün dürim-ün toli bicig. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriy-a. 1960. 920 niγur.
99. Эрийн сайн Хан Харангуй. Нэгтгэсэн эх. Гар бичмэл эхүүдийг харьцуулан боловсруулж, оршил бичиж, тайлбар үйлдсэн Р.Нарантуяа. БНМАУ Ардын Боловсролын Яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. УБ. 1986. 85 хууд.
100. Eldengtei, Ardajab seyiregülün tayilburilaba, Mongγol-un niγuca tobciyan seyiregülül tayilburi. öbür mongγol-un surγan kümüjül-ün keblel-ün qoriy-a 1986. 1044 niγur.
101. Eldengtei, Oyundalai nar-un ariγutγan sigügsen debter. Mongγol-un niγuca tobciyan. Kökeqota. 1980. 1083 niγur.
102. Eldengtei, Oyundalai, Asaraltu. Mongüvol-un niγuca tobciyan-u jarim üges-ün tayilburi. ündüsün-ü keblel-ün qoriy-a. 1991. 564 niγur

Хоёр. Гадаад хэлээр гарсан сурвалж бичиг, судалгааны зохиол.

А. Орос хэлээр

1. Алексеев Н.А. Ранние формы религии тюркоязычных народов. Сибири. Новосибирск. Наука. 1980. 315 с.
3. Балданжапов П.Б. Altan tobci-монгольская летопись XYIII в Улан-Удэ. 1970. 413 с
4. Банзаров Д. Черная вера или шаманство у монголов. -Собр. соч., М., 1955, стр. 48-100
5. Барт Ролан. Избранные работы (семиотика поэтика) пер. с франц. М.1994.615 с
6. Большая Советская энциклопедия. Третье издание. 23. М. Сов. энцикл. 1976. стр. 386-388
7. Владимирцов Б.Я. Общественный строй Монголов. Монгольский кочевой феодализм. Л., 1934, 207 с.
8. Викторова Л. Монголы: Происхождение народа и истоки культуры. Наука. М 1980. 224 с.
9. Генон Рене. Символы священной науки.пер.с.франц. Ника Тирос. Беловодье.М.2002.494 с
11. Герасимович Л.К. Фольклорные традиции в литературе Монгольской народной республики. Национальные традиции и генезис социалистического реализма. М. 1965. стр 655-656.
12. Гумилев Л.Н. Этногенез и биосфера земли. 2-е издание, исправленное и дополненное. Л. 1989. 495 с.
13. Дамдинсурэн Ц. Исторические корни Гэсэриады. М. Изд. АН СССР. 1957. 228 с.
14. Дамдинсурэн Ц. Рамаяна В Монголии. Наука. М. 1979. 216 с.
15. Джангар /Калмыцкий народный эпос/. Перевод С.Липкина. Калм. кн. изд. Элиста. 1989. 365 с.
16. Еренсей (Подготовка текста, перевод и примечания М.П. Хомонова) Улан-Удэ. 1968. с. 204.

17. Жуковская Н.Л. Категории и символика традиционной культуры монголов. Наука. М. 1988. 195 с.
18. Кафаров Палладий. Старинное монгольское сказание о Чингисхане. Труды членов Российской духовной миссии в Пекине. Том IY. 1866. Санктпетербург.
19. Кичиков А.Ш. Героический эпос "Джангар" (сравнительно-типологическое исследование памятника) Изд. 2-е Наука.М. 1994, 319 р.
20. Козин С.А. Сокровенное сказание. Монгольская хроника 1240 г под названием Mongγol-un niγuca tobciyan. Юэнь чао би ши-монгольский обыденный изборник. Том 1 М-Л., 1941.
21. Козин С.А. Эпическая символика в русском и монгольском эпическом творчестве. -АВ. Разряд 1. оп. 3, 52.
22. Лосев А.Ф. Античная мифология: в её историческом развитии Гос.уч.пед.изд. М.1957. 367 с.
23. Лосев А.Ф. Проблема символа и реалистическое искусство. Искусство. М.1976. 367 с.
24. Лубсанданзан. Алтан тобчи /"Золотое сказание"/. Пер. с монг. введ. коммент. прил. Н.Н. Шастиной. Наука. М. 1973.439 с
25. Льюис Джеймс.Р. Энциклопедия сновидений. пер.с англ. Серия "Энциклопедии". Ростов-на- Дону. "Феникс" 1997. 336 с
26. Маковский М.М.Сравнительный словарь мифологической символики в индоевропейских языках. Образ мира и миры образов. "Гуманитарный издательский центр Владос" М.415 с
27. Манжигеев И.А. Бурятские шаманистические и дошаманистические термины: Опыт атеист. интерпретации, Наука. М. 1978. 127 с.
28. Мелетинский Е.М. Поэтика мифа. Наука. М. 1976, 407 с.
29. Мелетинский Е.М. Время мифическое.-Мифы народов мира. 2, М. 1980. стр.252-253.
30. (Мелёхин А.В. Ярославцев Г.Б.) Сокровенное сказание монголов. Пер. А.В.Мелёхина и Г.Б. Ярословцева. Вступ. статья С.Дулам. Изд. "Сталкер" 2001. 255 с.

31. Митиров А.Г. О цветовой семантике орнамента монгольских народов. В кн: "Этнография и фольклор монгольских народов". Элиста, 1981, стр. 90-100.
32. Мифологический словарь. Гл. ред. Е.М.Мелитинский. Сов. энцикл. М.1991. 736 с
33. Мифы народов мира: Энциклопедия. в 2-х т. Гл. Ред. С.А.Токарев. М., Сов. энцикл. т.I, А-К 1980, 672 с, т.II, К-Я, 1982, 718 с.
34. Михайлов Г.И. Литературное наследство монголов. Наука. М. 1969, 174 с.
35. Михайлов Т.М. Из истории бурятского шаманизма: /С древнейших времен до XYIII в/. Наука. Новосибирск. 1980. 320 с.
36. Mongolica. К 750-летию "Сокровенного сказания". Наука. М.1993. 241 с.
37. Мэн-да Бэй-лү /"Полное описание монголо-татар"/ Памятники письменности Востока. XXYI. Факсимиле ксилографа п. с китайского, введ. ком. и прилож. Н.Ц.Мункуева. Наука. М., 1975
38. Неклюдов С.Ю. Героический эпос монгольских народов. Устные и литературные традиций. Отв. ред. Е.М.Мелетинский. Глав ред-ция вост. лит-ры. М.1984, 308 с.
39. Неклюдов С.Ю. О функционально-семантической природе знака в повествовательном фольклоре. Семиотика и художественное творчество. М. 1977.
40. Поппе Н.Н. Халха-монгольский героический эпос. Труды инст-та востоковедения XXYI Изд. АН СССР.М-Л. 1937. 125 с
41. Поппе Н.Н. Монгольский словарь Мукаддимат Ал-Адаб. ч. I-II. Труды инст-та востоковедения XIY. Изд. АН СССР. М-Л.1938, 566 с.
42. Рашид-ад-дин. Сборник летописей. Том 1. пер.с персидского Л.А.Хетагурова. Изд. АН СССР. М.-Л., 1952,
43.Рашид-ад-дин. Сборник летописей. Том II, пер. с персидского Ю.П.Верховского. Изд. АН СССР, М-Л.,1960. 221-248 с
44.Ринчен Б. Из нашего культурного наследия /Сборник статей/ УБ. 1958, 171 с
45. Санжеев Г.Д. Дархатский говор и фольклор. Изд. АН СССР, Л. 1931, 112 с.
46. Словарь литературоведческих терминов. Ред-сос. Л.И. Тимофеев и С.В.Тураев. Просвещение. М. 1974. 506 с.
47. Специфика жанров в литературах центральной и восточной Азии (Современность и классическое наследие) Наука. М. 259 р.
48. Теория литературы: основные проблемы в историческом освещении. В 3-х т. Образ, метод, характер. т.I. Изд. АН СССР, М.1962, 452 с.
49.Тресиддер Джек. Словарь символов. пер с.англ. С. Палько. Фаир-пресс.М.2001. 444 с
50. Тэйлор Э. Первобытная культура. пер. с англ., под ред., с предисл. и примеч. проф. В.К.Никольского. Соцэкгиз, М.1939, 567 с.
51. Фрейд З.Введение в психоанализ. лекции. Изд. подготовил М.Г.Ярошевский. Наука. М. 1989, 759 с
52. Фрейд Зигмунд. Толкование сновидений. Пер.с.нем. Попурри. Минск. 2000. 574 с
53. Фрэзер Д.Д. Золотая ветвь. Исследование магии и религии. Пер.с.англ. М.К.Рыклина. Редакция, Послесловие и комментарий проф. С.А.Токарева. Политиздат М.1980. 831 с
54. Цултэм Н. Искусство Монголии: с древнейших времен до начала XX века. Изобраз. Иск-во, М. 1984, 259 с.
55. Цыбиков Г. Избранные труды. Т.I II Новосибирск, 1981, 239 с.
56. Шара Туджи: Монгольская летопись XYII в. Свод.текст, пер., введ., примеч., Н.П.Шастиной. Изд. АН СССР. М-Л. 1957. 298 с
57.Шейнина. Е.Я.Энциклопедия символов. Изд. "Торсинг" М.

2002. 591 с.
58. Юнг Густав Карл. Архетип и символ. Серия "Страницы мировой философии" Ренессанс. С.П. "Иво-Сид" М. 1991.286 с.
59. Юнг Густав Карл. Воспоминания, сновидения, размышления Классики зарубежний психологии. "Изд. АСТ-ЛТД", Львов-Москва. 1998. 447 с.
60. Энциклопедия символов, знаков, эмблем. Автори-составители В.Андреева, В.Куклев, А.Ровнер. Изд. Локид-Миф. М.1999.
61. Энциклопедия китайских символов (Восточный символизм) Сос.К.А. Вильямс. Серия "Символы". Книга VI. Изд. В.П.Царёва. М. 2000. 424 с

Б. Бусад хэлээр

1. Altan tobci-(Hans-Peter Vietze, Gendeng Lubsang) Fine mongolische Chronik des XVII. jahrhunderts von BLO bzan bstan'jin. Text und Index Tokyo. 1992. 278 p.
2. Becker Ubo. The continuum encyclopedia of Symbols. Translated by Lance W.Garimer. Continuum. New York. London. 2000.345 p
3. Biedermann Hans. Dictionary of symbolism. Translated by James Hulbert. Meridian book. 1994.465 p
4. (Cirlot) A dictionary of symbols. Second edition. by J.E. Cirlot. transleted from the Spanish by Jack Sage Routledge & Kegan Paul Ltd. London and Henlgy 1971. 419 p.
5. (Cleaves) The Secret History of the Mongols. Translated and edited F.W.Cleaves. London 1982.
6. Haenisch E. Mangqol-un niuca tobca'an, Die Geheime Geschichte der mongolen. Leipzig, 1937, 141 p
7. Hamayon R. Tricks and Turns of legitimate Perpetuation or Taking the Buryat Uliger Literally, as "Model"-Fragen der mongolischen Heidendichtung 1981 230 p
8. Hamayon R. Tricks and Turns of Legitimate Perpetuation /11/-Fragen der mongolischen Heldendichtung 1982
9. Humhrey Caroline with Urgenge Onon. Sham ans and Elders Experence, kaawlenge, and Power among the Daur Mongols. Oxford unibersity Press. New York. 1966. 396 p
10. Heissig W. Ein innermongolisches Gebet zum "Ewigen Himmel," Zentralasiatische studien, 1974, No 8, Wiesbaden, S. 524-561
11. Heissig W. Geschichte der Mongolischen Literatur. Bond I, II. Wiesbaden. 1972, 969 s
12. Heissig W. Mongolische Volksreligiose und Folkloristische Texte aus europaischen Bilbiotheken, Wiesbaden, (Steiner), 1966, 256 s.c
13. Tsedev Dojoogiin. Монгол ардын аман зохиол болон бичгийн уран зохиол дахь ид шид, зөн совингийн тухайд /Монгол ардын баатарлаг туульс, "Монголын нууц товчоо"-ны харилцаа холбооны асуудалд/ япон хэлээр орчуулсан Kazuyuki Okada. Area and Culture studies, Tokyo university of Foreign studies. 1993, No 47, pp. 89-108
14. Tsedev Dojoogiin. "Монголын нууц товчоо"-ны тооны утга бэлгэдлийн асуудалд /япон хэлээр орчуулсан Kazuyuki Okada/ Area and Culture studies. Tokyo university of Foreign studies. 1994, No 49, pp. 51-81
15. Jagcid secin (Sechin Jagchid) Mongγol-un niγuca lobciyan. Taipei. 1979.
16. Kaluzynski Stanislaw. Tajna hisloria Mongolow. Anonimowa kronika mongolska z T111 w. Warszawa PIW.1970.
17. Kuribayashi H. Philological study of the Mongolian version of Geser-Khan Epic. Tokyo. 1994, 545 p.
18. Ligeti L. Histoirie secrete des mongols. Monumenta linguae mongolicae collecta I- Budapest, Akademiai Kiado. 1971. 268 c
19. Lörincz L. Die mongolische mytholgie-Acta Oruentalia Hung., Budapest. 1972. t 27. Pasc. I p 103-126
20. Miller.G.H.The dictionary of dreams 10.000 dreams interpreted. New York. 1992.617 p
21. Озава Шигэо. Монголын нууц товчооны бүрэн тайлбар.

(Дээд, дунд, доод дэвтэр, Япон хэлээр) Казамашобоо, Токио. 1984, 1985,1987.
22. Озава Шигэо."Монголын нууц товчоо"-ны бүрэн тайлбарын үргэлжлэл (Дээд, дунд, доод дэвтэр, Япон хэлээр) Казамашобоо, Токио, 1987, 1988, 1989.
23. Paul Pelliot. Histoire secrete des Mongols Restitution du texte mongol et traduction francaise des chapitres I A vi. Paris, 1949
24. Rachewiltz I. Index to the Secret history of the mongols. Bloomington, Indiana University, 1971, 347 p.
25. Rintchen B. Folklore mongol, Wiesbaden Otto verleg Harrassowits, 1965, Livre 4, Bd. 15, 325 p
43. Sagaster K. Das mongolische Epos Khuwei Buidar khu. Eine symbolkundliche Untersuchung.-CAJ.Vol. No 3-4 1977
44. Sagaster K. On the Symbolism in the Mongolian Geser Epic.-Third International Congrees of Mongolists. 1977
45. Sagaster K. Zur Zahlensymbolik im mongolischen Epos.-Fragen der mongolischer Heldendichtung 1981

SUMMARY

Although "The Secret History of the Mongols", a wonderful literary monument of the 12th and 13th centuries which clearly and skillfully expresses the spiritual ability and power of the Mongols has been studied by the scholars of many countries of the world. One of its deep researches was to study it from the pointview of symbolism in "The Secret History of the Mongols". A special attention is given to the establishment of the sphere of the cultural and historical conditions of symbolism. This is very comprehensive study of all the varieties of the symbolism found in the book. The wide involvement of the biosphere, the main cycle of human life and social relations in the symbolism of "The Secret History of the Mongols" is the context, content, and skillful representation of the work. Symbolism can contain many aspects of many periods, therefore it does not have identical features. The change in symbolism can occur in connection with the time period, including the new traditional ideas. So it left its trace in human customs and was preserved in future sources and works. It proves its ability to live for long time. Thus "The Secret History of the Mongols" absorbed the best parts of the symbolism, widely used in the oral and written literature and combined them with the new aspects of the particular time period. It showed the example of the link of traditions to each other. However, according to the work , the symbolism is not a single established model and may have many possible interpretations and variations. So the following conclusion can be made concerning symbolism and its expression of the meaning in "The Secret History of the Mongols".

1.Every number is an independent unit, containing a certain significance and meaning. Its connection with the related number was expressed in a simple formula "the substraction and division form of 9 is 3 and the addition and multiplication form of 3 is 9". When the repetition is made by the reduction and increase of possible numbers, the unit is changed out, but its basic meaning is preserved and is enriched

with a new content. The close association of the double meaning of the numbers to cultural traditions can be used symbolically to express their aspect of a certain time-period to some extent. There is a connection between the general feature and distinctive peculiarity of the number and its symbolism.

2.The understanding of "Tav" (five) from "Tavan Mus" (Five arrows), "Tavan kuruu" (Five fingers) and "Gal" (Fire), not depending on the attribute of number, the understanding of "Tsagaan" (White) and "Suu" (Milk) from the words "Kok" (Breast), "Kokson" (Suckled on the breast) and "Kokood" (Suckling on the breast) and the meaning "Kok" (blue) from the words "Monkh Tenger" (Eternal Heaven), "Deed Tenger" (High Tenger) show that the absorption of the symbolism (number and colour etc) in words and phrases according to the conditions of certain time-periods becomes a tradition in life.

3.The colour shows not only a colour, but also its significance. For example, white colour was the symbol of respect and cleaniness, black was the symbol of cruelty and might and blue was the symbol of the sky. These are the predominating features of the colours, but other aspects and significances can be expressed. Therefore the mix of pure colour with the aspect of the sinful and meritorious worlds and the internal depth of the human heart is the harmony of one and many aspects of symbolism.

4.Intuition is a foreseeing of fate and an expression of vigilance and warning given through it. The examples in "The Secret History of the Mongols " show that we can discover a deep understanding of intuition and a correct explanation of dreams including a recognition of the secret of harmony between man and nature and an understanding of inner human thought


Besides the expression of a single meaning, the combination of the double thought and the absorption of the content of a symbol into each other as well as the connection of the sense of one or two symbols to another are special feature of the symbolism. The complex symbolism of many types and several mini-symbols in one type enables

us to consider "The Secret History of the Mongols", as comprised of many units interconnected and joining a unity like a symphony orchestra. In this book there are many different symbols related to clothing. The clothes of the Mongols contain deep symbolism associated with their separate items including the hat and pouch, colour, purpose and type of usage (daily wear, complete outfit, age, sex, rank, costume as a gift). Thus, it like all the categories of symbolism, consists of individual units combined into a whole. The skilful representation of allegory, allusion, substitution in "The Secret History of the Mongols" is deeply connected to the symbolism for the concealment and transference of meaning. The secret of the work , the deposit of word treasure can not be opened, fully analyzed and summed up. So the detailed research of the open and secret meanings and the network of the symbolism of the words and phrases of the individual units of the work is one of the important issues in the research of "The Secret History of the Mongols". It is clear from the symbolism of "The Secret History of the Mongols" and its research that it has fused many types of meanings and culture, based on the rich tradition of the thought of the Mongols. It is connected to the deep expression of each category, complex and ensemble of the symbolism of the work and the relation of yin and yang. The symbolism shown in the relation between yin and yang, differences and connections of the word and its expression of symbol is a clear example of the sphere of the spiritual culture of the Mongols, demonstrating the high quality level of the historiography of the 12 and 13th centuries. The value and significance of "The Secret History of the Mongols " are its penetration into the inner secret of the heart of the tribes of the time of the establishment of united power of Mongolia of the 12th and 13th centuries and their representation. The research, based on the symbolism of "The Secret History of the Mongols" is a good test of the methodology of the research of a work and source from the symbolic point of view. It is a beginning in the expanding research of Mongolian symbolism as a model for research in other literature. The research of the symbolism of "The Secret History

of the Mongols " is a source to establish original Mongolian folk symbolism as well as a source to compare with symbolism of other nations related to Mongolian history and culture. Mongolia consisted of many tribes and khaganates. So symbolism contained all their customs. I consider that if researchers study the symbolism, connecting to the related customs of the other people who had cultural relationship with Mongolia, in particular the Asians, it will be a new contribution to the study of symbolism. A new aspect of the work is an effort to make a conclusion on the basis of "The Secret History of the Mongols" itself, rather than using theoretical comparative model. The second new aspect of the work is an endeavor to penetrate into the depths of thinking on the basis of the life and traditional customs and to present Mongolian conceptions of symbolism. The third new aspect of the work is an attention to the traditions of symbolism itself and its research and an attempt to prove it by rich examples. The fourth new aspect of the work is the involvement of some materials of the oral and written literature, which were not known before. In conclusion, the new aspect of the work is the first research of the symbolism in the framework of the monograph, based on a certain literary work, namely "The Secret History of the Mongols".

ХАВСРАЛТ-НЭГ

"ЭРДЭМТЭН МЭРГЭДИЙН БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ ОРШИБАЙ"



БНМАУ-ын Боловсролын сайдын 1990 оны 383, 1991 оны 97, 313 тоот шийдвэр, БНМАУ-ын Шинжлэх ухааны Академийн ерөнхийлөгчийн 1991 оны 238 тоот тушаалаар Д.Цэдэв нь докторантурт горилогчоор батлагдсан юм. Түүний дотроос БНМАУ-ын Шинжлэх ухааны Академийн ерөнхийлөгчийн 1991 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 238 тоот тушаалын хавсралт болох "1991-1992 оны хичээлийн жилд докторантур, аспирантурт суралцах хүмүүсийн жагсаалт"-ын "Докторант /горилогчоор/"-ийн 11 дүгээрт "Дожоогийн Цэдэв - Урлаг судлалын хүрээлэн" гэсэн байж билээ.

Чухам ингэж албан ёсоор докторантурт горилогчоор батлагдсанаас хойш Д.Цэдэв "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл сэдэвт бүтээлээ туурвин дуусгаж, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монгол улсын их сургуулийн Монгол судлалын дээд сургууль, Улсын багшийн их сургуулийн Монгол хэл, утга зохиолын факультет, МУИС-ийн Сэтгэл судлалын танхимын хамтарсан - "Утга зохиолын их семинар" -аар 1997 оны 1 дүгээр сарын 25-нд, Монголын Соёл урлагийн их сургуулийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний зөвлөлийн хурлаар 1997 оны 5 сарын 9-нд, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн утга зохиолын салбарын хурлаар 1997 оны 5 дугаар сарын 13-нд тус тус хэлэлцүүлжээ. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хуралд 1997 оны 5 дугаар сарын 13-нд Д.Цэдэв урьдчилсан хамгаалалт хийж жинхэнэ хамгаалалтын хугацааг товлуулж, шүүмжлэгч байгууллага болон албан ёсны шүүмжлэгчдээ тодруулсан ажээ. Д.Цэдэвийн "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл зохиолыг ингэж шат дараалан хэлэлцэж эрдэмтэн мэргэд санал бодлоо өргөнөөр, ажил хэрэгчээр гаргасанд тэдгээр хурлын үнэ цэнэ оршино. Эдгээр нь зөвхөн зэрэг горилогчид хамаарахын зэрэгцээ "Монголын нууц товчоо"-ны судалгаанд, түүний дотор бэлгэдлийн асуудалд холбогдоно. Үүгээрээ эрдэмтэн мэргэдийн асуусан, хариулсан, ярьсан бүхэн нь судалгааны чиглэл, арга зүйд хамаарч байгаа юм. Энэ бүхний

дотроос ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, тогтоол, шүүн хэлэлцэгч, ном айлдагч мэргэдийн асуулт, бодол, хэлсэн үг тэргүүтнийг энэ удаад хэвлэлд бэлтгэв. Үүний дээр Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлийн хурлын товлосон өдөртэй цаг хугацааны хувьд зөрөх Монголын Соёл урлагийн их сургуулийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний зөвлөлийн хурлаар хэлэлцсэнтэй холбогдуулан Б.Сумьяагийн бичсэн санал бодол, Монгол улсын Эрдмийн зэрэг цол олгох дээд зөвлөлийн хурлаар хэлэлцэхтэй уялдаж түүний шийдвэрийн дагууд бичсэн Ж.Цолоогийн шүүмж нэмж орж байгаа болно. Уг нь энэ хоёр санал шүүмж Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлийн хурлын баримт бичгийн өмнө нэг нь , хойно нөгөө нь ормоор боловч цаад утга учрыг бодож Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлийн хурлын тогтоолын урьд нэмж хамтад оруулсныг уламжлан тайлбарлаж байна.

Д.Цэдэвийн хэлбичгийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалсантай холбогдсон бүхий л баримт хэрэглэгдэхүүнийг Монгол улсын эрдмийн зэрэг цол олгох дээд зөвлөлд хүлээн авч 1997 оны 8 дугаар сарын 6-ны өдлжит хуралдаанаараа хэлэлцэж түүнд шинжлэх ухааны докторын зэргийг (Шинжлэх ухааны докторын диплом. 1997.VIII.6. № 97394) хүртээсэн юм.

Д.Цэдэвийн "Монголын нууц товчоо"-ны бэлгэдэл сэдвээр хэл бичгийн ухааны докторын зэрэг хамгаалсан ийм нэгэн түүхийн бяцхан хуудас "Эрдэмтэн мэргэдийн бодол эрэгцүүлэл оршибай" хавсралт нэгд орсон болой.

ШУА-ИЙН ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДМИЙН ЗЭРЭГ ХАМГААЛАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ПРОТОКОЛ

Дожоо овогтой Цэдэвийн "Монголын нууц товчооны бэлгэдэл" сэдэвт хэлбичгийн ухааны докторын зэрэг горилсон бүтээлийг хэлэлцсэн тухай

Эрдмийн зэрэг хамгаалах зөвлөлийн хурал 1997 оны 7 дугаар сарын 4-ний 14 цаг 20 минутад хүрээлэнгийн нэгдсэн байрын 410-р өрөөнд эхлэв.

Хурлыг доктор Д.Төмөртогоо нээлээ. Эрдмийн зэрэг цол олгох улсын комиссоос ирүүлсэн хурал явуулах зөвшөөрлийг эрдмийн зэрэг хамгаалах эрдмийн зөвлөлийн гишүүн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга О.Сүхбаатар уншиж сонсгов.

Уг зөвшөөрлийн бичигт, хурлын даргаар доктор Д.Төмөртогоог, эрдэмтэн нарийн бичгийн даргаар дэд доктор О.Сүхбаатар нарыг ажиллуулахыг зөвшөөрчээ. Хурлын дарга доктор Д.Төмөртогоо эрдмийн зөвлөлийн гишүүдийн ирцийг танилцуулж хурлыг нээлээ.

О.Сүхбаатар Хэл бичгийн ухааны докторын зэрэг горилогч Д.Цэдэвийн холбогдол бүхий материалуудыг уншиж танилцууллаа. Материалуудтай холбогдсон асуулт гарсангүй. Асуултыг нээлттэй орхилоо.

Дараа нь горилогч Д.Цэдэв ганц сэдэвт зохиолынхоо талаар илтгэл тавив. Илтгэлд урьдчилсан хамгаалалтын үеэр гарсан санал шүүмжлэл, зөвлөлгөөний дагуу хийсэн ажлаа оруулж тайлагнасан болно.

Албан ёсны шүүмжлэгч байгууллага МУИС-ийн саналыг МУИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн багш доктор С.Дулам уншиж танилцуулав.(Материалыг хавсаргав.)

Д.Цэдэв хариу үг хэлэв.

Албан ёсны шүүмжлэгч Хэлбичгийн ухааны доктор Д.Цэрэнсодном үг хэлэв. /Материалыг хавсаргав/

Д.Цэдэв хариу үг хэлэв.

Албан ёсны шүүмжлэгч Хэлбичгийн ухааны доктор Б.Сумъяабаатар үг хэлэв. /Материалыг хавсаргав/.

Д.Цэдэв хариу үг хэлэв.

Албан ёсны шүүмжлэгч Японы монголч эрдэмтэн доктор, профессор Ш.Озавагийн саналыг О.Сүхбаатар уншиж сонсгов. Мөн Токиогийн гадаад судлалын их сургуулийн багш Хасуми Харуо, Буриадын их сургуулийн профессор Сергей Чагдуров нарын саналыг уншиж сонсгов. (Материалыг хавсаргав.)

Дараа нь асуулт хариулт эхлэв.

Асуулт: Хэл бичгийн ухааны доктор Л.ХҮРЭЛБААТАР:

1-рт: Бэлгэдлийг үндсэн ай төрөл болгожээ. Энд Жуковская, Тангад, Катуу, Дулам гэх мэт хүмүүсийн ангилсан ангиллыг дурьджээ. Ер нь бэлгэдлийг айгаар ангилах нь арга зүйн хувьд зөв гэж үзэж байна уу?

2-рт: 10-р хуудсанд Алангоо гэрлээр жирэмсэлсэн нь угтаа Бурхан багшийн мэндэлсэн тухай домгийн монгол хувилбар гэж үзсэн Гүнжийн Сүхбаатарын саналыг зөвшөөрч байна уу?

Хариулт: Д.ЦЭДЭВ:

1-рт: Бэлгэдлийг судалсан эрдэмтэд хэдэн айд хувааж үзсэн зүйл нэлээд байна. Миний хувьд энэ зохиолдоо Монголын уламжлалтай холбогдуулан нэлээд хэдэн зохиолтой харьцуулж үзсэн. Энэ нь тодорхой нэг зохиолын хувьд тохирохгүй учир харьцуулан үзсэний үндсэнд тооны, зөн совингийн, өнгөний айд хуваасан. Учир нь бусад бэлгэдлийг эдгээрийн төвшинд авч үзэхэд учир дутагдалтай байсан. Өөрөөр хэлбэл миний хайсан бэлгэдэл олдохгүй байлаа. Уг зүйлийг тогтолцоотой болгохын хувьд айд хувааж үзсэн болов уу гэж би санана.

2-рт: Алангоогийн гэрлээр жирэмсэлдэг тухай 3 эрдэмтний саналыг диссертацид зэрэгцүүлэн үзсэн юм. Бурхан багшийн төрж мэндэлсний монгол хувилбар гэсэн Сүхбаатарын санал, домог зүйтэй холбогдуулсан Д.Цэрэнсодномын санал, үүнийг бөөгийн

ёстой холбогдуулсан С.Дулам гурвын саналыг зэрэгцүүлэн үзэв. Тэгээд "Ямар ч л байсан гэсэн жинхэнэ монгол ардын язгуур үзэл санаа, бөө мөргөлийн хувьд, ийм жишээ их олон гарвал гадаад нөлөөнөөс илүүтэй зүйл монголын жишээ баримттай холбовол дээр юм" гэсэн саналыг би тавьсан юм.

Асуулт: Ц.ӨНӨРБАЯН /УБИС/:

1-рт: Бэлгэдэл гэдгийн шалгуур юу юм бэ? Өнгөний бэлгэдэл, тооны бэлгэдэл гэх мэт. Бэлгэдэл гэдгийг шалгуур болгон авахдаа тохиолдлын шинж чанартай дүйж байгаа юм уу? эсвэл сайны бэлгэдэл хэд давтагдав, эсвэл ямар давтамжаар бэлгэдэж байна. Жишээ нь: Монголын нууц товчоонд 8 гэсэн тоо жинхэнэ бодит байдал 8 гэсэн тоогоор эсвэл 8 шарга гэсэн давтамжаар авч үзэхэд давтамжийг харж үзэхэд хичнээн давтагдаж байна вэ?

2-рт: Бэлгэдэл гэдэг ухагдахуун тэр үеийн бөөгийн мөргөлийн сэтгэлгээний бөөгийн гүн ухааны ухагдахуун, тэр үеийн МНТ-г бичиж байх үеийн монголчуудын сэтгэлгээний төвшин, бэлгэдэл 3-ыг ялгаж өгсөн шалгуур байна уу? Бөө мөргөлийн гүн ухааны суурь ухагдахуун байж болох юмыг бэлгэдлээр үзүүлсэн юм уу?

Хариулт: Д.ЦЭДЭВ:

Бэлгэдлийн хувьд эрдэмтэд үзэхдээ гүн ухааны ойлголт шиг хөдлөшгүй тогтвортой чанартай зүйл биш гэдэг. Энэ бол маш хувьсангуй чанартай, өнгө аястай олон сүлжээтэй, харьцангуй учраас энэ ойлголтыг тогтоон тодорхойлоход бэрхшээлтэй юм. Энэ бүхэнтэй Өнөрбаянгийн асуусан зүйл холбоотой болов уу. Өнгө, тооны бэлгэдлийн хувьд давтамж их байна. Ялангуяа 3, 9-ийн тооны хувьд их давтамжтай. Гэтэл зарим тооны хувьд алга. Олон цөөн давтамжаас шалтгаалахаасаа уг зүйлийн цаана, илэрхийлээд байгаа зүйлийн цаана тогтолцоот зүйлийг илэрхийлж байгаа зүйлд гол анхаарлаа хандуулах нь зүгээр юм гэж үзсэн. Харин ямар нэг тогтолцооны шинжтэй юм байна. Жишээ нь: 8-ын хувьд Чингист 8 шарга байгаагүй, хулгайд алдсан 8 гэвэл зохимжтой. Чингист 9

морь байсан. 9-ийн зохилдоог би тайлбарласан. Эндээс харахад МНТ-нд 8 гэсэн тооны тодорхой давтамж үгүй юм.

2-рт: Бөөд байдаг, бусад салбарт ч байдаг бэлгэдэл нь бөөгийн хувьд ч, ардын сэтгэлгээний хувьд ч наанаа ямар нэгэн юм үзэгдлийг илэрхийлээд байгаа боловч цаанаа агуулагдаж гүнд хадгалагдаж байгаа утга гэж заавал байдаг. Тиймээс эндээс бөөгийнхийг гэхчлэн салган авч үзье гэх нь хэцүү. Жишээ нь Монгол сэтгэлгээ, бөөгийн сэтгэлгээ хоёрыг зааглан салгана гэвэл яах вэ?

Асуулт: Ц.СҮХБААТАР /МУИС/:

1-рт: Дээр хөх тэнгэр байна. Ард чинь Чингис хаан байна энэ бэлгэдэлтэй холбоотой юу? Чингисийн 9 өрлөг дайн байлдаанд явахад үүнийг байнга хэлдэг. Энэ ямар учиртай юм бэ? Мөн үүнтэй адил хол боловч ойроор сэтгэх гэдэг үгийн учир юу вэ?

2-рт: зуны эхэн сарын шинийн гурван, дөрвөн, таван гэснийг сонирхов уу?

3-рт: Цэдэвийн ажилтай холбоотой гэхэд холбоогүй, холбоогүй гэхэд холбоотой гэх зүйл байна. Монголын зохиолчдын хорооноос 1995, 1996 онд гаргасан 20 боть номын 10 нь зөн, 10 нь совин гэсэн нэртэй цувралууд гарчээ. Энэ нь ганц сэдэвт бүтээлтэй чинь холбоотой юу?

Хариулт: Д.ЦЭДЭВ:

Сүүлчээс нь асуултыг хариулъя. "Зөн", "Совин" цувралын хувьд дадлага туршлагатай хүмүүсийн, шинэ тутам залуусын гэсэн ялагаатай юм билээ. "Зөн", "Совин" цувралын талаар зориуд сонирхоогүй. Номын тухайд гаргасан хүмүүс нь л сайн мэдэх байх. 2-рт. Хол боловч ойроор сэтгэх гэдэг нь доктор Цэрэнсодномын саналд ч байсан байх. Одоогийн бидний ойлголтоор зүйр цэцэн үг хэлц байдалтай. Тухайн үедээ тийм хэмжээнд хүрсэн байсан болов уу? Эсвэл тэр үед анх гарч ирээд дараагийн үедээ зүйр цэцэн үг болоод уламжилсан юм уу. Ийм мэргэн цэцэн, утгыг гүнзгийрүүлж тайлмаар олон хэллэг байгаагийн нэг нь энэ онол бодролын үг байна. Бусад эрдэмтний судалгааг үзээгүйгээр шуудхан тийм ийм утгатай гэж цээжээр тайлбарлахад

бэрхшээлтэй байна. Үүнийг уучлаарай. Хөх тэнгэр гэдгийн хувьд уг диссертацийн гурвын тооны бэлгэдэл, өнгөний бэлгэдэл гэсэн бүлэг хэсэгт нэлээд дэлгэрэнгүй хэлсэн. Үүнд: Бөөгийн мөргөлийн тахилгын тайлга, монгол сэтгэлгээтэй холбогдуулан тайлбарласан. Харин хол боловч ойроор сэтгэх гэдгийг "Уран үгийн дүрийн бэлгэдэл" гэсэн бүлэгт оруулж судлах хэллэгийн жагсаалтад оруулан судална гэж бодож байна.

Асуулт:П.ХОРЛОО:

Нууц товчоонд шим мандлын гол хоёр тулгуур багана ургамал амьтны төлөөлөл тодорхой байр эзэлнэ гэжээ. Энэ юуг хэлээд байна вэ? Үүнээс өөрөөр төлөөлсөн зүйл байдаггүй юм уу?

Хариулт: Д.ЦЭДЭВ:

Тэргүүн бүлэгт шим мандал гэдгийг төлөөлүүлж оруулсан.

Асуулт: П.ХОРЛОО:

Шим мандал гэдгээр ургамал амьтны төлөөлөл гарч байгаа юм уу?

Хариулт: Д.ЦЭДЭВ:

Энд сав ертөнцийг чулуугаар, шим ертөнцийг ургамал, амьтан хоёрт хувааж харуулсан. Амьтныг хэрээ, нохой, могой 3-аар төлөөлүүлсэн.

Асуулт:П.ХОРЛОО:

Хар хэрээ, хар нохой, могой гурвыг заавал сонгосон учир юу вэ?

Хариулт: Д.ЦЭДЭВ:

МНТ-нд нэлээд амьтан гарч байгаа юм. Түүний дотроос би тайлбарлаж болмоор, бэлгэдэлтэй зайлшгүй холбоотой учраас дээрх гурван амьтныг сонгосон. Чоныг авч байгаад тайлбар төдий л олигтой болоогүй учраас хассан болно.

Д.Оюунбадрах /УБИС/ үг хэлэв.

Би уг бүтээлийг сонирхож нилээд анхааралтай уншсан. Болзолт -бэлгэдэлт чанарын тухай судлал хоцрогдож байсан гэдгийг горилогч илтгэлдээ хэллээ. Сүүлийн үед энэ талаар

ажил хийгдсэн болон Катуу, Дулам нарын тухай ч горилогч бас дурджээ. Үүн дээр нэмэгдээд Д.Цэдэвийн хийсэн зүйл юу вэ? гэвэл тодорхой нэг зохиолд бэлгэдлийн асуудлыг гүнзгийрүүлэн судалсан явдал юм. Энэ бол уг зохиолын үнэхээр шинэ тал мөн гэж үзэж байна. Нэг зохиол дээр, тухайлбал МНТ дээр бэлгэдлийг аваад үзэхэд хоёр үндсэн асуудлыг шийдэх ёстой байсан байх. 1-рт: Бэлгэдэл нэг зохиолд ямар янзтай гарч ирдэг юм бэ? Янз бүрээр л гарч ирж байх шиг байна. Дулам нарын хуваасан хувариар нэг зохиол дээр болж өгөхгүй бэрхшээл гарч байх шиг. Болдог юм ч байх шиг.

2-рт: МНТ-ны судлалд бэлгэдлийн талаас би нэг шинэ судалгаа гараад ирж байна. Ийм хоёр үндсэн чухал зүйлийг шийдсэн шинэлэг бүтээл болжээ гэж үзэж байна.

3-рт: Судалгааны хэрэглэгдэхүүн, олон хэл дээр гарсан МНТ-г бас судлаачдын бүтээлийг хооронд нь харьцуулсан нь хангалттай болжээ.

4-рт: МНТ бол нэгэнтэйгүүр монголчуудын зан заншил, түүхийг бичиж байгаа юм болохоор бэлгэдэл яаж тусна вэ? Нөгөөтэйгүүр МНТ бол уран зохиолын дурсгал болохоор уран сайхны дүрээ боловсруулахад бэлгэдлийг яаж ашиглах вэ? гэсэн хоёр асуудлын аль алиныг жишээ баримтаар тодорхой сайн нотолж өгч чадаж үүрэг зорилгоо биелүүлжээ.

5-рт: Авч үзсэн бүлэг, хамарсан хүрээний хувьд зөв сонгон авч, түүн дотроо бусад хүний хэлээгүй сонин сонин зүйлсийг 3, 9-ийн тооны харьцааны асуудал, тоотой холбож 5 хуруу, 5 сумны багц, 5 гал зэргийг өгүүлжээ. Энэ мэтчлэн магтаад байвал олон зүйл байна. Ер нь докторын диссертаци бол нээлт байх ёстой. Энэ бүтээлд олон зүйлийг хамарсан шинэ нээлтүүдийг гаргаж ирснээрээ докторын диссертацийн үүргийг бүрэн дүүрэн биелүүлжээ. Харин илүү үг болгож хоёр зүйлийг хэлье. Үүнд: Нэг талаар хэлэхэд амьтны бэлгэдэлд нохойг сайн муу хоёр талаар авч үзжээ. Энэ бүхэн бэлгэдэл байна уу, эсвэл зүйрлэл байна уу. Бараг л зүйрлэл байх аа. Нөгөө талаар 8, 9 шарга гэдэг дээр

монголчууд морины зүсийг айхавтар сайн гаргадаг улс. Тиймээс шарга, хонгор 2-ыг ч будлихгүй болов уу гэж бодож байна. Оготор хонгорыг найман шарга дээр нэмдэг нь жаахан хүчээр хийгээд байна уу даа. Үүнийг нилээд үндэстэй гаргаж ирэхгүй бол болохгүй байх.

С.Галсан /доктор/ үг хэлэв.

Сэдвийн талаар энэ үнэхээр докторын диссертаци бичих сэдэв мөн үү гэж их бодсон юм. Тийм ч учраас энэ товчлолыг би их нарийн уншсан юм. Монголчууд тэнэг хүн тэг дундуур нь гэдэг чинь тэнэг хүн ухаангүй гэсэн үг биш байна шүү дээ. Тийм учраас би мэргэжлийн хувьд тэнэг учраас зориуд уншсан. Тэгээд нэг санаа орж ирээд байсан. Тэр санаа Хасумигийн санаатай ижил. Өөрөөр хэлбэл энэ ажил их том юмны захад хүргэж байгаа юм шиг бодогдож байгаа юм. Дэлхийд бичиг гарсан учраас оюун ухааныг их муужруулсан гэдэг. Тэгэхээр одоогоос 700-800 жилийн өмнөх хүмүүсийн дотор зөн бэлгэ, бидний ойлгож байгаа зөн бэлгэ биш байж. Маш том хүчтэй, маш том сэтгэхүйн фактор байсан байж магадгүй. Хэрэв ингэвэл Сумъяабаатар докторын хэлж байгаагаар энэ зохиол гүн ухааны сэтгэлгээнд их чухал гэж бодвол 700-800 жилийн өмнөх хүний сэтгэлгээний этолоныг түүгээр гаргаж болж магадгүй. Бид өнөөдөр зөн бэлгэ гэдгий чинь эвгүй ойлгоод байна. Гэтэл тэр үед тэргүүн зэрэгт байсныг хэн үгүйсгэх вэ? Өнөөдрийн хүний бодлоор нарийн ойлгоно гэдэг хэцүү. Ёгийн нууцыг бид ойлгож чадахгүй байна шүү дээ. Энэ үүднээс үзвэл энэ зохиолын энэ судалгаа цаашдын юм их чухал мэт бодогдож байна. Энэ бол хөндлөнгийн хүнд төрсөн бодол юм. Мэргэжлийн хүмүүс, утга зохиолын мэргэжлийн хүмүүс нарийн зүйлийг хэллээ.

Л.Хүрэлбаатар /доктор/ үг хэлэв.

Өнөөдөр бэлгэдэл гэдэг сэдэв судалгааны тэгэх тусмаа докторын их нарийн сэдэв болж гарч ирэв гэдэг жирийн зүйл биш. Социализмын 70 жилд монголын утга зохиол судлалыг хайрцганд

хашиж авч үзэж, социалист реализм гэдэг томъёоллоор өөрсдөө жижигрүүлж чөдөрлөж ярьж ирсэн. Чухал нарийн дээрээ социалист реализм гэдэг нь магадгүй харин бэлгэдэл, өмнөх үеийн уран сайхны туршлагын бүх ололт дунд байх ёстой юмыг, бодитой юмыг бичдэг, сэтгэдэг, уран сайхны сэтгэлгээний туршлага болгож, явцуурууллж өөрсдөө ойлгочихоод сүүлдээ энэ аргаа эргээд шүүмжилж байсан юмуу гэж бодогддог. Үүнийг нэг талаар задлан ухаарахад монголын утга зохиолыг бэлгэдлийн болзолт үйлдлийн үүднээс задлах гэж байгаа нь маш чухал шинэ, судалгааны ач холбогдолтой зүйл гэж үзэж байна. Бэлгэдлийн тухай, өрнө дахины тухай эрдэмтдийн бичсэн онолын бүтээл байдаг. Үүнд тааруулж судлахад бас зовлонтой.

Д.Цэдэвийн хийсэн ажлын онцлог бол Монголын нууц товчоо гэдэг түүхийн нилээд гүн үед боловсорч хөгжсөн түүх, уран зохиол, шашин, соёлын олон юмны уулзвар дээр байгаа зохиолыг сонгож авсан нь чухам нарийн дээрээ бэлгэдлийн түүхэн хөгжлийн дотоод хувьслыг харахад их гүн учир холбогдолтой сурвалжийг сонгожээ гэж бодогдож байна. Нөгөө талаар бэлгэдлийг тогтолцоотой ойлгож ухаарахын үүднээс ай болгож ангилсан байна гэж үзэж байна. Ер нь бэлгэдлийг ангилна гэдэг нэг талаар огт боломгүй, нөгөө талаар болмоор юм шиг хоёр юмны зангилаан дээр байгаа юм. Ер амьдралын үзэгдэл хязгаарлашгүй. Түүнийг тусгадаг сэтгэлгээний хийсвэрлэл хязгаарлашгүй. Тиймээс эдэн анги төдөн сав гэж ангилана гэдэг бүдүүлэг зүйл шиг санагддаг. Түүгээр барахгүй бэлгэдэл гэдгийг мөнхжих, тасалдах хоёрын ямар нэг зааг дээр авч үзэх вэ? гэдэг ойлгомжгүй. Олон давтагдсанаар нь авч үзнэ гэвэл их утгагүй. Ганц удаа гарч байгаагаараа ч бэлгэдэл болж байна. Түрүүчийн өгүүлсэн хөх тэнгэр дээр чинь байна. Чингис хаан ард чинь байна гэдгийг бэлгэдлийн утгаар авч үзвэл бас болно. Тухайн контекстийн дунд ямар үүргээр орж байна. Хөх тэнгэр гэдгийн цаана юуг ойлгох вэ? гэдэг санаа байна. Хөх тэнгэр гэдгийн цаана бөөгийн шашны, бумбын шашны бүхэл бүтэн үзэл ойлголт байна.

Ерөөсөө бэлгэдлийг нэг зохиол дээр аваад үзэхэд их сонин. Нөгөө тал нь бэлгэдлийн гол сүлжээ, олон шашны уулзвар дээр авч үзвэл нарийн учир зүй гарна.

Цэдэвийн ажлын нэг ололттой тал юу байна вэ гэвэл, МНТ-д байгаа бэлгэдлийг нэгдүгээрт сонгож түүгээд түүн дотроос тодорхой ажиглалтыг хийгээд МНТ-ны бэлгэдлийн өндөр уулын оргил дээрээс цааш харагдаж байгаа өчнөөн олон уулын уул үүл нь мэдэгдэхгүй, уул мэдэгдэвч ямар уул нь танигдахгүй олон юмны барааг харуулаад орхиж байгаа нь шинжлэх ухааны нээлт юм. Заавал асуудлыг шийдсэн байхдаа бус замыг хараад заагаад гаргаад орхисон нь судалгааны шинэлэг тал гэж үзэж байна. Ер нь цаашид энэ судалгаа үүгээр зогсохгүй монголын уран зохиолд байгаа МНТ-ны бэлгэдлийг нэг талаас нь судалж, нөгөөтэйгүүр бусад олон зохиолд бэлгэдлийг судалж байж тэр бүхний эцсийн дүнд монгол бэлгэдэл гэдэг чинь юу болох вэ гэдгийг гаргана. Монгол бэлгэдлийг гаргахын тулд зөвхөн монголын уран зохиолын биш, түүх соёл, шашны гүн холбоотой байсан энэтхэг, төвд, хятад, дорно дахины бусад төв Азийн нүүдэлчдийн бэлгэдлийн онцлогтой холбож, олон сүлжээнд хөл нийлж байж бүрэн гүйцэд судалгаа эцэст гарна. Энэ судалгааны эхний шатны зорилгыг энэ диссертац хангасан учир хэлбичгийн ухааны докторын зэрэг олгох бүрэн боломжтой сайн бүтээл болсон гэж эрдмийн зөвлөлийн гишүүний хувьд үзэж байна.

П.Хорлоо /Академич/ үг хэлэв.

Монголын утга зохиолын судлалд шинэ сэдэв орж ирж байна. Монголын нууц товчоог нарийвчлан судлах, түүний доторх агуулга санааг шинжлэх ухааны үүднээс судлана гэдэг бол утга зохиол судлалд орж ирж байгаа шинэ зүйл тул Д.Цэдэвийн хувьд нилээд зоригтой шинжилгээний ул үндэстэй юм хийе гэсэн эрмэлзлэлийн үүднээс энэ диссертацийг бичжээ. Үүгээрээ монголын утга зохиолын судлалд чухал зүйл болж уг сэдэв шинжлэх ухааны шинэ үндэслэлийг гаргах гэсэн оролдлого гэж би

үзэж байна. Бэлгэдэл гэдэг бол гоо сайхны гол баримжаа. Хүний оюун ухаан болоод сэргэж байгаа эрт балар үеийн гүн ухааны үзэл бодол бол бэлгэдлийн эхний уламжлал байх ёстой. Бэлгэдэл зүйг зөвхөн МНТ-ны хуудсуудаар авч үзэж болохгүй. МНТ-д жинхэнэ ардын бэлгэдэл зүй аль үеэс ямар нарийн шинжээр ард түмний гүн ухааны сэтгэлгээ орсон байна вэ гэдгийг нарийвчилж гаргах нь хэрэгтэй юм. Ийм учраас Цэдэв энэ асуудлыг монголын утга зохиолын 1240 оноос эхэлдэг үеэс өмнө монголын ард түмний гүн ухаан, гоо сайхны сэтгэлгээ бичиг үсэг үүсэхээс өмнө хүн төрөлхтөний оюун билэгт шингэчихсэн, ялангуяа нүүдлийн мал аж ахуйтай тал хөндийгөөр нүүдэллэж явсан ард түмний дунд бэлгэдэл эрт үеэс бий болсон. Ийм зүйл дээр Цэдэв нилээд гол зүйлийг авч тавьжээ. Энэ зохиолын оновчтой тал юу байна вэ гэвэл бэлгэдэл зүй нүүдэлчдийн аж амьдралтай холбоотой байсан гэдгийг гаргах гэж оролдсон чухал санаа, цаашид нарийвчлууштай чухал зүйл мөн.

Хоёрдугаарт хүний аж төрөх ёсонд сүсэг бишрэл биш, жинхэнэ ардын сэтгэлгээ яаж туссан бэ гэдгийг гаргах гэсэн ийм хоёр санаа зэрэг горилсон зохиолийн гол бүтэмжтэй ололттой тал гэж үзэж байна. Эрдэмтэд өөрсдийн саналыг хэлж байгаа нь зүйтэй. Уг зохиол МНТ-ны бэлгэдэл гэж байна. МНТ-той ард түмний бэлгэдлийг холбож авч үзэхэд юунаас эхлэх вэ гэдэг гол асуултын нэг. МНТ-ны бэлгэдэл зүй юунаас? гэвэл ард түмний гүн ухааны, балар үеийн гүн ухааны уламжлал юм. Тэр уламжлал МНТ-д яаж тусган авч вэ гэдгийг дэлгэрэнгүй авч ярих нь судалгааны нарийн асуудал. Козиний хэлснээр шившлэг зэрэг зүйл МНТ-д тусгагдсаныг, бас андгайлах ёс нь бэлгэдлийн нэг чухал зүйл гэдгийг анхаарах нь чухал юм. Миний асуусанд ургамал амьтны төлөөллийн тухай Цэдэв хариулсан. Түүнээс гадна монголчуудын эртний шившлэг, тарни, мөрөөдөл бэлгэдлийн зүйл уул усны тахилга бишрэлтэй холбоотой шүү. Эдгээрийг цаашдын судалгаандаа нарийвчлан анхаарна биз ээ.

Д.Цэдэвийн зохиол нилээд бодитой, чухал эх материалуудыг ашигласан, өөрийн санааг зоригтой хэлсэн шинэ санаа нь шинжлэх ухааны үүднээс судалсан материалаа түшиглэсэн учир хүртэмжтэй нилээд өгөөжтэй болсон байна. Энэ бүхий байдлаараа Цэдэвийн зэрэг горилсон зохиол докторын зэргийн хэв хэмжээ түүний шаардлагыг бүрэн хангасан байна.
Ц.Мөнх /дэд доктор/ үг хэлэв.

Д.Цэдэвийн "МНТ-ны бэлгэдэл" бүтээл нь Нууц товчооны судалгаанд шинэ судалгааны эхлэл тавьж өглөө. Нэг талаас бэлгэдэл нь түүхэн зүй юм. Түүхэн талаас авч үзвэл түүхэн ухамсар, философи талаас нь авч үзэхэд ямар ч байсан яг тэр ард түмний философийн ухамсар, гоо зүйн талаас нь авч үзэхэд ард түмний гоо зүйн сэтгэлгээ. Үүнийг бол олон талаас нь үзүүлжээ. Өөрөөр хэлбэл туурвил зүй юм. Нууц товчооны туурвил зүйн гол зүйл нь бэлгэдэл юм. Энэ бол монголчуудын гоо сайхнаар туурвих зүйл бол бэлгэдэл буюу бэлгэдэл зүй юм. Энэ бол монголчуудын гоо сайхнаар сэдэх, гоо сайхнаар ойлгох, ухамсарлах, дүр бүтээх энэ бүхэн бол болзолт арга, бэлгэдэлт арга. Манайхны ярьдгаар реалист арга гэх юм уу, өөрөөр хэлбэл социалист реалист арга. Энэ бол нүүдэлч монголчуудын бий болгосон гоо зүйн сэтгэлгээний бүтээн туурвих хэлбэр. Энэ бол Цэдэвийн зохиолын судалгааны шинэ нээлт юм. Тиймээс үнэтэй юм.

Зэрэг горилогч Д.Цэдэв үг хэлсэн хүмүүст хандаж "Үнэтэй санал хэллээ. Энд гарсан саналуудыг цаашид энэ бүтээлээ засч сайжруулахад харж үзнэ" гэж өгүүлэв.

Тооллогын комисст доктор Л.Хүрэлбаатар, дэд доктор Д.Оюунбадрах, А.Шархүү нарыг сонгов.

Хурал түр завсарласны дараа тооллогын комиссын 1, 2-р хурлын тогтоолыг дэд доктор Д.Оюунбадрах уншиж сонсгов.

Эрдмийн зэрэг хамгаалуулах хурлаас зохиолын талаар гаргах үнэлэлт дүгнэлтийн төслийг эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дэд доктор О.Сүхбаатар уншиж танилцуулав.

Тогтоолыг санал нэгтэй баталлаа.

Д.Цэдэв эрдмийн зөвлөлийн гишүүдэд хандаж үг хэлж талархал илэрхийлэв.

Эрдмийн зөвлөлийн дарга Д.Төмөртогоо, гишүүдийн өмнөөс Д.Цэдэвт баяр хүргэв.

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН Д.БОЛОРМАА

Г.БИЛГҮҮДЭЙ

Д.ЦЭДЭВИЙН "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ БЭЛГЭДЭЛ" ДОКТОРЫН ДИССЕРТАЦИЙН ТУХАЙ ШҮҮМЖЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ТОДОРХОЙЛОЛТ

1997.6.26

Монгол бэлгэдэл зүйн судалгаа сүүлийн үест эрчимтэй өрнөж байгаагийн дунд аман зохиолоос гадна бичгийн зохиолын өв рүү хандах болсон нь нэн сайшаалтай. Учир нь аман бичгийн уламжлалаа хамгийн төгс төгөлдөр хадгалсан "Монголын нууц товчоо" зэрэг зохиолыг нарийвчлан судалвал, язгуур монгол бэлгэдэл зүйг жинхэнэ ёсоор тодруулан харуулж болно.

Шинжлэх ухааны энэ чухал зорилтыг хэрэгжүүлэхэд дэд доктор Д.Цэдэвийн диссертаци чиглэсэн байна. Д.Цэдэв бэлгэдэл зүйн ерөнхий айн дотроос "Монголын нууц товчоо"-нд /МНТ/ илэрч буй гол гол айг /тооны, өнгөний, зөн совингийн г.м/ нарийвчлан судалсаны дээр энэ зохиол дахь бэлгэдлийн цогцолбор, чуулбарыг тусгай бүлэг болгон авч үзсэн нь нэн оновчтой болжээ. Энэ бүхнийг судлах "дэвсгэр" болгож, "МНТ"-ны бэлгэдлийн соёл-түүхийн хам нөхцөл, хамрах хүрээг" тэргүүн бүлэгтээ дэвшүүлэн гаргажээ.

Д.Цэдэвийн судалгааны энэ арга зүй мэргэжилтэн хүмүүсийн бүрэн дэмжих чиглэл мөн. МНТ бол соёлын гоц үзэгдлийн хувьдаа түүхэн тодорхой хам нөхцлийн бүтээгдэхүүн гарцаагүй мөн билээ. Иймд диссертацийн бүлэгт эртний

монголчуудын чулуун шүтлэг, модны шүтлэг, амьтны шүтлэгийн /нохой, хэрээ, могой/ ул мөр /23-32-р тал/ хэрхэн уламжилсан болон тэр нь энэ зохиолын бэлгэдэл зүйд хэрхэн холбогдохыг нарийвчлан задлан шинжилжээ.

Энэ бүтээлийн дотор буй эрдэмтэн мэргэжилтний сонирхолыг үлэмж татах нэг хэсэг нь "Хүний амьдралын гол мөчлөг ба бэлгэдэл" /33-46-р тал/ гэсэн хэсэг юм. Энд Алун гоо эхийн гэрлээс жирэмсэлсэн тухай алдарт домгийн өгүүлэмж, түүний бэлгэдлийн талаарх эрдэмтэн мэргэдийн саналыг /Бурханы шашны болон домог зүй-бөө мөргөлийн үндэслэлтэй гэсэн/ нэг бүрчлэн тунгаан үзээд "чухам энэ гурван эрдэмтний саналаас харахад уран сайхны сэтгэлгээний гадны нөлөөтэй холбохоос илүүтэй монгол сурвалжтай уялдуулан судалгааг гүнзгийрүүлж шинийг хайхад аман зохиол дахь "хувилж төрөх" олон арвин жишээнд анхаарахад илүү ач холбогдол өгмөөр байгаа юм. Чухам ингэж үзэх аваас эрдэмтдийн саналын цогцод нэгэн санаа сэдлэг өгч шинэ тайлбар нэмэгдэж болно". /36-р тал/ гэсэн өөрийн өвөрмөц санаагаа илэрхийлжээ. Мөн "монгол худ ургийн ёс, хурим, найр бол тэр аяараа бэлгэдлийн цогцлол мөн" /38-р тал/ болохыг гярхай ажиглаж, монголчууд шагайгаар "таван хошуу малыг төлөөлөх гол бэлгэдэл" /39-40-р тал/ болгодог бөгөөд анд бололцоход шаа буюу шагай солилцдогийн гол утга нь хоёр мөчийг бат холбогчийн үүргээр нь бэлгэдэл болгосон" /40-р тал/ гэж үзсэн нь бүрэн дүүрэн зөвшөөрч болох санал мөн. Энд мөн ах дүү-барилдах, эцэг хүү бололцох ёс, хаан удмынхныг цус гаргалгүй нөгчүүлэх ёсыг бэлгэдэл зүйн үүднээс хөндөж байна.

"МНТ-ны бэлгэдлийн гол ай" гэсэн дэд бүлэгтээ хэд хэдэн сонирхолтой жишээ дүгнэлт гаргасны дотроос "гурав" гэсэн тооны хүрээн дотор бол өөрийн гэсэн утга илтгэх, "гурав"-аас цаашилбал хүнийх болмуй гэсэн ойлголт байсан гэж бодогдоно. Тиймээс "гурав хоног" нь "гурбан нэүрит" гэдэгтэй адил өөрийн хүрээний дотор гэсэн утгатай ойролцоо санааг илэрхийлсэн гэж

болно. /57-р тал/ гэсэн цоо шинэ санал дэвшүүлжээ. Энэ саналыг тэгш, сондгой тооны талаарх монголчуудын уламжлалт бэлгэдлийн үзэлтэй холбон үзвэл бүр ч сонирхолтой үр дүн гарах буй заа. Түүнчлэн XIII зууны үед буюу түүнээс ч өмнөх үед монголчуудын дунд сарын доторхи цаг хугацааны үндсэн баримжаа нэгж нь "гурав хоног" байжээ гэсэн дүгнэлт /61-р тал/ хийсэн байна. Эндээс гурвын тооны олшруулсан хэлбэр "ес"-ийн бэлгэдэл-есийн тоонд "гурвын утга бэлгэдэл хадгалагдах", гурвын тоонд "есийн утга бэлгэдэл хадгалагдах" холбоо хамаарлыг гаргахаар зорьсон байна. Бас "таван ангида гал" гэдэг ойлголтыг шинжилж үзээд XIII зууны үед таван хүн нэгдэж "гал" болох тохиолдол байсан байж болох /74-р тал/ бөгөөд тэр гал нь сэтгэлгээ нэгтнээс бүрдэж байсан гэсэн санааг Жамухын мөхөл төгсгөлтэй холбон нэлээд үнэмшилтэй тайлбарлажээ.

МНТ дахь өнгөний бэлгэдлийн тухайд -бөртэ", "хоа" гэсэн хослол нь "хар цагааны" эерүүлэл "бараан, бүгээн" болох /83-р тал/ хийгээд "эцэг эх" өнгөний бэлгэдлийн үүргээ домог зүй, шүтлэг мөргөлийн түвшинд гүйцэтгэж байна гэсэн үг юм.

Зохиогч МНТ дахь зөн совингийн бэлгэдлийг тусгайлан судалж, сэтгэц задлагийн /З.Фрейд/ онолын сурвалжаар үндэслэн монгол домог зүй, бөө мөргөлийн үзэл төсөөлөлтэй холбон тайлбарласан байна. Тухайлбал, Жамухын хувь заяаг муугаар ёрлогч ухаагчин үнээ, Тэмүүжиний хувь заяаг сайнаар зөгнөгч Мухулар ухаа үхэр байгаа нь тэрхүү заарины онгон сахиус байсных бололтой /101-р тал/ гэж үзсэн нь анхаарал татаж байгаа бөгөөд монгол бөө мөргөлийн ёсонд үнэхээр зөн совин гэдэг бол онгод сахиулсны үйлс байдаг билээ.

Зохиолын гудгаар бүлэгт МНТ-ны бэлгэдлийн цогцолбор, чуулбарыг монгол хувцасны болон уран утга, дүрийн бэлгэдлээр төлөөлүүлэн авч үзсэн нь нэн оновчтой болжээ гэж дүгнүүштэй. Тухайлбал, монголчууд малгайг "хүний оюун санаа, сүлд хийморийн бэлгэдэл хэмээн үздэгийг" /125-р тал/ түүх-угсаатны зүй, ардын билиг зүйн олон иш баримтаар нотолжээ.

МНТ-нд байдаг үлэмж сонирхолтой үг хэллэгүүдийг шинжлэхэд уран сайхны болон угсаатны зүйн олон шинэ сонин зүйлсийг илрүүлж болохыг харуулсан байна. Тухайлбал, монгол туульс болон "МНТ" дахь улиран хувьсах уран сэтгэмжийн тухай шинжилгээ нь /157-р тал/ шашин судлал, соёл судлал, урлаг, уран зохиол судлалын аль ч талаасаа нэн сонирхолтой үзэгдэл бөгөөд бүхэл бүтэн бэлгэдлийн цогцолбор үүсгэдгийг баталсан байна. Тэгэхлээр тэнгэр, газар, усан мандлыг амьтан, эд өлгөөр төлөөлүүлэх /156-р тал/ ёс монгол болон Ази дахины бэлгэдэл зүйд түгээмэл байдаг билээ.

Эцэст дүгнэж үзвэл сонгож авсан сэдвийн чухал судалгаанд хамруулсан түүх, угсаатны зүй, соёл, шашин судлалын эх хэрэглэхүүний цар хүрээ, дэвшүүлсэн шинэ соргог дүгнэлт, өнөөгийн шинжлэх ухаанд ирээдүйтэй хэтийн төлөвийг нээж буй бэлгэдэл зүйн судалгааг гүнзгийрүүлэх чиг зорилго, үр дүнгээрээ горилогч Д.Цэдэвийн нэг сэдэвт бүтээл хэлбичгийн ухааны докторын зэргийн шаардлагыг бүрэн хангасан бүтээл болсныг эрдмийн зөвлөлийн гишүүд та бүхэнд өргөн айлтгаж байна.

Монголын Судлалын Дээд сургуулийн захирал
Хэлбичгийн ухааны дэд док, дэд проф. **Д.ГАЛБААТАР**

Утга зохиолын тэнхмийн эрхлэгч Хэлбичгийн
ухааны доктор, дэд проф. **С.ДУЛАМ**

Дэд доктор Д.ЦЭДЭВИЙН ХЭЛБИЧГИЙН УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГ ГОРИЛСОН "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ БЭЛГЭДЭЛ" ХЭМЭЭХ ЗОХИОЛЫН ТУХАЙ

Сүүлийн үед "Нууц товчооны" эх бичгийн судлалын ажлыг дагалдан утга судлалын шинэ сэргэг бүтээл гаргах болсон нь санамсаргүй зүйл биш юм. "Нууц товчооны" эхийг хичнээн зөв сэргээж, зөв буулгаж, зөв ухаарах тусам уг зохиолыг бид жинхэнэ утгаар нь ойлгох бололцоо тэр хэмжээгээр нэмэгдэх болно.

Дэд доктор Д.Цэдэв орчин үеийн "Нууц товчоо" судлалын гол гол бүтээлүүдийг ашиглаж "Монголын нууц товчооны бэлгэдэл" гэсэн ганц сэдэвт зохиолыг бичжээ. Энэхүү ганц сэдэвт нь Монголын нууц товчооны бэлгэдлийн соёл түүхийн хам шинж, бэлгэдлийн гол гол ай хийгээд, бэлгэдлийн цогцолбор, чуулбар гэсэн 3 бүлэгтэй юм.

Зохиогч эл бүтээлдээ "Монголын нууц товчооны" туурвилзүйн аргыг шинэ санаа, шинэ дүгнэлтээр баяжуулсан бэлгэдэл зүйн шинж чанарыг тогтолцоотой гаргаж ирсэн нь уг бүтээлийн гол амин сүнс болж байна. "Нууц товчоонд" илэрч буй бэлгэдлийн ойлголтууд нь тухайн үеийн зан заншил, ёс суртахуун, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл тэргүүтэн нийгмийн ухамсарын олон талын үйл ажиллагаатай нарийн шүтэлцээ бүхий тогтолцоотой үзэгдэл болохыг нээн гаргахыг оролдсон нь уг бүтээлийн бас нэг шинэлэг тал гэж хэлж болно.

Ялангуяа зохиолын тэргүүн бүлэг, дэд бүлгийн "Тооны бэлгэдэл", "Зөн совингийн бэлгэдэл" гэсэн хэсгүүдийн бичлэг баримт, нотолгоо сайнтай болсныг онцлон тэмдэглэе. Зэрэг горилогч "Нууц товчооны" бэлгэдлийн ойлголтуудыг тоочин тодорхойлохыг урьдал болгосонгүй түүний учир шалтгаан, гүн бүтцийн шинжийг нь тодорхойлох зорилгоор ардын аман зохиол хийгээд түүхийн бусад сурвалж бичгийн мэдээ баримттай аль болохоор холбож судлахыг хичээснийг бас дурдах нь зүйтэй юм.

Одоо энэ зохиолын дутагдал гэж үзсэн өөрийн зарим нэгэн ажиглалтыг өгүүлье.

1. Энэ зохиолд бэлгэдлийг /символика/ гол судлагдахуун болгосон авч бас бэлэг шинж /примета/ буюу сайн муу бэлэг ёрын зүйлийг бас хамруулсан шинжтэй юм. Жишээ нь: Эмээлийн худраг хөмөлдөг мултрах, тэрэгний тэнхлэг хугарах г.м. Гэтэл урианхадай анчин уушигт зүлдээ өөртөө үлдээсэн "Гүр хаан", "Чингис хаан" хэмээн цол хайрласан ёсны бэлэг тэмдэг, наймны Гүрбэсү хатан Ван ханы толгойг тахиж байтал инээв хэмээн муу ёрд үзсэн зэрэг сайн, муугийн олон бэлэг тэмдгийн талаар чимээгүй өнгөрчээ.

2. Тооны бэлгэдлийн хувьд 1, 3, 5, 7-гийн бэлгэдэл "Нууц товчоонд" илт мэдэгдэм содон байх бололтой. Үүнээс зохиогч зөвхөн гурвын тооны бэлгэдлийг үржвэр буюу хувилалынх нь тогтолцоонд (3 х 3 = 9) нэлээд дэлгэрэнгүй авч үзсэн боловч бусдыг нь цаг, цаас хэмнэх үүднээс ч юм уу товчилсон байна. Миний бодоход тооны бэлгэдлийг дан ганц үндсэн тооны нэгж бүрээр нь ярих бус түүний үржвэр хувилалын хам тогтолцоогоор нь судлах нь зохимжтой байж болох юм гэж үзэж байна.

3. Нууц товчооны бэлгэдлийн цогцолбор чуулбар гэсэн утгаар бүлгийн дэд зүйл болох уран үгийн дүрийн бэлгэдлийн зарим жишээг цаашид хэвлэн нийтлүүлж олны хүртээл болгох үест эргэж нягтлах баяжуулах хэрэгтэй мэт санагдана.

Тухайлбал:

"Өлөн дор хучиваас
Үхэр үл идэгдэх
Өөхөн дор хучиваас
Нохой үл идэгдэх" гэх мэт

Харин үгийн яруу сайхны бэлгэдлийн хувьд судлагчдын утга учрыг энэ хир нээн гаргасан, гаргаж хараахан амжаагүй байгаа

- Нүдэндээ галт
Нүүрэндээ гэрэлт

- Бие тэргүүт
  Дээл захт
- Холын хоорцог
  Ойрын одол
- Өдөр үзэх нүд
  Шөнө сонсох чих
- Нуган хөвүүн
  Нутаг сахих
  Охин хөвүүн

Өнгө шилэгдэх гэх мэт олон сонин үг хэллэг, уран шүлгийн бэлгэдлийн учир шалтгааныг нээн гаргасан бол энэ бүлэг улам сонирхолтой болох байсан болов уу гэж санагдана.

Миний дээр дурдсан хэдэн баримт бол уг бүтээлийн эрдэм шинжилгээний үнэ цэнийг бууруулах ноцтой зүйл огт биш бөгөөд хэрэв авах гээхийн ухаанаар тунгаан үзвээс дараа хэвлэн нийтлүүлэх цагт хэрэг болж юун хэмээн нуршин өгүүлсний учир энэ болно.

Эцэст нь дүгнэж хэлбэл дэд доктор Д.Цэдэвийн "Монголын нууц товчооны бэлгэдэл" хэмээх эл ганц сэдэвт зохиол нь "нууц товчооны" утга чанарыг жинхэнэ ёссор нь нээн гаргахад чухал хувь нэмэр болсон олон сонирхолтой шинэ санаа, дүгнэлт бүхий чамбай сайн ажил болсон тул хэлбичгийн ухааны докторын зэрэг олгохыг эрдмийн зөвлөлд уламжлаж байна.

АЛБАН ЁСНЫ ШҮҮМЖЛЭГЧ ХЭЛБИЧГИЙН УХААНЫ ДОКТОР Д.ЦЭРЭНСОДНОМ

1997.6.28

ДЭД ЭРДЭМТЭН ДОЖООГИЙН ЦЭДЭВИЙН "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ БЭЛГЭДЭЛ" ХЭМЭЭХ ХЭЛ БИЧГИЙН УХААНЫ ДОКТОРЫН ЗЭРЭГ ГОРИЛСОН ЗОХИОЛЫН ТУХАЙ

Д.Цэдэвийн дээр дурдсан докторын зэрэг горилсон зохиолыг шинжлэн уншсаны сэтгэгдлийг минь дараад нь бичиж барья.

1. Энэ зохиол бол монгол бэлгэдэл зүйг "Монголын нууц товчоо"-г хэрэглэгдэхүүн болгож судалсан нэг шилдэг судалгаа мөн.

2. Би "Нууц товчоо"-ны судлагчдын нэгэн болох тул энэ зохиолыг их сонирхолтой үншсан юм.

3. Зохиогч нь "Нууц товчоо"-ны дотроос:

а/ Тооны бэлгэдэл
б/ Өнгөний бэлгэдэл
в/ Зөн совингийн бэлгэдэл

гэдэг гол айг өргөн авч олон жишээнүүдийг өгсөөр байж саналаа дэлгэрүүлж байх нь их оновчтой юм.

4. Тэгээд "Нууц товчоо"-нд гарсан бэлгэдлийн жишээ бол давтагдсан, эс давтагдсан ч тохиолдлын төдий бус хэв шинжит тогтолцооны илрэл болж байгаад түүний нэгэн онцлог тал оршино гэж дүгнэж байна.

Ерөнхийлөн хэлэхэд Д.Цэдэвийн энэ зохиол нь "Нууц товчоо"-ны дотор эдүгээ судлалгаанд төдийлөн хөндөгдөөгүй шахам байгаагүй сайхан бүтээл гэж бодогдоно.

Токио Гадаад Хэлнүүдийн Их сургуулийн хүндэт профессор, доктор

ШИГЭО ОЗАВА 1997.6.25

ДОЖООГИЙН ЦЭДЭВИЙН "МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ БЭЛГЭДЭЛ" ГЭДЭГ ДОКТОРЫН ЗЭРЭГ ГОРИЛСОН ЗОХИОЛЫН ТУХАЙ

1. Мөхөс хүн, олон монголчуудын бэлгэ тэмдэг, бэлгэ дэмбэрэлийн тухайт асуудлыг нэг үе баахан сонирхож хөөж үзсэн юм. Мөн сонин мөртөө тун амаргүй хоол байна лээ.

Эртнээс авхуулаад өдгөөгийн монголчуудын ахуйн ба гүн ухааны сэтгэлгээнд бэлгэ тэмдгийн сэрэл, бишрэл, итгэл, ойлголт нэвт шингэсэн байдаг.

Бэлгэ тэмдэг гэдэг нь бодитой юм уу гэхээр харагддаггүй, баригддагүй, ихээхэн хийсвэр, бодигүй юм уу гэхээр үнэхээр байгаад оршоод, үйлчлээд байдаг тийм нэгэн гайхалтай үзэгдэл юм билээ. Орон зайд, цаг хугацааны орчилд, үндэстэн угсаатны хүрээнд өөрчлөгддөг, асар их хувирамтгай, олон өнгө аястай, тухайлбал томорч ихэсдэг, жижгэрч багасдаг, илэрч тодордог, холддог ойртдог, бүдгэрч бүхэд болдог, тасардаг гээгддэг, залгагддаг уламжлагддаг увидас чанартай зүйл байх шиг бодогдсон. Тийм учраас зон олон бэлгэ тэмдэг, бэлгэ дэмбэрэлийг дагадаг, сөрдөг, дундажийг нь барьдаг гурван хандлага байсаар ирсэн ба бэлгэ зүй нь нарийн бүтэцтэй, тодорхой тогтолцоотой, монгол үн ухааны сэтгэлгээний салшгүй нэг хэсэг юм билээ л.

Энэ мэтээс үзэхэд, дэлхийн монгол судлал, цаашлаад нүүдэлчдийн соёл иргэншлийн судалгаанд Монгол бэлгэ зүй гэдэг шинэ чиглэл үүсэх, салбар ухаан буй болох зайлшгүй шаардлагатай. Мөн бэлгэ дэмбэрэлийн нэг ай, эсвэл нэг сурвалж, нэг зохиол дахь бэлгэ тэмдгийн судалгааг хийхгүйгээр нийт монголчуудын бэлгэ зүйн тогтолцоог бүрэн төгс гаргаж чадахгүй нь ойлгомжтой. Чухам эндээс л олон шинэ зүйл, хосгүй баримт хэрэглэгдэхүүн гарч ирэх учиртай. Өнөөдөр ийм сайхан учрал дэмбэрэл бүрджээ.

2. Монголын нууц товчоо бол цагийг эзэлсэн нэгэн туургатныхаа унаган ахуй, аж төрөл, өлгий нутаг, үүх түүх, хэл соёл, уугал сэтгэл, үн ухааныг нэвт шингээсэн, өвөг дээдсийн маань

үе үеийнхний оюун ухаанаар бүтсэн их хөлгөн бүтээл билээ. Монголын нууц товчоотой золоор учирч хадаг барин шавь орж, нууц товчоо судлалд тоосоо өргөсөн билигтэн мэргэдийн тоо олон, дэвжээ уудам аа. Энэ удаа эрдэмтэн Цэдэв гурван бүлэг бүхий "Монголын нууц товчооны бэлгэдэл" гэдэг докторын зэрэг горилсон зохиол туурвин энэхүү ариун эгнээнд орж ирлээ.

Бичсэн зохиол нь *нэгдүгээрт* элж хуучирч улиг домог болоогүй нэр устай, *хоёрдугаарт* агуулга төгөлдөр, *гуравдугаарт* хэрэглэгдэхүүн арвинтай, *дөрөвдүгээрт* урьд хожид гарсан холбогдох ном, өгүүллийг ихэвчлэн олж үзэж ашигласан, урьдчилсан хамгаалалт дээр хүмүүсийн гаргасан саналын дагуу засч цэгцэлсэн, *тавдугаарт* задлан шинжлэх хийгээд багцлан дүгнэхдээ осол цалгай үгүй, маш нягт бүтээл болсон байна гэдгийг юуны өмнө цохон тэмдэглэхийн ялдар аа, монгол судлалд шинэ чиглэл, шинэ салбар буй болоход үнэт нэмэр хандив оруулсан чансаалаг зохиол туурвисан эрдэмтэн Цэдэвт горилсон докторын зэргийг нь хүртээхийг Эрдмийн зөвлөлийн эрхэм гишүүд болгоон соёрхох буй заа.

Хэвлэн нийтлэхийн тухайд харгалзан үзэхэд илүүдэх юун хэмээн дараах хэдэн саналыг хэлье.

